

“Онгод хайрлам, эш үзүүлэгийн, хүчирхэг ном.”

—A21 болон Пропел Вумэн хөдөлгөөний
үүсгэн байгуулагч Кристин Кэйн

Эргэлзээ, харьцуулалтын
энэ эрин цагт
өөрийгөө болон
зорилгоо
олж мэдэх

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

ЛИЗА
БИВЭР

Lioness Arising, Сэлэмтэй охид

бестселлер номын зохиолч

Найз минь,

Чи бол зорилготой хүчирхэг эмэгтэй байхаар Бурханаар бүтээгдсэн! Гэтэл олонх маань хамаг амьдралаа бөөн бөөн эргэлзээ, айдас дунд л өнгөрөөх юм. Бид өөрсдийгөө бусадтай харьцуулахдаа хамаг баяр хөөр, амар тайвнаа гээжээ.

Энэ үг нь нас насны бүх эмэгтэйчүүлд зориулагдсан үг бөгөөд энэхүү номоороо чамайг ерөөх нь миний хувьд нэр төрийн хэрэг билээ. Энэ үгийг бусаддаа ч чөлөөтэй дамжуулаарай. Энэ бол миний та нарт зориулсан бэлэг юм шүү!

Хайр, урам зориг, халуун сэтгэлээр зоригтой амьдраарай!

Хүндэтгэсэн,



Лиза Бивэр.
LisaBevere@ymail.com



“Энэ дэлхий дээрх хүн бүр өөрийнхөө үнэ цэнийг, өөрийгөө хичнээн их хайрлагдсаныг мэддэг ч болоосой. Өрсөлдөгчгүй номоороо Лиза биднийг Бурханаар хосгүй онцгой бүтээгдэж, хайрлагдсаныг ойлгуулжээ. Яагаад гэвэл Бурхан бидэнд Өөрийнхөө төлөвлөгөөний нэгээхэн хэсгийг биелүүлээрэй гэж даалгасан. Энэ ном нь Бурханыг, танд хандсан Бурханы даалгаврыг мөшгих урилга ажээ.”

— **Холи Вагнер**, пастор зохиолч

“Бид өнөөдөр өөрийгөө хэн болохыг мэдэх гэж буруу газраа хайсан, тэнэмэл сэтгэлээр дүүрэн нийгэмд амьдарч байна. Харин энэ ном нь эрчүүдийг ч, эмэгтэйчүүдийг ч жинхэнэ үүсэл гарал руу нь чиглүүлж өгчээ. Бид Бурханых. Тэр биднийг сонгосон. Тэр биднийг онцгойлон хайрласан. Лиза энэ мөнхийн үнэнийг мундаг хэлжээ. Заавал унших ном!”

— **Брэйди Бойд**, Колорадо Спрингс дэхь Нью Лайф Чуулганы пастор, *Addicted to Busy* номын зохиолч

““Өрсөлдөгчгүй” номдоо Лиза Бурхан биднийг хэн байлгахаар бүтээсэн, биднийг хэрхэн нэг бүрчлэн, онцгойлон хайрлагдгийг заажээ. Энэ номыг уншсны дараа өөрийг нь гэх Бурханы хайранд эргэлзэх хүн үлдэхгүй байх аа!”

— **Крис Ходжес**, Хайлэндсын Чуулганы тэргүүн пастор, *Fresh Air and Four Cups* номын зохиолч.

“Өөрийгөө хэн болохыг мэдэх гэж зөрчилдөж байгаа бол, энэ номыг унш. Христ дотор өөрийгөө хосгүй онцгой хүн болохыг мэдэх нь биднийг нөөц тоглогчоос Бурханы авралын аугаа төлөвлөгөөнд байр сууриа эзлэсэн гол тоглогч болгоно.”

— **Шэйла Уолш**, *God Loves Broken People* номын зохиолч, *Women of Faith* нэвтрүүлгийн гол хөтлөгч

““Өрсөлдөгчгүй” бол яг энэ цаг үеийнхэнд нөлөөлөх, нүд нээсэн ном. Лиза Бивэр Бурханы хайрыг уншигч бүрийг олзлом, маш үзэсгэлэнтэй, шинэлэг аргаар харуулжээ. Унших тусам, Бурханы хайрыг улам мэдэж, Бурханы дотроос өөрийгөө олж авна.”

— **Мэтью Барнет**, Дриим Төвийг хамтран байгуулагч

““Өрсөлдөгчгүй” бол хүмүүсийг гэх Бурханы хайрын үзэсгэлэнтэй санамж ажээ. Гэхдээ Лиза үүнийг маш уран яруу аргаар, шинэлэг илчлэлээр гаргасан байна. Уншигч бүрийг сэргээх маш сайхан ном байна.”

— **Каролин Барнэт**, Дриим төвийн пастор

“Өрсөлдөөн, харьцуулалтад идэгдсэн дэлхийд энэ номыг ээж бүр, охин бүр, удирдагч бүр, найз бүр уншиг. Өөрт байгаагаа харьцуулж байхаар, гар гараа барин нэгдэх цаг болжээ. Бие биеэ үгүйсгэж байхаар бие биеэ бишрээ. Бид өрсөлдөгчгүй. Тиймээс хүн бүр цэцэглэн хөгжиг ээ.”

— **Шарлот Гамбилл**, Английн Брэдфорд дахь Лайф Чуулганы удирдах пастор

“Өөрийнхөө үнэ цэнийг мэдрэхгүй эсвэл зорилго чиггүй санагдаж байгаа бол, дотоод шүүмжлэлийн чинь амыг үдэх хамгийн сайн арга нь “Өрсөлдөгчгүй” ажээ. Ямар ч нөхцөл байдлын дунд сэтгэл хангалуун байж, харьцуулалтгүй амьдрах байр суурийг Бурхан чамд олгосон.”

— **Стивен ба Холли Фуртик**, Элевэйшн чуулганы пастор.

“Чи бол ямар ч харьцуулалт, өрсөлдөөнгүй, Бурханы их гарын бүтээл бөгөөд Бурханаас өгөгдсөн онцгой хувь заяандаа хүрч чадна гэдэг мэдлэгээс ирэх эрх чөлөө, итгэлтэй байдлыг Лиза заажээ.”

— **Викториа Остин**, Техасын Хьюстоны Лэйквүүд чуулганы пастор

“Лизагийн “Өрсөлдөгчгүй” бидэнд Христийн дотор хэн болохыг маань цоо шинээр харуулжээ. Бурханлаг цэц ухаан, гэгээрлээр дүүрэн ном. Таныг Эзэний дуудлагын араас явахад чинь уриалж, урамшуулж, боловсруулна. Хувь тавиланд чинь хандсан Эзэний үгийг сонсохыг хүсч байгаа бол, яг л уншдаг ном! Заавал уншаарай.”

— **Крис Валлотон**, Калифорнийн Реддинг дэхь Бетел чуулганы туслах тэргүүн удирдагч

“Миний дотны найз Лизагийн ном олон хүнд эрх чөлөө авчрах болтугай. Уншиж байхдаа харьцуулж, өрсөлдөх хүслээ ялж, өөрөөрөө байж сурахад чинь туслахыг Бурханаас гуйгаарай.”

— **Жэймс Робисон**, *LIFE Outreach International* байгууллагын үндэслэн байгуулагч бөгөөд ерөнхийлөгч.

“Би Лизад хайртай. Тэр яг цагаа олсон үг хэлдэг. Энэ номыг хүн бүр унших ёстой, итгэх ёстой. Өөрийгөө хэн болохыг мэдэж, бусдын хэрэгцээг мэдэх нь маш чухал юм. Аавынхаа хэлж байгаа ганхашгүй, жинхэнэ тодорхойлолтыг уншаад, улам хүчирхэг болох чинь гарцаагүй.”

— **Женн Жонсон**, Бетел Мьюзикийн магтаалын удирдагч, дуу зохиогч

““Өрсөлдөгчгүй” бол нас насны эмэгтэйчүүдийг сэрээсэн ном. Бид Бурханаар онцгойлон хайрлагдаж, дуудагдсан гэдэг Лизагийн үг шиг хэрэгтэй үг алга. Хуудас болгоноос нь түүний сэтгэл зүрх, эрч хүч мэдрэгдэж байна.”

— **Алли Вортингтон**, *Breaking Busy: How to Find Peace and Purpose in a World of Crazy* номын зохиолч

“Лизагийн Сүнсээр дүүрэн, зоригтой үг олон эмэгтэйг харьцуулалт, бардамнал, атаархлаас чөлөөлнө. Лиза бол яг л номлосон шигээ амьдардаг хүн: Есүст хамаатай хүн өрсөлдөгчгүй амьдардаг.”

— **Сара Бесси**, *Jesus Feminist, Out of Sorts: Making Peace with an Evolving Faith* номын зохиолч

“Лизагийн шинэ ном үнэхээр эрдэнэ ажээ. Яг л Бурхан алгаа хоёр хацарт маань наан, Өөр рүүгээ харуулж байгаад, “Би чамд хайртай” хэмээн шивнэхтэй ижил.”

— **Лиза Харпер**, зохиолч, Библийн багш

“Өөрийгөө хэнийх болохыг, Бурханы гэр бүл дэхь онцгой байр сууриа бас Христийн зан чанарыг таньж мэдсэнээр бидний зүрх, сэтгэл эрүүл саруулаар бойжино. Лиза мөнхийн зарчмыг Библийн үнэн, хувийнхаа илчлэлээр заах ер бусын чадвартай. Үүгээр нь

та гагцхүү өөрийгөө хэн болохыг мэдээд зогсохгүй, Түүнийг бас өөрийнхөө, өрсөлдөгчгүй, хүчирхэг Аврагч болохыг нь таньж мэднэ.”

— **Брайн** болон **Бобби Хьюстон**, Хиллсон Чуулганы тэргүүн пасторууд

“Өрсөлдөөн харьцуулалтын энэ ертөнцөд Лиза Бивэр “Охин минь, чи онцгойгоор хайрлагдсан, байгаагаараа л хангалттай охин” гэдэг эдгээгч, хүчирхэгжүүлэгч, тордогч үгээрээ биднийг мундаг босгожээ. “Өрсөлдөгчгүй” ном нь биднийг шаардлагагүй өрсөлдөөнөөс суга татаж, Аавын маань зүрхэнд аюулгүй газардуулан, Түүний тэвэрт үндэслүүлжээ. Гүн харилцаа холбоо, тодорхойлолт, зорилгоор цангаж байгаа эмэгтэйчүүдийн заавал унших ном.”

— **Криста Блэк Гиффорд**, шагналт дуу зохиогч, илтгэгч, *God Loves Ugly and Heart Made Whole* номын зохиогч

“Лизагийн шинэ ном биднийг гэх Бурханы онцгой хайрыг маш үзэсгэлэнтэй дүрслэн харуулжээ. Бурхан биднийг Өөрийнх нь дотор онцгой үнэ цэнэтэй, тодорхойлолттой бүтээсэн учраас, бидэнд үнэхээр өрсөлдөгч байхгүй ажээ. Хүн бүр уншиг!”

— **Женцен Франклин**, Фрии Чапел Чуулганы пастор, *Нью Йорк Таймсын* шилдэг зохиолч


“Хайртай найз маань дахиад л мундаг ном бичжээ.

Өрсөлдөгчгүй бол онгод хайрлам, эш үзүүллэгийн, хүчирхэг ном бөгөөд чамайг хэн болохыг, хэнийх болохыг чинь таниулна. Таньдаг мэддэг хүн бүртээ нэгийг өгөөрэй - би ч бас тэгнэ.”

— **Кристин Кэйн**, A21 болон Пропел Вумэн хөдөлгөөнийг үндэслэн байгуулагч

“Бид үнэхээр тэгш биш, харин онцгой хайрлагджээ. Өрсөлдөгчгүй номд Лиза чамд өөрийнхөө хүч зорилгыг дахин нээхэд чинь туслах үнэнийг тайлж өгчээ.”

— **Марк Баттерсон**, *The Circle Maker* номын зохиолч, *Нью Йорк Таймсын* шилдэг зохиолч, Нэйшнэл Коммюнити Чуулганы удирдах пастор



Эргэлзээ, харьцуулалтын
энэ эрин цагт
өөрийгөө болон
зорилгоо
олж мэдэх

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

ЛИЗА
БИВЭР

Lioness Arising, Сэлэмтэй охид
бестселлер номын зохиолч

Without Rival, (Mongolian) by Lisa Bevere
© 2022 Messenger International

Originally published in English as Without Rival by Lisa Bevere
Copyright © 2016 Revell, a division of Baker Publishing Group

Additional resources in (Mongolian) are available for
free download and video streaming at
MessengerX.com and on the **MessengerX app**

To contact the author: LisaBevere@ymail.com
Printed in Mongolia

ӨРСӨЛЧДӨГЧГҮЙ (Монгол хэлээр) Лиза Бивэр
© 2022 Messenger International

Англиар анхлан зохиолч Лиза Бивэр, Without Rival нэрээр гарсан
Copyright © 2016 Revell, a division of Baker Publishing Group

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа
MessengerX.com болон **MessengerX app** -аас
шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Энэ номын цахим хувилбарыг үнэ төлбөргүй татаж авч, унших боломжтой ч,
цаасан хувилбараар худалдах эрх нь албан ёсоор Маранатад хадгалагдана.

Зохиолчтой холбогдох и-мэйл хаяг: LisaBevere@ymail.com
Монгол улсад хэвлэв.



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.
Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

Хонгор бүсгүй минь,

Чи бол яг энэ цагийн төлөө Ааваараа ямар ч өрсөлдөгчгүй бүтээгдэж, харьцуулашгүй үг амлалт хүлээж авсан нэгэн. Чи энэ цагт хамгийн аймшигтай бөгөөд гайхамшигтай байхаар сонгогдсон. Иймээс л хэнээс ч айлгүй хайрла... алмайртал итгэ... хэмжээлэшгүй найд.

Агуулга

1. Өрсөлдөгчгүй хувь чанар	13
2. Бидний өрсөлдөгчгүй Бурхан	25
3. Өрсөлдөгчгүй амлалт	43
4. Өөрийгөө өрөөлтэй хэзээ ч бүү харьцуул	65
5. Чамайг өрсөлдөгчөө гэж үзсэн нөхцөлд	81
6. Өрсөлдөгчгүй хүйс	101
7. Айдсын болон хайрын өрсөлдөөн	129
8. Гүн худаг, хүслийн худаг	145
9. Өрсөлдөгчгүй охин	165
10. Өрсөлдөгчгүй амьдрал	185
Номын зүүлт	201

1

Өрсөлдөгчгүй хувь чанар

“Бидний хамгийн чухал хүсэл бол биднийг хүрч чадах хэмжээнд маань тултал өрдөж чадах хүнийг олох юм.”

Ральф Валдо Эмерсон

Чамд өрсөлдөгч байдаг уу? Би тэмцээн дэхь нөхөрсөг өрсөлдөөний талаар яриагүй. Эсвэл аав ээжээсээ хайр хүссэндээ өөр хооронддоо өрсдөг жижигхэн маамаануудын талаар яриагүй.

Би нэгийгээ үзэлцдэг өрсөлдөөний талаар ярьж байна. Өрсөлдөгч гэр бүл шиг юмуу найз шиг байдаггүй. Өрсөлдөгч тоглоомд ялахаасаа илүү чамайг зайлуулахыг л зорьдог.

Гэхдээ чиний хүсээд байсан амьдрал чинь ямар ч өрсөлдөөнгүйгээр хүрч болох амьдрал байвал чи яах уу? Чи тоглоомоос ч гарах хэрэггүй, ялагдах ч үндэсгүй гэдгээ олж мэдбэл яах уу? Чи хайрцгаасаа гарч сэтгэхээр барахгүй, хайрцагны гадна амьдарч чадах бол яах уу?

Арваад жилийн өмнө би нэг ном уншсан юм. Тэр номд дэлхийн төгсгөл нь харь гаригийн довтолгоо шиг биш, харин хөрст дэлхийг самарсан их үймээн самуунаар ирнэ гэж хэлсэн байж билээ. Энэ нь дэлхий эсрэг тэсрэг хоёр хуаран юмуу сэтгэлгээний урсгалд хуваагдах цаг ирнэ гэсэн үг юм. Ийм хуваагдлын уур амьсгал газар авахад, эвдрэлцлийн ганц чүдэнз зураад хаяхад л, бүгд дэлбэ үсэрнэ.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Ийм өргөн хуваагдал нь өчүүхэн зүйлээс эхэлдэг. Гомдсон зүрхтэй, эв түнжингүй нэг гэрийнхнээс ч эхлэж болно. Эдгээр нь чиний бодол, хүсэл, мэдрэмжийг худал санаагаараа үймүүлж, эцэст нь чамайг өөртэйгээ болоод өрөөлтэй дайсагнахад хүргэдэг маш бодитой хүч юм.

Биднийг хангалттай сайн, залуухан, ухаалаг, хурдтай, баян байсангүй хэмээн хэмлэх үг ба үг хаягчаас амархан зугтах аргагүй. Тэд биднийг өөрийнхөөрөө байлгах гэж бөмбөгддөг. Бид ч хүн юм болохоороо “хангалттай биш” гэх тэр санаанд нь оногдож л орхидог. Тэгээд арга ядахдаа, нэг хэсэг нь бусдыг хуулбарлаж эхэлдэг бол, нөгөө хэсэг нь тэрслүү авир гаргаж, бусад руу халдаж эхэлдэг.

Бид шүүгдэхээрээ бусдыг шүүдэг.

Бид ичэхээрээ бусдыг ичээдэг.

Бид өөрийгөө үзэн ядахаараа бусдыг үзэн яддаг.

Бид дампуурахаараа төдөлгүй бусдыг дээрэмдмээр санагддаг. Энэ бол хэн ч ялдаггүй, бүгд ялагддаг тойрог юм. Гэхдээ Паулын үг үнэн байвал яах уу?

Харин итгэл сүсэг ба сэтгэл хангалуун байдал нь хамтдаа агуу ашиг мөн. (1Тимот 6:6)

Бурханы давуу чанарыг шингээж авах чадварыг бурханлаг зан чанар гэдэг. Өөрөөр хэлбэл Бурхан бусдыг хэрхэн үздэгт итгэдэг шигээ Бурхан чамайг тийнхүү үздэг гэдэгт итгэх явдал юм.

Өөрөө өөртөө сэтгэл хангалуун байх чанар нь бардам занг биш, бүтээлч занг бүтээдэг! Бүхий л саад, эргэлзээнээс эргэ. Бурхан чамайг ширтэж байгаа тул, чи Түүнийг л ширт.

Дараа нь яах уу?

Хүний юмтай өрсөлдөж байснаас өөрийнхийгөө олж ав.

Энэ чинь чамайг өдөр тутмын хор бохирдлоос цэвэрлэг. Хүний тулаанд оролцож байснаас, өөрийнхөө тулаанд ял. Цаана чинь чиний сэтгэлийн хатад таарах, жинхэнэ дайн өрнөж байна. Дэлхийд эзлэх *байр сууриа* мэдэх цаг чинь ирчихээд байна. Бүх худал хуурмагийг хойш тавиад, өөрийгөө хэн болохыг мэдэх цаг чинь иржээ.

Алдагдаад, олдсон нь

Би нохойнд хайртай. Саяхан намайг Өмнөд Солонгос руу аялсан хойгуур, миний хайртай нохой Тиа төөрчихжээ. Манайхаар ороод гарсан гадны хүн хаалга онгорхой орхисноос, Тиа Колорадогийн жавартай өвөл хорвоотой танилцахаар халуун дулаан гэрээсээ оргосон болтой. Гэхдээ хөөрхий минь тэр шөнөө төөрчихөж. Золоор нэгэн сайхан сэтгэлтэн Тиэг маань гэртээ хонуулаад, маргааш нь төөрсөн амьтдыг журамлах газарт тушаажээ.

Тиа маань уг нь хүзүүвчтэй боловч, хүзүүвчин дээрх утасны дугаарыг нь бид хэдийн ашиглахаа больсон байлаа. Ядаж байхад Тиэгийн маань лицензийн хугацаа дуусчихсан учраас, хайртай Тиэг маань хаанахын хэний нохой болохыг тодорхойлох ямар ч аргагүй байжээ. (Би лицензийг нь ахин дахин сунгах ёстойг мэдээгүйдээ хүлцэл өчье)

Гэтэл би Өмнөд Солонгост энэ талаар юу ч мэдээгүй явж байлаа. Хөвгүүд маань сэргэлэн юм болохоороо Тиэгийн “адал явдлыг” надаас нуухаар шийдсэн ч, өөрсдөө нилээд тэвдсэн нь тодорхой. Тэд Тиэг газар сайгүй хайж, чононд бариулчихаагүй байгаа гэж айжээ. Тэгээд аргаа бараад төөрсөн амьтдыг журамлах газар руу ярьжээ.

Аустин маань тэнд очихдоо, Тиэг таньж ядсан гэж билээ. Энэ адармаатай явдлаас болж Тиэгийн ааш нь эрс хувирч, хүүг маань хараад баярлах нь бүү хэл, харин ч зовнисон шинжтэй байжээ. Тиа чичирч дагжсаар торны буланд шигдэж байжээ. Аустин маань Тиэгийн тансаг зочид буудлын дайтай ганц хоногийн мөнгийг нь, дууссан лицензийнх нь торгуультай төлөөд дахин халуун дулаан гэртээ авчран хайрлажээ.

Би харьж ирээд, үүнийг сонсохдоо сэтгэл өвдөж билээ. Хөвгүүддээ гоморхсондоо биш, харин нохойгоо өрөвдсөндөө. Тиа маань манайд арваад жил болохдоо анх удаа л ингэж төөрсөн юм. Би ч “... Яагаад энэ олон жилийн дараа гэж? Хараа нь муудаа юм болов уу? Зөнөө юм болов уу? Намайг хайгаа юм болов уу?” гээд л зөндөө юм бодов.

Гэхдээ эцсийн дүнд яагаад төөрсөн нь чухал биш. Тиа явсан ч, манай нохой хэвээрээ л байсан. Бид Тиэгаа хайсан, торгуулийг нь төлсөн, лицензийг нь шинэчлэсэн тэгээд ичгүүрийн торноос нь гаргаж авчраад, миний хөлний дорх орон дээр нь тавьсан. Ганц

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

удаа тэнэсэн гээд бид Тиагаа хаяхгүй.

Чи миний санааг бараг ойлгосон байх. Бидэн шиг төгс биш эзэд нохойныхоо төлөө амиа тавих гэж байхад, тэнгэрийн Аав маань бидний төлөө бүр яах бол? Өөрийгөө хэн гэдгийг мэдэхийн тулд эхлээд Бурхан Аавынхаа хувьд хэн болохоо мэдэх хэрэгтэй. Үүнийг 1Иохан 3:1 дээр хэлсэн:

“Бид Бурханы хүүхдүүд гэж дуудуулахаар ямар их хайрыг Эцэг бидэнд соёрхсоныг хараач! Бид бол чухам энэ л юм. Биднийг ертөнц таньдаггүй нь Түүнийг таниагүйн учир юм.”

Тэгвэл Бурханы хайр ямар гайхамшигтай болохыг ярья. Аймаар, гайхмаар, дээдийн дээд. Жирийн гэдэг утгаас тэс өөр. Бид энэ хайрыг зүгээр л бишрэхээс биш, үнэндээ ойлгож барахгүй. Энэ хайр нь яг л захиалсан бэлэг шиг - гэхдээ хавьгүй дээр бэлэг шиг. Яагаад гэвэл энэ нь давхар бэлэгтэй бэлэг юм. Авралыг бидэнд бэлэглэсэн. Бурхан биднийг шашинжсан нийгмийн торон дотор дагжин чичирсэн, арчаагүй амьтан байхыг минь үзээд, төлөөсийг нь төлөөд аварсан. Гэхдээ авраад л болчихоогүй. Бурхан биднийг тэврээд, лицензийг маань шинэчлээд, Өөрийнхөө мөн хэмээн хүлээн зөвшөөрсөн (угааж цэвэрлэхээсээ өмнө шүү). Та үнэхээр Бурханых. Бурхан хүүхдүүдээ үнэн голоосоо хайрладаг. Гэхдээ онцгойгоор.

Тэгш үү, онцгой юу?

Хүн бид шударга загнах гэж оролдохдоо, Бурхан биднийг эн тэгш хайрлах л ёстой гэж санадаг. Сонсоход их зөв мэт боловч, *ижил* гэдэг хангалттай биш юм. *Ижил* гэдэг нь орлуулж, солих боломжтой гэсэн утгатай. “Яана аа, Таргетаас авсан ягаан хундагаа хагалчихлаа. Дахиад л аваас” гэдэгтэй л адил. Эсвэл миний ярьсан жишээ шиг “Арваад жил тэжээсэн нохойгоо алдчихлаа. Одоо өөр нохой л авахаас” гэдэг шиг.

Би л лав ингэж чадахгүй. Бурхан ч бас ингэж чадахгүй байх. Яагаад гэдгийг нь одоо тайлбарлаж өгье.

Нэг өдөр би жаал зүүрмэглэчихсэн юм. Гэхдээ орон дээрээ биш, харин лэптоп дээрээ дуг хийчихсэн байв. Тэгээд дав хийгээд сэртэл, найман хуудас “т” үсэг биччихсэн байлаа.

Тэгэхээр нь жинхэнээсээ жаахан дуг хийе гээд, хөлдөө хэвтэх нохойгоо аваад, ор руугаа гуйвав. Тийнхүү манарч явтал Ариун Сүнс надад: “Би хүүхдүүдээ тэнцүү хайрладаггүй” гэж хэлэх шиг болов.

Би ч юу билээ гэх шиг цочин орон дээрээ шовойн суугаад: “Яасан муухай бодол вэ? Та биднийг тэнцүүхэн л хайрлах ёстой. Эс бөгөөс шударга бус болно” гэж шивэгнэв.

Тэгтэл хариуд нь: “Үгүй. Тэнцүү гэдэг чинь хязгаартай хэмжээ. Гэтэл миний хайранд хязгаар байхгүй. Ижил гэдэг чинь Би хүүхдүүдээ орлуулж, сольж чадна гэсэн үг. Харин Миний хүүхдүүд тийм биш. Миний хайрыг харьцуулж болохгүй. Хэн ч Миний зүрхэн дэхь тэдний байр суурийг эзлэхгүй. Тиймээс л би хүүхдүүдээ тэнцүү хайрладаггүй, харин онцлон хайрладаг” гэх үг дуулав.

Одоо гүн амьсгаа аваад, сайн сонс. Бурхан биднийг тэнцүү биш, харин онцлон хайрладаг. Тэгээд ч онцлон хайрлуулах нь хамаагүй дээр гэдэгт итгээрэй.

Олон хүүхэдтэй хүн үүнийг сайн ойлгоно доо. Хоёр дахь, гурав дахь, отгон хүүхэддээ чи яг ижилхэн хэмжээний хайр хүргээдэг үү? Харин ч хайр чинь улам үрждэг бус уу? Бид хичээсэн ч, хүүхэд бүрээ яг тэнцүү хайрлаж чадахгүй. Зүрхний хэмнэлийг яаж эн тэгш хуваарилах вэ? Бид хүүхэд бүрээ онцгойлон хайрладаг. Хүүхэд бүр аав, ээжийнхээ хайрыг өөр өөрийнхөөрөө татдаг. Нэг хүүхэд чинь нэг чанараараа татаж байхад, нөгөө нь тэс өөр чанараараа татдаг нь үнэхээр гайхмаар. Жишээлбэл: надад нэг бужигнуулдаг ач охин бий. Гэтэл түүний ах нь тун аядуу зөөлөн зантай. Би тэр хоёрыг харьцуулдаггүй. Би тэднийхээ өөр өөр зан чанарыг аль алийг нь хайрлаж, баясч, эрхэмлэдэг. Би тэднийг яг адилхан байлгахыг хүсдэггүй. Тэдний аль нэг нь миний хайрыг илүү юмуу дутуу булаадаггүй. Би тэднийг тус бүр онцгойлон, бүрэн дүүрэн хайрладаг.

Тэнцүү гэвэл Бурханы хайр хязгаартай болно. Харин Бурханы хайр хязгааргүй. Онцгой гэдэг нь маш гүн утгатай үг. Энэ ертөнц дээр чи ганцхан л хувь байдаг. Ариун Августин “Бурхан биднийг



**Би хүүхдүүдээ
тэнцүү
хайрладаггүй,
харин онцлон
хайрладаг**

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

цорын ганц хувь шиг хайрладаг” хэмээн яг онож хэлсэн юм.

Бурхан Аавын хайр нь хүүхдүүдээ гомдоохгүй юмсан гэсэндээ эн тэнцүүхэн хувааж тавагладаг амтат бялуу биш юм. Түүний гайхамшигт хайрыг тооцоолох боломжгүй. Тэр чамайг бүхний эхлэл тавигдахаас ч өмнө хайрласан бөгөөд тэр хайранд төгсгөл гэж байхгүй. Чи Түүнээс нүүр буруулж, зугтаж, үхэгсдийн оронд ороо зассан ч, чамайг гэх Түүний хайр үгүйрэхгүй. (Гэхдээ хэн үхэгсдийн оронд унтахыг хүсэхэв дээ?)

Эзэн эш үзүүлэгч Иеремиагаараа дамжуулан хайрынхаа талаар: “Би чамайг үүрдийн хайраар хайрласан” (Иеремиа 31:3) хэмээн айлджээ.

Ямар цаг дээр байгааг харав уу? Өнгөрсөн цаг байгаа биз? Бурханы хайр бүх асуудлыг шийдсэн. Бурхан чамайг өргөн нарийн, хөгшин залуу байхаас чинь үл хамааран жинхэнэ чамайг хэзээ ч дуусахгүй, мөнхийн хайраараа бүхнээс онцлон хайрласан. Тэр чамайг залуу бөгөөд тэнэг байхад чинь хайрласан. Тэр намайг төлөвшсөн байхад ч хайрладаг, төлөвшөөгүй байхад ч хайрладаг. Бурхан бол хайр. Аавд маань чамд зориулсан хайр байхгүй. Учир нь Аав маань Өөрөө чамайг хайрлах хайр юм.

Аавын маань гайхамшигт хайр хязгааргүй, дотно, онцгой юм. Чи онцгой бүтээгдсэн учраас, онцгойлон хайрлуулдаг.

Онцгой гэдэг нь “цорын ганц анхны эх хувь” гэсэн утгатай. Гэхдээ би л хувьдаа “тэгшитгэлгүй, өрсөлдөгчгүй” гэсэн утгад нь хамгийн дуртай. Аав маань Өөрөө ямар ч өрсөлдөгчгүй, ганцаар онцгойрдог Нэгэн. Тиймээс Тэр биднийг ч өрсөлдөгчгүй гэж хардагт гайхах явдалгүй. Бидэнд өөр хоорондоо өрсөлдөх үнэндээ ямар ч шалтгаан байхгүй.

Чи бол цорын ганц хувь!

Чи бол өөрийнхөө эхлэл ба төгсгөл. Чи дуусаа л бол дуусаа. Чи бөөнөөр үйлдвэрлэх бүтээгдэхүүний эх хувь биш. Чиний өөр хувь ч байхгүй, чамтай дүйцэх хүн ч байхгүй. Чи Бурханы хайрыг хэнтэй ч булаалдах шаардлагагүй. Учир нь чамтай адил өөр хүн байхгүй!

Бурхан чиний ДНХ-г хосгүй бүтээгээд, эх биеийг чинь дэлхийг гайхам нууцаар хэлбэршүүлжээ. Бурхан зүрхний чинь илэрхийллийг зохиож, инээмсэглэлийг чинь урлаж, дуу хоолойг

чинь зохицолдуулж, зөвхөн чамайг бодон байж эд эс бүрийг чинь нэг бүрчлэн туурвижээ. Бурхан чамайг анх мишээхэд дагаж мишээж, анх алхахад чинь алга ташин баярласан.

Чамайг гэсэн энэ л өр зөөлөн хайр халамжийн улмаас амьдралын чинь тал бүр Түүний хайрыг онцгойгоор харуулдаг.

Бурхан энэ бүх хосгүй чанар, гоц чадварыг охин чамдаа бэлэглэсэн. Эдгээр чанар нь бүсгүй хүнээр хамгийн сайн илэрнэ гэдгийг Бурхан мэджээ.

Тэр чамтай зүгээр нэг харилцаа тогтоох биш, харин Өөрийнхөө охин шиг хандаж, харилцахыг хүсчээ. Аав охин хоёр цаанаа л амь байдаг шүү дээ.

Тэр чамайг урлаж байхдаа, өөр нэг охиноо бодож бүтээгээгүй. Тэр чамайг яг энэ байгаагаар чинь хүссэн.

Тиймээс л чи арай өндөр, нам, хар, цагаан байсан бол илүү дээр байхгүй байсан юм.

Мөн хэрэв чи эрэгтэй хүн байсан бол илүү дээр байхгүй байсан. Бурхан хөвгүүдээ ахиухан шиг, охидоо багахан шиг хайрладаггүй. Мөн эр, эм хүйсийг ч эн тэнцүү хайрладаггүй. Бурхан хөвгүүдээ ч, охидоо ч онцгойлон хайрладаг. Магадгүй чи хүүхэд байхдаа аав, ээжээсээ: “Энэний оронд хүүтэй байсан бол” гэсэн шивэгнээг эсвэл бүр хашхирааг сонссон байх. Эсвэл чи өөрөө өөрийгөө эр хүн болоод төрчихгүй хэмээн голдог байж магадгүй. Гэхдээ Бурхан хэзээ ч ингэж хүсээгүй.

Чамайг эхийнхээ хэвлээс унаж, анхны амьсгалаа авахад Аав чинь баярласан. Дараа нь Түүний Сүнсээр дахин төрж, охин нь болоход тэнгэрэлч нар Түүнтэй хамт баяссан.

Гайхамшигтай бүсгүй минь, чи бол тохиолдол биш.

Өрсөлдөгчгүй охин

Тэгэхээр, энэ бүхэн чинь ямар утгатай вэ? Энэ нь Бурханы хэмжээлэшгүй, барагдашгүй, хангалттайгаас ч хангалттай хайр бидэнд бий гэсэн үг юм. Чи байр суурийнхаа төлөө, Түүний хайрын төлөө тэмцэлдэх хэрэггүй гэсэн үг юм. Хэн ч чамайг гаргаж хаяж, орлож чадахгүй... чамд өрсөлдөгч байхгүй.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь хараахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг байгаагаар нь харах болно. Түүнд ийнхүү найдаж байгаа бүхэн Түүний цэврийн адилаар өөрийгөө цэвэршүүлдэг. (1Иохан 3:2-3)

Тэгэхээр бүгдээрээ бусдын хайр, тааллыг олох гэж хэн нэгэн болж хувирах биш, харин яаж жинхэнээсээ өөрөөрөө байхыг сурцгаая. Өөрийгөө бусадтай харьцуулахаа больё. Харьцуулалт хэнд ч ашиггүй. Харьцуулалтаас болж бид өөрийгөө ч, өрөөлийг ч мэхэлдэг. Гэтэл хэрэв бид өөрийгөө давтагдашгүй, онцгой гэдгээ ухаарах юм бол, хэнтэй ч өрсөлдөхөө болино. Харьцуулалт биднийг л зүдрээдэг. Чи бол өрсөлдөгчгүй онцгой тулаанд өрсөлдөгчгүй зэвсэг барьсан, өрсөлдөгчгүй охин юм.

“...бид олуулаа Христэд нэг бие бөгөөд хүн бүр нэг нэгэндээ эрхтэн юм. Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай.” (Ром 12:5-6)

Бичээсийн энэ хэсэг нь өрсөлдөгчгүй амьдралын хоёр том гүтгэлгийг илчилж байна: бардамнал ба атаархал. Өрсөлдөгчгүй онцгой гэдэг дүрслэлийг мэдээд л, бүх зүйл төгсчихөж байгаа юм биш. Үнэндээ чи өрсөлдөгчгүй онцгой гэдэг чанараа алхам алхмаар насан турш таньж мэдэх бөгөөд үүгээрээ Христийн бие дотор хийх ёстой ажлаа биелүүлж байгаа юм.

Бардамнал нь бидний чихэнд хэр хэмжээнээсээ хэтэрсэн төсөөллийг шивэгнэж: “Би л чухал, би л гоцолдог, би л хангалттай, биеэ даасан, ихэмсэг, өргөмжлөгдсөн” гэж хэлэхэд хүргэж, биднийг Христийн биеэс тасалдаг.

Гэтэл атаархал нь бидний даалгаврыг жижигрүүлж, дэлхий дээр Бурхан бидэнд хувьчлан даалгасан үүргийг үл тооход хүргэдэг. Атаархал: “*Миний үүрэг, хэсэг юу ч биш. Яагаад гэвэл би чинийхийг авч, чамайг тоглоомоос гаргамаар байна*” гэдэг.

Энэ хоёр нь хүмүүсийг замаасаа зайлуулж, холбоо бүхий бүлгүүдийг үйл ажиллагаа, байр сууриас нь хагаралдуулах үүрэгтэй хоёр талдаа үхлийн иртэй илд юм. Заримдаа дайсан

Христ доторх эрчүүдийг өрсөлдөөн болон хүйсийн бардамналаар довтолдог бол, эмэгтэйчүүдийг нь хүйсийн атаархалд унагах замаар хоёр ирийг нь хоёуланг нь хэрэглэдэг.

Тиймээс өөртөө өөрөөрөө бай, өрөөлд жинхэнэ найз нь бай. Бурханы охид “онцгой” чанараа хайрлаж, “ижил” байхыг эрмэлзэхээ больж, “илүү” ихийн төлөө тэмцэлдэхээ зогсоох хэрэгтэй. Чи жинхэнэ өөрөөрөө байхаа болихдоо өөрийгөө үл хүндэтгэх эрхийг бусдад өгч байгаа юм. Хүмүүс хулхи юмыг жинхэнээс нь ялгана. Тэгээд чиний хуурамч байдал хоосон үг, үйлдэл, байдлаас чинь шууд л мэдэгдэнэ. Үлгэр жишээг дагах болон хуулахын хооронд том ялгаа бий. Тиймээс л хүн бусдыг хуулах гэж оролдоод бүтэлгүйтдэг. Амьдрал бол яг л олон хариу бүхий тесттэй л адилхан бөгөөд өөрөө сонгоогүй хариулт нь үргэлж буруу байдаг.


Бид өөрийнхөө онцгой чанарыг няцаахдаа, Аавынхаа хайрын мөн чанарыг үнэгүйдүүлдэг. Гадаад үзэмждээ хамгийн бага зовцгооё. Хүмүүс өөрийгөө хувцас, үс, гоёл чимэглэл, оо энгэсгээрээ илэрхийлэх гэдэг. Гэхдээ эдгээр гадаад илэрхийлэл нь зүгээр л чимэг юм. Тэдгээр нь жинхэнэ чиний өчүүхэн хувийг ч илэрхийлж чадахгүй.

Үнэндээ чи бусдаас өөр боловч, онцгой чанараа огт ойлгоогүй явж байж болох юм.

Тиймээс байнга ийшээ тийшээ гэгэлзэж, зогсоо зайгүй өөрчлөгдөж байгаа нийгмийн үзэл суртлын хуулбар дүр төрх, санаа бодлын хээг өөр дээрээ наалгаад байхаа больё. Бурхан биднийг онцгойгоор харуулаарай гэсэн бүхнийг нь итгэл дүүрэн хүлээж авъя.

Чи хэнийх вэ?

Чиний хэнтэй найзладаг чинь хамаагүй. Чиний хэн болох чинь аав, ээж, сургууль, даргатай чинь ч холбоогүй. Чи чамайг өөрийн



**Хэн ч чамайг
гаргаж хаяж,
орлож чадахгүй
... чамд
өрсөлдөгч
байхгүй**

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

болгож худалдаж авахын төлөө амиа өгсөн Нэгэнтэй холбоотой. Гэхдээ Түүний золиос үүгээр дуусна гэж бодож байгаа бол, эндүүрч байна. Тэр чамайг олохдоо, хэд сэгсрээд буцаагаад байранд чинь тавьчихаагүй. Тэр чамайг босгож, зөвт байдлаараа нигүүлсэн.

Шивнээд ч хамаагүй яг одоо *Би Түүнийх, Тэр минийх* гэж хэлнэ үү.

Мөнхийн Аав чинь л чамайг хэн болохыг чинь тодорхойлох эрхтэй. Ээж чинь чамайг олж, тээж, халамжилсан. Гэхдээ тэнгэрийн Аав чинь л чамайг амьдруулах гэж нэрлэж, бүтээж, амьдрахыг тушаасан. Тэрбээр чамайг алдагдсан байхад чинь Өөрийн болгохоор авран сэргээсэн. Нэгэн цагт бидний мэдэх энэ амьдрал төгсөж, Бурхан биднийг шинэчлэх үед л бид энэ газрын амьдрал бол үр төдий зүйл байсныг, бид тэнгэрт л жинхэнэ утгаараа боловсрохоо ухаарна.

Чи яг одоо амьдралын ямар шатанд явааг би мэдэхгүй. Гэхдээ байршил, улирал, нөхцөл нь байнга өөрчлөгдөж байдгийг ойлгоорой. Энэ бүх бужигнаан дунд чи өөрийгөө хэн болохыг бас хэнийх болохоо л мэд.

Энэ бүлгээ би Ральф Валдо Эмерсоны “Бидний хамгийн чухал хүсэл бол биднийг хүрч чадах хэмжээнд маань тултал өрдөж чадах хүнийг олох юм” гэдэг өөрийнхөө дуртай ишлэлээр эхлүүлсэн. Тэр “хүн” нь Бурхан юм. Бурхан Өөрөө бас Бурханы хийдэг бүхэн биднийг өрддөг. Бүтээгч маань бидний харж байгаа, сонсож байгаа бүхнийг гайхамшигтайгаар урласан бөгөөд бүтээл - биднийгээ тэнгэрлэг нэрлэмжтэй маань дахин залгахыг хүсдэг. Бурхан бидэнтэй тогтоох харилцаагаа сэргээхийн төлөө л Хүүгээ илгээсэн.

Гэтэл олон хүн *юу хийдэг, юутай болсон, хэнийг хайрладгаараа өөрийгөө хэн болохыг тодорхойлох* гэж оролддог. Хялбархан авагдаж болох юмсаар өөрийгөө хэн болохыг тодорхойлох нь мунхаг юм. Ажил өөрчлөгдөж, ур чадвар алдагдаж, юмс хулгайд өртдөг. Тэр бүү хэл чухал харилцаа ч алдагдаж, мартагддаг. Чамд байгаа, чиний хийдэг, чамайг хайрладаг хүмүүс өөрчлөгдөж болно. Гэхдээ өөрийгөө алдахгүй байх л, хэн гэдэг Бүтээгчийнх болохоо алдахгүй байх л чухал.

Та зөвхөн хаашаа явахаа мэддэг бол, замдаа үрэгдэж дуусна. Зөвхөн дуудлагаа мэддэг бол, түүнийгээ биелүүлэх гэж ямар ч арга хэрэглэж болно.

Тиймээс “Учир нь хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?” (Матай 16:26) гэдэг эртний нэг асуулт ургана.

Өөрийгөө мэдэх нь хаашаа яваагаа мэдэхээс, юу хийхээ мэдэхээс чухал юм. Учир нь Тэр чиний Бүтээгч. Бурхан чамайг хэн болох талаар олон зүйл хэлэхийг хүсч байгаа. Харин өөрийгөө хэн болохыг мэдсэн хүн хэн болж чадахаа ойлгоно.

Чи хэн бэ?

Юу хийснээ - тэр бүү хэл юу туулснаа харах хэрэггүй. Хийж байгаа ажлаараа өөрийгөө бүү тодорхойл. Ганц бие, салсан, гэрлэсэн, үерхэж байгаа зэрэг гэр бүлийн байдлаараа өөрийгөө бүү тодорхойл. Ямар Фэйсбүүкийн статусаа шинэчлэж байгаа биш. Энэ мэдээлэл чинь өөрт чинь биш, өрөөлд л хэрэгтэй зүйл.

Чи өөрөө өөрийгөө хэн болохыг мэдэх хэрэгтэй.

Цаашаа уншихаасаа өмнө үзэг аваад, нүдээ аниад, чамд өгөгдсөн онцгой чанар юу болохыг Бүтээгчээсээ асуу. Өөрийгөө баахан сүрхий, сүрхий үг зохиогоод байна гэж бүү ай. Санаанд чинь орж ирж байгаа үгс үнэхээр Бурханаас ирсэн үгс мөн шүү. Хэсэг чимээгүй байж сонс. Түүний шивэгнэсэн гурван үг юмуу холбоо үгийг бич. Дараа нь чиний талаар хэлсэн хүмүүсийн үгийг хойш тавьж, Бурханы шивэгнэсэн тэдгээр үгсийг сайтар хар. Гайхаж байна уу? Чи өөрийгөө ингэж бодоогүй дэндүү удсан байна уу?

Бурхан Үгтэйгээ зөрчилдсөн юм хэзээ ч хэлдэггүй гэдгийг би баттай хэлье. *Харин гарчиг мэт өгөгдсөн Бурханы тэр Үгийг Ариун Сүнс амилуулдаг.* Гэхдээ бид Библийг зөвхөн уншаад л, сонсохоо болих ёстой юу? “Бурхан сонсдгийг” Еврей 12:28 дээр батлан хэлжээ. Илчлэл номд долоон удаа давтагдсан энэ асуулт нь өнөөдөр ч бидэнд хамаатай гэдэгт би итгэдэг:

Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун.
(Илчлэл 2:7, 11, 17, 29; 3:6, 13, 22)

Энэ асуулт нь Библийн ганц номд *долоон удаа* бичигдсэнээрээ л ямар чухал болохоо харуулж байна. Хүнийг сэрүүн байхад ч,

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

чих нь унтаж болдог. Тиймээс “Өрсөлдөгчгүй” ном маань үнэхээр чихийг чинь нээх болтугай.

Бид Бурхан руу эргэхдээ үгийг нь сонсдог. Бурханы амыг барьсан амьдралынхаа алив хэсэг дээр Үгээ айлдахыг Ариун Сүнснээс гуйвал яах бол? Бурхантай нүүр тулан уулзаж, сэтгэл сэтгэлээрээ ярилцахгүй гэж үү? Нөхөрлөл, гэрлэлт, гэр бүл дээр чинь Үгээ буулгахыг Бурханд зөвшөөрөхгүй гэж үү? Бид Бурханы анхааруулгад чихээ тагладаг учраас л, Түүнээс юу ч авч чадалгүй, гар хоосон хоцордог. Эхлээд хувь хүн Бурханыг сонсож сурч байж л дараа нь Христийн бие Бурханыг сонсож сурна. Тэгвэл чихээ нээхгүй гэж үү?

Бурханаас заяасан, онцгой хувь тавилангаа хэрхэвч бүү алд. Алдах юм бол, айж, түдгэлзэж, уурласандаа, Бурханаас бидэнд даалгасан бүхнийг үл хэрэгсэнэ. Бурхан чамайг авран сэргээж, сэргээж, өөрчлөхийг хүсдэг. Тиймээс чи өнгөрсөнд хэн ч байсан - одоо тэр хүн биш болсон. Тийм ээ, улирал, шүүмжлэл, үйл явдал нь хүнд бас хүний амьдралд нөлөөлдөг. Гэхдээ тэдгээр нь чиний амьдарлын эд эс биш юм. Чиний амьдралын эд эс бол Бурхан.

Чи онцгойгоор хайрлагдаж, өдгөө бусдад хүргэх Бурханы хайрын онцгой илэрхийлэл болсон. Бид бүтээгдсэн ном ёсоороо амьдарч эхлэх үедээ л Бурханы жинхэнэ хүүхэд шиг хүүхэд болдог. Хүн бүр өөрийгөө эрэн хайж байгаа энэ дэлхийд Бурхан эхлүүлсэн ажлаа дуусгаж байна. Энэ ном ч чамайг өөрийгөө олж авахаар Бурханы араас явахад чинь туслах болтугай!

Хэлэлцэх асуулт

1. Яагаад хаашаа явж байгаагаасаа илүү өөрийгөө хэн болохыг мэдэх нь илүү чухал вэ?
2. Онцгой нь яагаад тэнцүү юмуу ижлээс дээр болохыг ярилц.
3. Өөрийгөө хэн болохыг мэдэж, Бурханы хайрыг хүлээж авахад чинь саад хийдэг өрсөлдөөний хэлбэрээс нэрлэнэ үү.
4. Чамд хийдэг ажлаа биш, харин яг өөрийгөө дүрслэх хэцүү байдаг уу? Тийм бол яагаад?
5. Бурхан чамд ямар үг шивнэсэн бэ?

2

Бидний өрсөлдөгчгүй Бурхан

Бичигдсэн үгс нь ойлголт бол,
амьдарсан үгс нь эрдэм болой.

Гэгээн Августин

Түүнтэй эгнэх хэн ч үгүй

1980 оны сүүлээр Интегрити Мюзик байгууллага Хойд Америкт газар газрын магтаалыг танилцуулж эхэлснээр, Христчин магтаал сууриараа өөрчлөгдсөн юм. Манайх сар бүр захиалсан шинэ дуутай хуурцгаа догдлон хүлээгээд л (Тийм ээ, би тийм л эртний хүн), хүлээж авахаараа элэгдтэл нь тоглуулдаг байж билээ. Дуртай дуугаа зогсоо зайгүй тоглуулсаар байгаад, нөхөр маань замд гарахдаа сонсох гэхээр, нөгөө гоё дээшээ доошоо болдог өнгүүд нь бүгд арилаад, пар пар хийсэн чимээ л гардаг болчихсон байна. Бид ялангуяа “*Баярла, Африк минь, баярла*” гэдэг хуурцагт тун дуртай байж билээ. Миний хоёр дахь хүү Аустин Микки маусын бандагтайгаа, харагддаггүй сүнсний морио унаад л, сөөсгөр шар үсээ намируулан дэвхцээд л, дагаж дуулдаг байсан нь одоо ч харагдах шиг.

Нэг дууных нь дундуур Өмнөд Африкийн магтаалын удирдагч маш цоглогоор: “No one like Jesus!” гэж хэлдэг байв (Энэ нь “Есүстэй хэн ч эгнэхгүй” гэсэн утгатай боловч, үгчлэхээр “Есүст

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

бүгдээрээ дургүй” гэж бас ойлгогдож болох өгүүлбэр юм).

Тэгээд энэ дууг ахин дахин тоглуулах бүр гурван настай зулзага минь магтаалын удирдагчийг даган чин сэтгэлээсээ энэ үгийг тунхаглана.

Гэтэл нэг өдөр Аустин надаас асууж байна аа:

“Ээж ээ, яагаад Есүст бүгдээрээ дургүйм бэ?”

Тэгэхээр нь би: “Энэ чинь хүмүүс Есүст *дургүй* гэсэн үг биш, харин хэн ч Есүстэй *адилхан биш* гэсэн үг байхгүй юу” гэж ирээд л байдгаараа тайлбарлалаа.

Бурхан ганцаархнаа гэдэг нь бид ганцаардмал, уйтгартай Бурханд үйлчилдэг гэсэн үг биш юм. Түүнтэй эгнэх, зэрэгцэх хэн ч байхгүй гэдэг нь хүмүүс Түүнд дургүй гэсэн үг биш.

Бидний Бурхан зүгээр л гөлрөөд л, хүлээгээд сууж байдаг Бурхан биш. Тэр бүгдэд харагдаж, өдгөө ажлаа дуусгаад тухлан сууж байгаа бөгөөд хүүхдүүд нь Түүнээс юм асуухад, дуртайяа хариулдаг.

Түүнчлэн Дээдийн Дээд Бурхан маань цонхны гаднаас бидэн рүү шагайдаг Нэгэн биш.

Тэрбээр өнгөрсөн, одоо, ирээдүйг бүгдийг нь мэддэг бас чаддаг учраас, эхэнд төгсгөлийг нь харж, төгсгөсөн бүхнээ дахин эхлүүлдэг.

Бурханд бидний нүд биш, бидэнд Бурханы алсын хараа хэрэгтэй учраас л, Бурхан биднээр дамжуулан гадагшаа харахыг хүсдэг.

Дээдийн Дээд гэдэг нэрээр бидний мэдэхгүй *Дээд Бурханыг* дүрсэлдэг. Дуулал 96 дээр бичээч энэ илчлэлийг бахдан өгүүлжээ:

ЭЗЭНд шинэ дууг дуулцгаа.

Бүх газар дэлхий ЭЗЭНд дуулагтун!

ЭЗЭНд дуулж, Түүний нэрийг магтагтун!

Түүний авралыг өдрөөс өдөрт тунхаглагтун!

Түүний яруу алдрыг үндэстнүүдэд тунхаглаж,

Түүний гайхамшигт үйлсийг

бүх ард түмнүүдийн дунд яригтун!

Учир нь ЭЗЭН аугаа бөгөөд агуу ихээр магтагдах Нэгэн.

Мөн бүх бурхдаас дээгүүр Түүнээс эмээгтүн!

Учир нь хүмүүсийн бүх бурхад нь шүтээнүүд юм.

Харин ЭЗЭН, тэнгэрсийг бүтээсэн билээ.

Түүнд яруу алдар ба сүр жавхлан бий.

Түүний ариун газарт хүч чадал, үзэсгэлэн бий.

Ард түмнүүдийн ургууд аа, ЭЗЭНд өргөгтүн, ЭЗЭНд яруу

БИДНИЙ ӨРСӨЛДӨГЧГҮЙ БУРХАН

алдар, хүч чадлыг өргөгтүн!
Нэрд нь дүйцэх яруу алдрыг ЭЗЭНд өргөгтүн.
Өргөлөө авчран Түүний өргөөний хашаанд ирэгтүн!
Ариун хүндэтгэл дунд ЭЗЭНд мөргөгтүн!
Бүх дэлхий Түүний өмнө чичрэгтүн! (и1-9)

Бурхангай эгнэх хэн ч байхгүйг Бичээс янз янзаар ахин дахин хэлжээ.
Энэ нь зүгээр нэг биднийг бодлогошруулах гэсэн уриа бүхий асуулт биш, харин “Хэн ч биш!” гэдэг чанга хариултыг хүссэн, амьдрал шийдэгч шаардлага юм. Бид энэ тунхаглалд хэрхэн хандсанаараа л Бурханы бидэнд зориулсан зүйлийг нэг бол хүлээн авна, нөгөө бол түлхэн татгалзана. Нэгэн цагт өөрийгөө Дээдийн Дээд Бурхан гэж эндүүрсэн нэгэн гарч иржээ. Бид түүнийг Сатан гэдэг нэрээр нь мэдэх боловч, тэрбээр тухайн үед магтаал удирддаг тэргүүн тэнгэрэлч, үүрийн цолмон Люцифер гэгддэг байв. Тэрбээр Бурханы алдрыг тээн, сэнтийн ариун оршихуйд зогсдог байжээ. Езекиел 28:12-17 дээр түүнийг ийнхүү дүрсэлдэг:

Хүний хүү чи, Тирийн хааны тухай гашуудлын дууг гарган түүнд өгүүл. “Эзэн БУРХАН ингэж айлдаж байна.
«Чамд мэргэн ухаанаар бялхсан,
Үзэсгэлэн төгс бүрэн төгөлдөр тамга байв.
Бурханы цэцэрлэг Еденд чи байв.
Эрдэнэсийн чулуу бүр чамайг бүрхэж байлаа.
Бадмаараг, молор, алмаас, биндэрьяа,
Судалт гартаам, хаш, индранил, оюу, маргад байв.
Хүрээ, углуургууд чинь чиний дотор
Алтаар урлагдсан байв.
Чамайг бүтээсэн өдөрт
Тэдгээр нь бэлтгэгдсэн байлаа.
Чи халхалдаг тослогдсон херуб байсан
Би чамайг байрлуулсан.
Бурханы ариун ууланд чи байв.
Галт чулуунуудын дундуур чи явлаа.
Бүтээгдсэн өдрөөсөө авахуулан
Дотроос чинь гажуудал олдох хүртэл
Замналуудаараа чи гэм зэмгүй байв.
Наймааныхаа хөгжлөөр чи дотроосоо
Хүчирхийллээр дүүрч, нүгэл үйлдэв.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Тиймээс Би чамайг Бурханы уулаас
Бузартсан юм мэт хөөсөн.
Халхлагч херуб аа, Би чамайг
Галт чулуунуудын дундаас устгав.
Гоо үзэсгэлэнгээсээ болж
Зүрх чинь бардамнав.
Сүр жавхлангийнхаа улмаас
Цэцэн ухаанаа чи завхруулжээ.
Би чамайг газарт хаяж,
Хаадад чамайг харуулахын тулд өмнө нь тавина.

Бурхан түүнийг гоо үзэсгэлэнгээр гоёж, цэц ухаанаар цалгиаж, хэв хэлбэр, үйл ажиллагаа - бүх талаар хосгүй төгс бүтээжээ. Гэтэл яваандаа түүний магтаалын чансаа муудаж, тэрбээр зүгээр л хэлбэрдэж эхэлсэн болтой. Тэр чухам яаж нүгэл хийсэн нь бүрхэг боловч, ямар ч байсан тэр гайхамшигтай цэцэн бүтээл Бүтээгч Эзэнтэйгээ шөргөөцөлдөж эхэлжээ. Магтаал хүндэтгэлийн тал дээр бид нэг зүйлийг мэдэх ёстой. Бид Бурханаас тусгаар байвал - юу ч биш болно. Исаиа Люсиферийн алдааг ийн дүрсэлдэг:

Аяа, Үүрийн хүү, гялбаат цолмон.
Чи яаж тэнгэрээс унав аа?
Үндэстнүүдийг дордуулагч
Чи хөсөр хаягдлаа!
Учир нь чи зүрхэндээ «Би тэнгэрт гарна.
Би Бурханы оддын дээр сэнтийгээ босгоно.
Би умардын хамгийн чанадад
Чуулганы уулан дээр заларна.
Би үүлсийн орой дээр гарна.
Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн лугаа адил болгоно.»
(Исаиа 14:12-14)

Люсифер Дээдийн Дээд болох нь байтугай, үүрийн цолмон Люсифер ч *байхаа больж*, мэхлэгч Сатан болон хувирчээ. Энэ ухралт нь түүний зүрхнээс л эхэлсэн юм. Тэр төгс эхэлсэн ч, төгсгөлдөө сүйрсэн. Харин бид бөөн алдаа эндэлтэй төрсөн боловч, дахин төрөлтөөр Христ дотор бүрэн бүтэн, төгс болсон юм. Бардам зан өөрийгөө шүтэхэд хүргэдэг бол, даруу зан бардамналын аминч чанарыг эвддэг. Исаиа Эзэнийг үзээд хэн ч биш болжээ:

Тэгээд би —Би сүйрсэн тул золгүй еэ! Яагаад гэвэл би бузар уруултай хүн. Би бузар уруултай хүмүүсийн дунд амьдардаг. Учир нь нүд минь түг түмдийн ЭЗЭН болох Хааныг харлаа гэж хэлэв. (Исаиа 6:5)

Исаиагийн даруусалд Бурхан хариу үйлдэж, Люсиферийн голоор нь алхдаг байсан галт чулуудын нэгийг дарууссан Исаиа дээр авчирчээ.

Тэгэхэд серафуудын нэг нь тахилын ширээнээс хямсаагаар авсан, шатаж байгаа нүүрс гартаа барин над уруу нисэж ирэв. Тэгээд тэр аманд минь хүргэж —Харагтун. Энэ чиний аманд хүрснээр чиний хилэнц авч хаягдаж, чиний нүгэл уучлагдлаа гэв. (Исаиа 6:6-7)

Хэрэв бид Бурханыг хайвал олно. Үүгээрээ бид Бурханыг цорын ганц ариун, сайн, зам, үнэн, амь, Дээдийн Дээд Бурхан гэдгийг нь мэднэ.

Бурхан Өөрөө мөнхийн мөнх оршигч. Түүнд эхлэл цэг гэж байхгүй. Түүнээс өмнө өөр Бурхан байгаагүй. Бидний Бурхан хувьсан бий болоогүй. Бидний Бурхан байсан, байгаа, ирэх Бурхан. Бидний давтагдашгүй онцгой чанарыг ч Бурхан л бүтээсэн.

Түүнээс өмнө ямар ч Бурхан байгаагүй. Тиймээс бид Түүний өмнүүр бурхадтай байж болохгүй. Бурхан хэдий үзэгддэггүй боловч, Түүний байдгийг хэн ч няцааж чадахгүй. Ром ном ингэж хэлжээ:

Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг агаад Бурхан тэдэнд үүнийг ил болгосон юм. Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжиж ойлгогдож, илэрхий харагдаж байгаа тул тэдэнд шалтаг байхгүй. (Ром 1:19-20)

Бурхан байгааг бүх бүтээл баталдаг. Гэхдээ хүн бид Бурханыг тодорхойлно гэж байхгүй. Энэ бүлэг Бурхан, та хоёрын харилцааг тэс өөр төвшинд гаргах болтугай.

Тэнгэрийн Аав минь биднийг өрсөлдөгчгүй хайрладаг учраас, бид ч бас өрсөлдөгчгүй охид мөн. Тиймээс Бурханы охин шиг амьдрахын тулд энэ тэнгэрлэг хувь заяанд юу юу багтдаг

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

болохыг мэдэх хэрэгтэй. Ингэхийн тулд өрсөлдөгчгүй Бурханаа улам таньж мэдэх хэрэгтэй. Мириам Вебстерийн тайлбар тольд Бурханыг “Төгс хүчит, цэц ухаант, сайн сайхан Оршигч бөгөөд хүндэтгэл мөргөлийг хүлээн авагч Ертөнцийн бүтээгч, захирагч” гэдэг.

Чи үүнийг төгс тодорхойлолт гэж бодож байгаа бол, үгүй юм. Энэ бол дөнгөж өнгөн дүрслэл. Бид газрын хэлтэй, газрын хүмүүс учраас, тэр Хязгааргүй Нэгэний талаар ойлгох гэж зүдэрдэг. Бид үгээр дүрсэлж чадамгүй Нэгэнийг яаж дүрслэн ойлгох билээ?

Бурхан ямар ч тодорхойлолтод баригдахгүй.

Ямарваа зүйлийг тодорхойлохын тулд тэр зүйлийг чинь бодитой харагдуулах үгсээр үндсэн чанарыг нь дүрсжүүлэх ёстой. Гэтэл Бурхан хүний хэлийг давснаараа, эдгээр хэмжээсийг зад татдаг.

Тэгэхээр, тодорхойлолтоо орхиё. Тэгвэл Бурханыг дүрсэлж болох уу? Бас л боломгүй. Бид ойртохын аргагүй гэрэлд сохрох гэж байж, яаж хэлбэр төрхийг нь олж харах билээ?

Ерөөлт бөгөөд цор ганц хэмжээлшгүй Эрхт, хаадын Хаан, эздийн Эзэн цагт нь үүнийг харуулна. Түүнд ганцааранд нь үхэшгүй мөнх буй бөгөөд хүршгүй гэрэл дотор оршдог. Ямар ч хүн Түүнийг хараагүй бөгөөд харж чадахгүй. Түүнд хүндэтгэл ба мөнх ноёрхол нь байг! Амен. (1Тимот 6:15-16)

Нүд маань Бурханы дүр төрхийг тогтож харж чадахгүй байхад, бид яаж Түүний гайхамшгийг бүрэн утгаар нь цогцлоон өгүүлэх билээ? Үг ч олдохгүй. Бурханы гайхамшгийг үзээд бид дэмий л Иовын үгийг давтаж хэлэх биз:

Таны тухай чихээрээ сонсож л байлаа, би. Тэгтэл одоо нүд минь Таныг харж байна. Харин би хэлснээсээ буцаж байна. Үнс шороон дунд гэмшье гэв. (Иов 42:5-6)

Бурханы талаарх энэ илчлэл нь Иовын дотор улам их цангаа төрүүлжээ. Олон хүн Бурханы талаарх илчлэлийн үйрмэгт цадчихдаг. Бид номлол, подкаст сонсоод л, фэйсбүүк, инстаграмын олон “лайктай” постыг хараад л, өөр нэгний найрын ширээний үлдэгдлийг “ре-твиит” хийгээд л ханачихдаг. Эдгээр нь буруу биш

л дээ. Гэхдээ чамд зориулаад бэлдчихсэн байгаа Бурханы найрын ширээний дэргэд энэ бүхэн нь зүгээр л талхны үйрмэг юм. Гэтэл Бурхан чамайг Өөрийнх нь итгэмжтэй чанараар хооллоосой гэж хүсдэг. Би чиний хоолны дуршлыг хөдөлгөмөөр байна. Яагаад гэвэл Бурханы тухай ярих нь нэг хэрэг бол, чамтай ярихыг хүсч байгаа Бурханыг сонсох нь тэс өөр хэрэг буюу.

Зарим хүн ярьж чаддаггүй бурхдад үйлчилдэг. Энэ нь жинхэнэ Бурханы мөн чанарыг доромжилж байгаа хэрэг юм. Яагаад гэвэл Бурхан чимээгүй байсан ч, гайхамшигт бүтээлүүд нь Түүнийг чангаар мэдэгддэг. Бурхан биднийг тайтгаруулж, зөвлөхөөр Ариун Сүнсээ илгээсэн. Библи уншихад ч Ариун Сүнс л биднийг бүх үнэнд зааварлаж, хөтөлдөг. Бурхан хэлгүй, дүлий шүтээн биш. Бурхан ярьж чадахгүй, дэмий л сонсдог Аав биш. Хэрэв бид Бурханы нууцлаг чанарыг хүлээн зөвшөөрөхгүй юм бол, Түүнд хэрхэн ойртохоо мэдэхгүй. Бурхан бидэнтэй Үгээрээ, бүтээлээрээ, зарцаараа дамжуулан зүүд үзэгдэл, бие болох чуулганыхаа уялдаа бүхий хэсгээр ярьдаг. Бурхан чамтай энэ номоор ч ярина гэдэгт би итгэж залбирч байна. Бурхан ярьдаг. Гол асуудал нь бид Түүнийг хэр зэрэг сонсож байна гэдэгт л бий. Бид Бурханыг юутай ч харьцуулашгүй, хязгааргүй гайхамшигтай гэдгийг нь хүлээн зөвшөөрч, Тэр бидэнтэй ярихыг хүсдэг гэдэгт итгэх ёстой.

Нэрт теологич Томас Аквинас бараг бүх насаараа Бурханы тухай бичжээ. Тахилч бөгөөд гүн ухаанч тэрбээр шинжлэх ухааны ололтоо Бүтээгч Бурханыхаа талаарх ойлголттой хослуулахаар насаараа хөдөлмөрлөжээ. Гэвч нас барахаасаа гурван сарын өмнө Аквинас өнө мөнхийн ертөнцийг үзэгдлээр харан бишрээд, хамгийн сүүлд дараах үгийг бичээд, үзгээ хураасан гэдэг:

“Миний хүчин зүтгэл дууслаа. Бурханы илчлэлийн дэргэд насаараа бичсэн бүхэн маань зүгээр л сүрэл ажээ.”

Үгийг нарийн судалж, өч төчнөөн боть ном бичсэн энэ аугаа хүн Бурханы сүр жавхлан, чуулганы гайхамшигийг тунхаглахаас өөр үггүй болжээ. Түүнчлэн тэр хүн өнөөдрийнхөөс тэс өөр эрин цагт амьдарч байсныг мэдээрэй. Тэр үед Үг нь маш гүн гүнзгий утга илэрхийлдэг байсан бөгөөд Үгд тун нарийн няхуур ханддаг байжээ. Уншиж, бичих завшаан нь гагцхүү баян, язгууртан,

эрхтэн дархтануудад л олддог байв. Томас Аквинас бол үгийн мастер байсан. Гэхдээ тэр насныхаа хөдөлмөрийг сүрэлтэй жишсэн юм. Ер нь сүрлээр үнэ цэнэгүй юмыг л дүрсэлдэг. Сүрэл нь буудайны хаягдал бөгөөд мал амьтны хэвтэр, ургамлын бордоонд л ашиглагддаг зүйл. Үндсэндээ Аквинас өөрийнхөө нэг насны ажлыг хүн малын уланд гишгэгдэхдээ л таарна гэж үзжээ.

Бурханы тухай бичих болон Бурханы илчлэлийн хооронд ийм л ялгаа байж. Аквинасын хамгийн сүүлд бичсэн хоёр өгүүлбэр нь түүний 20 жилийн турш бичсэн бүтээл туурвилаас нь хавьгүй ихийг өгүүлсэн буюу. Аквинас энэ үгээ үнэхээрийн биширч мэхийсэн сэтгэлээр бичжээ. Учир нь тэрбээр амьдралынхаа төгсгөлд яг л “Бурханыг огт мэдэхгүй үедээ л хамгийн сайн мэднэ” хэмээн өөрөөс нь мянгаад жилийн тэртээ Августины тунхагласан үгийг биеэр мэдэрсэн байна.

Бид Бурханыг огт мэдэхгүй үед л Бурханы тухай илчлэл ундарна. Бид Бурханыг хүнийхээ утга агуулга, ухамсраар тодорхойлох гэж оролддог. Бидний зүгээс Бурханыг тодорхойлох гэж оролдох нь ярьж ч чадахгүй нялх хүүхэд ээжийгээ ийм тийм гэж тодорхойлохтой л ижил юм болно. Яг л халуун цөлийн элсэн дээр зогсоод, зах хязгааргүй далайн ус, далайн гүнийг дүрслэн хэлэх гэж оролдохтой адил.

Бидний Бурхан яг хэн бэ?

Гэтэл Бурхан Аав маань биднийг Өөрт нь ойртоосой, Өөрийг нь таньж мэдээсэй, оршихуйг нь эдлээсэй, дууг нь сонсоосой гэж хүсдэг. Яг л галын тухай мэдэх нь нэг хэрэг бол, гэрэл, дулаан, түлэгдлийг биеэр үзэх нь тэс өөр хэрэг байдаг шиг, Бурхан биднийг Өөрийнх нь талаар мэдэх биш, харин яг Өөрийг нь биечлэн мэдээсэй гэж хүсдэг. Бурхан Бичээст Өөрийгөө ийн танилцуулжээ:

Би бол... Нэгэн. Дэд хууль 6:4; Марк 12:29; Галат 3:20;
1 Тимот 2:5; Иаков 2:19.

Би бол... Альфа ба Омега. Илчлэл 1:8; 21:6; 22:13.

Би Бол... Би. Гэтлэл 3:14.

Би бол... мөнхийн мөнхөд. Дэд хууль 16:36.

Би бол... итгэлийн зохиогч бөгөөд төгсгөгч. Еврей 12:2.

- Би бол... тэнгэр газрыг Бүтээгч.** Эхлэл 1:1.
- Би бол... чадна.** Матай 3:9.
- Би бол... хайр.** 1Иохан 4:7-8, 16.
- Би бол... сайн.** Марк 10:18; Лук 18:19; 1Тимот 4:4.
- Би бол... та нарын дунд байгч.** Дэд хууль 6:15;
Лук 17:21; 1Коринт 14:25.
- Би бол... үнэн.** Иохан 3:33.
- Би бол... та нарын эдгээгч.** Гэтлэл 15:26.
- Би бол... Сүнс.** Иохан 4:24.
- Би бол... Аав.** Иохан 6:46; Филиппой 2:11.
- Би бол... Хүүгийн дотор алдаршуулагдсан.** Иохан 13:31.
- Би бол... та нарын гэрч.** Ром 1:9; Филиппой 1:8;
1Тесалоник 2:5.
- Би бол... илчлэгдсэн.** Ром 1:17.
- Би бол... та нарын төлөө.** Ром 8:31.
- Би бол... бүхний дээр.** Ром 9:5; Ефес 4:6.
- Би бол... өршөөнгүй.** Дэд хууль 4:31; Ром 12:1.
- Би бол... итгэмжтэй.** 1Коринт 1:9; 10:13; 2Коринт 1:18.
- Би бол... хүмүүсээс цэцэн.** 1Коринт 1:25.
- Би бол... самууны зохиогч биш.** 1Коринт 14:33.
- Би бол... амар тайвны зохиогч.** 1Коринт 14:33.
- Би бол... чиний хангамж.** 2Коринт 3:5.
- Би бол... нигүүлсэнгүй бөгөөд өгөөмөр.** Гэтлэл 34;
Нехемиа 9.
- Би бол... уурлахдаа удаан.** Иоел 2:13; Нахум 1:3.
- Би бол... өндөрт өргөмжлөгдсөн.** Филиппой 2:9.
- Би бол... та нарын дотор ажилладаг.** Филиппой 2:13.
- Би бол... үл үзэгдэгч.** Колоссай 1:15.
- Би бол... айсуй Бурхан.** Колоссай 3:6.
- Би бол... шударга Шүүгч.** 2Тесалоник 1:5.
- Би бол... хүмүүсийн Аврагч.** 1Тимот 2:3; 4:10.
- Би бол... хүлээсгүй.** 2Тимот 2:9.
- Би бол... бүхнийг байгуулагч.** Еврей 3:4.
- Би бол... шударга.** Еврей 6:10.
- Би бол... амьд.** Еврей 10:31.
- Би бол... залгигч гал.** Дэд хууль 6:3; Еврей 12:29.
- Би бол... гэрэл.** 1Иохан 1:5.

Би бол... та нарын зүрхнээс том. 1Иохан 3:20;

Илчлэл 1:18.

Би бол... байгаа, байсан, айсуй Бурхан. Илчлэл 4:8.

Би бол... ариун. Илчлэл 4:8.

Би бол... хүчирхэг. Илчлэл 11:17.

Би бол... та нарын хүч. Гэтлэл 15:2.

Би бол... та нарын дуу. Гэтлэл 15:2.

Би бол... хартай. Гэтлэл 34:14; Дэд хууль 4:24.

Би бол... хүн биш. Тооллого 23:19; Дэд хууль 4:24.

Би бол... бурхдын Бурхан, эздийн Эзэн. Дэд хууль 10:17.

Би бол... аугаа, хүчирхэг, гайхам. Дэд хууль 10:17.

Би бол... хэсэг биш. Дэд хууль 10:17.

Би бол... та нарын магтаал. Дэд хууль 10:21.

Би бол... тулаанд та нартай цуг. Дэд хууль 20:4.

Би бол... дайчин. Гэтлэл 15:3.

Би бол... та нарын орших газар. Дэд хууль 33:27.

Би бол... та нарын хад, хорогдох газар. 2Самуел 22:32-33

Би бол... ганцаараа Бурхан. Дэд хууль 4:32, 35, 35;

1Хаад 8:60.

Энэ бол зөвхөн нэгээхэн хэсэг нь шүү! Чи өөрөө бүгдийг нь судалж үзбэл тун сайн. Харин энэ бүлгээрээ би Бурханы гурван чанар дээр л төвлөрөн ярилцъя. Эхнийх нь Бурхан ганцаараа Бурхан гэдгийг мэдэх.

Түүнээс өөр Бурхан байхгүй

Сонс, Израиль аа! ЭЗЭН бол бидний Бурхан бөгөөд ганц ЭЗЭН. Чи Бурхан ЭЗЭНээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла. (Дэд хууль 6:4-5)

“Ганц” Бурхан гэдгийг ертөнцийн бусад бурхадтай тэмцэлдээд, нэгдүгээр байрт орсон Бурхан гэж бүү ойлгоорой. “Ганц” гэдэг нь Түүнээс өөр бурхан байхгүй - Тэрбээр цорын ганц жинхэнэ амьд Бурхан гэсэн үг юм шүү. Ганц гэдэг нь Түүнээс өөр байхгүй гэсэн үг. Тэр л ганцаараа цорын ганц жинхэнэ амьд Бурхан. Есүс ч үүнийг Аугаа тушаалаараа хэлсэн:

“Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла. Энэ бол агуу нь бөгөөд анхны тушаал мөн.”
(Матай 22:37-38)

Бид Бурханаа бүхий л зүрх, сэтгэл, оюунаараа хайрласан шиг хайрлах ёстой. Бурхан ганцаараа бидний хараанд байж, ганцаараа л бидний магтаал хүндэтгэлийг авах ёстой. Үүнийг хагас хугас зүрхээр хийх боломжгүй гэдгийг Бурхан мэддэг бөгөөд Тэрбээр ямар ч өрсөлдөгч бурханыг хүлцэн тэвчихгүй. Энэ нь ч ухаалаг арга юм. Бурхан Өөртөө итгэлгүйдээ ийм тушаал өгөөгүй. Харин биднийг төөрч, замаасаа гарах вий гэсэндээ л өгчээ.

Энэ нь өнөөгийн бидэнд жаахан ойлгомжгүй Бичээс байж болно. Учир нь хүмүүс өнөөдөр хэдийгээр эртний нэр устай баримал шүтээнд мөргөөд байдаггүй ч, хүний бүтээсэн бүтээлд мөргөдөг болсон. Бурхан энэ талаар хүүхдүүддээ сэрэмжлүүлсэн:

Та нар өөрсдөдөө зориулан бөхийн мөргөх гэж нутагтаа шүтээнүүдийг хийх ёсгүй. Өөрсдөдөө хөрөг эсвэл чулуун баганыг ч босголгүй, хэлбэрт чулууг ч бүү байрлуул. Учир нь Би бол Эзэн та нарын Бурхан. (Левит 26:1)

Бидний ихэнх нь байрныхаа гадаа чулуун багана, шүтээн босгоогүй байх. Гэхдээ энэ нь бидний зүрхэнд шүтээн байхгүйн баталгаа биш юм. *Шүтээн гэдэг нь таны хамаг хүчээ авдаг бас хамаг хүчээ өгдөг зүйл.* Чи үүнээсээ л амиа авдаг гэсэн үг. Хорогдох гэж гүйдэг газар чинь байж болно. Хоол хүнс мэтийн жирийн зүйлээс авахуулаад олон нийтийн сүлжээнд оролцох оролцоо чинь ч байж болно. Хэрэв чи Бурхан Өөрийгөө хэн болохыг хэлсэн дээрх жагсаалтыг дахин харбал, Бурхан бидний хүч, амь, хорогдох газар гэснийг харна. Бурханаас өөр ямар ч *хүн, харилцаа, байгууллага* чамайг захирах ёсгүй.

Заримын маань хувьд *мэдрэмж* маань шүтээн болдог. Тэгээд өөртөө *таалагдаж* байвал, өөрийгөө хөөрхөн гэнэ. Өөртөө таалагдаж



Шүтээн гэдэг нь таны хамаг хүчээ авдаг бас хамаг хүчээ өгдөг зүйл.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

байвал, өөрийгөө сайн гэнэ. Мэдрэмжээрээ амьдрах юм бол, мэдрэмж маань бидэнд худлаа хэлж, төдөлгүй бид замаасаа төөрнө.

Гэтэл үнэндээ дордсыг Бурхан авралаараа үзэсгэлэнтэй болгодог (Дуулал 149:4) учраас л, бид үзэсгэлэнтэй юм. Бүх юмыг Тэр тухайн цагт нь сайхнаар бүтээсэн (Номлогчийн үгс 3:11) учраас л, бид үзэсгэлэнтэй. Энэ дэлхийн сайхан хөөрхөн гэгддэг тэнэг шүтээн, дүр төрхийг *бүү сонс*. Бурхан *чиний амьдралыг* хэдийнээ ерөөсөн! Магтаалч Давид шүтээнийг ингэж дүрсэлжээ:

Тэдний шүтээнүүд гэвээс мөнгө ба алт,
Хүний гарын бүтээл буюу.
Амтай боловч ярьдаггүй
Нүдтэй боловч хардаггүй
Чихтэй боловч сонсдоггүй
Хамартай боловч үнэрлэдэггүй
Гартай боловч тэмтэрдэггүй
Хөлтэй боловч алхдаггүй
Хоолойгоороо ч дуу гаргадаггүй.
Тэдгээрийг бүтээгчид,
Тэдэнд итгэгч бүгд тэдэнтэйгээ адил буюу.
(Дуулал 115:4-8)

“Тэдэнд итгэгч бүгд тэдэнтэйгээ адилхан болно” гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүний юмыг өргөмжлөх үедээ бид хүний бүтээх чадварт баригддаг. Шүтээн нь ямар ч ажиллагаагүй хэлбэр юм. Тэд хүнд тус хүргэх хүчийг агуулдаггүй, зүгээр л амьд мэт дүртэй юм. Тийнхүү тэднийг шүтэгчид нь жинхэнэ Бурханаас өгөгдсөн мэдрэмжээ хөсөрдүүлж, дуу хоолойгоо алдаж, үйл хөдлөл хийх эрх чөлөөгөө гээдэг. Чи Бурханыг хүндэтгэхдээ Түүнтэй улам адилхан болж, алдраас алдарт хүрдэг. Жинхэнэ Бурхантай хэн ч эгнэхгүй учраас, Түүнийг дагасан хүн л жинхэнэ өөрийгөө олж авна. Чи бусдын сурагч байж болно. Гэхдээ бусдад мөргөж болохгүй.

Бурхан бол Альфа бөгөөд Омега

Хоёр дахь үнэн нь Бурхан мөнхийн мөнх Бурхан юм. Үүнийг өөрөөр Альфа бөгөөд Омега гэдэг. Альфа, Омега нь Грек цагаан

толгойн эхний болоод төгсгөлийн үсэг юм. Дэлгэж харах юм бол, энэ нь эхнээсээ дуустлаа гэсэн утгатай болно. *Альфа* нь “эхэлбэр, эхлэл, төрөлт, үүр, гараа, босго” гэсэн үг. Харин *Омегагийн* тухайд тодорхойлолт нь бүрхэг боловч, “төгсгөл, эцсийн цэг, хязгаар” гэсэн утгатай. Магадгүй омега гэдэг тодорхойлолт нь бидэнд илүү бүрхэг байдаг байх. Яагаад гэвэл хүмүүс бид ирээдүйг биш, өнгөрснийг л мэддэг. Тиймээс л бид Бурхан руу улам ойртох ёстой юм. Бидний мэдэх цаг хугацааг анхнаас нь гагцхүү Бурхан л мэднэ. Тиймээс л бидний Бурхантай хэн ч эгнэшгүй. Эш үзүүлэгч Исаиа:

“Учир нь Би Бурхан, өөр байхгүй. Би Бурхан. Надтай ижил нь үгүй учраас Өнө урьдын, эртний зүйлсийг санагтун.
“Зорилго минь хэрэгжинэ. Би тааламжит бүхнээ гүйцэтгэнэ” гэж айлдан Би эхлэлээс авахуулан төгсгөлийг, Хийгдээгүй байгааг ч өнө эртнээс мэдүүлсэн” (Исаиа 46:9-10) гэжээ.

Бурхан бүр эхэнд л бүхний төгсгөлийг тунхагласан. Тэрбээр дөнгөж Альфагаа бичихдээ Омегагаа тунхаглажээ. Тэгээд биднийг Түүний итгэмжтэй байдлыг эргэж хар гэсэн. Бурхан үүр цайж байхад л тэр өдөр хэрхэн дуусахыг мэддэг.

Би өнө эртний юмсыг эхнээс тунхаглан
Амнаасаа гаргаснаа Би зарласан бөгөөд
Гэнэт үйлдэхэд, тэдгээр нь биелсэн. (Исаиа 48:3)

Энэ бол бариа, төгсгөл. Тэр юуг ч дутуу үлдээгээгүй. Тэр хэзээ ч санаа бодлоо өөрчилж, ухрахгүй.

«Шүтээн минь үүнийг хийж,
Сийлмэл хөрөг, цутгамал хөрөг минь үүнд тушаасан» гэж
чамайг ярих вий гэсэндээ Би бүр эхнээс мэдүүлж,
Болохоос нь өмнө чамд сонордуулсан.
Чи сонссон. Энэ бүгдийг харагтун.
Чи үүнийг мэдүүлэхгүй юу?
Энэ цагаас эхлэн Би чамд шинэ юмсыг,
Чиний мэдээгүй нууцлагдсан зүйлсийг сонсгоё.
Тэдгээр нь урьд биш, сая бүтээгдсэн юм. «Хараач, би үүнийг
мэдэж байсан» гэж чамайг хэлүүлэхгүйн тулд

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Өнөөдрийг хүртэл чи тэдгээрийг сонсоогүй. (Исаиа 48:5-7)

Бурхан анхнаасаа л бидэнд адагтаа үгүйрч алга болох юмст итгэл найдвараа тавьсаар, хамтдаа сүйрэхгүй байхыг анхааруулжээ. Тиймээс бид өөрийнхөө хийснийг биш, Түүний үйлдсэнийг ярих ёстой бус уу? Бид бүтээлийн үгээр биш, Бүтээгчийн үгээр явах ёстой бус уу?

Тэдгээр нь урьд биш, сая бүтээгдсэн юм.
«Хараач, би үүнийг мэдэж байсан» гэж чамайг хэлүүлэхгүйн тулд өнөөдрийг хүртэл чи тэдгээрийг сонсоогүй.
(Исаиа 48:7)

Харав уу...

Бидний Бурхан эхэнд л төгсгөлийг тунхагладаг.
Бид Бурханыг хайрлахаас өмнө Христийн дотор Бурхан биднийг түрүүлж хайрласан,
унахаас минь өмнө барьж авсан,
хэлэхээс минь өмнө уучилсан,
нүцгэн шалднаа мэдэхээс минь өмнө зөвт байдлаар хувцасласан, бохир гэдгээ ухаарахаас минь өмнө цэвэрлэсэн.

Бурхан дайсан, хар элгийн, танихгүй байсан биднийг Өөрийнхөө хүүхэд, найз гэсэн. Тэгээд биднийг анхныхаа амьсгалыг амьсгалахаас ч өмнө амьдралын маань түүхийг бичсэн байжээ.

Энэ хэнтэй ч эгнэшгүй Бурханыг таньж мэдээд, Аавыгаа Түүний хамгаас хайртай, мундаг охид шиг дууриа.

Бурхан бол “Би бол Би” Бурхан

Гэтлэл 3:13-14:

Тэгэхэд Мосе, Бурханд —Хараач, би Израилийн хөвгүүд дээр очиж, тэдэнд “Эцэг өвгөдийн чинь Бурхан намайг та нар уруу илгээв” гэж хэлэхэд тэд надаас “Түүний нэр хэн бэ?” гэж асуувал би тэдэнд юу гэж хэлэх вэ? гэв.

Бурхан, Мосед —Би бол «Би байгаа» юм гэв. Тэгээд Тэр —Израилийн хөвгүүдэд чи “«Би байгаа» намайг та нар уруу илгээв” гэж хэл гэв.

Моше энэ нэрийг сонсоод ямар гээчийн нэр вэ гэж гайхаа байх. Чи хүнээс нэрийг нь асуутал, тэрбээр “Би бол би” гэж хариулбал, яах уу? Тэгээд дахиад лавлаад асуутал, тэрбээр “Би бол би” гэж хариулна. Мэдээж чи гайхаж эргэлзэнэ. Нэг иймэрхүү хачин яриа өрнөх байх: “Сайн уу, Биболби?” Тэр хүнтэй ярьж байгаа атлаа өөрийгөө хэлээд ч байгаа юм шиг. Гэхдээ энэ нэр ч бас цорын ганц жинхэнэ амьд Бурхан гэсэн утгатай болно. Миний хувьд - мэдээж би бол “Би бол Би” биш. Харин “Тэр байгаа учраас, би байгаа” гэж хэлбэл зохих байх.

Бурхан бол Бурхан. Тэр Бурхан учраас оршдог. Харин би өөрийнхөө хүчээр эсвэл аав, ээжийнхээ хүчээр бий болоогүй. Намайг Бурхан л бий болгосон. Бурхан бол бүх амьд сүнсний Бүтээгч болой.

Бурхан “Би бол Би” Бурхан учраас, би ч бас “Христийн дотор би бол би” гэж хэлж чадах болсон. Хүн бид энэ нэрийн жинхэнэ хүчийг үнэнээсээ ойлгож чадахгүй байх. Ойлгож чаддаг байсан бол, тун сэрэмжтэй амьдрах байсан биз. Дэлхий бидэнд Бурханыг тайлбарлах гэж оролдов ч, Бурхан Хүүгээрээ Өөрийгөө илчилсэн. Бурхан Өөрийгөө Хүүгээрээ дамжуулан илчлэхийг хүсдэг бөгөөд явц дундаа чамайг ч бас хэн болохыг чинь илчлэхийг хүсдэг. Матай 16:13-18 дээр нэг ийм үйл явдал болдог:

Цезарь Филиппийн нутагт Есүс ирээд шавь нараасаа —
Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? гэж асуухад

Тэд —Зарим нь баптисч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл эш үзүүлэгчдийн нэг гэдэг гэхэд

Тэр —Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ? гэсэнд
Симон Петр —Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв.

Есүс түүнд хариуд нь —Ионагийн хүү Симон оо, чи ерөөлтэй ээ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Эцэг минь илчилсэн юм.

Би мөн чамд хэлье. Чи Петр. Энэ хадан дээр Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй.
(Матай 16:13-18)

Сонсов уу? Бид Есүсийг хэн болох илчлэлийг авахдаа, үнэндээ өөрийгөө хэн болохыг сонсоход бэлэн болдог. Симон өмнө нь

ӨРСӨЛДӨГЧҮЙ

Петр байсан. Тэрбээр мөнхөд сэтгэл хөдлөл ихтэй загасчнаараа байхгүй. Тэрбээр Сүнсээр дүүрэн удирдагч, хад болно. Дараа нь Есүс ингэж ярихдаа, хичнээн догдолсон нь мэдэгддэг:

Би мөн чамд хэлье. Чи Петр. Энэ хадан дээр Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно. (Матай 16:18-19)

Хүн өөрийгөө хэн болохыг мэдэх үедээ... юутай болсноо мэддэг. Чуулган хэн болох нь, чуулганы тэнгэрийн хангамж нь тэр чигээрээ Христ хэн болох илчлэлтэй шууд хамааралтай байсан. Бид Үгийг мэдэхдээ, Үгээр залбирдаг бөгөөд тэнгэр “тийм бөгөөд амень” хэмээн цуурайтуулдаг.

Чи Есүсийг хэн гэх вэ?

Бурханы талаарх ойлголт чинь тэр чигээрээ чамд болон чиний шийдвэрт нөлөөлнө. Бид Есүсийг хэн гэж дуудна - яг тэр замаар Бурхан



Бурханы талаарх ойлголт чинь тэр чигээрээ чамд болон чиний шийдвэрт нөлөөлнө.

амьдралд маань илчлэгддэг. Бид Есүсийг сайн багш гэх юм бол, Тэр бидэнд зааж өгнө. Мундаг зөвлөх гэх юм бол, Тэр цэц ухаанаа бидэнд дамжуулна. Ислам Есүсийг эш үзүүлэгч бөгөөд эдгээгч гэдэг. Тусдаа энэ хоёр нэр нь дам яриа бөгөөд “талхны үйрмэг” юм. Есүсийг амьд Бурханы Хүү Христ гэдэг нэрээр нь дуудах юм бол, Есүс бол Эзэн гэдэг илчлэлийг ойлгоно. ИИохан ном дээр үүнийг хэлдэг:

Есүс бол Бурханы Хүү гэж хүлээн зөвшөөрдөг хэний ч дотор Бурхан байж,

тэрээр Бурханы дотор байна. Бурхан, биднийг хайрладаг хайрыг бид мэдэж, итгэдэг. Бурхан бол хайр мөн. Хайр дор байгч нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна. Үгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд

БИДНИЙ ӨРСӨЛДӨГЧГҮЙ БУРХАН

хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд
Түүн шиг байдаг. (1Иохан 4:15-17)

Энэ илчлэл дотор мөнхийн холбоо үүсч, Түүний авралын ажил хийгээд бидний бодит байдлын хоорондох ангал хаагджээ. Бид Бурханы Үгийг хэлэх үед биднийг үнэнээс тусгаарладаг орон зай дээр гүүр тавигдсан юм. Бидний хэн болох маань цаашид бидэн дээр үндэслэх бус, Бурхан дээр үндэслэх болжээ. Энэ нь би Түүний хэлсэн тэр хүн болсон гэсэн үг юм. Би Христтэй бат холбоотой болсон учраас, “Христ доторх” Бурханы бүх амлалтын биелэл, илчлэлийг эдлэх эрхтэй болсон юм. Тэр мөн Эдгээгч, Энхийн Ханхүү, итгэлийн маань зохиолч бөгөөд төгсгөгч биш үү? Би Есүсийг Бурхан гэх үү эсвэл зүгээр л сайн багш гэх үү?

Тэр хайр учраас, би өөрөө хайрлагдаж, өрөөлийг хайрлаж чадах болсон.

Тэр амьд учраас, би амьд болсон.

Тэр чадвартай учраас, би чадвартай болсон.

Тэр миний Ах учраас, Би Бурханы охин болсон.

Тэр хүчирхэг учраас, би хүчирхэг болсон.

Тэр эдгээгч учраас, би эдгэрсэн.

Тэр цэц ухаан учраас, би цэцэн болсон.

Түүний хүчээр би “би” болсон.

Тэр хэлсэн учраас, би “би” болсон.

Би аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн.

Би чамайг Бурханы Үгийг амьдралдаа уриасай гэж хүсэж байна. Яг одоо үүний төлөө залбиръя:

Тэнгэрийн Бурхан Аав аа,

Та намайг хэн гэж хэлнэ - би тэр хүн болсон. Таныг өчүүхнээр төсөөлж, бодлоороо өөр бурхдад мөргөсөнд намайг өршөөгөөрэй. Би хүний гараар бүтээгдсэн шүтээнд мөргөхгүй. Ариун Сүнс минь, амьдралын маань аль нэг талбарт эдгээр шүтээн байгаа бол, илчилж өгөөч. Та бол хайр, тиймээс би зөвхөн хайрлагдаад зогсохгүй, Таны хайраар

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

бусдыг хайрлаж чадах болсон. Та бол миний амьдралын эх үүсвэр бөгөөд амьсгалах амьсгал, цохилох зүрх минь.

Та миний амьдралд эхлүүлснээ заавал дуусгана. Би Таны хийгээрэй гэсэн бүхнийг хийх чадвартай болсон. Христ дотор би Таны охин, харин Та миний Аав учраас, Таны Сүнсний бүхий л хүч чадал надад бий. Та бол миний төгс Эдгээгч. Одоо би дэлхийгээс олсон шархаа эдгээх гэж дэлхий рүү гүйх шаардлагагүй болсон. Та бүхий л цэц ухааны эх ундарга учраас, би Таны зөвлөгөөнд найдна.

Таны хүчийг амьдралдаа хязгаарлаж, бусдын үйрмэгээр хооллож байсныг минь өршөөгөөрэй. Би ганцхан Таныг бүрэн мэдмээр байна. Та миний төсөөллөөс хол давсан Бурхан гэдэгт би итгэж байна. Та намайг өрсөлдөгчгүй гайхамшигт амьдрал руу хөтлөх болтугай. Та намайг хэн гэж хэлсэн - би тэр хүн болсон. Яг одоо юу мэдэрч байгаагаасаа үл хамааран, би аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн. Есүсийн нэрээр. Амень.

Хэлэлцэх асуулт

1. Урьд нь чи Дээдийн Дээд гэдэг хэмжээг өөрийнхөө мэдлэг юмуу туршлагаар хэмждэг байв уу? Жишээлбэл: чи Түүнийг сайн аав гэж боддог байсан уу, муу аав гэж боддог байсан уу? Тэгвэл одоо юу гэж бодож байна?
2. Чиний амьдралд бусдын үйрмэгээр эсвэл дам яриагаар амьдарч байгаа талууд байгаа юу?
3. “Бурханыг огт мэдэхгүй үедээ л хамгийн сайн мэддэг” гэж хэлсэн Августины үгийг чи юу гэж ойлгож байна?
4. Чи Бурханы яг аль чанарыг амьдралдаа илүү ихээр мэдэж, харахыг хүсч байна?
5. “Шүтээн бол хамаг хүчээ өгч, хамаг хүчээ авдаг зүйл” гэхээр, чиний амьдралд санаатай бөгөөд санаандгүйгээр шүтээн шүтсэн талууд байна уу?
6. Бурханы оршихуйд ороод, чи Түүнийг нэрээр нь дуудахад, Тэр чамайг хэн гэж дуудаж байна?

Өрсөлдөгчгүй амлалт

Хэрэв бид Сайн мэдээн дэхь “цадиггүй” шагналын амлалтыг үзэх юм бол, Эзэн маань бидний хүслийг дэндчихсэн биш, харин ч дэндүү жул байна гэж үздэг мэт харагддаг. Бидэнд хязгааргүй аз жаргал өгөгдсөөр байтал, бид архи, секс, амбици хөөх, хоёрдмол зүрхтэй адгуус лугаа адил ажээ. Яг л баярын ширээ гэж юу байдгийг мэдэхгүй учраас, хогноос хаягдал түүж идэхээс өөр хүсэлгүй тэнэмэл хүүхэд шиг. Дэндүү хямдхан зүйлд дэндүү амархан цадах юм даа бид.

Си Эс Люис

Пөөх... хэлэх ч үг алга.

Чиний амьдралд хандсан өрсөлдөгчгүй амлалт гэж бий. Энэ нь бас чиний эрдэнэс юм. Энэ эрдэнэс хэмжээ хязгаар, цаг хугацаанд баригдахгүй. Энэ эрдэнэс нь чамд хүрэшгүй хүчин чадлын хэлбэрээр ирдэг. Иймээс л ихэнх нь энэ бэлгээ амьд атлаа унтаа хэлбэрт оруулан царцаадаг байна.

Жишээлбэл би чиний дансанд тэрбум доллар хийчихлээ гэвэл, чи яаж баярлах бол? Чи тэр мөнгийг насаараа үрээд ч дуусгахгүй. Гэхдээ харамсалтай нь чи тэр мөнгийг аваад үхэхгүй учраас, тэр мөнгө үнэндээ чинийх биш юм. Гэтэл түрүүний бидний ярьсан эрдэнэс нь улам өсөн арвижсаар, чамайг өнө мөнхлөл рүү явахад чинь дагаад л явна.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Энэхүү өрсөлдөгчгүй амлалт нь аймаар их баялгаас гадна бас хүрэх боломжтой баялаг юм. Амлалтын үр жимс нь чамайг тэнгэрт очиход ч дагалдана, чамайг явсны дараа чиний үр хүүхдийг ч дагалдана. Энэ амлалтыг хулгайлах боломжгүй ч гэлээ бас Есав шиг ганц аяга шөлөөр худалдчих боломжтой (Эхлэл 25). Тиймээс үүнийг мөрөөдөл, найдвараараа өлгийдөөд, далдхан шиг нуусан нь хавьгүй дээр. Зүрхнийхээ хөрсийг арчилж тордсоор байвал, энэ эрдэнэс улам л цэцэглэж, улам л өснө. Тэгээд хичнээн хүн хувь хүртсэн ч, хэзээ ч дундрахгүй.

Би хаадын Хаан, эздийн Эзэний ерөөлийн талаар ярьж байна. Үүнийг цаасан мөнгө, зоосон мөнгө, алт, мөнгөөр ч хэмжишгүй. Чи өмссөн хувцастайгаа үлдсэн байсан ч, энэ эрдэнэс чамтай хамт байна. Энэ баялаг хүний гараар бүтээгдсэн зүйлийг дагалддаггүй, мөнхийн зүйл бөгөөд шивнэх төдий залбирлаар л шилжүүлэгддэг юм. Чи ийм л шидэт гүнж шүү.

Хааны урилга

Хаалга чинь тог тог хийв. Гүйж очоод тайлтал, хааны зарлага зогсож байв. Яг л Үнсгэлжин дээр гардаг шиг. Гэхдээ хааны зарлага нь тэнгэрэлч ажээ. Тэр өндөр тэнгэрэлчийн ард та хоёрын уулзалтыг гэрчлэн харахаар ирсэн үй олон хүн байх юм гэнэ. Тэгээд тэр тэнгэрэлч чиний нэрийг дуудаад, чамайг тэнгэрийн өв залгамжлагч гүнж гэж дуудна. Нир хийтэл алга нижигнэв. Чи ч гайхшаа бараад: “Та намайг хэлээд байгаам уу?” гэтэл, тэнгэрэлч толгой дохиод, чамд нэг урилга гардуулав. Чи чичирсээр дугтуйгаа нээтэл, үнэхээр чиний нэрийг алтан үсгээр сийлсэн байлаа. Чи санаа алдаад, нулимс мэлмэрүүлсээр өөдөө хартал, гав ганцаараа зогсож байв. Тэнгэрэлч бараа бологч нартайгаа хэдийн яваад өгчээ. Тэгтэл гэрийнхэн чинь: “Хэн бэ?” гэж дуудлаа.

Харин чи амандаа: “Би л байна” хэмээн шивэгнэв.

Тэрхэн эгшинд чиний дотор хувьсгал гарсан боловч, гадна талаасаа бүх юм чинь бахь байдгаараа л байв. Тэнгэрэлч чиний байр байршил, ахуй нөхцлийг өөрчлөх гэж биш, харин чамайг дотроос чинь өөрчлөх, өрсөлдөгчгүй урилгыг өгөхөөр иржээ.

Чи доошоо харна. Хаалга тайлахдаа өмсөж байсан нөгөө л

хувцастай зогсож байна. Гэвч дотор чинь ямар ч нэр ус, хочийн хүлээс дарамтгүй, нэг л хөнгөн шингэн санагдана. Өрөө рүүгээ алхаж явахдаа ч, цаанаа л нэг саруул санагдана. Хэдий чи гэртээ байгаа ч, энэ гэр чинь хэдийнээ чиний гэр биш болжээ. Бурхан Аавын чинь бүтээсэн алсын хот чамайг даллан дуудна. Чи явсаар, том өрөөндөө чамайг жаахан гайхсан янзтай ажиглан суугаа гэрийнхнийхээ хажуугаар гараад, унтлагын өрөөндөө орлоо. Тэгээд ганцаараа тухлан суугаад, урилгаа зориглон уншив:

Хайрт охин минь, одоо чи Дээдийн Дээд Бурханы гүнж Сарх болсон.

Есүсийг таньж мэдэх тусам, Түүний нигүүлсэл, амар тайван амьдралд чинь үржсээр байна.

Ариун Бичээсийг олборлох тусам, чиний залуу нас, оюун ухаан чинь улам бүр шинэчлэгдэн, чамд баталгаажсан аугаа их нандин амлалтын их санг ойлгох болно. Энэ бүхэн нь чамд л зориулагдсан юм шүү! Хонгор охин минь, магад чи эргэлзэж байгаа бол, чи үүнээс эрхэм урилга хэзээ ч хүлээж авахгүй шүү! Гагцхүү чамаас нүүрээ буруулсан дэлхийгээс л нүүрээ буруулж яваарай.

Би энэ захидлыг 2Петр 1:2-4-ээр ишлэлээс сэдэвлэн бичлээ:

Бурханыг болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон. Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанарыг хуваалцагч болох юм.

Хэрэв Есүс миний зүрхийг тогшоогүй байсан бол, би ямар ч итгэл найдваргүй амьтан болж дуусах байлаа. Миний хувьд ямар нэг юм өвлөж авна гэдэг ёстой л үлгэрийн далай болох байсан байх. Аав, ээж хоёр маань дүү, бид хоёрт аль нэг өв үлдээх чадалтай хүмүүс байгаагүй. Гэхдээ би өв хүлээж авахыг хүсэх

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

үү эсвэл хаягдал хүлээж авахыг хүсэх үү? Бурханы амлалт эд хөрөнгөөс урт настай болохыг би анхнаасаа л ойлгосон юм.

Тэгвэл Бурханы энэ амлалтад яаж хүрэх вэ? Амлалт нь итгэлээр дамжин биднийх болдог. Галат 3:14:

Энэ нь Абрахамын ерөөлийг Христ Есүсээр харийнханд ирүүлэхийн тулд юм. Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм.

Абрам, Сарай хоёртой танилц

Энэ амлалтын талаар илүү мэдэхийн тулд Бичээсийн нэгэн танил түүхийг дахин үзье. Бурхан биднийг сургамж авч, суралцаасай гэсэндээ Бичээстээ хүмүүсийн түүхийг өгүүлдэг. Тэдгээрийг уншихад, тэр хүмүүсийн амьдрал нүдний минь өмнө амилах шиг л болдог. Би тэр түүхийг дүрслэн төсөөлөөд, Ариун Сүнсийг

сонсдог. Ийнхүү би зүгээр л Библиэс Бурханыг Үгийг уншсанаараа, харахгүй сонсохгүй байгаа юмсаа харж, сонсдог юм. Тэгээд: “Би тэдний оронд байсан бол, яах байсан бол? Юунаас хамгийн их айх байсан бол?” гэж асуудаг.

Энэ нь Бичээсийг унших олон аргын нэг юм. Энэ нь Библиэс гажууд зүйл огт биш. Харин ч Бичээсийг тунгаан бодож, амилуулах нэг арга

юм. Бидний өмнө аж төрж байсан тэдгээр итгэлийн өвөг дээдэс маань ингэж л амьдарчээ. Би ингэж л села¹ хийдэг буюу түр зогсоод, тунгаан боддог.

Эхлээд Абрахамтай танилц. Тэр бол бидний итгэлийн эцэг. Итгэмжтэй, алдаа оноотой, бурханлаг, настай хүнийг төсөөл. Дараа нь түүний гэргий Сарайг. Тэр бол бидний амлалтын эх. Тэрбээр маш үзэсгэлэнтэй, итгэмжтэй, алдаа оноотой, бурханлаг настай эмэгтэй.

Энэ хоёр Бурханаас урилга хүлээж авахдаа, хамаг юмаа хаяад явах зүрх зориг гаргажээ. Бурхан энэ үр хүүхэдгүй хосыг ерөөж, үржүүлэхээ амласан. Тэгээд манай хоёр адал явдалд гарчээ. Тэд

хэзээ ч хараагүй зүйлээ буюу Бурханы байгуулсан үндэстнийг хайсаар явсан. Бид ч бас тэдэнтэй хамт хэдэн арван жил аялдаг. Тэгээд Абрам зуу хүрч, Сарай ертэй золгов.

Тэд олон жил цөлөөр алдаатай оноотой явсан. Тэгэхээр, товчхондоо Бурхан тэднийг ерөөсний дараа тэд зөндөө эсэргүүцэлтэй тулгарчээ: Лот гэдэг хамаатнаасаа зам салж бас Сарай Фараоны эхнэр болохоо алдсан ч, Бурхан түүнийг аварчээ. Цаашаагаа тэд бяцхан дайнд ялж, хулгайлагдсан Лотыг аварч, Дээдийн Дээд Бурханы тахилч Мелхизедек хаанд арван хувиа өргөсөн. Түүнээс гадна тэд арга тасарсандаа маш муу шийдвэрт хүрч, Сарай хүүтэй болохын тулд Хагарыг нөхөртөө өгч Ишмаел гэдэг хүүтэй болсон. Гэвч Сарай хүссэндээ хүрээгүйгээр үл барам, Хагарт дорд үзэгдэж эхэлсэн. Эхнэр, нөхөр, зарц хүүхэн гурвын тэр хачин харилцаа тийм ч таатай байгаагүй байх.

Абрам, Сарай хоёрын амьдрал товчхондоо ийм авай.

1. Тэд *бүх амьдралаа бооцоонд тавьсан*. Абрам, Сарай хоёр эргэж харалгүйгээр Ураас гарч явдаг. Тэд буцаж ирэхгүй. Бурхан тэднийг дуудсан учраас, тэд дагасан. Эхлэл 12:1-2 дээр:

“Тэгээд ЭЗЭН, Абрамд айлдахдаа: —Чи эх нутгаасаа, төрлүүдээсээ мөн эцгийнхээ гэрээс гарч чамд Миний харуулах нутаг уруу явагун. Чамаас Би агуу үндэстнийг гаргаж, чамайг бас Би ерөөн, чиний алдрыг Би агуу болгоно. Чи тэгээд ерөөл болтугай” гэжээ.

Бурхан шинэ зүйлийн төлөө шинэ арга замаар зам тавьж байжээ. Бурхан тэр хоёрыг итгэл, найдвар дотор дагуулсан. Тэд зөндөө алдсан ч, эргэж хараагүй.

2. Тэд *дайсагналаас зайлсхийсэн*. Абрам, Сарай хоёр Ураас явахдаа, Лотыг дагуулж явсан нь тийм ч сайн санаа байсангүй. Абрамын ерөөлөөр Лот ч ерөөгджээ. Тэгээд тэд нэг газарт багтаж шингэхээ больж, малчид нь ч хоорондоо муудалцах болов. Байдал хурцдахаас өмнө Абрам Лотод дуртай газраа сонгох сонголтыг нь олгожээ.

Тэд цугтаа дайсагнаж байснаас салсан нь хавьгүй дээр байж. Жич: хэрэв та хамт байх ёсгүй хүмүүстэйгээ амьдралынхаа замыг туулж байгаа бол, Бурхан та хоёрыг салтал чинь үржүүлж өсгөх тохиолдол байдаг ажээ. Дайсагнал нь Бурханы ерөөлийг, амьдралын чинь үр нөлөөг хаадаг.

3. Тэд *итгэлээр үйлдсэн*. Абрам Мелхизедект арван хувиа өргөхдөө, Бурханы амлалтын ачийг ачаар хариулжээ. Тэрбээр Содомоос ирэх мэдээг хүлээж авахын оронд найдвараа зузаатган, итгэлээр өргөсөн байна.

Дээрх гурван зүйл болсны дараа Бурхан Абрамтай уулзан, Эхлэл 17:4-5 дээрх дараах амлалтыг тунхаглажээ:

—Миний хувьд, харагтун, Чамтай байгуулах Миний гэрээ бол: Чи тоо томшгүй олон үндэстний эцэг өвөг болно. Би чамайг олон үндэстний эцэг болгосон учир Үүнээс хойш чамайг Абрам гэж дуудахгүй харин Абрахам гэх болно.

Мөнхийн гэрээ

Чи өөрийгөө өв залгамжлагч гэдгийг мэдэх юм бол, Бурхан чиний нэрийг өөрчилнө. Бурхан Абрамын нэрийг Абрахам болгохдоо, амьдралыг нь тэлсэн юм. Абрахам цаашид үндэс угсаагүй хүн биш, харин олон үндэстний аав болжээ. Эхлэл 17 дээр Бурхан энэ гэрээний хүч, цар хүрээг нарийвчлан хэлсэн. Абрахамын амьдрал үе залгалмжилсан, мөнхийн гэдэг үгсээр бүслэгджээ. Абрахамын гадны хүн болж хөл тавьсан газар нь эцэстээ түүний үр удмын мөнхийн өв болох ажээ. Бурхан Абрамтай байсан шигээ, Абрахамын үр садтай хамт байхаа амласан юм. Абрахам тэр сайхан ирээдүйг бодоод Бурханы оршихуйд уйлсан байх гэж би боддог юм.

Абрахам Бурханы өмнө сөгдсөн байх. Тэгээд дараа нь өндийж босоод, нулимстай нүдээр тэнгэр өөд ширтээ байх. Тэрбээр цөлийн саруул шөнийн хар тэнгэрт гялалзах оддод шүргэх мэт гараа явуулаа байх. Түүний талархлыг хэмжээлэх аргагүй. Амлалтын үг бүр нь яс маханд нь шингээ байх. Нэгээхэн эгшинд

Абрахамыг дарсан насны ачаа нурж, эд эс бүр нь гайхамшгаар амилж, цэл залуужих мэт санагдаа байх.

Абрахам гэдэг шинэ нэр нь зүрхэнд нь баяр хөөр, найдвар цалгиагаа байх. Абрахам Ишмаелыг хараад: “Энэ бүхэн миний хүүгийнх болно. Миний хүүгийн амьдрал дэлгэрч, үржиж, мөнхийн мөнхөд ерөөгдөх нь байна” гэж бодоо байх.

Гэтэл Эзэн Абрахамд энэ гэрээнд “гарын үсгээ” зурах хэрэгтэйг нь хэлжээ. Тэр нь Ноад үзүүлсэн ил гоё тэмдэг биш, харин далд бас их зовиуртай тэмдэг байв. Абрахамын гэрийн бүх эрчүүд хөвч хөндүүлэх хэрэгтэй болжээ. Махан биеийн энэ тасархай нь Абрахам бөгөөд түүний үр сад Дээдийн Дээд Бурхантай гэрээ байгуулсны тэмдэг болов. Тэгтэл үүний дараа Бурхан Абрахамтай маш чухал яриа хийжээ:

Бурхан, Абрахамд — Чиний эхнэр Сарайн хувьд чи түүнийг Сарай гэж дуудахгүй харин түүний нэр Сара байх болно. Би түүнийг ерөөж, түүгээр чамд хүү өгөх болно. Би түүнийг ерөөж, түүгээр үндэстнүүдийг бий болгох бөгөөд үндэстнүүдийн хаад түүнээс гарна гэж айлдав. (Эхлэл 17:15-16)

Би Абрахамын мэл гайхсан царайг бараг л харж байна. Тэрбээр гайхаж балмагдсан царайгаар хөмсгөө зангиралдуулаад ... “Сарааа? Энэ чинь надтай, Хагараас төрсөн миний хүү Ишмаелтай байгуулсан гэрээ биз дээ?” гэсэн байх. Гэрээний энэ шинэ зүйл заалт Абрахамыг нилээд барайлгасан байх.

Тэгэхэд Абрахам нүүрээрээ газар унан инээж — Зуун настай хүнд хүү төрнө гэж үү? Ерэн настай Сара хүүхэд төрүүлнэ гэж үү? гэж зүрхэн дотроо хэлжээ. (Эхлэл 17:17)

Хүүтэй болно гэдэг үгийг сонсоод Сарах эмээ инээсэн талаар бид зөндөө сонссон. Гэхдээ хамгийн түрүүлж инээсэн хүн нь үнэндээ Абрахам өвөө байжээ. Абрахам инээгээд зогсохгүй, Бурханд өөр хувилбар санал болгосон:

Абрахам Бурханд — Ишмаел л Таны өмнө амьдраасай гэж хэлсэн. (Эхлэл 17:18)

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Абрахам Ишмаелыг л төлөвлөгөөндөө багтаачих гэж үзээд байх шиг. “Сарахаас хүүхэд гаргаж, явдал чирэгдэл болоод яахнав дээ? Шинэ нэр авлаа гээд ямар хэвэл, нөхөр хоёр нь залуужчих биш дээ.” Би Абрахамын түмэн шалтгийг ойлгож байна. Гэхдээ Бурхан түүний учир явдлыг огт хүлээж аваагүй юм:

Бурхан — Үгүй ээ, чиний эхнэр Сара чамд хүү төрүүлж өгнө. Чи түүнийг Исаак гэж нэрлэнэ. Би түүнтэй гэрээ байгуулж, түүний үр удамтай энэ гэрээгээ мөнхийн гэрээ болгон байгуулна. (Эхлэл 17:19)

“*Үгүй ээ, чиний гэргий Сара...*” хэмээн маш тодорхой айлджээ. Яг л Абрахамын бодлыг уншсан юм шиг л хэлж. Бодоод үз! Бурхан Абрахамын үгийг хүлээн авч, Ишмаелыг ерөөсөн ч, түүнийг мөнхийн гэрээндээ багтаагаагүй. Хоёр хүн гэрлэлтээр нэг болохдоо, хоёул Бурханы гэрээнд багтдаг. Мэдээж Абрахам Ишмаелд хайртай байсандаа энэ бүх амлалт түүнийх болоосой гэж хүсэх нь гарцаагүй. Гэхдээ Ишмаел нь махан бие, тэмцлийн талбарт хүлэгдсэн боол хүүхний хүүхэд байсан. Өрсөлдөгчгүй амлалт нь хуучны зүйл дээр биш, харин цоо шинэ тэмдэг, гайхамшгаар дамжиж ирнэ. Үргүй, настай эмэгтэй хүүхэд олно гэжээ:

Харин Би гэрээгээ ирэх жилийн өдийд Сарагийн чамд төрүүлж өгөх Исаактай байгуулна гэв. (Эхлэл 17:21)

Бид ийм юм хийдэггүй гэж үү?

Бурхан бидэнд цоо шинэ гайхамшиг үйлдэнэ гэж хэлэх үед, бид өөдөөс нь ингэж явдал чирэгдэл болох хэрэггүй ээ... надад хэдийнээ байгаа юмыг л ерөөчих гэдэг. Гэхдээ бидэнд байгаа, бидний хийж байгаа нь хангалттай өргөн дэлгэр биш юм. Бурхан үүнд чинь оролцохыг хүсч байна. Бурхан ганц чамайг биш, үр удмыг чинь боддог. Энэ гэрээ нь хараахан төрөөгүй байгаа Исаакаар дамжин биелэгдэх ажээ. Абрахамын мах цусны тасархайгаар биш, харин түүний шоолоод өнгөрсөн тэр хүүхдээр!

Би Абрахамын хүнлэг чанарт дуртай. Гэхдээ энэ нь бидний хувьд том сургамж юм. Бурхан нигүүлсэнгүй учраас, бидний өөрийнхөө хүчээр барьж байгуулсан юмсыг ерөөдөг. Гэхдээ мөнхийн гэрээ нь хүний хангамжийн талбарыг давж байгуулагддаг юм.

Шинэ нэр = Шинэ тавилан

Еврей уламжлалаар, хүний нэр нь түүний хүчин чадал, хувь тавиланг тээдэг ажээ. Тиймээс нэр өөрчлөх нь мөн чанар, хувь тавилангаа өөрчилж байгаатай л адил болно. Жишээлбэл, бид үр хүүхдээ ийм тийм хүн болж, ингэж тэгж амьдраарай хэмээн билэгдэж нэр хайрладаг. Би үүнийг Бурхан Ааваасаа сурсан юм. Учир нь би хөвгүүдээ нэрээр нь дуудах бүрийдээ амьдрал дээр нь нэрийнх нь утгыг тунхаглана.

Бурхан хүний төрөлх нэр нь түүний мөн чанарыг цаашид илэрхийлэхгүй гэж үзэх бүртээ нэрийг нь өөрчилсөн байдаг. Хавчигч Саул Паул нэрийг авсан. Загасчин Симоныг Есүс хад буюу Петр гэсэн. Исаакийн хүү Иаков “Бурханы ханхүү” гэсэн утгатай Израиль нэрийг авсан. Бурхан нэр солих дуртай. Энэ нь надад яг л гэрчийг хамгаалах хөтөлбөр шиг санагддаг юм - бид бүгдээрээ Есүсийн нэрийн мөн чанар дороос ажиллах болно.

Бурхан Абрахамтай гэрээ байгуулахдаа, Абрамын нэрийг өөрчилснөөрөө хүчин чадлыг нь өсгөжээ. Надад Мессаиад итгэдэг нэг мундаг рабби найз бий. Түүнийг Бриан Билечи гэдэг. Тэрбээр надад энэ бүх нэрийн өөрчлөлтийн ач холбогдлыг тайлбарлаж өгсөн юм. Бурхан Абрамын нэрийг Абрахам болгохдоо, нэрийг нь дундуур нь таслаад, Өөрийнхөө нэрийн үсгийг нэмж хийжээ. Абрам гэдэг нэр нь “өргөмжлөгдсөн аав” гэсэн утгатай бол, Абрахам гэдэг уртасгасан нэр нь “олны аав” гэсэн утгатай.

Шинэ нэр нь Абрахамыг хэн болохыг тунхаглажээ. Энэ нэрийн утга нь Абрахамыг амьд ахуй цагт биелж дуусашгүй байв. Абрам Бурханыг хүндэтгэдэг байсан учраас, өв залгамжлал нь зах хязгааргүй үржих болно. Нэр хувь тавилантай холбоотой байдгийг бүү мартаарай. Мөн рабби Бриан Абрамын гэргийн нэрийг давхар өөрчлөхөөс нааш Бурханы амлалт биелэхгүй байсныг цохон тэмдэглэсэн юм. Сарай нь “Иехува бол ханхүү” гэсэн утгатай бол, шинэ нэр Сарах нь “Бурханы гүнж” гэсэн утгатай юм. Бурхан мөн л Өөрийнхөө Яахвэх нэрийн “Х” үсгийг түүний нэрэнд нэмжээ.

Сарахын нэрийн өөрчлөлт нь тэрбээр энэ бүх үйл явдал дунд ямар утга агуулга илэрхийлэхийг нь хэлж байгаа юм. Тэрбээр үүгээрээ Бурхантай дотно холбогдож байгаагаас гадна амлалтын бүх охид

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

нь язгууртны байр сууринд очно гэдгийн тунхаг болж байгаа юм. Сарахийн шинэ нэр нь асуудлыг Бурханы гарт даатгажээ.

Сараигийн нэр “Иехувагийн ханхүү” гэдэг эршүүд хэлбэрээсээ “Бурханы гүнж” гэдэг бүсгүйлэг хэлбэрт хөрвөхдөө, утга нь ч, байр суурь нь ч өөрчлөгдсөн юм. Абрахамын шинэ нэр өөртөө үй олныг багтаах хүчин чадалтай болж өссөн бол, тэр амлалтын үрд амлалтын хөрс бас шаардлагатай болно. Харин Сарахын хэвэл нь Абрахамын хөрс буюу амлалтаар амилсан амьдрал болжээ.

Сарахын шинэ нэр нь түүний цөлжсөн хөрсийг хагалж, Абрахам, Сарах хоёрт итгэмжлэгдсэн өсөлт үржилд бэлтгэжээ. Бурхан Абрахамд олон үндэстний эцэг болно, харин Сарах үндэстэн болж, хүмүүсийн хаад түүнээс гарна гэсэн. Бурхан тэдэнд хоёуланд нь төсөөлөл, хараа суулгажээ.

Хүмүүс өөр хоорондоо болон Бурхантай холбогдох үед Бурхан орж ирээд, боломжгүй зүйлийг үйлддэг. Үргүй хэвэл амь орж, хүүхэд төрүүлэх хүчтэй болдог, үхсэн гэрлэлт эдгэрдэг, хөвгүүд охид чөтгөрөөс чөлөөлөгддөг, хүүхдүүд үхлээс амилдаг. Найдвар сэргээгдэж, итгэл дүрэлзэж, хайр ялж, дайсан ухарч, заль мэхийн дуу унтардаг.

Чи үүнийгээ ухаарсан үгүйг мэдэхгүй. Гэхдээ чамайг дахин төрөх үед нэр чинь шинэчлэгдэж, өргөжсөн юм. Абрахамын амлагдсан үр болох Есүс бидний нэрэнд Өөрийнхөө нэрийн үсгийг нэмж, өргөтгөхөөр барахгүй, Өөрийнх нь нэрээр Аавтай шууд орж уулзах хязгааргүй эрхийг олгожээ. Иохан 16:26-27:

Тэр өдөр та нар нэрээр минь гуйх болно. Би та нарын өмнөөс Эцэгээс гуйна гэж байгаа юм биш. Та нар Намайг хайрласан бөгөөд Бурханаас ирсэн гэдэгт итгэсэн тул Эцэг Өөрөө та нарыг хайрладаг.

Есүс загалмай дээр хадуулахдаа нүцгэрч, бидний ичгүүрийг Өөр дээрээ авсан. Тэрбээр Өөрийнхөө бүхий л өө сэвгүй амьдралаа бидэн шиг авахын аргагүй хүмүүсийн төлөө өргөж, төгс тахилаараа бүрэн төгс аварч, амлалтын хөвгүүд, охидод бүгдэд нь боломж завшаан олгов.

“Яг ш дээ!”

Эхлэл 18 дээр Бурхан дахин Абрахамтай уулзсанаар түүх маань үргэлжилж байна. Абрахам майхныхаа үүдэнд сүүдэр бараадан салхилж суугаад өөдөө хартал, өмнө нь Мамрегийн царс модны дэргэд гурван хүн зогсож байхыг үзжээ. Ихэнх эрдэмтэд тэднийг тэнгэрэлч нар байсан гэдэг. Абрахам тэдэн рүү гүйж очоод, мэхийн ёслоод, тухлан саатахыг гуйжээ:

Эзэн минь ээ! Хэрэв мэлмийд тань тааллыг олсон бол зарц намайгаа битгий орхин өнгөрөөрэй гэж би гуйж байна. Жаахан ус авчруулж та нар хөлөө угаагаад энэ модны доор амарна уу? Та нар зарцынхаараа нэгэнт дайрч ирсэн тул би жаахан талх авчиръя, та нар тэнхээ ороод явна уу гэж хэлэв. Тэд —Чиний хэлсэн ёсоор болог гэв. (Эхлэл 18:3-5)

Абрахам замын гийчдийг уриалгахнаар угтаж, хүндэтгэсэн нь надад үнэхээр сайхан санагддаг. Абрахам мэдээж өчүүхэн юм амлаад, бөөн хөл хөөрцөг болдог. Тэрбээр Сарах дээр гүйж очоод, дээдийн дээд гурилаар бин хийхийг үүрэгдэв. Дараа нь малчин дээрээ очоод, хамгийн тарган бяруугаа нядлаж, хоол бэлтгэхийг тушаав. Тэгээд зоогоо ааруул идээтэй барьжээ. Тэрбээр зочдоо гараа гарган дайлав!

Тэгтэл ийм асуудал гарчээ:

“Тэд Абрахамаас —Чиний эхнэр Сара хаана байна вэ? гэж асуусанд —Тэнд майхандаа байгаа гэв.

Тэр —Би зохих цагт нь чам дээр заавал эргэж ирнэ. Харагтун, эхнэр Сара чинь хүүтэй болно гэжээ. Сара ард нь, майхны үүдэнд зогсоод сонсож байв.” (Эхлэл 18:9-10)

Энэ хэсгийг уншихаар, яг л Сархтай хамт байгаа юм шиг санагдаад байдаг юм. Яг л майхан дотроос Сархын ард зогсоод, мөрөн дээгүүр нь гадагшаа шагайх шиг. Абрахам гадаа модны сүүдэрт зочидтойгоо хөөрөлдөнө. Харин тэдний хувцсыг хийсгэх цөлийн халуун салхи яриаг нь ч бас тээсээр, тэр даруй майхан дотор авчрав.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Сарах харанхуй майхны үүдэнд зогсоод, тэдний яриаг алдаг оног сонсоно. Тэрбээр хэнд ч мэдэгдэхгүй сэм байсан ч, юу бодож байсныг нь Бичээс хэлдэг:

Абрахам, Сара хоёр өндөр наслан өтлөж, Сара хүүхэд гаргах наснаасаа хэдийнэ хэтэрчээ. Сара дотроо инээж — Хөгшин би, өглөсөн эзэн бид хоёр яаж ч жаргах юм билээ? гэв.
(Эхлэл 18:11-12)

Абрахамтай адил инээд нь хүрсэн Сарахыг үзээд би... Сарах энэ үгийг анх удаа сонссон юм болов уу гэж боддог юм. Сарах мэдээж итгэлээр үйлдээгүй л дээ. Заримдаа арга мухардах үед л амлалт хаяанд ирчихсэн байдаг.

Эхлэл 17:21 дээр “дараа жилийн өдийд...” гэдэг үг бий. Тогтоосон хугацаа өөрчлөгдсөн болтой. Абрахам, Бурхан хоёрын анхны ярианаас тэнгэрэлч нартай уулзсан энэ уулзалтын хооронд яг хэдий хугацаа өнгөрсөн нь тодорхойгүй боловч, нэг их удаагүй байх. Магадгүй сар хүрээгүй байх. Эзэн энэ яриандаа Сарахыг заавал багтаахаар шулуудсан байж.

ЭЗЭН, Абрахамд

—Юунд Сара инээгээд “Хөгшин болсон би үнэхээр хүүхэдтэй болж чадна гэж үү?” гэж хэлээд байна вэ?

ЭЗЭНд дэндүү хэцүү юм байна уу? Би тогтсон цагт чам дээр эргэж ирнэ. Зохих цагтаа Сара хүүтэй болно гэв.

Сара айсандаа

—Би инээгээгүй гэж мэлзсэнд

—Үгүй, чи инээсэн шүү дээ гэж Тэр хэлэв. (Эхлэл 18:13-15)

Сарах инээгээд зогсохгүй, худлаа ярьсан! Сарах яг ш дээ гэсэндээ л инээсэн ч, баригдахаараа айжээ.

Чиний гэргий Сарах хаа байна?

Өмнөх хэсгийн урдах болон арын ишлэл нь хэлмээр байгаа ч дуугүй өнгөрсөн зүйл хичнээн их байсан бол гэж бодоход хүргэдэг. Би энэ талаар хэдэн зүйл хэлмээр байна. Өмнө нь хэлээгүй өнгөрсөн зүйлээ нөхөж хэлмээр байна гэх үү.

Нэгдүгээрт - “Сарах хаана байна?” гэдэг асуултын талаар ярьмаар байна. Тэр яагаад майхандаа нуугдана вэ? Тэр яагаад нөхрийнхөө дэргэд суугаад, зочидтой ярилцсангүй вэ?

Бид ч яахав, энэ түүхийн төгсгөлийг мэднэ. Гэтэл Сарах тэр үед мэдээгүй байсан шүү дээ. Төдий насалсан тэр эмэгтэй өөрийнхөө амьдралын түүхийг хэдийн дууссан гэж бодож байсан байх. Тэрбээр нөхрийнхөө амрагийн явдал, Хагарын үзээрийн хандлагаас болоод өөрийгөө хэн ч биш болсон гэж бодож байсан байх.

Хүний богинохон амьдралд туулж өнгөрүүлсэн зовлон, хийсэн алдаа, удаа дараалсан гутрал, хатуурхсан хувь тавилан нь хамаг сэтгэл итгэлийг нь ховх соржээ. Уг нь бие давхар болоход тийм их хүч хэрэггүй. Заримдаа хүн санаандгүйгээр ч жирэмсэн болчихдог. Гэтэл Исаакийн ээж, Израиль үндэстний ээж болох гэж байгаа хүн чинь уг нь бэлтгэлтэй байх ёстой байсан.

Сарах арван гурван жил Ишмаел хүү хэрхэн өсч торниж байгааг харжээ. Уг нь тэрбээр Хагарын хүүг өөрийн мэт өсгөхийг санасан ч, хүний хүүхэд хүрэн бөөртэй гэдэг яг л үнэн байж. Абрахам ч яахав, санаа амарчихсан, харин Сарахын эмтэрсэн зүрх улам л үйрсээр байжээ. Амьдрал тэр чигээрээ түүний эсрэг байх шиг. Гэтэл хамгийн эмгэнэлтэй нь энэ бүх зовлон дунд Сарахыг хэн болохыг тэрбээр өөрөө ч, эр нөхөр нь ч таг мартжээ.

Тиймээс “Чиний гэргий Сарах хаа байна?” гэдэг асуулт нь намайг цохиод л авах шиг болдог.

Манайд зочид ирэхээрээ Жоноос: “Чиний гэргий Лиза хаана байна?” гэж асуудаггүй. Заавал гэргий энэ тэргэж тодорхойлох шаардлага байхгүй. Манай гэрт нэгээс олон Лиза байсан бол л тэгж асууна. Жишээлбэл хэрэв манай хөвгүүдийн нэг нь Лиза гэдэг бүсгүйтэй гэрлэчихсэн байсан бол, “Жон, Лиза - чиний гэргий хаана байна?” гэж асууна.

Харин таньж мэддэг хүмүүс маань зүгээр л: “Лиза хаана байна?” гэж асуудаг. Танихгүй хүмүүс бол Жоноос: “Гэргийтэй чинь уулзах гэсэн юм. Хаана байгаа юм бол?” гэж асууна.

Гэтэл тэдгээр тэнгэрийн зочид Абрахамд Сарах бол түүний гэргий гэдгийг сануулах шаардлагатай болжээ. “Та хоёрын нас явж, чи Хагараас хүүтэй болсон ч, Сарах чиний гэргий хэвээрээ л байгаа шүү” гэжээ. Магадгүй тиймээс л Сарах зочидтойгоо ярилцахын оронд холоос сонсож зогссон байх. Хүний бараа харна

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

гэдэг нүүдэлчин хүмүүсийн хувьд хөл хөөрцөг байсан биз. Абрахам майхныхаа үүдэнд сууж байгаад, хүмүүс ирж явааг харуутаа босон харайсан шүү дээ. Библийн түүхүүдийг харах юм бол, зочдыг хөнгөн зоогоор дайлахад хэдхэн л минут болдог байсан бол, мал төхөөрч, хоол хийнэ гэдэг хэдэн цагийн ажил байсан байгаа.

Бурханы амлалтын тухай яриа өрнөж байхад хэн ч зүгээр нэг сонсоод сэтгэл ханахгүй, харин оролцохыг л бодно. Зочид нь ийш тийш хараад: “Энд итгэлийн эцэг нь байх юм, харин эх нь хаачаа юм бол?” гэж хэлсэн байх.

Хэрэв манайд тэнгэрэлч нар зочилж ирээд, Жон тэднийг оройн зоогт урьсан бол, Жон намайг бараг хүчээр хажуудаа байлгах байсан биз. Бид хоёр зочдоо хамтдаа л угтаж, дайлдаг. Жоны зочид бол миний ч зочид. Хэрэв тохиолдлоор би өөр өрөөндөө байж таараад, тэдний хорхой хүргэм яриа чихэнд минь хүрэх юм бол, би бушуухан шиг гүйж ороод л, ярианд нь оролцох байсан.

Тэд Сарахыг гарахыг хүссэн ч юмуу эсвэл Абрахам Сарахыг ярианд бүү оролц гэж хүссэн байх гэж би бодохгүй байна. Би Сарахыг өөрөө л оролцохыг хүсээгүй байх гэж бодож байна. Хүмүүс гутарсандаа өөрийгөө хэн болохыг амархан мартдаг. Найдахаас айдаг. Тиймээс тэд нуугддаг, дараа нь инээдэг, дараа нь худлаа ярьдаг.

Аль нэг шалтгаанаар Сарах гаднаас дотогш шагайдаг болчихсон байсан ч, Бурхан түүнийг буцаагаад дунд нь оруулжээ. Бурхан эхлээд Абрахамд ч, Сарахд ч тэрбээр Абрахамын гэргий хэвээрээ байгааг нь сануулсан. Энэ мэдэгдлээрээ Бурхан Сарахын өрсөлдөгч Хагарыг зайлуулж, улмаар Сарах хэн болохыг бүгдэд сануулжээ. Сарах бол Хааны охин!

Яагаад Абрахамаас асуув?

Миний гайхшралыг төрүүлсэн дараагийн нэг асуудал нь Сарах инээж, Абрахам асуугдсан явдал байв:

ЭЗЭН, Абрахамд —Юунд Сара инээгээд “Хөгшин болсон би үнэхээр хүүхэдтэй болж чадна гэж үү?” гэж хэлээд байна вэ?
(Эхлэл 18:13)

Сарахын үйлдлийн төлөө яагаад Абрахам байцаагдав? Үүнийг

харахаар, Эхлэл 17 дээр өрнөсөн яриа Сарахд хүрээгүй юм шиг санагддаг юм. Магадгүй Абрахам Бурханы хэлсэн үгийг өдий хүртэл эргэцүүлсээр явсан юм болов уу? Тэгээд л Сарахд хэлээгүй байх. Заримдаа Жон, бид хоёр ч бие биедээ ямар нэгэн мэдээллээ хэлэхээ мартчихдаг. Эсвэл Абрахам, Сарах хоёр яриад, амлалтыг тоолгүй өнгөрсөн байх. Ямар ч байсан тэд Сарахаас хүү мэндэлнэ гэдэг амлалтаар амьдраагүй нь тодорхой байна. Тэнгэрэлч нар Абрахамд:

“ЭЗЭНд дэндүү хэцүү юм байна уу? Би тогтсон цагт чам дээр эргэж ирнэ. Зохих цагтаа Сара хүүтэй болно” гэжээ.
(Эхлэл 18:14)

Жилийн дотор Сарах хүүтэй болно. Сарах асуугдаагүй, нөхөр нь асуугдсан байхад, Сарах инээгээгүй хэмээн гүрийж, худлаа ярьсан нь надад хөгжилтэй санагддаг. Гэхдээ Сарахын инээдээрээ халхалсан зүрхнийх нь аниргүй мэгшлийг мөнхийн гэрээтэй Бурхан Аав маань сонссоныг нь би биширдэг.

Итгээгүйдээ инээх болон баярласандаа инээх нь тун өөр юм. Сарахын амьдрал инээхтэй манатай байсан. Гэтэл Исаак энэ бүхнийг нь өөрчлөх байв. Абрахам, Сарах хоёр аяллаа хамтдаа эхлүүлсэн бөгөөд дахин хамтдаа инээхдээ амлалтыг биелэл болгох байв. Амлалтыг амьдруулахын тулд нөхөр эхнэр, ах эгч дүүс, эрчүүд эмэгтэйчүүд хоорондоо ярих ёстой. Эмэгтэйчүүд голдуу л нуугдсаар байдаг. Харин Бурхан чамайг яриандаа оролцуулахыг хүсдэг.

Бурхан амлалтынхаа хүмүүсийг байгуулахын тулд Сарахын хүслэн, гүний гүнээр дутаж байсан. Галат 4:22-23 дээр:

“Абрахам хоёр хүүтэй байсан бөгөөд нэг нь шивэгчнээс, нэг нь эрх чөлөөт эмэгтэйгээс төрсөн гэж бичигдсэн байдаг.



**Бурхан
амлалтынхаа
хүмүүсийг
байгуулахын тулд
Сарахын хүслэн,
гүний гүнээр
дутаж байсан.**

Харин шивэгчний хүү махбодын дагуу төрсөн байтал эрх чөлөөт эмэгтэйн хүү амлалтаар төрсөн” гэжээ.

Сарахыг хэн хамгаалах вэ?

Сарах Исаакийг энгэртээ тэврэхээсээ өмнө дуугүй өнгөрөхийг хүссэн бас нэгэн үйл явдал өрнөсөн байдаг. Үүнд миний ухаан үнэхээр хүрдэггүй ч, энэ удаа Сарахыг чимээгүй байж, худлаа хэлэхэд нь Бурхан хөндлөнгөөс оролцсон байдаг:

Тэр үедээ Абрахам өөрийн эхнэр Сараг миний дүү охин гэж хэлсэн учир Герарын хаан Абимелех хүн илгээж, Сараг авчээ. Гэтэл Бурхан шөнөөр Абимелех дээр зүүдэнд нь хүрч ирээд, түүнд хэлсэн нь — Чи авсан энэ эмэгтэйгээсээ болж үхнэ. Учир нь тэр эмэгтэй бол гэрлэсэн эмэгтэй гэв. (Эхлэл 20:2-3)

Энэ удаа Абрахам ч, Сарах ч амаа үдсэндээ сэтгэл хангалуун байх мэт санагдана. Гэхдээ Бурхан Сарахыг өмгөөлсөнд би баярладаг. Тэд юугаа бодож байсан юм бол оо? Бурхан шинэ зүйл хийж байсан ч, тэд бие биедээ хуучнаараа л хандаж байсан. Тэдний ахан дүүсийн харилцаа олон талаараа буруу байсан ч, энэ удаа бүр хамгийн буруу байв. Бурхан тэдний нэрсийг өөрчилж, Сарах Исаакийг тээж эхлэх байсан.

Сарах хэнийг ч дагууламгүй, гоо эмэгтэй байсан нь тодорхой байна. Гэхдээ тэр чинь ертэй байсан шүү дээ! Магадгүй хачин гоё өтөлсөн ч юмуу эсвэл Бурхан Исаакийг төрүүлэхэд бэлтгэн, Сарахыг огцом залуужуулсан ч юм уу. Ямартаа ч яаж ч бодсон Абрахам жилийн дотор өөрийнх нь хүүг төрүүлэх гэж байгаа гэргийгээ хүнээс өмгөөлж хамгаалмаар. Эс бөгөөс Сарахын хүүхэд хэний хүүхэд болохыг яаж мэдэх билээ? Заримдаа бид дуугүй өнгөрдөг зангаа захирагдах явдал гэж эндүүрдэг ч, энэ нь захирагдаж байгаа явдал биш, үнэндээ худлаа хэлж байгаа явдал юм. Захирагдах явдал нь хэзээ, хэрхэн ярихаа мэддэг. Харин энэ нь тийм явдал огт биш байв.

Абрахам, Сарах хоёр ах дүүс байсан ч, одоо эхнэр нөхөр хоёр болсон. Ямар ч байсан урьд нь энэ харилцаа тодорхойгүй байсан юмаа гэхэд, тэнгэрэлч нарын айлчлалын дараа андуурахын

аргагүй тодорхой болсон шүү дээ. Шинэчлэгдсэн нэрсээ дагаад, Абрахам, Сарах хоёрын харилцаа ч шинэчлэгдэх ёстой байв. Жилийн дараа хүүтэй болно гэдгээ тэд хоёулаа мэдсэн. За яахав, Сарах тавин хувь л итгэсэн байж болно. Гэхдээ ийм байтал тэр хоёр юугаа бодож байсан улс вэ гэж би үнэхээр гайхдаг.

Абимелех, Абрахамыг дуудаж —Чи бидэнд юу хийчихэв ээ?
Би чиний эсрэг ямар нүгэл хийсэн болоод чи намайг болон миний хаант улсыг ийм их нүгэлд унагах гээ вэ? Чи хийх ёсгүй юмыг надад хийлээ гэв. (Эхлэл 20:9)

Абрахам яагаад худлаа хэлэх болсноо тайлбарласны дараа Абимелех хаан Абрахамыг ерөөгөөд, өөрийнхөө нутагт төвхнөхийг урьсан. Харин Абрахам Абимелехийн төлөө залбирч өгөхөд, Бурхан хааны гэр бүлийн бүх эмэгтэйчүүдийнх нь хэвлийг нээсэн юм. Эр нөхөр нь хүртэл өөрийнхөө аюулгүй байдлыг гэргийгээсээ дээр тавьж байхад, Бурхан л Сарахыг хамгаалсан. Бусдын хувьд үнэгүй Сарах Бурханы хувьд эрдэнэ мэт нандин байсан тул, Бурхан хааны зүүдэнд хүртэл Өөрийн биеэр оржээ. Тиймээс аюулгүй байдлынхаа төлөө Бурхандаа найдаж, хамгийн дотно хүмүүс маань ч, тэр бүү хэл эр нөхөр маань ч биднийг хөсөрдүүлж байсан ч, Бурхан амлалтаа амьдралд маань биелүүлнэ гэдэгт итгээрэй.

Чөлөөт эмэгтэй, боол эмэгтэй

1Петр 3:6 дээр “Түүнчлэн Сара Абрахамыг эзэн гэж дуудан, дуулгавартай дагасан юм. Та нар ямар ч аюулаас айхгүйгээр (гэнэтийн үлэмж айдсыг зөвшөөрөх юмуу зовнилд авталгүйгээр) зөвийг үйлдвэл, тэр эмэгтэйн хүүхдүүд болно” гэдэг. Сарах охин төрүүлээгүй ч, Бичээс биднийг түүний охид болж болно гэжээ. Бид үйл хөдлөл, зориггоо айдасд алдахгүй бол, чөлөөт эмэгтэйн амлалтын охид болно.

Сарах бол Бурханыг бөгөөд нөхрийгөө хүндэтгэдэг чөлөөт эмэгтэй байсан. Нөгөө талаас Хагар эзэгтэй Сарахаа үл хүндэтгэдэг, боол эмэгтэй байсан. Хагарын хүү Ишмаел ээжийгээ

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

дууриагаад Исаакийг шоолсон. Тиймээс чөлөөт нь боолоос тусгаарлагдах ёстойг Сарах ойлгожээ. Галат 4:30 дээр “Энэ зарц бүсгүйг хүүтэй нь зайлуул. Зарц бүсгүйн хүү эрх чөлөөт эмэгтэйн хүүтэй хамт өв залгамжлахгүй” гэдэг.

Зарц хүүхний хүүг өв залгамжлалаас хасчээ. Тэр хүү аваасаа бас гэр бүлээсээ салсан. Чөлөөт эмэгтэй, боол эмэгтэй хоёр дундаа нэг нөхөртэй, тус тусдаа нэг, нэг хүүтэй байжээ. Гэхдээ тэд Абрахамтай тэс өөр харилцаатай байсан. Хагар махан бие, боолчлолыг төлөөлж байсан бол, Сарах эрх чөлөө, амлалтыг төлөөлж байсан. Галат 4:22-26 дээр үүнийг дүрсэлдэг:

Абрахам хоёр хүүтэй байсан бөгөөд нэг нь шивэгчнээс, нэг нь эрх чөлөөт эмэгтэйгээс төрсөн гэж бичигдсэн байдаг. Харин шивэгчний хүү махбодын дагуу төрсөн байтал эрх чөлөөт эмэгтэйн хүү амлалтаар төрсөн. Үүнийг үлгэрлэвэл тэр хоёр эмэгтэй нь хоёр гэрээ юм. Нэг нь Синаи уулаас гаралтай. Тэр бол боолчлолд орох хүүхдүүдийг төрүүлэх Хагар байжээ. Эдүгээ Хагар нь Араб дахь Синаи уул бөгөөд одоогийн Иерусалимтай дүйцдэг. Учир нь хүүхдүүдийнхээ хамт тэр боолчлолд байна. Харин дээр оршигч Иерусалим нь эрх чөлөөтэй. Тэр бол бидний эх юм.

Би “энэ бол Сарахын зам юм” гэдэг үгд дуртай. Сарах Христ доторх өтлөшгүй, хагдрашгүй, завхрашгүй гоо үзэсгэлэнгийн дүр дүрслэл юм. Чи энэ амлалтын үр дүнд төрсөн.

Итгэлийн аав Абрахам, түүний гүнж Сарах нь Христ болоод Христийн сүйт бүсгүй - чуулганыг үлгэрлэх жишиг юм. Бид Христийг удаалж, Христээс бүрэн хамааралтай байхаар дуудагдсан. Тэр бидний тэргүүн бөгөөд итгэдэг нь Түүний эзний эрх мэдэл, удирдагчийн эрх мэдэлд захирагдана. Гэхдээ бид айх ёсгүй юм. Тэр бол биднийг бүтээсэн хань нөхөр маань бөгөөд биднийг хайраараа өлгийлдөг.

Нуугдахаа боль!

Хэрэв Бурхан чамд ямар нэгэн хүсэл тэмүүлэл өгсөн бол, тээж, төрүүлэх хүчийг нь өгнө. Харин Бурхан чиний амьдралд айлчлах

үед энэ хүч ирдэг юм. Магадгүй эдгээр хуудас нь яг л Сарахын зочид шиг байж болно. Магадгүй эдгээр үгс нь чамд хэн болохыг чинь сануулахаар байгаа байх.

Гэхдээ Бурхантай хийх шууд яриаг юу ч орлохгүй. Тиймээс чиний хувь тавилангийн тухай асуудал яригдаж байхад, чи шууд оролцох ёстой. Чиний амьдралдаа тээж байгаа зүйл бидэнд хэрэгтэй. Одоо эмэгтэйчүүдийн нуугдах цаг биш. Одоо нэрээ хэлээд “Би энд байна, би энд байна! Би сонсмоор байна!” гэдэг цаг.

Өрсөлдөгчгүй амьдармаар байгаа бол, нуугдахаа больж, ярианд оролц.

Жилийн дотор олон юм болжээ. Сарахын хувьд урьд хожид үзээгүй жил байсан байх. Ялангуяа Бурханы зочдыг хүлээж авсан бол, гайхах юм байхгүй.

Тэгвэл энэ жил чиний амьдралд тийм юм болбол, яах уу? Чи энэ жилийг эхлүүлэхдээ харанхуйд нуугдаад, ганцаараа инээж, худлаа ярьж эхэлсэн бол, төгсгөхдөө амлалт тээсээр үдэж болно.

“Байзаарай, байзаарай!” гэж бодож байгаа бол, би худлаа яриагүй шүү.

“Чи өөрийгөө хэн гэж итгэнэ - яг л тийм байх болно:

Хожимдсон гэвэл хожимдоно.

Залуудсан гэвэл залуудна.

Хөгшидсэн гэвэл хөгшиднө.

Тэнцэхгүй гэвэл тэнцэхгүй.

Алдсан гэвэл алдана.

Хэрэггүй гэвэл хэрэггүй.

Надад мөрөөдөл хэрэггүй гэвэл чамд мөрөөдөл хэрэггүй л болно.”

Хүсэх юм алга гэж битгий худлаа хэлээрэй дээ. Мөрөөдлөө бүү няцаа. Тэгэх юм бол, чи эхлээд инээнэ, дараа нь худлаа хэлж, зүрхнийхээ үүдийг түгжинэ. Зүрхээ дэлгээд, өмнө чинь дэлгээтэй байгаа ид шидийн гайхамшиг руу хөл тавин ор. Миний тэнгэрлэг, гайхамшигтай амьдралаар амьдарна гэдэг юу байдаг юм хэмээн энэ урилгыг шоолж, үл хэрэгсэхийн оронд ямар гайхамшигтай болохыг төсөөлөөд галзуу юм шиг тас тас хөхрөө л дөө! Бид бол

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Үнсгэлжин, харин энэ дэлхий бидний хойд эхийн охид. Үүдэн дээр чинь Ханхүү ирчихээд тогшиж байхад, чи өчигдрийнхөө үнсний төлөө уйлсаар байх уу? Чи Бурханы мөрөөдлийн амьдралаар амьдарч чадна. Чам руу залгаж байхад, чи яагаад утсаа авахгүй байх юмуу өөр хүнээр авахуулах гэж?

Чи юунаас нуугдаав?

Чи ямар мөрөөдлөө шоолж байна? Тас үсэрчихсэн найдвар чинь юу вэ? Итгэхэд дэндүү зовиуртай учраас, худлаа инээдээр нуугаад өнгөрөх гэж оролдоно уу? Сонс! Чи мундагтаа тэнцдэг эсвэл муудаа тэнцдэггүй юм биш. Христ байгаа учраас л чи энэ амлалтад багтаж байгаа юм.

Эсвэл зовлондоо дасаад сүүлдээ бүр өвчнөө ч мэдрэхгүй, нулимс ч гарахгүй, зүгээр л гөлийчихсөн байж болно. Бурхан хөндмөгц, асгартал уйлдаг газар чамд байдаг уу? Хүмүүс хоосорсондоо л найдварыг басамжилж хөхөрдөг юм.

Эсвэл чи зарим юмс Бурханы хувьд ч хүндэднэ, Бурхан ч тус болохоосоо өнгөрсөн хэмээн бодсон Абрахам шиг инээж байна уу?

Чиний амьдралд хайр авчрахад Бурхан дэндүү хожимдсон гэж бодож байна уу? Чиний хувьд Бурхан ч хийж чадахгүй хэмээн найдлага тасарсан зүйл бий юү?

Галат 4:4-7:

Харин цаг нь болоход эмэгтэй хүнээс хуулийн дор төрөх Хүүг Бурхан илгээсэн юм. Энэ нь хуулийн дор байгсдыг золихын тулд юм. Ингэснээр бид үрчлэлийг хүлээн авах юм.

Та нар бол хөвгүүд нь мөн тул, Бурхан Өөрийн Хүүгийн Сүнснийг бидний зүрхэнд илгээсэн байна. Тэр Сүнс “Ааба, Аав аа” гэж дууддаг. Тиймээс чи цаашид зарц биш, харин хүү нь юм. Хэрэв хүү нь юм бол Бурханаар дамжин өв залгамжлагч нь ч бас мөн.

Чи бол хулгайлагдаад байсан ч, Есүс төлөөсийг нь төлж, чөлөөлсөн охин. Тиймээс чиний төлөө Есүсийн үхлээрээ худалдаж авч өгсөн бүрэн дүүрэн байдал дотор амьдрах нь хамгийн эрэлхэг, жавхлантай зүйл шүү. Гагцхүү Бурханы Үгийг түүхэн баримт шиг биш, хайрын захидал шиг уншсан нөхцөлд л, Есүс чамайг юутай болгосныг мэдэх болно. Дараа нь Түүний Үгийг зүрхэндээ тунхаглан багжуул. Харагдахгүй, мэдрэгдэхгүй байж болно.

Гэхдээ Бурхан чамайг хэн гэж хэлнэ - чи яг л тэр хүн юм. Өнөөдөр ч Бурхан чамд шинэ нэр өгч, амлалтаа биелүүлж, Бурханы хүүхэд гэдгийг чинь баталж байна. Чиний амьдралд зориулсан Бурханы тавилан, чиний дээр айлдсан Бурханы үг чиний нөхцөл байдлаас ер хамаарахгүй. Түүний амлалт нь өрсөлдөгчгүй. Тиймээс үүнээсээ бүү нуугд. Гарч очоод тэврээд ав.

Хэлэлцэх асуулт

1. Христ доторх амлалтаар дамжуулан Бурхан яг одоо биднийг Хүүгийнхээ тэнгэрлэг мөн чанарыг хуваалцагч болгохоор урьсан гэдгийг чи мэдэж байсан уу?
2. Амьдралд чинь өгөгдсөн Бурханы амлалтыг биелүүлэхийн тулд салах ёстой эсвэл Бурханы өмнө эдгээлгэх ёстой талбар, харилцаа амьдралд чинь байна уу?
3. Чи нуугдаж байна уу? Тийм бол, юунаас?
4. Бурхан чамайг оролцоосой гэж хүсдэг яриаг чи зөвхөн холоос л сонсдог уу? Яагаад?
5. Ямар үед дуугүй өнгөрөх нь захирагдаж байгаа явдал биш болдог вэ?
6. Чи Бурханы ямар амлалтыг шоолж инээж, худлаа ярьж байна?
7. Амьд, идэвхитэй оролцохын оронд гаднаас нь хараад зогсож байгаа байдлаа өөрчлөхийн тулд яах хэрэгтэй вэ?

4

Өөрийгөө өрөөлтэй хэзээ ч бүү харьцуул!

Харьцуулалт бол баяр хөөрийн хулгайч.

Теодор Рузвельт

Энэ бүлгийг анхааруулга дагалдана шүү!

Би чамд өөрт тохиолдсон нэгэн хөгтэй явдлыг ярьж өгье. Жаахан ичмээр бас инээдтэй явдал. Над шиг тэгж хэсэг зуур хагас галзуурлын байдалд ордог хүн та нарын дунд цөөхөн л байгаасай. Гэхдээ тийм хүн байгаа бол, зүгээр ээ - чи ганцаараа биш шүү. Тэгэхээр, ийм явдал болсон юм.

Тэр өдөр жирийн л эхлэв. Би Колорадогийн 1-ээр сарын жихүүн өвлөөс биеэ хамгаалсандаа унтлагын хувцасныхаа гадуур гэрийнхээ дээлийг чангахан шиг бүсэлж аваад, гал тогоо руугаа орлоо. Жон надаас цаг гаруйн өмнө сэрээд Библиэ уншиж байв. Намайг эспрессо машиныхаа өмнүүр нааш цааш холхих зуур Аустин ажилдаа, Алек сургуульдаа гарахаар зэхнэ. Тэгээд үүд хаагдсаны дараа би буйдан дээрээ тухлаад, хоёр дахь аяга цэврээс цэвэр какао, шанцай, түүхий чихэр цацсан өтгөн кремтэй эспрессогоо тамшаахаар буйдандаа шигдлээ. (Болдогсон бол, бүх найздаа ингэж хийж өгөх юмсан) Өвлийн нар байшингийн араас дөнгөж мандаж байлаа. Би буйдандаа шигдээд, гүн хөх сүүдрийг хөөх ягаан туяаг ажлаа. Өнөөдөр хаашаа ч нисэхгүй. Эрт уулзалт ч

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

байхгүй тул яаран шүршүүрт орох ч хэрэггүй. Өнөөдөр тааваараа дуртай юмаа хийнэ. Би санаа алдаад, товгор хээтэй аягаасаа бага багаар оочиход, халуун кофе хамаг биеийг маань дулаацуулж, цус ч тархи руу маань урсаж байгааг мэдрэв. Төгс эгшин.

Иймээс л би Библиэ барьж аваад, тэр үед хийж байсан судлалаа үргэлжлүүлэх юмуу эсвэл зүгээр л Бурханы сайн сайхны талаар тунгаан бодох хэрэгтэй байсан юм.

Би утсаа унтраах хэрэгтэй байсан юм. Надад итгээрэй... одоо бол би шууд л унтраана. Гэхдээ миний сул тал бас миний хүчтэй тал болдог. Би олон нийтийн сүлжээг найз нөхөдтэйгээ харилцах завшаан гэж үздэг. Шинэ постуудыг гүйлгэж харах нь яг л дотно нөхөдтэйгээ кофе зооглохтой л адил юм. Зөв цаг, зөв газартаа бол бусадтай холбогдох шиг зөв юм байхгүй. Гэхдээ энэ удаа эдгээрийн аль, аль нь биш байжээ. Би гадагшаа гарахаасаа өмнө эхлээд кофетойгоо, дараа нь Ариун Сүнстэйгээ холбогддог нэгэн билээ.

Жагсаалт

Би твиттерээ шалгатал, найзууд маань нэгэн сэдвээр санал бодлоо хуваалцжээ. Миний таньдаг, хайртай - тэр бүү хэл өмгөөлж хамгаалдаг хүмүүс маань нэгэн жагсаалтад нэрсийг нь багтаасны төлөө нэр бүхий нэг эрхэмд учиргүй их талархсан байхыг би харлаа. Тэр нь зүгээр ч нэг жагсаалт биш, харин “амин чухал” ЖАГСААЛТ байв. Тэр жагсаалтад багтах нь миний олон жилийн мөрөөсөл байсан юм.

Тэгэхээр жаахан тайлбарлах хэрэгтэй байх.

Энэ нь жил бүр шинэчлэгддэг жагсаалт л даа. Сүүлийн хэдэн арван жил янз бүрийн байгууллага, хувь хүмүүс нийлж байж энэхүү “шилдгүүдийн жагсаалтыг” гаргадаг болсон юм.

Гэтэл энэ удаа тэр жагсаалтыг байгууллага биш, харин нэг хүн ганцаарчлан гаргажээ. Эмэгтэй хүн... миний таньдаг боловч, сайн мэддэггүй эмэгтэй. Гэхдээ би түүнийг мэддэггүй байлаа гээд, тэр жагсаалтад багтахыг хүсдэггүй гэсэн үг биш юм.

Тэгээд би тэр жагсаалтыг шалгалаа. Хүмүүсийн нэрс нь цагаан толгойн дарааллаар байв. Миний овог “Б” үсгээр эхэлдэг учраас шууд гүйлгэж хараад л, миний нэр дахиад л тэр жагсаалтад багтаагүйг мэдлээ.

Би тэр жагсаалтад ер нь хэзээ ч багтаж үзээгүй л дээ. Гэхдээ энэ удаа миний таньж мэддэг бүх хүн тэр жагсаалтад орчихсон байв. Шавь нар маань ч хүртэл. Миний номыг Испани хэл рүү хөрвүүлсэн хүн ч орсон байлаа.

Энэ нь юун жагсаалт болоод... тэгтлээ сүр бадруулаад байгаа юм бол гэж чи бодож байна уу? Тэгвэл би хэлье.

Тэр жагсаалт нь Америкийн шилдэг эмэгтэй үйлчлэгч нарын жагсаалт юм.

Зүрх минь дэлдэж эхлэв. Миний толгойд шалинээдтэй, харьцуулалт, асуултууд гүйлдэж байлаа. Би яахаараа байдаггүй билээ?

Би хангалттай сайн блог бичээгүй юм болов уу?

Миний толгой дотор дайн болж байлаа.

Сая гаруй ном борлуулж, хорин жил шахуу аялж, эмэгтэйчүүдэд үйлчилсэн би гэдэг хүн яагаад тэр жагсаалтад багтдаггүй билээ?

Би сайн найз. Би нөхөртэйгээ гучин жил ханилж, дөрвөн хүү өсгөсөн, бие биедээ хайртай, сайхан гэр бүлтэй хүн.

Би жагсаалтын арын тайлбарыг уншлаа. Жагсаалтыг гаргасан эмэгтэй энэ жагсаалтад орох ёстой боловч, орхигдсон хүмүүс байж болзошгүй тул, хүлцэл өчин хоосон зай үлдээсэн байлаа.

Би гүйлгэж харлаа.

Өөрийнхөө нэрийг нэмчихбэл буруудах уу?

Би үнэнгээсээ ярьж байна уу? Мэдээж буруудна!

Эсвэл туслахаараа нэрээ нэмүүлчихдэг ч юм уу? Би одоо өөрийгөө арван жилийн охин шиг галзуурч эхэлж байгааг мэдээд, нөхрөө хайж олохоор бослоо.

Тэгээд нөхрийнхөө ажлын өрөөнд унтлагынхаа хувцасны хормойг хийсгэсээр дайрч ороод: “Жон, би дахиад л нөгөө жагсаалтад багтсангүй” гэж ирээд л уйлагналаа.

Библиэ уншиж байсан нөхөр маань намайг шилэн дээгүүрээ духаараа хараад, юун тухай яриад байгааг гайхав. Жон тэр жагсаалтын талаар юу ч мэдэхгүй байлаа. Тэгээд би гараа хаялж байгаад л юун жагсаалт болохыг нь тайлбарлаж гарав. Жон хөдөлсөнгүй. Би тэр жагсаалтад хэн хэн багтсаныг хэлээд, өөрийгөө тэнд багтаагүйд гомдоллов. Жон суудлаасаа ч хөдөлсөнгүй. Тэр гартаа өнгийн фломастераа барьсан чигээрээ хөмсгөө өргөлөө. Миний жүжиг дууссаны дараа Жон надад тун

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

тайвнаар хэд хэдэн Библийн ишлэл уншихыг санал болгов.

Би түүнээс ийм хариу хүсээгүй! Би Жоныг: “Өө, Лиза ямар муухай юм бэ? Энэ үнэхээр муухай алдаа байна. Миний утсыг аваад ир. Би чиний нэрийг оруулъя” гэж хэлээсэй гэж хүссэн ч, Жон тэгсэнгүй.

Тэгэхээр нь би: “Би тэр ишлэлийг унших шаадлагагүй. Би цээжээрээ мэднэ! Би чамаас ийм үг сонсмооргүй байна! Чи намайг ойлгохгүй байна уу? Би тавь гарчихаад одоо хүртэл тэр жагсаалтад орохгүй байна!” гэв.

Жон надаас: “Тэр жагсаалтыг хэн гаргадаг юм?” гэж асуулаа. Би нэрийг нь хэлтэл, Жон таньсангүй.

- “Чи тэр эмэгтэйг мэддэг юм уу?”

Би ч толгой сэгсэрлээ. Жон удаанаар толгой дохиод, Библиэ дахиж харснаа, түрүүний хэлсэн ишлэлүүд дээр өөр нэгийг нэмж уншихыг санал болгов.

Би тэр хүнээс ямар ч тайтгарал олохгүйгээ ойлгомгоцсоо: “Би буруугаа ойлгох гэж тэр ишлэлийг чинь уншихгүй, за!” гэсээр Жоны өрөөнөөс шуургалан гарлаа. Би буруугаа мэдэж байлаа. Гэхдээ би буруу байлаа гээд, энэ жагсаалт зөв болохгүй шүү дээ!

Би эмэгтэй хүнтэй ярихаар шийдэв. Тэгээд гомдлоо дахиж нөхөртөө сонсохгүйн тулд тэг градусын хүйтэнд унтлагынхаа хувцастай тагтан дээрээ гүйж гарлаа. Гэхдээ би ядаж намайг худлаа тайтгаруулах биш, үнэнийг хэлчих хүн рүү залгасан нь ямай. Тэгээд би: “Би буруу гэдгээ мэдэж байна л даа...” гэж байгаад л хамаг явдлаа дахиад л тоочиж гарав.

Тэгтэл найз маань: “Миний нэр байна уу?” гэлээ.

- “Мэдээж байгаа. Надаас бусад нь бүгд байгаа!”

- “Тэр жагсаалт ер нь хэнд хамаатай юм б дээ?”

Би ч урдаас нь: “Чи тэнд байгаа юм чинь мэдээж чамд хамаагүй. Гэхдээ надад хамаатай” гэж ирээд л дайрлаа. Тэгээд дараа нь: “Би буруу гэдгээ мэдэж байна. Гэхдээ зүгээр л багтарсан сэтгэлээ хүнд нээмээр байна. Жон надад Библийн ишлэл унш гэж хэлсэн” гэлээ.

Нам гүм.

Заримдаа өөрийгөө хажуунаас харахаар, галзуу эмэгтэй шиг л харагддаг. Би тэр үед яг л тэгсэн юм.

Би яг л тэгсэн. Тэгээд ярих тусам, улам л хөгийн авирлаж байлаа. Би шал дэмий эхлүүлсэн тэр яриагаа бушуухан шиг дуусгах

хэрэгтэй байв. Тэгээд ингэж хэллээ: “Би чамаас зөвлөгөө сонсох гэж л залгасан юм. Би энэ явдлыг мартмаар байна. Мартах ёстой!”

Найз маань ч намайг буруу гэдэгтэй бүх зүрхээрээ санал нийлээд, яриагаа дуусгав.

Би яавал зөв болохыг мэдэж байлаа. Нөхөр маань ч мэдэж байсан. Найз маань ч мэдэж байсан. Гэхдээ л энэ бүхэн шал буруу санагдсаар л байв.

Тэр би жагсаалтад, тэр жагсаалтын эзэнд үнэхээр уур хүрч байлаа. Яахаараа ийм хачин жагсаалт гаргадаг байна аа? Тэгээд ч дахиад сайн харах юм бол, тэр жагсаалтад багтаагүй өөр олон хүн байв... Ер нь би энэ жагсаалтыг гаргадаг ч юм билүү? Тэгвэл бүгдийг нь багтаачих байв! Ер нь ч би тэр жагсаалтын зохиогчоос хавьгүй олон твиттер, фэйсбүүкийн найзтай юм чинь. Ер нь тэр хэн болоод энэ жагсаалтыг гаргадаг билээ? Ийнхүү арваад секунд бодсоны эцэст би ийм юм хийхгүйгээ ойлгов!

Би жагсаалт гаргах гэж оролдсон ч, заавал хэн нэгнийг үлдээх л байсан. Тэгээд тэд надаас болж над шиг галзуурбал яана? (Гэхдээ хэн ч байсан, над шиг хагас цаг галзуурах байсан нь юу л бол)

Би утсаа тавьлаа. Нүдээ аниад, гүнзгий амьсгалаад, мартахаар шийдлээ. Тэгээд амьсгаагаа гаргахад Ариун Сүнс: “Лиза, чи яагаад өөрийнхөө нэрийг багтаагаагүй энэ жагсаалтаас болж уурлана вэ? Энэ жагсаалтад чиний нэр байсан бол, чи үүнийг хүчингүй, худлаа жагсаалт гэж хэлэх байсан уу?” гэх нь тэр.

Үнэнтэй нүүрэлдэх цаг. Мэдээж багтсан бол би тэгэхгүй байсан. Би өөрийнхөө мэдэхгүй тэр эмэгтэйд олон нийтийн сүлжээгээрээ талархаад, магадгүй жагсаалтад багтсан бусад руугаа ретвиит хийх байсан биз.

Би ч хэлэх үггүй болов.

Тийм ээ, би нэг нөхрийн эхнэр, дөрвөн залуугийн ээж бас ач нарынхаа эмээ мөн боловч, харьцуулалтын харгис нөхцөлд сөхөрч, өөрийгөө хэн болохыг мартдаг өчүүхэн л хүмүүн. Тиймээс тэр жагсаалтын ачаар би өөрийгөө хаана явааг мэдсэн учраас, тэр нь миний хувьд бараг л бэлэг байсан юм.

Бид хүмүүст таалагдах гэж бусдыг царайчлахдаа, яг л гадна зогсоод дотогшоо шагайж байгаа хүн шиг болдог. Үнэнийг хэлэхэд, энэ дэлхий дээр чамайг төгс хангаж чадах нэг ч хүн байхгүй (Уучлаарай, төгс нөхөр чинь ч хангаж чадахгүй). Эсвэл

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

амьдралын ямар ч том ололт амжилт, жагсаалт, шагнал нь Бурханы өгдөг баталгааг чамд өгч чадахгүй.

*Хайрлагдсан, үзэсгэлэнтэй, үнэ цэнэтэй, дотно танил...
Минийх.*

Баяр хөөрийн хулгайч

Юмс гаднаа яаж ч харагдаж байсан, эмэгтэй хүний зүрх яагаад зарим юманд чичирдгийг бас сэтгэлээ тайтгаруулахаа умаргаж, харьцуулалтад баяр хөөрөө алдсан, унтлагын хувцастай галзуу эмэгтэйг яаж тайвшуурлахыг Бурхан ганцаараа л мэднэ. Өрсөлдөөн чиний хүчийг сордгийг би баталгаатай хэлж чадна. Теодор Рузвельт гуайн хэлснээр “Харьцуулалт бол баяр хөөрийн хулгайч.”

Өрсөлдөөн чиний хүчийг сордгийг би баталгаатай хэлж чадна.

Тэр өглөө би ч бас тэр хулгайг гэрчлэн харсан юм. Уг нь би өөрийгөө ингэх хүн чинээ хэзээ ч бодоогүй. Үнэндээ ийм ааш гаргалгүй олон жил болсон! Гэтэл тэр өглөө сэтгэлээ хайхрамжгүй орхисон явдал, цэвэршилт хоёр маань намайг улайтгажээ. Амьдралын маань зарим эх үүсвэр бохирдож, зүрхний маань цэцэрлэгт хүрээлэнд арчилгаа дутсан болтой. Хэрэгтэй хэрэггүй сөрдийсөн мөчрүүдийг нэжгээд сайн тайрах шаардлагатай болсон болтой.

Харьцуулалт нь татуургатай байдаг. Чи өөрөө зөвшөөрөх аваас, энэ нь чиний яг голоос угз татна. Харьцуулалт нь чамайг бардамналын хорон унаанд чихэж суулгана эсвэл айдсаар хүчирхийлэн доош дарна. Аль нь ч байсан чи тун удахгүй гадаа зогсоод, дотогшоо шагайх мэт болно.

Хэн нэгнийг зориудаар шоовдорлохыг би тэвчихгүй. Гэхдээ заримдаа бид гадуурхагдсан мэт санагдах үедээ л гаднаас дотогшоо шагадаг. Би тэр жагсаалтыг гаргасан эмэгтэйн талаар ярья. Тэр бол хурц ухаантай, ухаалаг залуу эмэгтэй. Би түүний хандлагатай санал нийлсэн ч, нийлээгүй ч, ямар ч байсан тэр

жагсаалт миний байдлыг илчилж өгсөнд үнэхээр талархана.

Дараа нь би өөрийнхөө маш тэвчээртэй нэгэн найзыг мессежээр бөмбөгдлөө. Тэр маань намайг галзуурчихаагүй байгаа л гэж бодсон байх. Тэгээд ариун нөхрийнхөө өрөөнд дахин нэг ороод, түүнийг нэг сайн тэвэрчихээд, дараа нь гэрийнхээ шаахайтайгаа унтлагынхаа өрөөнд ороод, хаалгаа хаан, сөгдөөд залбирав:

*Тэнгэрийн Аав аа, Миний өө сэвийг ил болгосонд баярлалаа.
Намайг өршөөгөөрэй. Энэ хогийн ургамлын үндсийг
илчлээрэй. Есүсийн нэрээр. Амень.*

Тэгээд л амьдрал минь үргэлжлэв. Одоо өөрийнхөө ганц цагийн галзуурлыг бодохоор инээд хүрдэг юм. Энэ явдлын дараа би туслахтайгаа уулзаад, цахим шуудангаа шалгатал, маш сонин захидал ирсэн байлаа. Тэнд бидний хэдэн цөөхөн эмэгтэйг нэгэн эмэгтэйчүүдийн цуглаанд хүндэт зочноор урьжээ. Тэгээд зохион байгуулагч нар нь биднийг дуурайлгаж 12 ширхэг хүүхэлдэй хийсэн байв. Харин миний хүүхэлдэйг Жоны албан өрөөг чимэхээр, түүн рүү илгээжээ. Тэгээд би хүүхэлдэйгээ хүлээн авахдаа “Би тайзан дээр хэзээ ч цагаан жийнс өмсдөггүй ш дээ” гэж бодоод, чангаар хөхөрсөн юм. Дараа нь хүүхэлдэйгээ хажуу тийш тавьтал, нөгөө танил хоолой: “Чамайг хүүхэлдэй болгожээ. Одоо сэтгэл амрав уу?” гэж хэлсэн юм.

Би өөрийнхөө цагаан жийнстэй, хуванцар дүрийг хараад толгой сэгсэрлээ. Тэр хүүхэлдэй яг л мөнөөх жагсаалт шиг хуурамч байв. Би дахиад л инээлээ. Би тэр хүүхэлдэйг хаях гэсэн боловч, нөхөр маань тэр хүүхэлдэйг над руу биш, түүн рүү илгээснийг сануулаад, хураагаад авчихсан юм. Нөхөр маань цаашдаа намайг дахиж галзуурбал, санамж болгож байх гэж хүүхэлдэйг маань хадгалсан байх.

Гурван зарчим

Тэгэхээр, нөгөө Жоны санал болгосон - миний цээжээрээ мэднэ хэмээн онгирсон Бичээс юу байв? Эхнийх нь 2Коринт 10:12 юм:

Учир нь бид өөрсдийгөө магтдаг хүмүүсийн тоонд орохыг, тэдэнтэй өөрсдийгөө харьцуулахыг (юмуу ангилахыг) эс зүрхэлнэ. Тэд өөрсдөө өөрсдийгөө хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг нь ухаангүй аж.

Надаас сур! Өөрийгөө магтаж, харьцуулах юм бол, дэмий шүү! Яагаад? Харьцуулалт нь чамайг доош хийж байсан ч, энэ нь бардам үйлдэл юм. Харин бардамнал нь сүйрлийн өмнө явдаг. Энэ гурван үйлдэл нь биднийг маш аюултай - заримдаа бүр аймшигтай байдалд оруулдаг.

Ангилбал юу болох вэ?

Цэцэн хүмүүс ангилдаг ч үгүй, ангилуулдаг ч үгүй. Хүмүүсийг ангилах нь сайн зүйл биш. Ангилах гэдэг нь аль нэг газарт тавих юмуу аль нэг ангилалд багтаах явдал юм. Ангилахыг өөрөөр

үнэлэх, төвшин тогтоох, нэрлэх, бүлэгжүүлэх, зэрэглэх, нэр ус өгөх гэж болно. Нэр хочийг Мириам Вебстерын тайлбар тольд “Жинхэнэ ээдрээг тусган харуулж чаддаггүй, нарийн ангиллыг дүрсэлдэг үг” гэжээ.


**Өөрийгөө
магтаж,
харьцуулах юм
бол, дэмий шүү!**

Амьдрал дээр нарийн ангилал гэж байдаггүй. Амьдрал замбараагүй байдаг. Үнэндээ хүний амьдрал харагдаж байгаагаасаа хавьгүй төвөгтэй байдаг. Эрүүл ухаантай хэн ч өөрийгөө элдвээр хочлуулаад байхыг хүсэхгүй. Олон нийтийн сүлжээ бидний буруу шүүлт, үзэл бодлыг хязгаарлах юмуу дэвэргэх бас нэг боломж болдог.

Энэ үеийхэн бид өөрөөсөө: “Би эцсийн эцэст байшингийн ямар хэсэг байхыг хүсч байна?” гэж байнга асуух хэрэгтэй. Би зэрэглэгдэж, үнэлэгдэж, бусадтай архивлагдахыг хүсч байна уу? Тэр жагсаалт нь нийтлэг байдлыг хөхүүлэн дэмжих гэсэн оролдлого юм. Тэр эмэгтэйчүүд зорьсон газраа хүрсэн! Тэр жагсаалт нь хэний ч ойшоодоггүй байсан зүйлийг буюу эмэгтэйчүүдийн үйлчлэлийг үнэлэх гэсэн оролдлого байв.

Гэхдээ хэрэв бид ангилагдахыг хүсбэл, өөртөө ханасны шинж

юм болов уу. Олон жилийн өмнө нэгэн ухаант настан нөхөрт маань: “Хүмүүсээр бүү шошголуул. Тэд чамайг шошголоод эхэлбэл, алсдаа чамайг тэнцүүлэхгүй гэж тэр шошгоо байнга ашиглана” гэж хэлсэн юм.

Олон хүмүүс үүнийг бодолцдоггүй. Тиймээс муухай хандуулж, гадуурхагдаж үзсэн хүмүүс эргээд бусдыг дуртайяа хочилдог.

Харьцуулбал юу болох вэ?

Харьцуулалт тэднийг тэнгэрт тултал өргөж байсан ч, зоригтой хүмүүс ер нь бол харьцуулдаггүй. Тэд өмнө нь олон шат байгааг мэднэ. Тэд өнө мөнхийг амталж үзсэн учраас, газрын юунд ч хорогддоггүй. Тэд ирээдүйгээс даллах сүр жавхлант зүйлст “шунах” алсын хараандаа хөтлүүлдэг. Харин цаана нь илүү их зүйл байгаа гэдэгт итгэх зориг зүрхгүй, хулчгар хүмүүс харьцуулалт дотор үүрээ засдаг.

Бид ямар ууланд авирч байна? Алдар нэр үү? Тэгвэл энэ чинь өнө мөнхийн дэргэд дов толгод л юм. Эсвэл Бичээсийн дагуу үзбэл, Филиппой 3:8 дээр үүнийг овоолсон нохойн баас гэдэг. Баасан дээр гишгэх дуртай хүн байхгүй. Баасыг хүмүүс тойрч л явдаг. Гэтэл олон хүн баасан дээр гишгэсэн балиар мөрөө хаа сайгүй тарьсаар явна. Бүр үнэр танарт нь ч дасчихсан. Гэхдээ баасны үнэр ямар л олигтой байх билээ? Филиппой 3:7-9:

Гэвч миний хувьд ололт байсан болгоныг би Христийн төлөө хохирол болгон тооцов. Тэр ч байтугай, би Христ Есүс Эзэнээ танин мэдэхүйн хосгүй давуу талын төлөө бүх юмсыг хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд бөгөөд Хуулиас гардаг өөрийнхөө зөвт байдалтай биш, харин Христэд итгэснээр ирдэг, итгэлд суурилсан Бурханы зөвт байдалтайгаар Түүнд би олдохын тулд юм.

Есүсийг Эзэн гэдгийг мэдэх нь хамгийн том завшаан юм. Гэтэл би Түүнийг таньж мэдэхийн оронд утсаа барьж авахдаа, муу сонголт хийжээ.

Хүнд танигдаж байхаар Бурханыг таньж мэдэх нь хавьгүй дээр буюу.

Өөрийгөө магтбал юу болох вэ?

Тэгвэл өөрийгөө магтбал юу болох вэ? “Өөрийнхөө” гавьяаг хааяа хааяа үнэлэх юу нь буруу гэж? Тийм ээ, өсөлтөө тэмдэглэж, баярлах цаг байлгүй яахав. Гэхдээ үүнээсээ болж бид Бурханаас үнэгүй авсан зүйлээ өөрийнхөө ололт амжилт мэт тооцоход хүрдэг. Үр жимс ургадаг бол, бэлэг нь зүгээр л өгөгддөг бөгөөд бэлэг нь биднийг гагцхүү итгэмжтэй нярав байлгахын тулд л даалгагдсан юм.

Зарим хүн ер бусын хөөрхөн, баян - бараг л алтан цээж, мөнгөн бөгстэй төрдөг. Ийм хүмүүс тун ховор. Ихэнх нь тэс өөр нөхцөлд төрдөг. Тэд ямар ч танил талгүй, ядуу зүдүү гэр бүлд төрж өсдөг. Хүний харц булаамгүй зүс царайтай хүмүүс ч олон бий. Дийлэнх нь гол хавиар нь л татдаг. Гэхдээ эдгээр хүчин зүйлсийн аль нь ч чиний түүхийг бичихгүй, чиний үнэ цэнэд нөлөөлөхгүй. Бурхан хүний гадаад төрхийг хардаггүй... зүрхийг нь хардаг. Энэ үеийн баялаг далавчаа дэвсээр, ирэх үеийнхнийг орхичихож мэднэ.

Мэдээж энэ шударга биш. Гэхдээ Бурхан шударга гэдгийг би мэднэ. Бурхан хүн бүрийн бэрхшээл, давуу талыг мутраараа жинлэхээ мэднэ. Шударга ёсны жинлүүр Түүнд л бий. Тиймээс л бид харьцуулж болохгүй юм. Учир нь газар дээр жинлэгдэж байгаа бүхэнд маш бодитой мөнхийн тал бий.

Энэ амьдралд бид буланд шахуулахдаа, Бурханы биш, харин хүний хүндэтгэдэг юмсыг үлгэрлэн дагаж, явцдаа ямар ч шаардлагагүй өрсөлдөөнд орчихсон тууж явдаг. 2Коринт 10:12-ын хоёрдугаар хэсгийг тайлж уншъя:

Учир нь бид өөрсдийгөө магтдаг хүмүүсийн тоонд орохыг, тэдэнтэй өөрсдийгөө харьцуулахыг эс зүрхэлнэ. Тэд өөрсдөө өөрсдийгөө хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг нь ухаангүй аж.

Би яг ингэснийг чи мэдэж байгаа. Бид бараг бүгдээрээ л ингэж үзсэн байх. Бид бүгдээрээ хэмжиж, харьцуулдаг. Бид маш мунхгаар өөрийгөө бусадтай жишиж, түүгээрээ Бурханы бидэнд хадгалсан зүйлсийг жижигрүүлдэг.

Үзэгдлийн нэг үзүүрийг бардамнал, нөгөө үзүүрийг нь өөртөө итгэлгүй зан эзэлдэг. Аль аль нь эрс тэс бөгөөд аюултай. Бидэнд нэг л жинхэнэ хэмжүүр байгаа. Тэр нь бидний тослогдсон хаадын

Хаан, хэмжээлшгүй Христ юм. Тэрбээр ганцаараа ариун бөгөөд, цэвэр, хүчирхэг. Бид бол шоргоолж иддэг амьтныг өөрөөсөө айж байна гээд бодчихсон, тэнэг шоргоолж юм. Гэтэл тэр шоргоолж иддэг амьтан сүүдэрт амарч хэвтэх арслангаас айжээ. Дэлхийн юмс хичнээн хүчирхэг, магтууштай байсан ч, биднийг бүтээсэн Нэгэний дэргэд юу ч биш юм.

Миний унших хэрэгтэй байсан өөр нэгэн Бичээс нь Иохан 5:44 юм:

Та нар цорын ганц Бурханаас алдрыг хайдаггүй атлаа бие биенээсээ алдрыг хүлээн авдаг. Тийм байж яаж итгэж чадах юм бэ?

Бид өрсөлдөгчгүй Бурханы оршихуй руу дуудагдсан атлаа яагаад бусадтай өрсөлдөж, цаг алдах гэж?

Би хүмүүсээр амьдралаа шийдүүлэх бүрийдээ, Тэнгэрийн Аавтайгаа тогтоосон харилцаагаа алдаж буйгаа мэддэг. Тэгээд миний хараа алдагдаж, би өөрийгөө Бурханы хэлснээр биш, бусдын хэлснээр тодорхойлж эхэлээ. Заримдаа би өөрийгөө мунхаг үйлдэл, хязгаалагдмал ойлголтоороо өөрийн мэдэлгүй хичнээн балаг тарьдаг бол гэж боддог юм.

Чи миний тэр өглөөний хөгийг шоолж болно. Гэхдээ өөрөө хөгөө чирэхгүйн тулд сургамж аваарай даа. Ганц удаа биш, өдөр бүр, байнга тийм явдал болдог бол, ямар хэцүү байх уу? Гэхдээ намайг мунхаглах үед минь сэнхрүүлээд өгдөг нөхөр, найзуудынхаа ачаар л би байнга тийм алдаа гаргаад байдаггүй юм.

Хазаж, залгих

Олон нийтийн сүлжээ нь өөрийнхөө амьдралд шаардлагагүй хүмүүс, дуу хоолойг урих бас нэг зам юм. Олон нийтийн сүлжээ ашигтай зүйл. Гэхдээ бас маш олон нөхөрсөг бус хөршүүдийг авчирна. Тэднийг хайрлах хэцүү байвал, хил хязгаараа тогтоох хэрэгтэй. Чамайг үзэн яддаг хүнд яг адилхан хариу бариад байлгүй, харин өндөр жишиг тогтоо. Нигүүсэл дор амьдарлаа гээд бусадтай бүдүүлэг харилцаж болно гэсэн үг биш юм. Паул чамайг өөрийгөө хөрштэйгээ харьцуулаад, ямагт урд нь гарч алхаарай гэж хэлээгүй.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Харин “Учир нь хууль бүхэлдээ нэг үгэнд л багтдаг юм. Энэ нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн нь мөн. Хэрэв та нар нэг нэгнээ зуудаг, цөлмөдөг бол та нар бие биенээ хөнөөх вий гэж болгоомжлогтун” (Галат 5:14-15) гэж хэлсэн. Энд тийм ч сайхан дүр зураг харагдахгүй байна. Христэд итгэдэг бидний хувьд бие биеэ идэж дуустлаа араатан шиг цуслах нь байж болшгүй зүйл юм. Гэтэл бидний цахим ертөнц дэхь үгэн дайн яг л ийм байдаг. Хэдийгээр чиний утас, цахим хуудас дээр шууд харагддаггүй ч, сүнс дотор бол цусан аллага өрнөдөг. Урьд нь хүмүүс ийм амархан хоорондоо холбогдож байгаагүй. Гэтэл өдгөө нүд ирмэхийн зуур л бие биеэ хазаж, залгидаг болжээ. Би ч бас үүнд оролцож явсан учраас, үүнийг мэднэ.

Миний архирч хаздаг зүйл нь голдуу миний сул талыг илчилдэг. Хэрэв хүн миний эмзэг талыг хөндөх юм бол, би шууд л шархаа хамгаална. Тэгээд алсныхаа дараа би утсаа яг л цэнэгтэй буюугаа тавьж байгаа юм шиг тавьчихаад л яваад өгдөг. Магадгүй таагүй өдрөө бид ийм аллага үйлдэх нь олонтаа.

Бусдыг сэргээх ба атаархал төрүүлэх нь том ялгаатай. Яг л нэг хэсгийг нь албаар урьчихаад, нөгөө хэсгийг нь албаар үлдээхтэй л адил юм. Хэрэв чиний олон нийтийн сүлжээгээр дагадаг хүн чинь чиний хамаг л муу муухайг хөдөлгөж байвал, тэднийг яллахын оронд гэдрэг ухраад өөрөөсөө: “Яагаад?” гэж асуубал дээр.

Дайсны хорлолыг Бурханы сайн руу хувиргаж сурах хүртэл чинь өрсөлдөөн чамайг дээрэмдсээр л байна. Бичээс өрсөлдөөнийг ингэж дүрсэлжээ:

Харин махбодын үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар тачаал, садарлал, шүтээн шүтлэг, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, харгалдаан, хагарал, тэрс үзэл, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулья. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй. (Галат 5:19-21)

Энэ үгийг уншихаар уйлмаар байдаг юм. Паулын бичсэн эдгээр зүйлсийн хичнээн нь өдгөө газар аваад байгаа билээ. Би дэлхийг гоочлох гээгүй. Галат бол чуулганд бичсэн захидал. Мессеж Библи дээр хүмүүсийг нэр нүүргүй болтол нь өрсөлдөөнд тухирдаг гэдэг. Энэ юу

гэсэн үг вэ? Энэ нь хүнийг хувь хүн биш болгодог гэсэн үг юм. Хувийн мөн чанар, хувь чанаргүй болгодог. Нацистууд эхлээд Еврейчүүдийг хүний тоонд оруулахаа больсон бол, эцэстээ өөрсдөөсөө бусдыг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн... хувь хүн гэж үзэхээ больсон юм. Тэд хүмүүсийг тэдний Ари дүр төрхийг тусгадаггүй, маш том асуудал гэж үзжээ. Гэтэл өнөөдөр яг энэ тактик хэрэгжиж байна.

Хүмүүс бие биеэ маш амархан шүүж, ялгаварлаж, хочилдог. Хүмүүс чинь зүрх сэтгэлтэй учраас цахим үгд ч шархалдаг. Яг л Асопын хэлсэн шиг “Алсаас аймшиггүй зоригтой байх ч амархан л даа.” Олон нийтийн сүлжээ “аюулгүй орон зай” гээчийг бүтээдэг. Энэ нь нэр нүүргүй болгосон хүмүүсээ дээрэлхэж, гүтгэх зорилготой хулчгар, шүүмжлэлийг улам л дэвэргэдэг. Тэд үүнийгээ хэзээ ч нүүрэн дээр нь хэлж чадахгүй. Яагаад? Яагаад гэвэл нүдэндээ нулимстай хүнд робот шиг хандаж чадахгүй. Христэд итгэгчид бие биеэ буруу номтноос авахуулаад гичий, янхнаар нь дуудаж байхыг би харсан. Харин Сатан шоолж хөхөрсөөр. Бид Сатаны өмнөөс хамаг ажлыг нь хийгээд өгч байна шүү дээ.

Яаж зэмлэж, засах вэ?

“Гэхдээ буруу байгаа хүмүүсийг олон нийтийн дунд засах ёсгүй гэж үү?” Тэгвэл Бурхан үүнийг шийдэх маш сайхан апп гаргажээ:

Далдлагдсан хайраас ил зэмлэл дээр.

Андын чинь учруулсан шарх сайныг.

Дайсны чинь үнсэлт заль мэхийг. (Сургаалт үгс 27:5-6)

Ил зэмлэ гэдэг нь яа гэсэн үг бэ? Ил буюу нээлттэй гэдэг нь гол түлхүүр үг шүү. Нээлттэй зүрх, тэвэр, царайгаар хэл гэсэн үг. Бид яаж засуулахыг хүсдэг билээ - яг тэр янзаараа бусдыг зас. Үнэндээ би намайг хамгийн сайн сайхан болгож чадах хүмүүсээр л зэмлүүлэхийг хүсдэг.

Дээрх Бичээс дээр найз нөхдийн засварын талаар хэлсэн боловч, энэ зарчмыг удирдагч, багш, ажилтнууд дээр ч хэрэгжүүлж болно. Учир нь чамайг сайн мэддэг, хайрладаг хүнээсээ л зэм үг

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

сонсох нь хамгийн зөв юм. Тэгээд хоёулханаа байвал бүр ч сайн. Нүүр нүүрээ харж чадахгүй бол, утсаар ярьсан нь зөв.

Гэхдээ мессежээр зэмлэхийг би дэмждэггүй. Яагаад гэвэл буруу ойлгогдож болно. Мессеж дуу хоолойны өнгө, биеийн хэлийг харуулахгүй. Жон, бид хоёр ч хоорондоо мессеж солилцохдоо, маш инээдтэй байдлаар буруу ойлголцдог. Жишээлбэл, хэн нэг нь (голдуу би) санаагаа тодруулах үүднээс ТОМООР биччихбэл, нөгөөдөх нь тэрийг нь СҮРДҮҮЛЭГ хэмээн ойлгочихдог.

Бид бүгдээрээ л ар нуруугаараа муулуулж үзсэн. Хүмүүс чиний оролцоогүйгээр чамайг засч байвал, тэдэнд бүү итгэ. Тэдний хэлж байгаа үг нь үнэн байж болох ч, чи өөрөө оролцоогүй юм чинь ямар ч тусгүй юм.

Ийм маягийн засвар нь өсөлтийн үйл явцыг дэмжих биш, гэмтээдэг. Яагаад гэвэл чиний араар муулж байгаа хүмүүс чамаас хариу хамгаалалт хийхийг өдөөдөг. Харин жинхэнэ найзын, нүүр нүүрээ харсан “ил зэмлэл” нь оролцож байгаа бүх хүмүүст харилцан ашигтай байж, засварыг үр дүнтэй болгодог.

Хүнийг олон нийтийн сүлжээ сувгаар засварлах нь олон нийтийн дунд гэдэг утгаараа нээлттэй гэсэн үг биш юм. Надад олон хүчирхэг, сайхан найз бий. Би тэднийг яаж амьдаргийг дотно сайн мэднэ. Гэтэл нүүрэн дээр нь юу ч хэлж чадахгүй өөдгүй хүмүүс тэднийг маань олон нийтийн сүлжээгээр гүтгэн доромжлох явдал бишгүй гардаг. Библи энэ сэдвээр маш тодорхой хэлсэн:

Зөрчилдсөн хүнээс анхны ба хоёр дахь удаагийн сануулгын дараа татгалз. Тийм хүн гажууд бөгөөд нүгэл үйлдэж, өөрийгөө ялладгийг мэд. (Тит 3:10-11)

Тийм хүмүүсийн тэмдэглэлийг бүү унш, бүү маргалд, Твиттер, Фэйсбүүк дээр бүү дага. Энэ нь эрүүл үйлдэл биш. Салан тусгаарлалыг биш, харин онгодыг хай.

Нас нэмэх тусам хүний найзын тоо цөөрч, чанарждаг. Найзууд маань надад хэн болохыг хүсч байгааг минь харуулдаг бол, дайснууд маань хэн болохыг хүсэхгүй байгааг минь илчилдэг. Өрсөлдөөнийг өдөөдөг уур амьсгал нь эхлээд бидний муухай талыг ил гаргадаг. Гэхдээ явц дунд Бурхан оролцож, тухайн зөрчлөөр дамжуулан бидэнд зан чанар суулгадаг.

Сургаалт үгс 27:7:

Цатгаланд сархинагийн бал ч амтгүй
Өлссөнд гашуун юм ч чихэрлэг.

Бидний амьдрал бурханлаг мөн чанарын үр жимсээр үнэхээр хомсдож байна. Улам их өсмөөр байна. Бурханд ойртох тусам, Түүний амийг дотор минь байлгахгүй гэсэн саад ихэсдэг. Найзын маань үнэн зэмлэл шиг сайхан юм байхгүй. Дайсан биднийг зусар гоё үгээр шархдуулдаг. Тиймээс хүний жагсаалт, харьцуулалтаар амьдрахгүй байя. Алдаа дутлаа хараад хэмлүүлэх юмуу бардамналын ихэрхэлд автахдаа, өвдөг сөхөрч сурья. Хэрэв бид Аав дээрээ очбол, Аав маань бидний замд тээглэгч саадыг баяртайгаар зайлуулна.

Хэлэлцэх асуулт

1. Чи нэр хоч авч үзсэн үү? (Хүйсийн, арьс өнгөний, насны).
Энэ нь чиний хүчин чадлыг боогдуулсан уу?
2. Амьдралын чинь аль талбар дээр харьцуулалт чамайг хоослож байна?
3. Бид ангилж, харьцуулж, магтах нь үнэндээ юуны тэмдэг вэ? (Сургаалт үгс 29:25)
4. Олон нийтийн сүлжээ чамд өгөөж өгч байна уу, уршиг тарьж байна уу? Чамайг босгон байгуулж байгаа эсэхийг яаж мэдэх вэ?
5. Ил зэмлэл, далд зэмлэлийн хандлага, сэдлийн ялгааг тайлбарла.

Чамайг өрсөлдөгчөө гэж үзсэн нөхцөлд

Тодорхой хэмжээний эсэргүүцэл чамд тустай. Цаасан шувуу салхинд унадаггүй, улам л хөөрдөг шүү дээ.

Люис Мамфорд

Би саяхан нэг найзтайгаа утсаар ярьлаа. Нөхөр нь маш мундаг, хөгжимчин, хөгжмийн зохиолч бөгөөд найз маань ч хүчирхэг үйлчлэгч, маш онцгой хүн юм. Тэд яриангүй маш цэвэр, даруу, халуун сэтгэлтэй хүмүүс. Гэтэл тэд саяхан маш хүнд замаар туулсан юм. Тэд хорон муу хэл аманд өртөж, эсэргүүцэгдэж, шударга бус шүүмжлэлд өртжээ.

Найз маань: “Тэд биднийг тэдэнд, тэдэнд гүтгэсэн” хэмээн хэрэг явдлын гол гол эздийг нэрлэв. Би сонсоод л байлаа. Би ойлгож байлаа. Тэгснээ сүүлдээ би түүний ярианы учрыг олохоо больж, тэднийг яасныг нь, яг одоо юу болоод байгааг нь ойлгохоо байв. Гэхдээ би тэднийг хаашаа чиглэж байгааг нь харж байлаа. Тэгээд: “Сайн байна! Чи тэдний төлөө Бурханд талархах ёстой. Тэдний тэр муу муухай хандлага өнөөдөр чамайг өдий зэрэгт хүргэсэн” гэж хэлсэн юм.

Би тэр хүмүүсийн муу муухай харилцаанд баяссан юм биш. Харин тэр хоёрын хариу үйлдлээс тэдний ирээдүй ямар гэрэл гэгээтэй байгааг ойлгосон юм.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Мэдээж гадны хүний хувьд ингэж хэлэх амархан л даа. Тиймээс би өөрийгөө оролцуулаад: “Би надтай өрсөлдөж байгаа хүмүүсийн эсэргүүцэлд үнэхээр талархаж сурсан шүү” гэж хэлсэн юм.

Надад ч тэр өдөр тэр яриа маш их хэрэгтэй байлаа. Буруу номтон нэр зүүж, шударга бус хандуулахыг би та нарын хэнд ч хүсэхгүй. Энэ зовлонг туулсан хүн л үүний зовиурыг мэднэ.

Гэхдээ урам алдаж, болихын оронд би эргэж хараад, Бурханы хэзээ ч хөсөрдүүлдэггүй, итгэмжтэй чанарг талархаж сурсан. Дахиад нэг ч гишгэж тэсэхгүй мэт санагдах замаар Тэр намайг тээгээд л гардаг. Би Бурханы талаар найзуудаасаа илүү дайснаасаа л сурдаг. Тодруулбал, би өөрийнхөө талаар найзуудаасаа илүү дайснаасаа сурдаг.

Найзууд чамайг өмгөөлж хамгаална. Энэ сайн хэрэг. Гэхдээ өсөлтийг чинь нэг их дэмжихгүй. Найзууд чамайг амьдралын шуургаас хамгаалахыг хүсдэг бол, дайсан чамайг усан бороонд гадаа хаяхыг хүсдэг. Гэхдээ Бурхан чамд Тэр л чиний цорын ганц хамгийн найдвартай хамгаалалт гэдгийг заахыг хүсч байвал, яах уу? Тэгэхээр хэн нь илүү сайн багш болж байна - найз уу, дайсан уу?

Амьдралд өрсөлдөөн байдаг нь үнэн бөгөөд харамсалтай. Хэдий муухай ч, энэ үнэн. Гэхдээ өрсөлдөөн бүхэн зорилготой. Өрсөлдөөнгүй амьдрал бүтээнэ гэдэг нь өрсөлдөгчөө амьдралаасаа зайлуулахыг хэлэхгүй, харин Бурханы зорилгын төлөө дуудагдсан байхад, бүх зүйлс хамтдаа бидний сайны төлөө ажилладаг гэдгийг ойлгох явдал юм. Бид илүү том өсөлт, ухаарал руу гарахын төлөө өрсөлдөөний хүч дээр дөрөөлж болно.

Эерэгээр харах юм бол, өрсөлдөөн нь бидний сул талыг илчилж, хүчтэй талыг маань бэхжүүлэх өөрчлөгч хүч болж чадна. Өрсөлдөгч биднийг хүчин чадлаас минь хэтэртэл түлхэж, ганцаардахдаа дээшээ харахад хүргэдэг.

Чи “Байзаарай, та чинь дөнгөж сая намайг өрсөлдөгчгүй охин, өрсөлдөгчгүй амлалтын өвлөгч, өрсөлдөгчгүй Бурханыг хүндэтгэхээр бүтээгдсэн” гэж хэлээ биз дээ гэж бодож байгаа байх.

Бүгд үнэн. Чи бол Бурханы нүдэнд ямар ч өрсөлдөгчгүй охин. Чи яг л ийм өнцгөөс Бурхантай болоод бусадтай харилцах ёстой. Гэхдээ бидэнд өрсөлдөгч байхгүй, бид амлалтад ямар ч тэмцэлгүй хүрнэ гэж бодож байгаа бол дэндүү гэнэн явдал юм. “Чи бол дэлхийн гэрэл” (Матай 5:14) гэдэг мэдэгдэл нь харанхуй

байдгийг хүлээн зөвшөөрч л байгаа биз дээ? Өрсөлдөгчгүй охин гэдэг нь чамд ямар ч өрсөлдөгч гарахгүй гэсэн үг биш, харин чи харанхуйд хэзээ ч хаягдахгүй гэсэн үг юм.

Өрсөлдөгч гэдэг үг нь гурван утгатай: нэр үг, тэмдэг нэр, үйл үг.

Өрсөлдөгч гэдэг нь: хүн, газар, юм байж болно; хүн газар юмыг дүрсэлж болно; хүн, газар, юмны үйл хөдлөл байж болно. Нэр үгийнхээ хувьд өрсөлдөгч нь найз, үе тэнгийн хүн, тэмцэлдэгчдээс авахуулаад харанхуйн дайсан, атаатан, жөтөөрхөгч хүртэл байж болно. Өрсөлдөгч гэдэг тэмдэг нэр нь найз нөхдийн нөхөрсөг өрсөлдөөнөөс авахуулаад дайсантай хийх өрсөлдөөнийг дүрсэлнэ. Эцэст нь өрсөлдөх гэдэг үйл үг нь эвлэх, дууриах, харьцуулах найрсаг өрсөлдөөнөөс авахуулаад, давж гарах, нүүрэлдэх, хол хаян ноёрхох хүртэл өргөн утга илэрхийлнэ.

Өрсөлдөөн бодитой. Заримдаа биднийг огт мэдээгүй байхад ч хүмүүс бидэнтэй өрсөлдөөд л явж байдаг. Дийлэнх хүмүүс спорт, оюун ухаан, шинжлэх ухааны тэмцээн, сонгуулиас өөр зүйлд сайн дураараа өрсөлдөхийг хүсдэггүй. Чи ажилдаа өрсөлдөгч нартай уулзах гэж явдаггүй шигээ чуулганд ч хэнтэй ч өрсөлдөхийг хүсэхгүй! Гэвч өрсөлдөгч нар амьдралын тал бүр дээр гарч ирдэг бөгөөд хүн чамайг яаж харахыг чи шийдэж чадахгүй. Уучлаарай, тэр бүү хэл олон нийтийн харилцааны хамгийн шилдэг фирмийг хөлсөллөө ч, энэ нь олон нийтийн үзэл бодлыг зохицуулахаас илүүг хийж чадахгүй. Үүнийг эртхэн ойлгох тусмаа л сайн. Гэхдээ нэг сайн мэдээ байна аа. Чи бусдыг хэрхэн харахаа шийдэж чадна! Хүмүүст хандах хандлагаараа бусдын хандлагыг өөрчлөх боломжтой шүү. Энэ талаар хожим дэлгэрэнгүй ярина.

Өрсөлдөгчийн сэдлээс үл хамааран, өрсөлдөөнийг хэзээд өөртөө ашигтайгаар эргүүлж болдог. Гагцхүү хяналтын талаарх дараах хоёр түлхүүр зарчмыг санаж яваарай.

1. Чи бусдын үг, бодол, үйлдэл, мэдрэмжид хариуцлагагүй бөгөөд хяналтгүй.
2. Чи өөрийнхөө үг, бодол, үйлдэл, мэдрэмжид хариуцлагатай бөгөөд хяналттай.

Өрсөлдөгч хүмүүс биднийг яаж чаддагийг бид мэднэ. Гэхдээ

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

энэ бүлгээрээ бүгдээрээ өрсөлдөгч бидний төлөө юу хийж чаддагийг сурна.

Өрсөлдөгч Бурханы хүчийг илчилдэг

Төрөхдөө нууцлагдаж, хааны гэрийнхэнд олдож, Фараоны гэрт өссөн Мосегийн амьдрал эхнээсээ л нууц явуулга байв. Бурхан Мосегийн амьдралыг хамгаалахын төлөө эдгээр хүчин зүйлсийг ашиглажээ. Гэхдээ хувь тавилан тав тухтай улиралд биш, харин тэмцлийн улиралд илчлэгддэгийг Мосе сурсан юм.

Мосе энэ бүхнийг өөрийн гараар зохицуулах гэж оролдсон ч, өөрийнхөө мэддэг амьдрал, хүмүүсээсээ салж цөлөгджээ. Тэрбээр цөлд урт удаан хугацаанд нүүдлийн амьдралаар л амьдарсан байх. Гэтэл цөлд дүүрвэж явсан Мосег гэнэт Бурхан араас нь товшжээ. Эндээс нэг зүйлийг сурах хэрэгтэй. Чиний өнгөрсөн амьдралын алдаа ирээдүйг чинь шийдэхгүй. Мосе яагаад амьд үлдсэнээ, Бурхан түүнийг хэн болгож, яалгахаар дуудаж байгааг мэдэрсэн боловч, түүнд чөлөөлөгчийн зан чанар дутаж байв. Бурхан Мосегийн дотор ордонд байхдаа хэзээ ч сураагүй бөх чанарыг суулгах хэрэгтэй байжээ. Бурхан биднийг нэг л өдөр олны төлөө ашиглах гэж хувьчлан бэлтгэдэг юм. Дараа нь Мосе тэс өөр хүн болоод ах Аарон, эгч Мириам бас Израилийн ард түмэн дээр хүрч ирсэн байдаг. Тэгээд цаг нь болмогц Бурхан Мосег Фараонтай уулзуулахаар чөлөөлөгч, элчингээрээ томилдог юм.

Бурхан Мосег өрсөлдөгч Фараонтай нь халз тулуулахаар илгээдэг. Бурхан Мосег Фараон руу илгээхдээ, Фараон түүнийг сонсохгүй гэдгийг нь анхааруулжээ:

Чамд Миний тушаах бүхнийг чи хэл. Чиний ах Аарон “Израилийн хөвгүүдийг нутгаасаа явуул” гэж Фараонд хэлэх болно. Гэвч Би Фараоны зүрхийг хатууруулж, тэмдэг ба гайхамшгуудаа Египетэд олон болгоно. Тэгээд Фараон та нарыг сонсохгүй. Тэгэхэд Би мутраа Египет дээр тавьж, үлэмж их ял шийтгэлүүдээр дамжуулан Өөрийн ард түмэн Израилийн хөвгүүдийг түг түмээр нь Египет нутгаас гаргана. Би мутраа Египет дээр сунгаж, Израилийн хөвгүүдийг тэдний дундаас гаргахад египетчүүд Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно гэв. (Гэтлэл 7:2-5)

Бурханд хэзээ ч бүтэшгүй мэт зорилго байв. Яг энэ шалтгаанаар л Фараоны алдрын байр суурь нь ч газрын хүмүүсийн дунд Бурханыг өргөх учиртай байжээ:

Би мутраа сунгаж, чамайг болон ард түмнийг чинь тахлаар цохисон бол чи дэлхийгээс устгагдах байсан. Харин Би хүчээ чамд үзүүлж, Өөрийн нэрийг бүх дэлхий даяар тунхаглахын тулд үүнд чамайг босгосон юм. (Гэтлэл 9:15-16)

Өрсөлдөгч Бурханы хүчийг илчилдэг. Египетийн зөрчил нь Бурханд итгэдэг, нэр ч үгүй, хэлбэр ч үгүй, дарлагдсан хүмүүсийг шүтээн шүтдэг хүмүүс дундаас ялгаж, өргөх зорилготой байжээ. Тэгвэл чиний амьдралын ямар өрсөлдөөнөөр Бурхан чиний амьдрал дээр байгаа мутраа харуулж, чамайг болон бусдыг чөлөөлөх гэж байгаа бол? Яг одоо чиний хувь тавилантай тэмцэлдэж байгаа зүйлийг анхааралтай ажаад, чамд өрсөлдөгчийн бэлэг байгаа эсэхийг мэд. Өрсөлдөгч бол бэлэг шүү дээ.

Давид хааныг хэн алдартай болголоо? Эш үзүүлэгч, аав, найз нь уу? Үгүй, өрсөлдөгч Голиат нь.

Филистин өрсөлдөгч гарч ирээгүй бол, Давид цөлд л амьдралаа дуусгах байсан биз. Тэгээд ч цаадах чинь найман хүүхэдтэй айлын отгон нь байсан шүү дээ. Самуел Давидыг хаан болгож тосолсон ч, тэрбээр хаан болохоосоо өмнө хэд хэдэн өрсөлдөөнийг дарах ёстой байсан. Тосолгоо нь чамайг тусгаарладаг бол, Голиаттай хийх халз тулаан нь чамайг бэлэн болгоно.

Голиат уг нь тулааны талбар дээр Саултай тулах ёстой байсан. Саул хэдий Голиат шиг том байгаагүй ч, Израилийн тэргүүн, ур чадвартай дайчин байсан. Библи Саулыг Израилийн бусад эрчүүдээс толгой өндөр байсан гэдэг. Эрдэмтэд Саулыг 182-198 см өндөр байсан гэж үздэг. Харин Голиат 2 метр 70 орчим байсан гэдэг.

Ямар ч байсан, дайчин Голиат Саул хаанаас хавьгүй өндөр байсан бол, хаан Саул хоньчин Давидаас өндөр байжээ. Гэхдээ Давидад өндрийг нь нөхөж гүйцээх нэгэн зүйл байсан нь түүний эр зориг байв. Эр зориг гэдэг нь зориг, урам, шийдвэр, шийдэл гэсэн үг юм. Саяхны нэгэн судалгаагаар Вест Поинтын цэргийн академийн сонсогчдоос хэн нь илүү сайн төгсөхийг сурлагын дүн юмуу эрдмийн зэргээс илүү “шазруун” гэдэг чанар нь шийддэг

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

болохыг харуулжээ. Сонсогчдод эр зоригийн хүчин зүйлийг нь 1-5 оноогоор дүгнэх, бие дааж гүйцэтгэх даалгавар өгсөн байна.

Харин Давидынх 5+ байсан байх. Тэр нилээд эр зоригтой байсан болоод л арслан, баавгайтай үзэлцсэн байх. Тиймээс л Давид Голиатыг цааш нь харуулж чадна гэдгээ эргэлзээгүй мэдсэн байх. Саул биеэр өндөр ч, эр зоригийн хувьд Давидаас хавьгүй нам байжээ. Эр зориггүй хүн домог болдоггүй. Хүч тэнцүү хоёр хүн үзэлцээд нэг нь ялах нь тийм дуулиантай явдал биш. Оролцож байгаа хүмүүсийг ангайлгам тэгш бус өрсөлдөөн байх хэрэгтэй. Үзэгчдийг: “Ийм юм байдаг аа? Ямар мундаг бэ!” гэж дуу алдам, ер бусын өрсөлдөөн байх хэрэгтэй. Давидад өөрийг нь түүхэнд мөнхлөх хэмжээний өрсөлдөгч хэрэгтэй байжээ. Алдартай авч аймхай дайчин Саул, Филистиний аймшигт дайчин Голиат хоёр Давидыг өрсөлдөгчгүй дайчин болгожээ.

Давид, Голиат хоёр гэдэг номдоо Малком Гладвел энэ талаар яг хэлдэг:

Энэ дэлхийн түүхэнд мөнхөрсөн юмс нь ямагт хүч тэнцвэргүй иймэрхүү зөрчлөөс л төрсөн байдаг. Учир нь байж боломжгүй зөрчилтэй нүүр тулсан халз тулаанаас л аугаа байдал, гоо үзэсгэлэн мэндэлдэг. ... Хүмүүс дорд нэгнийг юмын чинээ үздэггүй учраас, түүний өөрчлөгдөх бололцоо, чадварыг хардаггүй. Гэтэл энэ нь үүд нээж, боломж төрүүлж, боловсруулж, гэгээрүүлж, хүний бодож ч зүрхлээгүй юмсыг боломжтой болгодог.”²

Чи боломжгүй дайсантайгаа нүүр тулахдаа, хоёр сонголттой тулна: Нэг бол гараа өргөн бууж өгөх эсвэл цэх зогсоод, өмнөө байгаа өрсөлдөөнийг өөр дотроо байгаа хавьгүй том зүйлээр халз тулаанд дуудах. Давид өөрийг нь боож байсан Саул хааны хуяг дуулгыг тайлж хаяад, Бурханыхаа нэрийг дуудаад, Филистин хүн рүү ингэж хашхирчээ:

Чи илд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол, харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түг түмдийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна. Өнөөдөр ЭЗЭН чамайг миний гарт өгнө. Би чамайг алаад, чиний толгойг биеэс чинь таслан авна. Өнөөдөр би филист цэргүүдийн

ЧАМАЙГ ӨРСӨЛДӨГЧӨӨ ГЭЖ ҮЗСЭН НӨХЦӨЛД

хүүрийг огторгуйн шувууд, хээрийн араатанд өгнө. Бүх улс, Израильд Бурхан байна гэдгийг үүгээр мэдэх болно.
(1Самуел 17:45-46)

Голиат Давидыг хувь тавиланд нь хүргэснээр бүх юм дуусаагүй шүү. Филистинийг ялсан ялалтаар Израилийн дээр Бурханы мутар байгааг даян дэлхий мэдсэн юм. Давидын нэгэн адил чи Бурханыг алдаршуулахын хүслэн болж байгааг чинь би мэднэ. Бидний ертөнцөд ч Голиатууд байж л байна. Тэд биднийг Бурханаа няцаахыг уриалдаг. Тэдгээр үлэмж биетүүд нь сургууль, ажил дээрх дээрэлхүү гаруудын дүрээр юмуу нийгмийн үзэл бодлын хэлбэрээр хаа сайгүй явж л байдаг. Тиймээс хаданд шигдэхээ больж, амандаа Бурханы Үгийг тээгээд дайрах цаг болжээ.

Христийг булшнаас амилуулсан яг тэр Сүнс чамд байна. Өрсөлдөгч нар чамайг тэдний болзлоор бас хүнийхээ хүчээр тулалдахыг шаарддаг. Гэхдээ чи тэгж болохгүй. Чи түүнээс том байх ёстой. Өрсөлдөгчгүй хүүхдүүдийнхээ хувьд бид муу ёрыг сайнаар тулах ёстой юм. Эцсийн эцэст бид алдарших биш, Бурхан л алдарших ёстой.

Голиат Давидыг алдаршуулсан. Олон нийтийн сүлжээ хүнийг алдаршуулж чадна. Гэхдээ алдар нэр хүнийг хаан болгодоггүй юм. Буруу ашигласан алдар нь хүчирхэг зарц нарыг биш, харин амиа хичээсэн дарангуйлагч нарыг төрүүлдэг. Бурхан Саул шиг аймхай хулчгар удирдагчийг хүсээгүй. Бурханд Өөрийг нь хүндэтгэдэг, хүч чадлаа ил харуулдаг хүн хэрэгтэй байсан. Бид Бурханыхаа хаадаар бөгөөд тахилч нараар томилогдсон. Бид хүмүүсийн дунд нэр олохын төлөө биш, Эзэнтэйгээ амь нэг байхын төлөө явдаг. Давид Бурханаас айсан бол, Саул хүмүүсээс айсан.

Алдартай байхын нөгөө тал нь чи дагалдагч юмуу дагагч нарыг биш, харин бишрэн шүтэгчдийг олдог. Бишрэн шүтэгчид тогтворгүй. Тэд нэг эгшинд чамайг хайрлаж байгаад, төд удахгүй залхдаг. Давид хаанд бишрэн шүтэгчид хэрэггүй байсан. Түүнд амиа ч хайрлалгүй зүтгэдэг эрчүүд, эмэгтэйчүүд хэрэгтэй байсан. Бурханлаг хаадад цэцэн зөвлөхүүд, үнэнч цэргүүд, итгэмжтэй зарц нар хэрэгтэй. Ийм хүмүүсээр хүрээлүүлэхийн тулд Давидад жаахан шинэтгэл шаардлагатай байжээ. Тэгээд Бурхан Давидыг хаанчлалд бэлтгэхийн тулд түүнд нэгэн өрсөлдөгчийг бэлтгэсэн байв.

Өрсөлдөгч чиний хувь тавиланг илчилдэг

Өрсөлдөгч чамайг тодорхойгүй байдлаас чинь суга татаж хаяад, баталгаатай байр сууриас чинь цохиж унагаж чадна. Гэхдээ тэдгээр нь чиний амьдралд ямар үр дүн авчрахыг чи өөрөө л шийднэ. Өрсөлдөгч чинь чамайг дийлэх үү эсвэл өрсөлдөгчийнхөө ачаар чи улам шилдэг болох уу? Яг энэ шалтгаанаар өрсөлдөгч бас чиний хувь тавиланг илчилж чадна.



Өрсөлдөгч чинь чамайг дийлэх үү эсвэл өрсөлдөгчийнхөө ачаар чи улам шилдэг болох уу?

Давид Бурханыг хүүгийнх нь хувьд бас хоньчныхоо хувьд мэддэг байсан. Тэрбээр Ойрх Дорнын одод гялбасан саруул тэнгэр дор хонин сүргийнхээ дунд Бурханаа магтаж байхдаа арслан, баавгайтай тулалдаж сүргээ аварч байсан удаатай. Тийнхүү Давид зэрлэг амьтад яаж дайрч, яаж зулгааж авч явдгийг мэддэг байжээ.

Саул хааны ачаар зоригт Давид хүмүүсийн оршихуйгаас Бурханы оршихуй руу орж, тэндээ тосолгоо хүлээн авч, хаан заяа нь илчлэгджээ.

Саул, Давид хоёрын харилцаа төгссөн шигээ эхлээгүй. Эхэндээ Саул Давидыг ихэд хайрлаж, Бурханы мутар Давидын дээр байгааг мэддэг байжээ. Саул сэтгэл санаагаар тавгүйтэж тарчлахдаа, Давидыг дуудаж, хаанчлалынхаа хамаг хэргийг даатгадаг байв. 1Самуел 18:5:

Ийнхүү Давид Саулын илгээсэн газар бүрд явж ялалт байгуулсанд Саул түүнийг дайчдынхаа ахлагч болгов. Энэ нь бүх ард түмний болон Саулын зарц нарын нүднээ тааламжтай байлаа.

Саулд Давидаас илүү генерал байгаагүй. Тэгээд муу сүнс Саулыг дайрах үед Давид босоо ятгаараа хөгжимдөн, сэтгэлийг нь тайтгаруулдаг байжээ. Ийнхүү Саулын чихэнд өөр нэгэн дуу хүрэх хүртэл бүх юм дардан байлаа. Харин тэр дуунаас хойш юу болсныг чи мэдэж байгаа байх:

ЧАМАЙГ ӨРСӨЛДӨГЧӨӨ ГЭЖ ҮЗСЭН НӨХЦӨЛД

Давид өнөөх филист хүнийг устгаад, бүгдээрээ буцаж ирэхэд эмэгтэйчүүд Израилийн бүх хотуудаас гарч ирэн хэнгэрэг болон хөгжмийн зэмсэг барин, дуу дуулан бүжиглэж, хөл хөөрцөг болон Саул хааныг угтав. Эмэгтэйчүүд тоглон — Саул мянгыг, Давид түмийг алав гэж дуулалдав. Тэгэхэд энэ үг Саулын дургүйг хүргэсэн тул тэр ихэд уурлан — Тэд Давидад түмийг хамааруулж, надад мянгыг өгөв. Одоо түүнд хаанчлал л дутуу байх шив! гэжээ. Саул тэр өдрөөс хойш Давидыг нүд үзүүрлэх болов. (1Самуел 18:6-9)

Тэр хоёрын хэн нь ч ийм тооны хүн алаагүй ч, Саул тэр харьцуулалтад гомджээ. Тэр эмэгтэйчүүдийн дуу Саулын нүдийг нээсэнд, тэрбээр амаа нээгээд өөрийнхөө үхлийг зөгнөсөн юм. Эмэгтэйчүүд уг нь хошигнож дуулсан ч, энэ дуу нь Саулыг инээлгэх нь бүү хэл, харин ч яг мэдрэл рүү нь хатгав. Саулыг дуулгаваргүй авирласнаасаа болж хаан ширээгээ алдана гэж хэлсэн зөнчийн үгээс хойш олон жил өнгөрчээ. Саулаас хаанчлал нь булаагдаж, өөр хүний гарт очих талаар Самуел хэлсэн байдаг. (1Самуел 51:28) Тэгээд яг тэр дуугаар Саулын амьдралын эд эс нь задарч эхэлсэн юм. Саул Давидыг өөрийнхөө орны хүн болохыг мэдмэгцээ, хэдхэн секундын дотор зөн совиндоо шууд ялагддаг. Гэхдээ Саул эв найрамдалтайгаар зайгаа тавьж өгөх санаагүй байв.

Өөртөө итгэлгүй хүний хувьд таагүй харьцуулалт нь нүд ирмэхийн зуур анд нөхрийг нь атаатан болгодог. Саул цаашид Давидыг хүлээн зөвшөөрч чадахаа больжээ. Саул Давидыг аюул занал хэмээн үзэж, ганц шөнийн дотор л бүх юм эргэв.

Дараа өдөр нь Бурханаас ирсэн муу сүнс Саул уруу хүчтэй дайрч, гэр дотор нь түүнийг огшоов. Давид урьдын адил ятгаа гартаа авч тоглож байв. Саулын гарт жад байлаа.
(1Самуел 18:10)

Энэ үг нь хүний теологитой яльгүй зөрчилддөг боловч, “Бурхан зорилгоо биелүүлэхийн тулд юуг ч ашиглаж чадна” гэдгийг л бидэнд сануулж байгаа юм. Энэ тохиолдолд Бурхан атаархуу хааныг суудлаас нь унагахын тулд тамлагч сүнсийг илгээжээ.

Тэр өдөр Давид урьдын л адил хөгжмөө тоглож байсан ч, одоо Саулын зүрх хувирсан учраас, тэрбээр гартаа тэс өөр зүйл барьсан байв.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Дараа өдөр нь Бурханаас ирсэн муу сүнс Саул уруу хүчтэй дайрч, гэр дотор нь түүнийг огшоов. Давид урьдын адил ятгаа гартаа авч тоглож байв. Саулын гарт жад байлаа. Саул “Давидыг хананд хадъя” гэж бодоод жадыг шидэв. Гэтэл Давид түүнээс хоёр удаа бултан зайлав. (и10-11)

Одоо энд гарч байгаа харьцуулалтыг дүрсэлж үзье. Давид маш тайвнаар магтаал тоглож байтал, Саул зэвсэг агссаар гэртээ давхиж орж ирдэг. Энэ харьцуулалтыг жаахан дэлгэрүүлж бодъё. Гэртээ илд шийдэм барьж гүйдэг хүн байна уу? Саул зэрлэг хүн шиг л авирлажээ.

Би сэлэмний талаар ном бичиж байсан учраас, манай гэрт янз янзын олон сэлэм бий. Гэхдээ би тэдэнд бараг хүрдэггүй. Тэр бүү хэл сэгсийтлээ уурлаж байсан ч, аль нэгийг нь шүүрч авах талаар санадаг ч үгүй. Ер нь туршлагаасаа харж байхад, хилэгнэсэн хүн гартаа таарсан юмаа авч шидэхэд бэлэн байдаг. Тийнхүү Давид өчигдөрхөн л мөр зэрэгцэн тулалдаж явсан, итгэлт нөхрөөсөө өнөөдөр амиа авран зугтах хэрэгтэй болжээ. Давидын шилдэг нь Саулын дордыг илчилж, бутнаж байсан зөгнөл нь нас биед хүрсэн айдсын сүнс болтлоо бүрэн боловсорчээ.

ЭЗЭН өөрөөс нь салж, Давидтай хамт байгааг харсан Саул Давидаас айж байлаа. Тиймээс Саул Давидаас дөлж, түүнийг өөрөөсөө холдуулж, мянгатын даргаар томилов. Давид хүмүүсийн тэргүүнд удирдан гарч ордог байв. ЭЗЭН, Давидтай хамт байсан учир тэр бүх юманд агуу амжилтыг олж байв. Давид агуу их амжилт олж буйг үзээд Саул түүнээс маш их жийрхэж байлаа. (1Самуел 18:12-15)

Давид байгуулсан гавьяа бүрээрээ Саулын ялалтыг л зузаатгаж байсан. Гэтэл Саул Давидын эр зоригийг өөрийнх нь хаанчлалыг бэхжүүлэх явдал гэж үзэхийн оронд Давид тулаан бүрээрээ өөрийг нь эрх мэдлээс нь нүцгэлж байна гэж үзжээ. Саул Давидыг хүүгээ хэмээн үзэхээ больж, түүний тайвшралыг хүсэхээ больж, түүнийг нүднээс далд оруулахыг л хүсчээ. Гэхдээ ингээд ч ханасангүй. Энд нүдэнд үзэгдэхгүй бол, толгойд хорогдохгүй гэдэг зарчим ажилласангүй. Саул Давидыг газрын хөрснөөс арчихыг санаархсандаа дайнд явуулдаг. Тэгтэл цаадах нь үхэх нь бүү хэл, улам гялалзсан. Саул түүнийг булшлахыг хүссэн ч, Давид улам л өөдөө дэгжсээр байв:

ЧАМАЙГ ӨРСӨЛДӨГЧӨӨ ГЭЖ ҮЗСЭН НӨХЦӨЛД

ЭЗЭН, Давидтай хамт байгааг мэдээд мөн өөрийнх нь охин Михал Давидад хайртайг Саул харан Давидаас улам их айж, ийнхүү Саул Давидын үргэлжийн өстөн дайсан болжээ. (1Самуел 18:28-29)

Ийнхүү маш богино хугацаанд Давидын талаарх Саулын бодол нь сэжгээс үзэн ядах айдас болтлоо боловсорчээ. Нөгөө хайрладаг хүү, баатарлаг дайчин, холбоотон Давид нь үгүй болж, харин хууль зөрчигч Давид гэдэг этгээд төржээ. Давидын хувьд Саулын ордон доторх хэсэгхэн хугацааны ивээл нь төгсөж, гэм зэмгүй Давид Саулын гэнэтийн дайрлагаас амиа авран зугтав.

Давид ордноос зугтахдаа, амьдралын тэс өөр улиралд хөл тавьсан юм. Тэрбээр байр суурь, шан харамж, эрх ямбын оронд байнгын эсэргүүцэл, хатуу харгис хандлага, цөлийн аюулд оржээ. Зарим эрдэмтэд энэ үеийг найман жил байсан гэдэг. Гэхдээ яг энэ зовлон дундаа л Давид Бурханы зүрхийг дагадаг хаан болж бэлтгэгдсэн гэдэг.

Давид Саулын мөрдлөгөөс зайлан, нэг агуйгаас нөгөө рүү зугтаж байв. Өөрт нь тусалсан гэм зэмгүй тахилч нарыг Саул хороосныг дуулаад Давид асар их гашууддаг. Энэ хугацаан дахь Саулын арсалдаан нь Давидад нэг л зүйлийг ойлгуулжээ: хааны ордонд байсан ч, хар цөлд байсан ч бурханлаг чанар л хамгийн чухал. Саул бол Давидын хоёр дахь Голиат байжээ.

Одоо тайлбарлая.

Давид жаахан “аавын” асуудалтай байсан гээд хэлчихбэл нэг их буруудахгүй болов уу. Яагаад гэвэл Давид Саул хаантай цөлд тулгарах бүрийдээ, түүнийг “аав минь” гэж дууддаг байсан. 1Самуел 24:11 үүнийг харуулдаг:

Хараач эцэг минь, гарт минь буй дээлийнхээ хормойг хараач. Таны дээлийн хормойг би огтлон авсан боловч таныг алаагүй нь хорон муу болоод гэмт үйлдэл нь миний гарт үгүй гэдгийг танд мэдүүлэг. Таны эсрэг би нүгэл үйлдээгүй боловч та амийг минь авахаар мөрдөж байна.

Давид төрсөн аавтайгаа асуудалтай байсан гэж үзэх ямар ч шалтгаан байхгүй ч, айлын найм дахь буюу отгон хүүхэд

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

байсандаа жаахан шоовдор өссөн байж магадгүй юм. Магадгүй долоон сүрлэг ахынхаа сүүдэрт дарагддаг байсан биз. Мэдээж хүүхэд л болсон юм хойно, тэрбээр аавынхаа баталгаа, зөвшөөрөл, тааллыг хүсдэг л байсан байгаа. Гэхдээ элч Самуелыг ирээдүйн хааныг тослохоор гэрт нь хүрэлцэн ирэх үед аав нь үл мэдэх нэг шалтгаанаар отгон хүүгээ дуудаагүй байдаг:

Ийнхүү Иесси долоон хөвгүүнээ Самуелын урдүүр явуулсан боловч Самуел, Иессид —ЭЗЭН эднийг сонгоогүй гэж хэлэв. Самуел, Иессид —Хөвгүүд чинь бүгдээрээ энд байна уу? гэхэд Иесси —Отгон хөвгүүн минь үлдсэн. Тэр хонио хариулж байгаа л даа гэв. Тэгэхэд Самуел Иессид —Хүн илгээж, тэр хөвгүүнийг авчрагтун. Тэр хөвгүүнийг энд иртэл, бид суухгүй гэж хэлэв. (1Самуел 16:10-11)

Самуел яахаараа хүү чинь хаа байна гэж асуух ёстой болдог билээ? Самуелыг ирэхэд, Иессе гуай өөрөө хүүгээ дуудах ёстой байсан бус уу? Магад Иессе хүүгээ хаан болох заяатай хүү гэж үнэлдэггүй байсан болтой. Хэрэв эш үзүүлэгч Самуел манай гэрт ирсэн бол, би ямар ч хамаагүй аргаар гэрийнхэнийгээ бүгдийг нь оролцуулна. Скайп, Фэйстайм, утсаар дуудаж, хэнийг ч үлдээлгүй, бүгдийг нь оролцуулна.

Давид аавынх нь анхаарлыг булаалдсан долоон өрсөлдөгч ахтай байсан. Давид болон ах нарынх нь харилцаа нэг их халуун дулаан байгаагүйг Бичээс хэлдэг. Үнэндээ ах нар нь Давидыг их зантай, сэхүүн пацан гэж дуудсан байдаг. (1Самуел 17:28)

Магадгүй иймээс л би Давидын дууллыг уншихдаа, түүний үгийг биш, зүрхийг нь сонсдог байх. Надад түүний олон жилийн цөллөг, цөхрөлийн зовлон харагддаг. Давид өөрийнхөө гэм зэмгүйг Саулд байн байн баталсан боловч, Саул түүнтэй өрсөлдсөөр байсан.

Тиймээс Давид өөрийнхөө гэм зэмгүйг хүнд хэзээ ч баталж чадахгүй юм байна гэдгийг ойлгожээ. Саул ч Давидыг хэзээ ч уучлахгүй ажээ. Бурхан л ганцаараа ийм зүйл хийж чадна. Давид Саулаас зугтаж, нуугдаж байхдаа Бурхан руу гүйж, Түүний дотор нуугдаж сурчээ. Олон хүн тослогдохыг хүсдэг. Гэхдээ тосолгоо нь дайсны оршихуйд биелдэг зорилго тээж ирдгийг тэд мэддэггүй.

Хожим Давид Абсаломаас зугтахдаа, ингэж уйлсан байдаг:

ЧАМАЙГ ӨРСӨЛДӨГЧӨӨ ГЭЖ ҮЗСЭН НӨХЦӨЛД

Өстнүүд минь юутай олширно, ЭЗЭН!
Өөдөөс минь олуул босжээ.
Булт олон миний тухайд
“Бурханы аврал түүнд үгүй” гэлцэнэ. Села
Гэвч ЭЗЭН, наддаа халхавч бамбай, миний цог жавхлан,
тэргүүнийг минь өргөгч.
Өндөр дуугаар ЭЗЭНд би хашхирахуй
Өөрийнхөө ариун уулаас надад Тэр хариулвай. Села
Хэвтээд л би унтдаг,
Эргээд бас сэрдэг нь ЭЗЭН намайг түшдэгийнх.
Тойрч бүслээд ирсэн түмэн хүнээс ч би айхгүй. (Дуулал 3:1-6)

Давидын зовлон яагаад ихэссээр байв? Сайхан асуулт байна. Яагаад Бурхан эдгээрийг зүгээр л таслан зогсоочихоогүй юм бол? Зүгээр л цөлийн шуурганд булчихгүй.

Давид Самуелаас намайг хаан болгоод аль гэж гуйгаагүй. Давид угаас зоригт хүн учраас, Бурханыхаа төлөө эрэлхэг байхаас өөр аргагүй байсан. Давид аавынхаа итгэмжтэй хүү нь байсан шигээ, хаандаа ч итгэлт дайчин нь байжээ. Ионатан ч Давидаас илүү үнэнч нөхөр олохгүйгээ мэдсэн. Давид тийм л гэм зэмгүй хүн байсан. Гэтэл зовлон нь нэмэгдсээр байв. Яагаад тэр вэ?

Бид шалтгаан нэхэж байна. Яагаад гэвэл шалтгаан байвал, энэ бүхэн арай утга төгөлдөр болж ирнэ. Гэтэл энэ бүхэнд ямар ч утга алга. Давид өөрийнхөө зөрчлийг дүрслэн бичихдээ, ирээдүй рүү тэлэн, Есүсийн талаар зөгнөснөө өөрөө ч мэдээгүй байх. Амьдралд өрсөлдөгч гарч ирэхэд, бид яагаад гайхдаг вэ? 1Петр 4:12-13:

Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин Христийн зовлонг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Түүний алдар илчлэгдэхэд та нар хөөрөн баярлах юм.

Гадаад дарамт дотоод өөрчлөлтийг авчирдаг. Өрсөлдөгч нар Бурханы бидэнд бэлтгэсэн хувь тавиланг илчилдэг. Бурханы алдар амьдралд маань өсөхийн тулд бид буурдаг. Өрсөлдөгч нь бидний хувьд суралцах, шинэчлэгдэх, боловсрох багцын маань

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

нэгээхэн хэсэг болж ирсэн бэлэг юм. Хүн ер нь болж л өгвөл бэрхшээлээс зугтдаг. Гэхдээ бид зовохдоо, Есүсийн зовлонг үүрэлцээд зогсохгүй мөн Тэрбээр бидэнд хувь тавиланг маань илчлэх үед бид Түүний алдраас бас хуваалцдаг юм.

Өрсөлдөгч чамайг зүрхээ хамгаалахад хүргэдэг

Зүрхний чинь чулуу бутлагдахад, махан зүрх чинь ил гарна. Чи ямар ч утгагүй өрсөлдөөн дунд орохдоо, зүрх чинь доромжлол үздэг. Чамайг өөртөө эргэлзсэн, өөрийнхөө сэдэл санааг шалгасан бодлууд бөмбөгдөнө. Тэгээд чи “Би л болохгүй, бүтэхгүй байна, Бурхан хаана байна, яагаад ийм юм болоод байна, яахаараа үргэлжлээд байна?” гэж бодно.



Бид дайралтаар зүрхээ хатууруулах уу эсвэл Бурханаар эдгээлгэх үү?

Эдгээр асуултын хариу ч голдуу л таг байдаг. Тэгээд бид Бурхан үнэхээр намайг сонсож байна уу хэмээн гайхширна. Завсарлагааны үеэр Бурхан голдуу дуугүй байдгийг би сурсан. Энэ үеэр тайз засал өөрчлөгдөж, дүрүүд өөр өөрийнхөө байрыг эзэлдэг. Урамтай байгаарай. Амьдралын чинь улирал шилжих гэж байна. Өөрийнхөө байгаа байдлыг хэмжиж байснаас, Бурхан чамайг энэ

хүртэл дагуулж авчирсныг санаарай.

Чимээгүй чагнаж байхдаа, бид дараагийнхаа үед шилжихэд бэлэн болдог. Бид Бурханы хэлсэн үгд итгэх үү эсвэл өрсөлдөгчийнхөө үгд итгэх үү? Бидний дотор сайн ажил эхлүүлсэн тэр л Бурхан итгэмжтэйгээр дуусгаж чадна. Бид дайралтаар зүрхээ хатууруулах уу эсвэл Бурханаар эдгээлгэх үү? Бид Бүтээгчийнхээ үгд анхаарах уу эсвэл дайсныхаа үгд анхаарах уу?

Үгийг минь анхаар, хүү минь
Хэлэхийг минь чих тавин сонс, үр минь
Үүнийг хараанаасаа алдаж үл болно

Түүнийг өр зүрхэндээ хадгалж яв.
Энэ нь олсон нэгэнд нь амь.
Тэр нь бие махбодод нь эдгэрэл.
Зүрх юугаан урьтан хамгаал
Амийн булгууд түүнээс ундарюу. (Сургаалт үгс 4:20-23)

Тэдний үйлдэлд бүү анхаар. Тэдний үгд бүү анхаар. Өөрийнхөө нөхцлийг тэднийхтэй бүү харьцуул. Зүрхээ хамгаал тэгээд шивнэгдсэн амлалт бүрийг сэтгэлдээ нэвчээ. Өөрийгөө гацаа байдлаас гаргаж, Бурханы дуутай өөрийнхөө дууг тааруул. Бурхан чамтай ярихыг хүсээгүй бол, юу гэж ингэж урамшуулах вэ дээ? Түүний дуу хоолой зүрхнээс чинь зуурдаг.

Хүн амьдралд голдуу л идэвхигүй ханддаг. Гэхдээ чиний хүсээд байдаг тэр Бурханы өрсөлдөгчгүй, эрч хүчтэй амьдралыг зүгээр нэг аргаадааг явдлаар олж авахгүй шүү. Алхам тутам саадтай учруулдаг энэ дэлхий дээр үүнийг анхаарч явбал зохино. Чамд зорилго байхгүй бол, чи энэ их сарнил дунд зүгээр л уусч алга болно.

Христийн үг нь бидний туйлын зорилго юм. Бүтээгчийн маань үг бидний амьдралд бичигдсэн зүйлсийг биелүүлэх хүчийг тээдэг. Амийн жинхэнэ ундаргаас салдаггүй хүний л бие, сэтгэл нь эгнэж, амьдрал нь эрүүл мэнд, зорилго, хүчээр давалгаалах байр сууринд очно. Бид Үг дээр анхаарахдаа, өрсөлдөгчийнхөө хүрч чадахгүй амьдралд ордог.

Бид үр шиг Үгийг анхаарахаар барахгүй, зүрх болох цэцэрлэгээ ч арчлан торддог.

Зүрхээ хамгаалах болон зүрхээ хорихын хооронд том ялгаа бий. Нэг нь зүрхээ үнэт эрдэнэ мэт харж хандаж, хамгаалах явдал бол, нөгөө нь зүрхээ хоригдол мэт хорих явдал юм.

Олон хүн зүрхээ хамгаалж байна хэмээн эндүүрээд, хориод хаячихдаг. Би охин байхдаа яг тэгдэг байсан. Эхэндээ нээрээ л тайвшрах шиг болдог байлаа. Би намайг гомдоосон хүмүүсийг амьдралаасаа тасалж хаяад, зүрхнийхээ үүдийг түгжээд, өөрийгөө гав ганцааранг нь хорьчихдог байж билээ. Тэгсээр байгаад би өөрийгөө хоригдол болгож орхисон юм. Би өөрийгөө зовлон нэвтэрдэггүй болгох гээд, эцэстээ баяр хөөр мэдэрдэггүй болгочихсон юм.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Зүрхээ хамгаалах гэдэг нь хорихыг хэлэхгүй, харин аюулгүй байлгахыг л хэлнэ. Хэрэв чи зүрхэндээ цоож зүүчихсэн бол, залбирах цаг гарга. Чамайг чулуун шоронгоос гаргаж, зүрхийг чинь баяр хөөр, зовлон зовиур мэдэрдэг зүрхээр сольж өгөхийг Бурханаас гуй.

Тийм ээ, энэ зовиуртай. Гэхдээ нулимсаа битгий боо. Зүрхээ усалж, зөөллө. Зовлонгоо хар тамхи, архинд бүү живүүл. Эдгээр нь мэдрэмжийг чинь үрэн таран хийж, чамайг долоо дордуулна. Тархийг чинь харлуулж, сэтгэлийг чинь харанхуйлах өш хонзонгийн тухай бодлоор оюун санаагаа бүү бохирло. Энэ талаар хэтэрхий их бодолгүй, суугаад, хүссэн хэмжээгээрээ уйл. Ганцаараа бай, өвдөлтөө тултал нь мэдэр. Амар тайван бууж ирэхэд, тэнгэр өөдөө хараад, Бурхан руу дуугаа өргө. Давидын үлгэр жишгээр сэтгэл, учир шалтгаан, өрсөлдөгчөө Бурханд даатгаж сур. Дуулал 51:8-12 дээр яг үүнийг хэлдэг:

Надад баяр хөөр, баясгаланг сонсгооч.
Та яйруулсан ясаа баясгаач.
Гэм нүглээс минь нүүрээ буруулж,
Хилэнц бүхнийг минь арилгаач.
Оршихуйгаасаа намайг бүү холдуулаач.
Ариун Сүнсээ надаас бүү аваач.
Авралынхаа баясгаланг надад сэргээж өгч,
Хүсэл зоригийнхоо сүнсээр намайг тэтгээч.

Хатуурсан, хориотой зүрх нь дүлийрч, хариу үйлдэх чадваргүй болдог. Бусдыг шүүдэг хүмүүс нь байнга өөрийнхөө нүглийн жинд нухлуулж явдаг. Зөвхөн Бурхан л зүрхийг маань бохиороос цэвэрлэж, биднийг дахин Өөрийнхөө оршихуйд зөвөөр зогсоохын тулд буруугаас зөв болгодог.

Хатуурсан зүрх Бурханы оршихуйд зогсож чадахгүй. Тэрбээр өөрийгөө тусгаарлаж, эдгэрлийн зөөлөн замыг сонгосон хүмүүсийн зовиурыг шоолдог, басамжлагч хүмүүсийн хүрээнд явж ордог.

Би чамд дахин анхааруулъя. Эхлээд энэ нь чамд сайхан санагдаж болно. Гэхдээ эцэстээ чи тэднийг зүрхээ хамгаалалгүй явсаар, хоригдол болсон хүмүүс байсныг нь мэдэх л болно. Халуун, энэрэнгүй, өрөвч сэтгэл үгүйрч, хатуурхал, үл тоосон

байдал орыг нь эзэлнэ. Нандин зүйлээ хамгаалах болон зүрхээ цоожлохын хооронд том ялгаа байх шүү.

Зүрх маань хоосон бөгөөд нүцгэн үед амаа магтаалаар дүүргэх шиг сайхан зүйл байхгүй. Өөрөө дуулж чадахгүй тарчилж байсан Саулыг Давидын магтаал тайтгаруулдаг байсан. Дуу сонсох нь биднийг зарим зүйлээс тайтгаруулж дөнгөдөг ч, дотроос маань төрсөн дуу л биднийг тэс өөр хүн болгодог. Сонсох биш, харин дуулах үед зүрхний маань түгжээ мултарч, бид Бүтээгчтэйгээ холбогддог.

Саул ярихдаа ч, үйлдэхдээ ч харгис хүн байсан. Түүний зүрхэн дэхь доргио нь үйлдэл дээр нь харагддаг байсан юм. Давид өөрийнхөө зүрхийг тайвшруулж чаддаг байсан шигээ бусдын зүрхийг ч тайтгаруулж чаддаг байжээ:

“Би сэтгэлээ үнэхээр тэгшитгэн нам гүм болгов. Хөхнөөс гарсан хүүхэд эхтэйгээ байх адил Сэтгэл минь хөхнөөсөө гарсан хүүхэд мэт болой.”

Би чамд жаахан ичмээр юм хэлэх үү? Би хөхнөөсөө гарсан хүүхэд шиг сэтгэлээ түвшитгэхийн оронд, нялх хүүхэд шиг аашлачих гээд байдаг хүн л дээ. Олон арван жилийн өмнө манай чуулган магтаал дээрээ Дуулал 3-аар бүлгийг дуулдаг байсан юм. Би дуулах бүрийдээ жаахан хүүхэд шиг өмөгнөж ирээд л уйлна. Гэхдээ гэртээ бол би дуулж, бүжиглэх дуртай байв. Миний гашуудал Давидын Дуулал номыг бичиж байхдаа мэдэрч байсан яг тэр мэдрэмжтэй адилхан санагддаг байлаа. Гэхдээ хамгийн гол нь би өчүүхэн эмтэрснийхээ төлөө асгартал гашууддаг байсан юм. Тийм ээ, тэр үед тэдгээр нь аймшигтай том санагдаж, намайг гүн шархлуульж, сэтгэлийг маань өвтгөдөг байв.

Харин одоо бол өөр санагддаг. Тэдгээр эмтрэл нь хөөрхийлөлтэй бөгөөд өрөвдмөөр байжээ. Яльгүй юмс, багахан эелдэг бус үгс, магадгүй нөхөртэйгээ тар тур хийх. Гэтэл намайг нус нулимстай минь хутгасан тэр аахар шаахархан асуудалтай амьдралыг минь надтай солилцох хүсэлтэй хүн олон байгаа. Өдөр бүр итгэлийнхээ төлөө алуулахад бэлэн буй эрэлхэг зоригтой эмэгтэйчүүдийг би харсан. Хаашаа ч харсан үр хүүхдээ тэжээхийн төлөө амсхийх чөлөөгүй ажиллаж байгаа зоригт, хөдөлмөрч ээж зөндөө байна. Зодуулсан, хүчиндүүлсэн, хүний наймаанд өртсөн, гэр бүл нь худалдчихсан хүмүүсийн талаар дурьдаад ч хэрэггүй биз.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Би чиний зовиурыг эс хэрэгсэж байгаа юм биш шүү. Тэр зовиур хичнээн бодитой байдгийг би мэднэ. Гэхдээ Бурхан хамгийн аймшигтай зүйлийг ч сайнаар эргүүлдгийг мэдбэл, тэр нөхцөл яг л Иосефын хэлсэн шиг болно:

Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө түүнийг сайнаар эргүүлсэн юм. (Эхлэл 50:20)

Өрсөлдөгчийн талаарх үзэл бодлоо өөрчилбөл, Бурхан чамайг зовиураас чинь аварна. Драматург Эдмонд Бурк энэ талаар: “Бидэнтэй хамт зөрчилддөг нь бидний мэдрэлийг хүчжүүлж, ур чадварыг маань хурцалдаг. Бидний өрсөлдөгч нь бидний туслах юм” гэж хэлжээ.

Бусдад хаалгаа хаах нь өөрийнхөө ирээдүйг хааж байгаатай л адил юм. Бусдаас зайгаа авах гэж оролдох бүрийдээ бид өөрийгөө хасах эрсдэлд ордог. Нээлттэй зүрх нь үүд нээж, бусдад тэврээ дэлгэдэг. Бурхан хэнийг ч орхигдуулахгүйн тулд Есүсийг илгээсэн. Байр сууриа хамгаалахын оронд зүрхтэйгээ хичээнгүй ажиллаж, сайтар хамгаал.

Удирдагч болох хүсэлтэй олон хүн байна. Гэхдээ нөлөөллийн хэмжүүртэй байна гэдэг нь хоёр талаар зүсдэг, хоёр иртэй илд юм шүү. Чамайг хайрладаг боловч, мэддэггүй хүмүүс байна. Бас чамайг үзэн яддаг ч, чамайг мэддэггүй хүмүүс байна. Тэд бол зүгээр л үзэгчид юм. Тэд өрсөлдөгч биш, зүгээр л солилцоог хардаг хүмүүс. Мосе Фараонтай хамт өссөн. Давид Саулд хүү шиг нь л байсан. (Голиат бол амьдралынх нь нэг л үлэмж биетэн байсан) Дийлэнх тохиолдолд өрсөлдөгч нь чамайг сайн мэддэг байсан хүн болж таардаг. Давид өрсөлдөгчийг ингэж дүрсэлжээ:

Учир нь намайг доромжилдог нэгэн нь дайсан минь биш.

Тийм байсан бол би тэсэхсэн.

Миний эсрэг өөрийгөө өргөмжилдөг нэгэн нь

намайг үзэн ядагч биш.

Тийм байсан бол би түүнээс нуутдахсан.

Гэвч надтай ижил тэгш хүн,

Миний анд ба дотнын найз минь билээ.

ЧАМАЙГ ӨРСӨЛДӨГЧӨӨ ГЭЖ ҮЗСЭН НӨХЦӨЛД

Бид хамтдаа таатай чуулал хийж,
Бурханы өргөөнд олны дунд алхаж байсан.
(Дуулал 55:12-14)

Өнөөдөр бид үүнийг орчин цагийн хэллэгээр “найзын дүрд хувирсан дайсан буюу найз - дайсан” гэдэг. Энгийнээр хэлбэл өрсөлдөгч. Тэд бол хэн нь жинхэнэ нөхөд болохыг таниулах бэлэг боловч, нөгөөтэйгүүр бидний өрсөлдөгч нар л эцсийн эцэст биднийг жинхэлдэг юм. Бид өрсөлдөгчөөр минь дамжуулж биднийг шижир болгож, байранд маань байршуулж байгаад талархаж болно эсвэл нус нулимстайгаа хутгалдаж болно. Гомдоллож болно эсвэл залбирч, дуулж болно. Сонголт нь биднийх бөгөөд ямар ч өрсөлдөгч биднээс үүнийг булааж чадахгүй.

Хэлэлцэх асуулт

1. Өрсөлдөгч чинь чиний зөвлөгч болж байсан үе байдаг уу?
2. Өрсөлдөгч чиний ямар сул талыг ил гаргасан бэ?
3. Чиний зоригтой тал юу вэ?
4. Чиний илүү зоригжих ёстой тал юу вэ?
5. Бишрэн шүтэгч болон дагалдагчийн гурван ялгааг хэлнэ үү.
6. Гартаа илд бариад гэрээрээ гүйж байсан удаа чамд бий юу? Тэгээд яаж буулгасан бэ?
7. Зүрхээ хорихгүйгээр яаж хамгаалах вэ?

Өрсөлдөгчгүй хүйс

Хүн яаж ч өөрчилж чадахгүй зүйлээсээ буюу арьс өнгөнөөсөө болж гадуурхагдахыг би тэвчихгүй атлаа бас л ялгаагүй яаж ч өөрчилж чадахгүй зүйлээрээ буюу хүйсээр гадуурхагдахыг зөвшөөрөх болж байна уу?

Аркбишоп Дэсмонд Туту

Надад хувийн залбирал гэж бий - *ганцаараа* залбирдаг залбирал. Гэхдээ яг ганцаараа залбирах залбирал маань голдуу зочид буудлын өрөө, машиндаа л өрнөчих гээд байдаг талтай. Жолоогоо барьж явахдаа, асар ер бусын залбирал хэлнэ шүү дээ. Магтаалын дуу тавиад л, Бурханы оршихуйд умбах шиг сайхан юм байхгүй. Хэдэн жилийн өмнө амьдрал маань ёстой л хар эрчээрээ гүйж байлаа. Заримдаа өөрийгөө яваад байна уу, ирээд байна уу гэдгээ ч мэдэхээ больчихно. Яг тэр үеэр намайг Иорданд байхад миний “*Эрслэн сэрэв*” гэдэг ном маань дөнгөж хэвлэгдээд байсан юм. Он дуусах дөхөж, Талархлын баяр ч хаяанд ирээд байв. Тэр үед миний хувийн залбирал нэг иймэрхүү л өрнөдөг байлаа:

“Аав аа, Та намайг дөнгөж сая нэг ном хэвлүүлснийг мэдэж байгаа. Ном маань хэдийнээ таван хэл дээр хэвлэгдсэн ч, энэ үнэхээр Таны хүсэл мөн байсан гэдэгт би итгэлтэй баймаар байна. Нэгэнт өнгөрсөн явдал гэдгийг би мэдэж байна л даа. Гэхдээ Та цаг хугацаанд баригддаггүй Бурхан гэдгийг би мэднэ. Тиймээс

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

энэ бүхэн Таны хүсэл байсан гэдгээ надад баталж өгөөч. Есүсийн нэрээр. Амень.” Тийм ээ, жаахан ичмээр байгаа ч, байдал яг л ийм байсан. Би зүрхээ Эзэнийхээ мутарт өгөх хэрэгтэй гэдгээ мэдэж байлаа.

Гэхдээ хүссэн баталгаа маань нэг их удалгүй ирсэн юм. Тэр орой найман цагийн алдад би бага хүүгийнхээ хичээлийн төсөлд туслах гэж ухнатаж байлаа. Дээрээс нь бас ахынх нь төсөлд юу, юу хэрэгтэй болох талаар ярьж байтал, бага маань надад даалгавраа хийхэд нь нэгэн төрлийн тусгай самбар хэрэгтэй гэдгийг хэлэв. Би тэр самбарыг нь олж өгөхөөр гарахаасаа өмнө дүүдээ тусалбал, хармааны мөнгөөр шагнахаар ах нартай нь тохироо хийв. Намайг гэртээ иртэл гэр маань бөмбөг дэлбэрчихсэн аятай л угтлаа - ширээгээр нэг сэтгүүлийн тасархай, өнгийн харандаа, үсэг хөглөрөөтэй. Нэг ах нь Ардены уншиж өгсөн юмыг нь бичиж, нөгөө нь хайчилбар зураг нааж байлаа. Би тэдэнд тэр зургуудыг нь наах самбарыг нь дөнгөж өгчихөөд байж байтал, утас хангиналаа. Жон залгажээ.

Тэр байдгаараа догдолчихсон, харин би байдгаараа цуцчихсан байлаа.

Тэгтэл Жон намайг тэр орой нэг хүнтэй заавал яриатаач гэх нь тэр. Нөхөр маань намайг огт танихгүй хүмүүстэй утсаар яриулдаг, нэг тийм сонин зантай л даа. Чухам яаж байгаад би тэр хүмүүстэй нь ярих ёстой болчихдгийг сайн хэлж мэдэхгүй байна. Гэхдээ ямар ч байсан ийм явдал байнга болчихоод байдаг юм. Тэр хүмүүс нь надтай ярих ямар ч сонирхолгүй байж болно... гэхдээ Жон тухайн үед нэг юм мэдэрдэг ч юм уу, яадаг ч юм бүү мэд - ямар ч байсан намайг л яриулаад байдаг юм.

Эхлээд миний дургүй хүрдэг байлаа. Харин одоо бол хувь тавилантайгаа эвлэрсэн. Цэц ухаант эмэгтэйчүүдэд хэлэхэд - хэрэв нөхөр чинь аль нэг хачин жигтэй дадал хэвшлээрээ чамайг арван жилээс дээш хугацаагаар залхааж байгаа бол, тэр занг нь ядаргаа биш, харин хөөрхөн занд тооцохоос өөр арга байхгүй. Тиймээс манай нөхөрт намайг огт танихгүй хүмүүстэй утсаар яриулдаг, нэг тийм хөөрхөн зан байдаг юм. Гэхдээ тэр орой би эсэргүүцлээ илэрхийллээ.

- “Жон, надад танихгүй хүнтэй ярьж байх зав алга. Би Ардены даалгаврыг хийлгэж байна.”

- “Өө, зүгээр зүгээр. Миний найз яг одоо ярих шаардлагагүй шүү дээ. Тэр цэргийн хүн болохоор яг одоо өөрөө ч завгүй байгаа. Гэхдээ би түүнд чиний дугаарыг өгчихсөн. Орой залгахаар нь ярьчихаарай. За найз нь явлаа, хайртай шүү!” гэж хэлээд, үг ч хэлүүлэлгүй, алга болоод өгөв.

Хүүгийн маань даалгавар ид дундаа орж байлаа. Гэтэл цагийн дотор утас дуугарав. Тэгээд би хамгийн залхмаар, унтаа, сөөнгө дуугаар хариулахаар шийдлээ.

- “Байна?”

Мань хүн жаахан гайхсан янзтай.

- “Лиза Бивэр мөн үү?”

- “Мөн байна... .”

- “Лиза, нөхөр чинь орой цуглаан дээр таны шинэ номыг танилцуулсан юм. Тэгээд арслангууд бол шилдэг алуурчид, харин эрслэнгүүд бол шилдэг анчид байдаг гэж хэлсэн” гэлээ.

Би ч дотроо: “Юугаа ярина вэ? Мэдээж шүү дээ. Эний чинь би Жонд хэлсэн юм чинь... тэгээд тэр өөр юу ч мэдэхгүй юм чинь... тэгж хэлэлгүй яахав дээ. Жон миний номыг мэдээж уншаагүй л явж байгаа!” гэж бодлоо. Тэгтэл нөгөө хүн: “Тийм ээ, Жон үнэн хэлсэн. Эрслэнгүүд бол шилдэг анчид!” гэх нь тэр.

Би түүнийг яг юу хэлэх гээд байгааг ойлгосонгүй. Шал танихгүй хүн над руу залгачихаад, миний нөхөртөө хэлсэн үгийг надад эргүүлж хэлээд байгааг нь би ойлгосонгүй. Гэхдээ тун удахгүй энэ ярианы учиг тайлагдах гэж байлаа.

- “Лиза, бид яагаад Афганистан дахь дайнд ялахгүй байгааг мэдэх үү?”

Би ч мэддэг ганц хоёр юмаа хэллээ. Албаа хаагаад харьж ирж байгаа цэргүүдтэй нэг онгоцоор ниссээр байгаад овоо мэдээлэлтэй болчихсон гэх үү.

- “Та биднийг яагаад ялахгүй байгаа нэг шалтгааныг мэдмээр байна уу?”

- “За, мэдмээр байна.”

“Бид Афган эмэгтэйчүүдэд хүрч чадахгүй байна” гээд тэрбээр цааш нь тайлбарлав: “Эмэгтэй хүнд хүрч чадахгүй байна гэдэг чинь тэр соёлыг өөрчилж чадахгүй байна гэсэн үг. Соёлыг өөрчилж чадахгүй бол, дайнд ялж чадахгүй.”

Одоо би түүнд анхаарлаа.

- “Би бааздаа яг юу хийдгээ тайлбарлая. Би онцгой даалгавар гүйцэтгэдэг хүмүүстэй ажилладаг. Ажил маань онц аюултай учраас, урьд нь дандаа эрэгтэй баг илгээдэг байлаа. Гэхдээ одоо

эмэгтэй баг ч илгээдэг болсон. Тэд Афган эмэгтэйчүүдэд тэдний дуу хоолой, үнэ цэнийг нь ойлгуулах болно. Тэд тэдэнд яагаад ардчилал тэдний хөвгүүд, охидод ашигтай болохыг тайлбарлана. Тэд тэдний анхан шатны эмнэлгийн хэрэгцээг хангаж, хүүхдийг нь эх барьж авна. Тэр эмэгтэйчүүдийн тусгай багийн нэрийг та мэдэх үү?” гэлээ.

Би ч ёстой бүү мэд гэлээ.

Тэгтэл тэр хүн: “Тэднийг *Эрслэнгийн баг* гэдэг. Тэд удахгүй хөдлөх гэж байгаа. Та тэдэнд бүгдэд нь номоосоо өгч болох уу?” гэсэн юм.

Бид мэдээж өгсөн!

Тэр эмэгтэйчүүд Афган эмэгтэйчүүдэд хүрч үйлчилж, үр удамд нь дайн, гамшгаас хавьгүй том найдварыг түгээхийн төлөө ажиллаж байгаа учраас, мэдээж бид тэднийг дэмжинэ. Тэдгээр эрслэнгүүд зүгээр нэг цэргийн тушаал биелүүлж байгаа биш, харин ямар нэгэн мөнхийн үйл хэрэгт оролцож, зүгээр л эмэгтэй хүн болж төрснийхөө төлөө нийгэмдээ гадуурхагдаж яваа өөр эмэгтэйчүүлд эдгэрэл, амь түгээх үүрэг хариуцлагаа биелүүлж яваа юм. Америк эрэгтэй цэргүүдэд Афган эмэгтэйчүүдтэй харилцахыг хориглож, харин Америк эмэгтэй цэргүүдэд тэдэнтэй харилцахыг тушаажээ.

Би утсаа тавьсныхаа дараа эмэгтэйчүүдийн оролцоогүйгээр маш олон дайнд ялах боломжгүй байдгийг ухаарсан юм.

Америк улс эмэгтэйчүүдийн оролцоогүйгээр дайн хийж болох ч, ялж болдоггүйг ойлгочихоод байхад, чуулган тулаанд зөвхөн байлдах биш, харин ялахын тулд эмэгтэйчүүдийг эн тэгш оролцуулах ёстойг ойлгох цаг нь болсон биш үү?

Хүйсийн өрсөлдөөн хоёр тал руугаа туйлширдгаараа алдартай боловч, голдуу эмэгтэйчүүдийг гадуурхах маягаар төгсөх нь

элбэг. Миний хувьд бараг гучаад жил хүйсийн өрсөлдөөнд өртсөн эмэгтэйчүүдийг зүрхэндээ тээж явна. Би энэ талаар дуу хоолойгоо өргөхгүй байж, ном бичсэн гэж яриад ч яахав.

Маш олон фронт дээр дэвшил гарч байгаа ч, гэр бүл, гэрлэлт, ажил, чуулганд энэ асуудал хэзээ ч тасрахгүй байна. Олон нийтийн хэвлэл мэдээн дээр ч эмэгтэйчүүдийг нүд үзүүрлэсэн коммент нэг ч тасрахгүй байна. Секс наймаа, хүйсийн ялгаварлал, порнографын талаар ярих ч хэрэггүй.

Хамгийн харамсалтай нь хүйсийн буруу шүүх нь одоо ч бидний сайн мэдээний хил хязгаарыг балласаар, бид ч эрчүүдэд бүрэн аврал, эрх чөлөөг олгох атлаа эмэгтэйчүүдэд хязгаартай хувийг тогтоосоор байна.

Шашны удирдагч нарын заналхийлэл

Тэгэхээр, би хүйсийн буруу шүүхийн талаарх энэхүү яриагаа Есүсийн амиллын дараа чуулган дөнгөж мэндлээд эрч хүчтэй, өсч байхад Бурханы Сүнс хөвгүүд охид дээр аль аль дээр нь асгарч байсан түүхээс эхэлмээр байна. Есүсийн амилал тунхаглагдахад, Сайн мэдээ үгээр ч, үйлсээр түгэн дэлгэрч байв. Сүмийн сандралдсан удирдагч нар шуургыг намжаах гэсэндээ дөчин жил тахир татуу явсан хүнийг эдгээсэн Петр, Иохан хоёрыг баривчилжээ.

Ингээд тэднийг дуудаж, Есүсийн нэрээр огт ярьж, заахгүй байхыг тушаав. (Үйлс 4:18)

Тушаасан хүмүүс нь тухайн үеийн шашны удирдагч нар бөгөөд харин тушаал сонссон хүмүүс нь Петр, Иохан хоёр юм. Есүсийн нэрээр үйлдэгдсэн энэ гайхамшиг нь амилсан Христийг номлох үүдийг дэлгэж өгчээ. Тэр хүн эдгэрсэн нь хэнд ч тодорхой байсан тул Иүдейн шашны удирдагч нар наашаа ч үгүй, цаашаа ч үгүй болоод, ингэж шийджээ:

Энэ хүмүүсийг бид одоо яах вэ? Тэдний үйлдсэн илт гайхамшиг нь Иерусалимд суудаг бүхэнд нэгэнт тодорхой тул бид үгүйсгэж чадахгүй. Харин цаашид үүнийг ард олны

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

дунд улам тархаахгүйн тулд энэ нэрээр дахин хэнтэй ч ярихгүй байхыг тэдэнд сануулъя гэцгээв. (Үйлс 4:16-17)

Гэхдээ тэр хоёрыг заналхийллээ гээд юу ч өөрчлөгдөөгүйг бид мэднэ. Харин ч бүр эсрэг үр дүн авчирж, тэднийг улам ч зоригтой болгочихсон.

Ингээд тэднийг дуудаж, Есүсийн нэрээр огт ярьж, заахгүй байхыг тушаав. Гэвч Петр Иохан нар тэдэнд —Та нарыг Бурханаас илүү сонсох нь Бурханы өмнө зөв үү? Өөрсдөө шүүн тунгаагтун. Учир нь бид үзсэн, сонссоноо ярихаа зогсоож чадахгүй гэжээ. (Үйлс 4:18-20)

Петр, Иохан хоёр зогсохгүйг шашны удирдагч нар сайн ойлгожээ. Тэднийг зогс гэж ятгаад ямар ч нэмэргүйг ч мэдэж байлаа. Тэр хоёр үнэнийг зааж, номлохоос өөр ямар ч сонголтгүй байв. Тэд заримдаа дуугүй байх нь дуулгаваргүй байхтай адилхан гэдгийг ойлгожээ.

Ийм занал өнөөдөр ч байдаг. Гэхдээ заналхийлэх арга хэлбэр нь арай өөр болсон. Энэ нь одоо харанхуй бүдүүлэг загасчдад тушааж байгаа шашны удирдагч нарын тушаал шиг байхаа больсон. Энэ нь дэлхий даяарх соёлын шахаа шиг болсон. Хэлбэр нь өөр боловч, зорилго нь яг л адилхан юм. Өнөөгийн энэ нийгэм чамайг Есүсийн нэрийг хэрэглэхгүй л байвал, Бурханы тухай хүссэнээрээ ярьж, хүссэнээрээ сүнслэг байхыг зөвшөөрдөг.

Нийгмийн тайз бидэнд Есүсийн нэрээр зааж, номлохыг зөвшөөрдөггүй. Гэхдээ чуулган гишүүдээ хязгаарлаж, дуугаа намсгах юм бол... энэ чинь тэс өөр араатан болж хувирна.

Хоёр мянганы турш шашны удирдагч нар чуулганы охидод Сайн мэдээг зааж, номлохыг хязгаарлаж, заримдаа бүр хориглосоор ирсэн. Үйлс 4:18-ыг дахин унш:

“Ингээд тэднийг дуудаж, Есүсийн нэрээр огт ярьж, заахгүй байхыг тушаав.”

Би энэ ишлэлийг тунгааж байхдаа, Ариун Сүнс *“Миний үйлчлэлд дуудаж, Сүнснийхээ бэлгийг өгсөн өчнөөн олон охид маань чуулганаас болж ухарч, дуудлагаасаа няцсан”* гэж айлдахыг сонссон юм.

Чи шашны удирдагч нараас: “Эмэгтэйчүүд эрчүүдэд биш, зөвхөн эмэгтэйчүүддээ заана” гэхийг эсвэл “Эмэгтэйчүүд номлох биш, зөвхөн хуваалцана” эсвэл “Эмэгтэйчүүд удирдаж болно, гэхдээ чуулганаас гадуур” гэж хэлэхийг сонсож явсан л байх. Эдгээр халхавч бүхий занал нь зөв зүйтэй мэт сонсдож болох ч, Сайн мэдээг хайрцаглах гэсэн яг л адилхан зорилготой. Итгэлдээ чанга эмэгтэйчүүлийг юм л бол харгис хатуу гэдэг. Бурхандаа итгэл дүүрэн байдаг эмэгтэйчүүдийг амбицитай гэж андуурдаг. Гэхдээ Петр, Иохан хоёрт хандсан яг л тэр асуудал бидний өмнө тулгарч байна. Хүмүүсийг сонсох уу, Бурханыг дагах уу? Тэгвэл Бурхан хөвгүүд, охиддоо юу хийгээрэй гэсэн бэ? Есүсийн яг дээшээ явахасаа өмнө айлдсан үг дотор хариулт нь байна:

“Есүс тэдэнд —Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй нь яллагдах болно. Итгэгчдэд дагалдах тэмдгүүд нь: Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярих болно. Тэд могойг барина. Бас үхүүлэх ямар ч юм тэд уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтөнд тэд гар тавивал эдгэнэ гэж айлдлаа. Ингээд Эзэн Есүс тэдэнд айлдсаны дараа тэнгэр өөд авагдаж, Бурханы баруун гарт залрав.” (Марк 16:15-19)

Энэ удирдамжийг бүх итгэгч хүнд өгсөн. Аугаа тушаал нь зөвшөөрөл бөгөөд аль аль хүйсд өгөгдсөн мандат юм. Христийн дотор Бурханы Сайн мэдээг тунхаглах дуудлага, эрх чөлөө нь бүгдэд олгогдсон. Бурханы эрх чөлөө, үнэнийг мэдсэн хүн хүний заналхийллээр амаа үдүүлж хэзээ ч болохгүй.

Хаанаа дага

Бурхан бол бидний хамгийн дээд, ариун Хаан. Хаан маань биднийг томилж, хүчирхэгжүүлсэн. Тэр биднийг Өөрийнх нь өмнөөс хүмүүст ярихыг тушаасан. Тийм байтал чи яаж Хаанаас дорд хүмүүсийн хоригт автана вэ? Бид бүгдээрээ Матай 4:10-ын амьсгалагдсан тунхаглал байх ёстой:

“Бурхан Эзэндээ чи мөргөж, зөвхөн Түүнд үйлчил.”

Хааны албатуудыг дагахын төлөө Хааныг үл дагаж байвал, чи Хааныхаа өмнө асуудалд орлоо гэсэн үг. Үүнийг Эстерийн амьдралаас харж болно. Персийн ордны хуулиар хаан нь өөрөө хатнаа дуудаагүй байхад, хатан нь дур мэдэн хаан дээрээ орж болдоггүй байв. Гэхдээ Эстер хааны хуулийг дагах нь Бурханы хуулийг эс дагасантай тэнцэнэ гэдгийг ойлгожээ. Эстер хүмүүсийн дургүйцлийг төрүүлэхээсээ илүү Бурханыхаа дургүйг хүргэхээс айдаг байсан тул хаан дээр орсон юм. Гэхдээ мэдээж стратегитэй хөдөлсөн. Ард түмнийх нь амь аюулд ороод байхад, Эстер дуугүй өнгөрч чадаагүй. Гэтэл өнөөгийн дэлхий тэс өөр болжээ. Маш олон охид стратегийн газар юмуу нөхцөл байдалд нуугдаж байна. Зарим нь бусад эгч дүүсийнхээ хамт мацаг барин залбирч, зуучлан залбирах боломжийг хүлээж байна.

Гэхдээ би нөхрийнхөө юмуу чуулганыхаа өөдөөс тэрслээд бай гэж хэлээгүй шүү. Зүгээр л чиний амыг барьсандаа сэтгэл нь ханадаггүй жинхэнэ бодит дайсан цаана чинь байгааг л чамд ухааруулах гэсэн юм. Тэр дайсан чиний амийг, үр хүүхдийн чинь амийг авлах гэж байна.

Үнэний цаг. Хэрэв нөхөр чинь чамайг Сайн мэдээ ярихаа боль гэвэл, чи үгэнд нь орох уу?

Би тэргүүн пасторынхаа дүрд орж, индрийн араас номлох талаар яриагүй байна. Би зүгээр л чамайг үнэхээр жинхэнээсээ эрх чөлөөтэй байна уу, гэрчилж чадаж байна уу гэдгийг чинь л асууж байна? Чи өөрөөсөө залуу эмэгтэйчүүдийг дагалдуулж, тэдний төлөө залбирч, тэдэнд хариулахад бэлэн байна уу?

Жон, бид хоёр саяхан энэ талаар ярьлаа л даа. Жон надаас яагаад тийм олон эмэгтэйчүүд Есүсийн элчин сайд байхаас цааргалж, хойш суугаад байдгийг асуусан юм. Тэгэхээр нь би зүгээр л айсандаа тэр байх гэж хариулсан. Тэгтэл яг тэр долоо хоногт онгоцонд надтай зэрэгцэж суусан нэг эрэгтэй хүн надад “Хүмүүс таныг араар чинь “Гутаан доромжлогч!” гэдэг” гэж хэлсэн юм. Би хариуд нь түүнд: “Нүүрэн дээр минь ч тэгж хэлдэг!” гэж хэлсэн.

Одоо арьсаа хамгаалж, нэр нүүрээ бодох цаг биш. Энэ бол эрэгтэй, эмэгтэй байх нь хамаагүй - Бурханы дүр төрхийг тээгчдийн хувьд дайсантай нэгийгээ үзэлцэх цаг. Тэгээд энэ дайнд бидэнд ямар ч хэрэггүй нэг зүйл бол - өөр хоорондоо тэмцэлдэх юм. Ингэхэд, зарим

эмэгтэйчүүд яг энэ яриатай нүүрэлдэх ёстой. Тэд дуугүй байх нь захирагдах явдал гэж сурсан бөгөөд Бурхан тэдний нэрийг өөрчилсөн гэдгийг тэд мэддэггүй. Бурхан чамд юу хий гэж хэлсэн? Чи тэр залуухан ээжийг дагалдуулах хэрэгтэй биш үү? Гэртээ залбирлын бүлэг юмуу Библи судлал хийвэл яаж байна? Бурханлаг дуулгавартай байдал нь Бурханыг дагангаа, нөхрөө хүндэтгэх явдал юм.

Эмэгтэйчүүд хүчээ хэрхэн захиран зарцуулахаа заалгаагүй, сураагүй учраас, өөрийнхөө хүчээс айдаг. Эмэгтэйчүүд өөдтэй, олигтой загнахгүй байхыг бид бүгдээрээ л хардаг. Би ч бас зөндөө буруу юм хийсэн. Би хэцүү хатуу байхыг хүссэндээ биш, харин яаж бусдад дуу хоолойгоо хүргэхээ мэдэхгүй учраас, зөндөө алдсан. Суралцах нь саяхныг хүртэл эмэгтэйчүүдийн хувьд боломжгүй, ховор зүйл байсан учраас, сурлага хэмждэг сум нь огцом заалттай байна.

Эмэгтэйчүүдийн дуу хоолойг устгах биш, харин эмэгтэйчүүдийг боловсруулах нь үүний шийдэл юм. Надад өсөх боломж олгохгүй бол, би өсөхгүй. Би өсөхгүй бол, бусдыг өсгөж чадахгүй.

Бид өөрсдийгөө ууртай эмэгтэйчүүд гэж дуудуулах уу? Эсвэл охид нь Аавынхаа үгийг тунхаглаж чадахын тулд цэц ухааныг олох уу? Хариултыг нь мэдэж байгаа хүмүүс амаа үдэх ёстой гэж үү? Бурхан үүнийг бүү зөвшөөрөг! Бид охидоо бурханлаг бөгөөд дуулгавартай байдалд идэвхитэй сургах ёсгүй гэж үү? Тэгээд энэ нь 1Петр 3 дээр эмэгтэйчүүд сүнсээр намуун бөгөөд даруу байх ёстой гэсэн үгтэй яаж авцалдах вэ гэж асууж байгаа хүн байвал, би үүнтэй төгс санал нийлнэ! Даруу байхыг Есүсийн болоод Мосегийн амьдралаас сурч болно.

Мосе гэгч хүн газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа. (Тооллого 12:3)

Есүс мөн ийн айлдсан:

Буулгыг минь өөрсөд дээрээ ав. Надаас сур. Би дөлгөөн, зүрхэндээ даруу. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. (Матай 11:29)

Есүс, Мосе хоёр бидэнд даруу байдлын үлгэр жишээ болжээ.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Бидний зарим хүйсийн асуудал нь зүгээр л инээдтэй байдаг. Би Жоноос найзуудыгаа авчирч болох уу гэж асуудаггүй, Жон надаас найзуудтайгаа гольф тоглож болох уу гэж асуудаггүй. Би Жоноос дэлгүүр дотор хүнд Есүсийн тухай ярьж болох уу эсвэл чуулганыхаа залуусын цуглаанд зааж болох уу гэж асуудаггүй. Бид хоёр хэн хэнд маань бас гэр бүлд маань нөлөөлөх зүйлсийн талаар зөвлөлддөг боловч, өдрөө хэрхэн зарцуулах тал дээр зөвлөлддөггүй. Бид өчүүхэн юм болгоны төлөө бие биеэсээ зөвшөөрөл аваад байвал, туйлдаж гүйцнэ. Түүнээс гадна Жон надад итгэдэг, би Жонд итгэдэг! Би Жоноы гэргий болохоос биш, хүүхэд нь биш!

Өнөөдөр бид айдаст нэрвэгдсэн цаг үед аж төрж байна. Хүмүүст чиний зүрхэнд байгаа алдрын найдвар хэрэгтэй байна.

Эцсийн эцэст Есүсийн захирамжид дуулгаваргүй байсныхаа төлөө бид өөрсдөө л буруутай болно. Тийм ээ, хүмүүс биднийг бүдрүүлж, нүгэлд унагаж болох ч (Матай 18:6; Марк 9:42; Лук 17:2), Хаандаа дуулгавартай байх эсэх маань эцсийн дүнд бидний л сонголт юм. Петр, Иохан хоёр шиг бид Христийн гайхамшиг дотор бүрэн гүйцэд алхах ёстой бөгөөд энэ нь бид харсан, сонссон зүйлийнхээ талаар чимээгүй байж болохгүй гэсэн үг юм.

Аман дайрлага

Өнөөдөр энэ замаар замнаж яваа эмэгтэйчүүд зодуулж, шоронд хаягдахгүй байж болох ч, эсэргүүцэл, доромжлолд бэлэн байгаарай. Энэ нь чи байнгын буруу тайлбар, аман доромжлол, гадуурхалд өртөж болно гэсэн үг юм.

Жон, бид хоёр энэ тал дээр жаахан ялгаатай үзэл бодол тээдэг. Жон өөрийнх нь очдог дийлэнх чуулганд эмэгтэйчүүдийг индэрт гаргадаг гэж хэлдэг. Тэгээд манай улсад төдийгүй, хилийн чанадад ч бүгд мэддэг болсон бидний хайрлаж, хүндэтгэж явдаг гурван эмэгтэйг нэрлэсэн юм. Тэд удирддаг, заадаг бас номлодог. Энэ бүхэн нь онолын хувьд үнэн гэдэг дээр би Жонтой санал нийлсэн ч, амьдрал дээр арай өөр байдгийг хэлсэн юм. Тиймээс би Жоноос жилд ганц болдог Ээжүүдийн баяраас өөр өдөр эмэгтэйчүүдийг индэр дээр байнга гаргаж номлуулдаг чуулганыг нэрлэхийг хүстэл, Жон арваас илүүгүйг нэрлэсэн юм.

Ярианыхаа явцад Жон надад “Эмэгтэйчүүд юу ч хэлсэн

гэсэн, эмэгтэйчүүдийг удирдагч болохыг бас заахыг эсэргүүцдэг теологичдын үзэл бодлыг өөрчлөх боломжгүй учраас, эмэгтэйчүүдийг хүрч чадах хүрээндээ Сайн мэдээг тасралтгүй номлохыг байнга зааж сануул. Харин удирдагч нарт юу ч хэлээд нэмэргүй” гэсэн утгатай зөвлөгөө өгч билээ.

Тийм ээ, түүний зөв. Би удирдагч нар дээр төвлөрөхгүй. Би үүнийгээ ятгалга хэрэгтэй байгаа эгч дүүс, ээж, охидод айдас чичрэлээр бичиж байна. Би чуулган дотор зааж, ярьж болох үгүйгээ ч мэдэхгүй байгаа хүмүүст номло гэж зааж чадахгүй. Учир нь Хуулийн үсэг тэдний зүрхийг сүлбэжээ. Бурханы жинхэнэ охин болсон хэн ч Аавынхаа хүслийг зөрчихийг хүсэхгүй. Тэд удирдагч нарынхаа зөвшөөрөөгүй юмсыг сурахгүй. Бурханыг төлөөлж байгаа эрх мэдэлтэн насан турш чамайг хоёрдугаар зэрэглэлийн хүн гэж хэлбэл, чи итгэх л болно. Харанхуй амьдрал туулсан хүн бүр амархан итгэнэ.

Би өөрөө тийм байсан учраас, сайн мэдэж байгаа юм.

Итгэл муутай хүнд өөрийнхөө болон өөрийнхөө хувь нэмрийн талаар байнга л хоёрдагч бодол төрдөг. Харин би чихний чинь бөглөө, нүдний чинь боодлыг авч хаяад, хуульчлалын өргөсийг зүрхнээс чинь сугалж хаямаар байна. Тэр цагт чи эдгэрч, өөрөө сонсож чадна. Ариун Сүнс чамайг хууль, анагаах, бизнес, засаглал, гэртээ сайн мэдээний элчин байгаарай гэж дуудсан бөгөөд бидний хийсэн бүхэн Эзэний дотор хийгдэх ёстой. Энэ үйлдэл нь нийгмийг нандин байлгана. Гэтэл чуулгандаа тодорхой хүчин чадлаараа зааж, номлож, удирдах дуудлагатай гэж мэдэрч байгаа хүмүүст Ариун Сүнс тэдэнтэй ярихгүй гэж хэлэх нь буруу юм.

Хүний удирдах чадварт хүйс ямар ч хамаагүй. Маргарет Тэтчер эмэгтэй хүн байсан. Тэгээд Английн аугаа удирдагч болж чадсан л биз дээ? Үнэндээ хүйс нь асуудал биш, харин бидний бардам зан, бусдыг шүүх буруу шүүх, хандлага л асуудал болдог. Эдгээр нь маш сайн удирдагчийг ч сохолж чадна. Удирдагч хүнийг хүйс биш, харин даруу байдал, туршлага, итгэмжтэй чанар, боловсрол гэх мэт чанар нь тэнцүүлдэг юм. Түүнчлэн Христээс тусгаар бол, бид юунд ч тэнцэхгүй. 2Коринт 3:4-6:

“Христээр дамжин Бурханд хандах ийм итгэл бидэнд бий.

Бид чухамхүү аливааг өөрсдөөсөө мэт зүтгэж чадахгүй ч бидний чадвар Бурханаас юм. Тэр биднийг Шинэ гэрээний үсгийн бус харин Сүнсний үйлчлэгчид байх чадвартай болгосон. Учир нь үсэг хөнөөдөг бол, Сүнс амь өгдөг аж.”

Нэгэн нэрт удирдагч 1Тимот 2 -ыг ингэж тайлбарласан юм. “Паул ердөө л чуулган удирдах тал дээр эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол хавьгүй хөнгөмсөг бөгөөд итгэмхий учраас зохисгүй гэжээ.”¹

Бид Тимот номын тус ишлэлийг тун удахгүй үзнэ. Гэхдээ эхлээд “Энэ үг чамд ямар санагдаж байна. Ичгүүртэй, ялтай, дарамттай? Эсвэл “Ашгүй дээ!” гээд хойш суух сайхан шалтаг шиг санагдаж байна уу?

Мэдээж хэнд ч хүч, урам хайрлам үг биш байна. Би энэ хэсгийг үнэхээр дурьдмааргүй байсан. Яагаад гэвэл энэ үг нь эмэгтэйчүүдийг гадуурхах газар авсан сэтгэлгээг л тодотгоод байх шиг. Тэр удирдагч цааш нь ингэж бичжээ: “Олон эмэгтэйчүүд Паулын энэ дүгнэлттэй санал нийлэхгүй байсаар ирсэн ч, Паулын хэлснээр бол өөрийнх нь зааврыг сонсдоггүй ийм эмэгтэйчүүд нь сайхан сэтгэлтэй ч, буруу явуулгатай ээж Еватайгаа л адилхан буюу”² гэжээ.

Бид уурлахгүйгээр санал зөрж болох уу? Би уурлахгүйгээр нөхөртэйгээ санал зөрдөг. Бас ажилчидтайгаа, найзуудтай!

Гэхдээ дээрх хүний хэлж байгаагаар бол, хэрэв 1Тимот 2-ын энэ даалгавартай санал нийлэхгүй байвал, бид бүгдээрээ муу санаатай, ууртай эмэгтэйчүүд болох нь байна. Тэрбээр биднийг Бурханы дуулгавартай охид байна гэж юу гэсэн үг болохыг мэдэхийг хичээж байгаа, бурханлаг, сэтгэн боддог, сониуч эмэгтэйчүүд байж болно гэсэн саналыг ч дэвшүүлээгүй байна. Тэр бүү хэл - Паул манай нийгэмд байхгүй ч, тухайн үеийн нийгэмд байсан асуудлын талаар ярьсан байж магадгүй гэсэн боломжийг ч гаргаж ирээгүй байна.

Тэгэхээр, энэ тайлбар нь бидэнд худлаа тодорхойлолт өгч байна. Ева бидний ээж биш. Бид дахин төрөхдөө Адам, Ева хоёрын хүүхдүүд байхаа больсон. Бид Бурханы хүүхдүүд болсон.

Зохиолч өөрийнхөө үгээр биднийг ичээж чимээгүй болгох гээд байх шиг. Эндээс би хүйсийн ялгаварлал, эмэгтэйчүүдийг үзэн ядах үзлийг л сонсож байна. Эндээс би Ариун Сүнсийг сонсохгүй

байна. Есүс дандаа хайр, хүлээн зөвшөөрлөөр зааж, чиглүүлдэг. Есүс чуулганыг сүйт бүсгүй гэсэн. Харин тэр зохиолчийн үгс нь яг л эмэгтэйчүүдийг үзэн ядсан могойн үзэн ядалттай л адилхан байна.

1Тимот нь Грек соёл дунд чуулганыг хэрхэн тэргүүлэн удирдах талаар Тимотод заасан Паулын захидал юм. Тэгвэл өнөөгийн бидний соёлд тэднийхтэй адил юм нэг ч байхгүй байхад тэдэнд хэрэгжиж байсан юмс бидэнд хэрэгжих ёстой юу? Магадгүй чи юу гэж хариулахаа мэдэхгүй байгаа байх. Яагаад гэвэл чи Бурханыг хүндэтгэхийг хүссэндээ удирдлагадаа хэзээ ч эргэлзэж яваагүй бөгөөд тэдний томилгоог хувь тавилангаа хэмээн хүлээж авсан байх.

Тэгвэл цааш нь шалгая. Чи өөрийнхөө охиныг ийм үгээр хүмүүжүүлж чадах уу? Хүмүүс түүнийг тэнцэхгүй, хөнгөмсөг, итгэмхий, амархан мэхлэгддэг, худлаа мэдээлэлтэй гэхийг нь зүгээр л хараад зогсох уу? Эр ч бай, эм ч бай хэн нэгнийг ийм маягаар дүрсэлж засварлах нь Ариун Сүнсний арга зам гэж үү? Бурхан Аав чинь чамайг насан турш ингэж хочилно гэж үү?

Магадгүй чи өөрийгөө ингэж дүгнэж, ингэж цоллосон байх. Итгээд тодорхой хугацаа өнгөрсөн бол, чуулганы чинь эмэгтэйчүүдийн талаар багш, удирдагч нар чинь ч иймэрхүү юмс ярьдаг байж магадгүй. Саяхан л гэхэд, олон жил үйлчилсэн нэгэн эмэгтэй манай байгууллага руу утасдаад, түүнийг чиглэсэн тэр их хавчлагын улмаас өөрийнх нь хийсээр ирсэн зүйлс ер нь зөв байсан эсэхийг лавтай мэдэхийг хүссэн юм.

Тэгэхээр, охин минь, дүү минь, найз минь би нэг зүйлийг чамд амлаж чадна: Бидний сүйт хархүү болох Эзэн Есүс Христ чиний дээр хэзээ ч ийм үг хэлээгүй шүү. Тэр намайг номлосноороо Өөрийг нь гутаан доромжилж байна гэж нэг ч удаа надад хэлээгүй. Мэдээж би төгс номлодоггүй. Мэдээж би үйлчлэх тусам, улам л сайжрахыг хичээдэг. Ариун Сүнс намайг амьдралын минь талбар бүр дээр засварладаг. Гэхдээ дуудлагын тал дээр болон Тэрбээр намайг хэрхэн хардаг тухайд Бурхан намайг байнга урамшуулдаг. Тэр чи, бид хоёрын талаар юу гэж хэлснийг үз: Тэр чамайг тэр чигээрээ хайрлагдсан, тэнцсэн, чадвартай гэдэг. Тэр чамд шинэ зүрхийг өгч, чамайг улам ухаантай үнэн болгодог сүнснийг сэгсэрсэн юм. Тэр чамайг мэхлэгдсэн, мангар охин гэлгүй, харин чиний ойлголтын мэлмийг ялгах хараагаар гэгээрүүлэхийн тулд

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Ариун Сүнсээрээ дүүргэж, Бурханы Үгийг даалгасан. (Дуулал 45:11; Езекиел 36:26; 2Коринт 3:6; Ефес 1:18)

Эрчүүд ч, эмэгтэйчүүд ч Түүний сүйт бүсгүй мөн. Тэр бидний бохирыг Үгийнхээ усаар угаах явцдаа цусаараа хоёр хүйсийг хоёуланг нь аварсан юм. Гэтэл манайд Библи судлахаар цугласан эмэгтэйчүүдэд 1Тимотын 2-ыг тайлбарласан дээрх тайлбарыг уншиж өгөхөөр, тэдний царай баяр хөөрөөр гэрэлтдэггүй. Яахав, өнгөрсөн амьдралдаа бүтэлгүйтэж, шархалж явсандаа болоод тэр багшийн үгийг үнэний ортой гэж хэлэх эмэгтэйчүүд гардаг л даа. Бас үүнийг өөрөөр тайбарлах ямар ч арга байхгүй гэж боддог ч эмэгтэйчүүд байна.

Гэхдээ намайг охины чинь талаар асуухад, чиний дотор ямар нэг юм болоогүй гэж үү? Үрээ өмгөөлөн хамгаалах эх хүний эр зориг чинь сэрээгүй гэж үү? Тэгвэл чиний тухайд? Чи Христийн олж өгсөн эрх чөлөөг эдлэхийн оронд өөрийгөө боомилсоор байх уу? Чи охиныгоо хязгаарлахгүй байж, яаж өөрийгөө хязгаарлана вэ? Ефес 2:10 дээр “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ” гэдэг.

Чи өөрийгөө амархан мэхлэгддэг, итгэмтгий, зохисгүй гэж хэзээ ч дүгнэхгүй байхын төлөө би залбирч, найдаж байна. Хэрэв чи буруу мэдээлэл авсан бол үүнийгээ засч залруулж болно. Би ч бас өөрөөсөө ухаантай хүмүүсээс байнга суралцаж явахыг хичээн зүтгэдэг. Тэгэхээр, эхлээд Паулын заавраар бие биеэ гэгээрүүлье. 1Коринт 14:34-35:

“...чуулгануудад эмэгтэйчүүд чимээгүй байг. Учир нь тэдэнд ярихыг зөвшөөрдөггүй. Харин хуулийн хэлдэг шиг тэд захирагдаж байг. Хэрэв тэд ямарваа юм сурахыг хүсвэл гэртээ нөхрөөсөө асууг. Учир нь эмэгтэй хүн чуулган дээр ярих нь ичгүүртэй.”

Харин дараа нь 1Тимот 2:11-15 дээр:

“Эмэгтэй хүн дуугүйгээр, бүрэн эрхшээл дор суралц. Харин эмэгтэй хүн заах, эсвэл эр хүнийг захирах эрх мэдэлтэй байхыг би зөвшөөрөхгүй. Харин дуугүй байг. Учир нь эхлээд

Адам, дараа нь Ева бүтээгдсэн билээ. Адам мэхлэгдээгүй. Харин эмэгтэй нь мэхлэгдэж, гэмд унасан юм. Гэвч эмэгтэйчүүд итгэл, хайр, ариусал дор даруухан байваас тэрээр хүүхэд төрүүлэхээр аврагдана” гэжээ.

Грек хэлээс нь нэгтгэж харах юм бол, бүхэлдээ Христитгэлийн тухай л өгүүлдэг. Эмэгтэйчүүд хуурамч шүтээнүүдийн дунд эзэлж байсан - Диана дагины сүмээс олгосон байр сууриа эзлэхээ больжээ. Чуулганы эмх цэгцийн талаар Тимотод хандсан Паулын зааврыг унших юм бол, тэрбээр хуулийг эшлээгүй байгаа. Бас Есүсийг ч эш татаагүй байгаа. Паул Тимотод зүгээр л яаж Грек соёлд итгэгч хүмүүсийг хэрхэн зүй ёсоор цуглуулах талаар л санал дэвшүүлжээ. Тэр үед тэдний соёлд эмэгтэйчүүдийг сүнслэг юмс дахь эрх мэдэлтнүүд гэж үздэг байсан юм.³

Тухайлбал Арамей хэлээс хөрвүүлсэн Пэйшн Библийн орчуулга 1Тимот 2:11-12 дээрх Паулын үгийг ингэж буулгажээ:

Шинээр итгэсэн эмэгтэйчүүд нь удирдагч нартаа бүрэн захирагдахад суралцах хүсэлтэй байж, ээлж дараагаа зөрчиж ярихгүй байг. Шинээр итгэсэн эмэгтэйчүүдийг чуулганд багш болж, эрчүүдийн дээр эрх мэдлээ бататгахыг би өмгөөлөн дэмждэггүй, харин эв найртай амьдраасай гэж хүсдэг. Учир нь Бурхан эхлээд Адамыг, дараа нь Еваг хэлбэршүүлсэн. Адам Еваг төөрүүлээгүй, харин Ева түүнийг төөрүүлж, Бурханы тушаалыг зөрчсөн болно. Гэвч эмэгтэй хүн үр хүүхдээрээ дамжиж буюу тэднийг итгэл, хайр дотор бойжуулсан нандин хүүхдүүд болгож өсгөхөөс болон цэц ухаан дотор алхахаас ирэх ерөөлийг хүлээн авч, сэргээгдсэн нэр төр дотроо аж төрөх ёстой.

Энэ нь манай өнөөгийн нийгэмд хэрхэн хэрэгжихийг мэдэхийн тулд би нутгийн чуулганыг удирдаж, номлож эмэгтэйчүүдийн динамиктай ажилласаар ирсэн нэгэн теологич, чуулганы удирдагчид хандсан юм. Уитон коллежийн профессор, Виллоу Греек Чуулганы ахлах Др. Гилберт Билезкиан удирдлага дахь эмэгтэйчүүдийн сэдвээр арван найман сар судалгаа хийжээ. Тэгээд *Beyond Sex Roles* гэдэг номдоо өөрийнхөө олзоос мэдээллэжээ:

Товчхондоо Нүглээс өмнө эрчүүд, эмэгтэйчүүд нь хамтрагч нар шиг харилцан холбогдож, хэн хэн нь Бурханы дүр төрхийг тээн, Бурханы бүтээсэн дэлхийг халамжлахдаа хамтдаа дуудагдсан байжээ. Эрчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь Бурханы алдрын төлөөх үйлчлэлээ Бурханы өгсөн бэлгийнхээ бөгөөд хуваарьлагдсан итгэлийнхээ дагуу биелүүлэх хариуцлагатай байсан. Харамсалтай нь Нүглээр энэ хамтын ажиллагаанд ноцтой гэмтэл учиржээ. Авралын төлөөх Бурханы нигүүлсэнгүй төлөвлөгөө нь нүглээр дамжин эвдэрсэн бүхнийг - тэр дундаа эрчүүд, эмэгтэйчүүдийн харилцааг - Бүтээлийн эхний өдрүүдэд байсан гоо үзэсгэлэн рүү нь буцааж сэргээнэ гэдэгт бид итгэдэг. Маш олон үнэнч, мэдлэгтэй Христэд итгэгч нар бидний дүгнэлттэй санал нийлэхгүй биз. Гэхдээ бид эрт орой хэзээ нэгэн өдөр энэ болоод өөр олон сэдэв дээр Бурханы төгс цэц ухаанаас алдуурч одсон хэм хэмжээгээ мэдэх л болно. Харин би зориглон эмэгтэйчүүдийг Бичээсээс хэлсэн зүйлээ хийхийг буюу өөрсдийгөө зүйл зүйлийн сүнслэг бэлэгт бүрэн бололцоотой байлгахыг урамшуулж байна.⁴

Эмэгтэй хүн номлож, зааж, удирдахаар дуудагдсан бөгөөд тэрбээр Бичээст заагдсан зан чанарт тэнцэх амьдралаар аж төрж байгаа бол, түүнийг номлож, заах зэрэг Бурханы захирамжилсан аливаа хүчин чадалдаа тултал нь боловсруулж, сурга. Би ч бас Доктор Билезкианы байр суурийг даруугаар боловч багтай баримталдаг.

Евагийн талаарх Раббигийн ойлголт

Саяхан надад Мессиаид итгэдэг, мундаг Рабби Бриан Билечитэй уулзаж сайхан ярилцах завшаан тохиосон юм. Би түүнтэй Бурханы маш олон охид өөрсдийгөө хэн болохыг ч мэдэхгүй явдаг талаар санал бодлоо хуваалцсан юм л даа. Бурханы охидын тодорхойлолт, нэр төр нь энэ дэлхийн хатуу харгис сүнсний дайрлага дор байсаар байгаа бөгөөд Бурханы маш олон хүндэтгэлийн өргөө нь эмэгтэйчүүлд өгсөн Бурханы бэлгийг хэрхэн тордохоо мэддэггүй.

Бурхан охидынхоо талаар ямар бодолтой явдгийг нь би насаараа номд нь боловсорсон Еврей эрдэмтнээс асуусан юм. Би түүнээс Евагаар эхлэж, Сарахаар үргэлжлүүлэн, Христийн сүйт

бүсгүй болох Чуулган хүртэл яриач гэж хүсэв. Рабби надад маш олон зүйл ярьсан боловч, эдгээрээс би хамгийн чухал гэж үзсэн хэдэн зүйлээ та нарт заавал хэлмээр байна. Учир нь тэдгээр нь чамд өөрийгөө хэн болохыг бататгахад чинь тусална.

Бурхан Адамыг арай ахиу, Еваг арай бага хайрласан юм биш. Ева анхнаасаа л Адамтай цуг байсан. Хэдийгээр Адам Еваг нэрлэж, тэр бүү хэл түүгээр дутаж байсан ч, Ева анхнаасаа л Бурханы санаа байсан юм. Бурхан Евад эмэгтэй хүнийх нь онцгой үзэл бодол, илэрхийллийг өгсөн. Эмэгтэй хүн хэзээд эрэгтэй хүний дотор байсан учраас, эр хүн ганцаараа байснаас эмэгтэй хүнтэй байвал, хавьгүй дээр байна. (Эхлэл 2:18) Ева гарч ирснээр Адамын “сайн биш” нь “маш сайн” болсон юм.

Адамыг гүн унтуулаад, хавиргыг нь задалж, Еваг бүтээснийг бид мэднэ. (Эхлэл 2:21) Эрчүүд ба эмэгтэйчүүд нь тус тусдаа боловч, саланги хэсгүүд биш юм. Тэд хоёулаа нийлээд нэгэн цул болдог. Эрчүүд эмэгтэйчүүд нь илэрхийллээрээ тусдаа боловч, хүчээр салгагдахаар бүтээгдээгүй юм. Нүглээс өмнө үүргийн ялгаа гэж байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс хоёр нь зорилго, зурх, махан биеэр нэг байж чадна.

Нэгэн эмгэнэлт өдөр Ева мэхлэгдэж, Адам тэрсэлсэн. Адамын урвалтаас болж бүх эрчүүд тэрслэх төөрөг тавилантай болоогүй шиг, Евагийн сонголт бүх эмэгтэйчүүдийг мэхлэгдэх төөрөгтэй болгоогүй. Адамын нүглийг Евагийнхаас гайгүй байсан мэтээр дүрслэхийг би бишгүй сонсдог. Үүнийг зүгээр л “хийх ёстойгоо хийгээгүй нүгэл” л гэдэг. Харин рабби маань үүнтэй санал зөрсөн юм. Тэгээд үүнийгээ Бичээсээр баталсан:

Учир нь ганц хүний дуулгаваргүйгээс болж олон нь нүгэлтэн болсны адил Ганцын дуулгавраас болж олон нь зөвт болгуулна. (Ром 5:19)



**Эрчүүд
эмэгтэйчүүд нь
илэрхийлээрээ
тусдаа
боловч, хүчээр
салгагдахаар
бүтээгдээгүй юм.**

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Адамын нүгэл нь зүгээр л хийх ёстойгоо хийгээгүй явдал байгаагүй. Үүнийг арай зөөлхнөөр “зориуд дуулгаваргүй загнах” гэж болох ч, зарим эрдэмтэд урван тэрслэл гэдэг.

Надад Адам, Ева хоёр Бурханы нэрийг хулгай хийх гэж оролдоогүй байгаа гэж бодогддог юм. Учир нь тэд Бурхан болохыг хүссэн шүү дээ!

Манай гэрт хүүхдүүд маань аав, ээжийнхээ зааврыг зориуд зөрчөөд, найзуудынхаа юмуу бие биесийнхээ үгийг сонсбол, бид үүнийг нь хийх ёстойгоо хийсэнгүй дээ гэж үздэггүй. Бид үүнийг нь дуулгаваргүй явдал гэж үздэг. Цэрэгт тушаалыг зориуд зөрчих юм бол, үүнийг нь хийх ёстойгоо хийсэнгүй гэж үзэхгүй, харин тушаал зөрчсөн гэж үздэг. Тэгээд Бурхан Өөрөө Адамын зөрчлийг хэрхэн дүрсэлснийг унш:

Тэрээр Адамд Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир Чамаас болж газар хараагдлаа. Чи түүнээс амьдралынхаа бүхий л өдрүүдэд бэрхшээл зүдүүр дунд хооллох болно. (Эхлэл 3:17)

Адамын хариуцлагыг зөөллөх маяг газар авчээ. (Бид Христийн дотор авран сэргээгдчихээд байхад, Адамын сонголт, үйлдлийг зөөллөж, хамгаалах ямар хэрэг байдгийг би сайн ойлгодоггүй юм.)

Энэ талыг баримтлагчид нь эрчүүдийг босоод, сайн удирдагч байхыг ятган үүрэгддэг бөгөөд би ч үүнд нь үнэн голоосоо: “Тийм бөгөөд амень!” гэдэг. Эрчүүдэд сайн үлгэр загвар хэрэгтэй байгааг би хүлээн зөвшөөрнө. Гэхдээ хамгийн гол нь тэдний энэ суртчилгаагаа хийж байгаа хэлбэрт нь би үнэхээр зовнидог. Тэд эмэгтэйчүүд дуугүй байвал, эрчүүд илүү сайн удирдах юм гэдэг дүгнэлтээ энэ л Адам, Ева хоёрын түүхээр түрүү барин зөвтгөдөг.

Гэхдээ энэ шалтаглал, хандлагад маш их цав цэв бий. Тийм л юм бол, Адам урагшаа гарч ирээд үнэнийг хэлсэн бол, энэ бүхнээс сэргийлж болох л байсан биш үү? Тэрбээр холч ухаанаа Ева дээр биш, могой дээр хэрэглэж болох л байсан шүү дээ. Адам дуу хоолойгоороо могойн амыг барьж чадах л байсан. Эцсийн эцэст бид чинь мах цусны эсрэг дайтаагүй шүү дээ. Үүнтэй адилхан эрчүүд дуу хоолойгоороо Бурханы дүр төрхөөрөө бүтээж, сайн гэж хэлсэн эмэгтэйчүүдийн биш, харин муу ёрын амыг үдэх ёстой юм.

Алс ирээдүйд алдаа гаргахаас сэргийлэх шилдэг арга нь хоригийг биш, зааврыг нээх юм. Өнгөрсөн цагт Евагийн гаргасан алдаа нь ирээдүйд түүний охидын дуу хоолойг үдэх ёсгүй шиг, Адамын нүгэл ч, түүний хөвгүүдийг хүлэх ёсгүй! Хорь гаруй зууны турш эрчүүд, эмэгтэйчүүд чуулганд мөр зэрэгцэн алхахыг сурч явна. Өдгөө бид Христийн дотор хэн болохоо мэдэж, цэцэрлэг дотор анх хэрхэн ажиллахаар бүтээгдсэн шигээ мөр зэрэгцэн удирдахыг сурах цаг болжээ. Эрчүүд нь эр хүн шиг удирдаж, эмэгтэй нь эмэгтэй хүн шиг удирдах ёстой.

Одоо бидэнд Есүс гэдэг үлгэр загвар байгаа - Тэр бидэнд Сатантай хэрхэн харилцахыг үлгэрлэн харуулж өгсөн:

Есүс —Зайл, Сатан аа! “Бурхан Эзэндээ чи мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” гэж бичигдсэн байдаг юм гэлээ. (Матай 4:10)

Бид учир шалтгааны тэмцлээр бохирлогдохын оронд Бурханы үгийг давтах ёстой. Итгэлийн амьдралаар амьдран, амьсгалтай, амьд баримт болж, Бурханд гайхамшигтайгаар үйлчилье. Бидний төгс үлгэр жишээ бол Есүс юм. Бид Түүн шиг алхах ёстой юм. Бид хэн хэнээс илүүтэй - тэр дундаа Паулаас ч илүүтэй Есүсийг дагах ёстой юм. Паул өөрөө Тимотод: “Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайгчид бай” (1Коринт 11:1) хэмээн тэрбээр Христийг дууриадаг шиг өөрийг нь дууриа гэжээ.

Сатаны худал, Бурханы эдгэрэл

Бид Сатаны сүйрлийн зөвлөгөөг сонсох юм бол, тэрбээр эрчүүдийг ч, эмэгтэйчүүдийг ч дээрэмдэж, нэгээс нь хулгайлсан хүчээ нөгөө хүйст нь нэмж өгдөг. Цаг хугацаа урсаж байна. Тиймээс Есүсийн өгсөн мандатыг дагаж, алдагдсан зүйлийг аврахын төлөө явах цаг иржээ. (Лук 19:10) Энэ эвдэрсэн, салан тусгаарласан дэлхийд олон үндэстэнтэй, олон үеийнхэнтэй хүйсийг зорилгоор нэгтгэн, амьсгалтай, амьд үлгэр загвар болох цаг нь хэдийн болжээ. Хүйсийн асуудлыг буруу шийдвэрлэснээрээ, бид аль аль хүйсийг нь тасчиж, гэмтээжээ. Бид Бурханаас өгөгдсөн тодорхойлолтоо сэргээхэд, хүйсийн эдгэрэл явагдаж эхэлдэг.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Заримдаа эмэгтэйчүүд өөрийнхөө тодорхойлолтод асуулга тавьж, энэ эргэлзээ нь түүнийг “би эрэгтэй хүн болчихгүй яв даа” гэхдээ тултлаа томордог байна. Олон эмэгтэй хүйсээ солиулж, хос хүйстэн болсноороо эдгэрэлд хүрэх гэж оролддог. Гэтэл Бурхан эш үзүүлэгч Исаиагаар ингэж хэлүүлжээ:

“Та орвонгоор нь эргүүлжээ! Ваарчинг шавартай адилтган үзэж болох уу? Бүтээгдсэн зүйл нь бүтээгчдээ “Тэр намайг хийгээгүй” гэх юм гэж үү? Ваар нь ваарчиндаа хандан “Тэр мулгуу хүн” гэж өгүүлэх үү?” (Исаиа 29:16)

Тэгэхээр, бид Бурханд итгэдэг үү гэсэн асуулт үлдэнэ? Бид Түүнийг биднийг эхийн хэвэл дотор охид болгон урлаж байхдаа алдаа хийгээгүй, сайн Бурхан гэдэгт итгэж байна уу? Эсвэл гутарсандаа болоод асуудлыг өөрийн гараар шийдэх гэж оролдож байна уу?

Би шарх гэж юу байдгийг мэднэ. Надад итгэ. Бас зарим хүний шарх миний мэдэхгүй хэмжээнд гүн байдгийг ч мэднэ. Гэхдээ хүний гар хүрч чадахгүй газарт Бурхан л хүрч эдгээдэг. Би эмэгтэй хүн болж төрснөө үзэн яддаг байсан. Ээжтэйгээ хэл амаа олдоггүй байсандаа ч тэр үү эсвэл дайсан миний амьдралыг хожим ямар болохыг мэдсэндээ хорлон сүйтгэх ажлаа хийж байсан уу, бүү мэд. Ямар ч байсан амьдралд тохиолдсон явдал, эмэгтэйчүүдтэй тогтоосон харилцаа, чуулган дахь явдал энэ тэрээс болж би эмэгтэй хүн болж төрснөө жигшсэн юм. Бас охидоос илүү хөвгүүдтэй найзалдаг, эршүүд охин байж билээ. Би хөвгүүдэд илүү дуртай байлаа. Тэгээд өсвөр насанд хүрээд, нэг харь гаригийн амьтан шиг юм л ягаан өнгөний болоод гоо сайхны ертөнцийн босгоор хүчээр шахуу давж орсон юм даа. Охидын дохио зангаа, жиг жуг шивнээ, аальгүй занг болхи, танхай охин би ойлгодог ч үгүй, эзэмшээ ч үгүй байлаа. Их сургуульд байхдаа би бүсгүй хүний хэлбэр галбир, шархтай сэтгэлээ пааргар жийнс, мөрөвчтэй өмдөөр л нууж явдаг байсан юм.

Би Жонтой сүй тавихдаа, өөрийгөө эмэгтэй хүний биетэй, эр хүний тархитай амьтан гэдгээ тайлбарлах гэж хичээв. (Харин Жон надад тийм юм байхгүй гэдгийг шууд л хэлсэн!) Эергээр харбал, энэ бүхэн нь намайг дөрвөн хүүтэй болгоход бэлтгэж байсан Бурханы арга зам гэдэгт би итгэдэг. Бурхан намайг

эдгэрлийн урт аян замаар дагуулсан даа. Тэр намайг үнэ цэнэтэй охин гэж шивнэсэн юм. Намайг эмэгтэй хүний маань хувьд хүлж байсан бүх шашны ичгүүр Бурханы оршихуй дотор сүр жавхлант хувцсаар солигдсон юм. Бурхан миний сэтгэлийн цөмд хүрч, охин миний амьдралд ээжийн минь санаандгүйгээр хавчаардаж орхисон айдас, золиосын сэтгэлгээг хуулж хаяад, оронд нь урам зориг, хүч өгсөн юм. Би биеэ үзэмжээр нь биш, харин чадамжаар нь хайрлах болов. Энэ бүхэн нь үйл явц, аялал байсан бөгөөд миний энэ амьдралын гэрчлэлээр өөр олон хүн эдгэрэлд хүрч чадах болсон юм.

Гэхдээ өнөөдөр энэ эрин цагт хүйсийн эрх үүргийн ялгаварлалыг хөхүүлэн дэмжих явдлаас болж, би хүйсийн асуудалтай зөрчилдөж байна. Орчин үеийн соёл бүхнийг өөрийнхөө гарт авч, үндсэндээ эр хүн болохыг уриалах! Гэхдээ хэрэв би ингэсэн бол, Бурханы эдгэрлийн үйл явцыг болон өдийг хүртэл сурсан бүх сургамжаа таслан зогсоох байсан. Бид өөрийгөө бусадтай харьцуулахаа больчихбол сул талтай, юутай хийтэй нь байгаагаар нь л хүлээж авч сурна.

Тэгэхээр, эдгэрлийг харахын тулд ямар алхам хийх вэ?

1. *Залбир.* Чамд хоёрдмол бус зүрх өгч, бүхий л буруу сэтгэлгээ, дуулгаваргүй талыг чинь илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуй. Хүйсийн шүүвэр, няцаалт нь бидний өөрийнхөө талаар болоод өрөөлийн талаарх үзэл бодол руу маань мацан, хорлон сүйтгэж чадна. Хуваагдлын бус, эвлэрлийн үйлчлэгч бай.
2. *Бурханы хүсэлд бүрэн даатга.* Чи мэддэг Бичээсийнхээ үгийг юмуу залбирлаар илчлэгдсэн зүйлээ бус, хүний үгийг дагаж, эргэлзэж байсан байж магадгүй. Эсвэл хүнээс айх айдсаасаа болж Бурханы хүслээс дайжсан байж магадгүй. Аугаа захирамж нь амьдралын чинь энэ улиралд хэрхэн хэрэгжих ёстойг Бурханаас асуунгаа, дараагийн улиралд чинь өөрөөр хэрэгжиж болохыг бас мэдээрэй.
3. *Дайснаа мэд.* Бид мах, цустай дайтаагүй. Хоёр санаатай хүн хоёр талд ажилладаг тагнуул шиг л байдаг. Гэтэл Иаков биднийг Бурханд захирагдаад, диаволыг эсэргүүцбэл, тэр зайлна гэсэн.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

4. *Амьдрал, яриагаа нягтал.* Чиний хэлж, үйлдэж байгаа зүйл чинь хүйсийн шүүхийг тэжээж байж болох? Ариун Сүнс чиний буулт хийж байгаа талыг чинь илчилсэн бол, шүүх, эсэргүүцэх асуудал амьдралд чинь байгаагийн л шинж.
5. *Зогс.* Юуны ч төлөө зогсдоггүй хүмүүс бүх юманд унах эрсдэлтэй. Эрчүүд, эмэгтэйчүүд мөр зэрэгцэн ажиллахыг эсэргүүцдэг хүмүүс нь Бурханы анхдагч мандагтай зориуд бусаар дайсагнаж байгаа юм.
6. *Христийн биеийн нэгдлийн төлөө тэмц.* Эрчүүд, эмэгтэйчүүд нь өрсөлдөгч биш юм. Бид ахан дүүс, бат хамтрагч, хамгаалагч нар юм. Бид нөхөрлөл, харилцан хүндэтгэл, ахан дүүсийн хайраар амьдрах ёстой юм. Бид бие биеийнхээ бэлгийг урамшуулан дэмжих ёстой. Бурхан эмэгтэй хүнийг таг дуугүй байгаасай гэж хүссэн бол, юу гэж дуу хоолой өгөхөв дээ? Адамд ч, энэ дэлхийд ч эмэгтэй хүний дуу хоолой хэрэгтэй гэдгийг Бурхан мэдэж байжээ.

Бие биеэ нөхдөг, харилцан хамааралтай

Би ач охидоо сэтгэх, сурах асуулт асуух хүчтэй байгаасай, тийнхүү жинхэнээсээ сураасай, сурснаараа итгэлээрээ амьдраасай гэж хүсдэг. Эмэгтэйчүүдийг дахин төрж болно гэж хүлээн зөвшөөрдөг ч, тэднийг жинхэнээсээ бүрэн төгс эрх чөлөөтэй болсныг няцаах доктрин, ухуулга байсаар байна. Тэд эмэгтэй хүмүүсийг Христийн захирамжийн эрх чөлөө дотроос биш, харин чуулганы хязгаар дотроос ажиллахыг л зөвшөөрдөг.

Мунхаг эрчүүд, эмэгтэйчүүд аль Эдэний үеэс л бие биеэ тэнэг сонголтынх нь төлөө яллсаар ирсэн. Ял, ичгүүр нь хэзээ ч хэнд ч өөдлөх шат болж байгаагүй. Ял, ичгүүр нь хөвгүүд, охидын хэн хэнийх нь дүр төрхийг бохирлон бүрхэгдүүлдэг. Энэ бохирдол нь Христийн дотор Бурханы цэвэр болгоогүй зүйлийг дахин бохир болгодог.

Хүйс нь тэнгэрлэг гоо үзэсгэлэнг илэрхийлэхээр бүтээгдсэн. Харамсалтай нь бид гагцхүү Бурханы л өгч чадах баталгааг бие биеэсээ авахыг хүссэндээ, нэг нэгнийхээ тэнгэрлэг нэр төр,

хүчийг дээрэмддэг. Бурхан биднийг бие биеийнхээ ялгааг гутаан доромжлох биш, харин талархан дэмжээсэй гэж хүсдэг.

Тэгээд одоо бидний нүцгэн байдал Христийн дотор зөвт байдлаар хувцаслагджээ. Христийн дотор эрэгтэй, эмэгтэй хүмүүс дайсан биш, хамтрагч байхаар бүтээгдсэн. 1Коринт 11:10-12 дээрх Паулын үг нь бидэнд бие биеэ хэрхэн харах тодорхой зураглал өгч байна. Энэ үгийг ишлэл ишлэлээр нь задалж үзье. 10-аар ишлэл:

“Тиймээс тэнгэрэлч нарын улмаас эм хүн толгой дээрээ эрх мэдлийн тэмдэг байлгах ёстой.”

Христийн дотор эрчүүд, эмэгтэйчүүд тусгаар гэхээсээ илүү харилцан хамааралтай юм. Бидний эх ундарга нь Бурхан боловч, эдгээр ишлэл нь хүйсийн тэмцэл гэдэг өрсөлдөөний талаар хэлжээ.

Бидний ялгаа нь бие биеэ сэлбэхийн төлөө юм. Харилцан хамаарал, оролцоо байгаа газар даргалал, ноёрхол байх газаргүй. Библи энэ талаар цааш нь ингэж хэлжээ:

Гэвч Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм. (и11)

Паул энд эр, эм хүйсийн талаарх ярианаас зориуд эр хүн ба эхнэрийн талаарх яриа руу шилжиж байна. Тэрбээр энэ үгээрээ аль аль хүйст өндөр үнэлгээ өгч байгаа нь надад гоё санагддаг. Нөхөр минь Бурханыг, намайг, хүүхдүүдээ хайрлах хайраараа намайг сайхан харагдуулдаг шиг, би ч бас Бурханыг, гэр бүлээ, нөхрөө хайрлах хайраараа ханиа сайхан харагдуулахыг хүсч байна. Дараа нь Паул гэрлэлтийн динамикаас хавьгүй ерөнхий сэдэв рүү эргэжээ.

Учир нь эм хүн эр хүнээс буй болсончлон эр хүн эм хүнээр буй болсон. (и12)

Эмэгтэй хүн анхлан эр хүний дотор шаглагдсан бол, өдгөө эр хүн эмэгтэй хүний дотор шаглагддаг болжээ. Эхлээд эмэгтэй хүн Адам гэдэг эр хүнээс төрсөн бол, бид бүгдээрээ хоёр дахь Адам болох Есүсээс төрсөн юм. Паул цааш нь:

“Харин бүгд Бурханаас болой” (и12) гэж хэлжээ.

Хэн хамгийн чухал бөгөөд шилдэг болох өрсөлдөөн нь Бурхан хэн бэ гэдэг илчлэлийн өмнө хөсөр унах ёстой. Бурхан ганцаараа ариун гэдэг тэнгэрлэг үзэл бодлыг бид сэргээх ёстой. Тэр эхэн бөгөөд эцэс, эхлэл бөгөөд төгсгөл, Альфа хийгээд Омега Бурхан. Бидний Аав шиг удирддаг, хайрладаг хэн ч байхгүй.

Энэ нь Бурхан хөвгүүдээ охидоосоо илүү хайрладаг гэсэн үг биш юм. Бас Бурхан хүйсийг эн тэгш хайрладаггүй. Бурхан эрэгтэй, эмэгтэйг онцлон хайрладаг. Бид нэгийг нь нөгөөгөөс нь дээр өргөхдөө, Бурханы дүр төрхөөс салж явдаг. Учир нь Бурхан хүйсийг Өөрийнхөө илэрхийлэл болгосон юм.

Анхны чуулган дахь эрчүүд, эмэгтэйчүүд

Бид жинхэнэ түүхээ мэдэхгүйгээсээ болоод, хувь тавилангаа бууруулдаг ч, бидний ойлголтыг бүрхээд байсан дайсны бүрхүүлийг Ариун Сүнс нурааж хаяж байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна. Бичээсийг тоймлон үзбэл, анхны чуулган ч энэ асуудалтай тулгарч байсныг харж болно. Соёл нь тэдний хөдөлгөөнийг хязгаарлах гэж оролдсон ч, энэ нь тэднийг улам л тэлж, улам л том газрыг эзлэхэд хүргэжээ. Тэд Хамгийн дээд Нэгэнд хэдийнээ мөргөчихсөн учраас, газрын хаадын тушаалд баригдаагүй юм. Тэд өдөр тутам тэмдэг, гайхамшиг, ер бусын гайхамшиг дотор явж байсан. Туйлын эрх мэдэл нь үл харагдах талбарт байдгийг тэд ойлгосон байжээ.

Тэд Бурханы Сүнсээр тэмдэглэгдэж, гавьяа байгуулахаар тусгаарлагдсан байв. Сүмийн нэг хэсэгт эрчүүд, нөгөө хэсэгт эмэгтэйчүүд багшралдаж байсан гэж бүү төсөөлөөрэй. Тэд голдуу гэрээр, зах зээлд, газар доорх байгууламжид, тэр бүү хэл усан онгоцон дээр бас шоронд уулзалддаг байсан. Янз бүрийн овог аймаг, хэл, ахуй соёлоос гаралтай хоёр хүйс ганц л Ариун Сүнсээр нэгдэж, Христийн сүйт бүсгүй болох нэг л биеийг бүрдүүлэхээр нэгдэн зогсжээ. Бид хамтдаа зогсбол, ямар ч тал биш, Христийнх гэсэн ганц л тал байна. Тэд Сайн мэдээг гэрээс гэрт хуваалцсан. Энэ органик бие хэрхэн органикаар өссөнийг бид Үйлс 2:42-44-өөс харж чадна:

“Тэд, элч нарын сургаалд мөн нөхөрлөлд, талх хуваалт, залбиралд өөрсдийгөө зориулдаг байлаа. Хүн бүрд айдас байлаа. Учир нь элч нараар [Иерусалимд] олон гайхамшиг, тэмдэг үйлдэгдэж байв. Итгэсэн бүгд хамтаараа байцгаан, бүх юм нь нийтийнх байв.”

“Бүх юм нь нийтийнх байлаа” гэдэг хэллэгийг зөвхөн эд юмсаар хязгаарлаж ойлгож болохгүй. Үүнд тэдний хүндэтгэл, эмээхүй, нөхөрлөл, хоол, залбирал, эзэмшил бүгд багтана. Нийтлэг гэдэг нь хамтын, түгээмэл, өдөр тутмын, нийтийн гэсэн утгатай.

Эрчүүд, эмэгтэйчүүд нөхөрлөх ба заахын аль аль тал дээр бие биедээ маш дотно байв. Нөхөрлөхгүйгээр заах нь бие биеийнхээ хэрэгцээнд үйлчилдэг нийгмийг бүтээхгүй. Бас ширээ тойрон ярилцахгүйгээр заах нь нэг хүний дарангуйллыг үүсгэх юмуу үнэнийг сүйтгэнэ. Сурсан зүйл маань бидний үнэнийг хэр зэрэг мэддэг мэдлэгээр биш, харин хэр зэрэг үнэнээр амьдардгаар л харагдана. Маш олон хүн амьдардаггүй атлаа толгойдоо хадгалдаг мэдлэгээсээ болоод зөрчлийнхөө хоригдол болдог. Биднийг байрандаа цэх байж, үнэнийг хэрэгжүүлэхэд гэр бүл, нөхөд маань маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

Анхны чуулганд эмэгтэйчүүд дуу хоолойгоо өргөдөг байсан. Эс бөгөөс Ананиа, Сафир хоёрын түүх өөрөөр эргэх байв. Үйлс 5:1-11 дээр гэргийгээ байхгүй хойгуур Петрт худлаа хэлээд үхсэн эрийн тухай гардаг. Гурван цагийн дараа гэргий нь ирдэг. Тэрбээр нөхрийнхөө үхлийн талаар мэдээгүй байсан ч, юу гэж худлаа хэлэхээ сайн мэдэж байжээ. Петр түүнээс нөгөө л асуултаа асуухад, тэрбээр нөхөртэйгээ адилхан худлаа хэлээд үхэхийн унадаг. Тэгвэл өнөөгийн заадаг шиг эмэгтэй хүн дуугүй л байх ёстой юм бол, Сафир “нөхрийнхөө хүслийг хамгаалж, хүндэтгэсэн” гэдэг шалтгаар амьд үлдэх ёстой биз дээ? Гэтэл Сафир үнэнээ хэлэхийн оронд худлаа хэлээд, амиараа шийтгүүлсэн юм. Тэр дуу хоолойгоо буруугаар ашиглажээ. Хэрэв тэр Петрт үнэнээ хэлсэн бол, амьдрах л байсан юм.

Нигүүлсэл, өршөөлийн илчлэл хэнийг ч орхигдуулдаггүй. Эрчүүд ч, эмэгтэйчүүд ч үнэ цэнэтэй хувь нэмэр авчирдаг. Тэдний олонх нь энэ эрч хүчийг анх удаа л мэдэрсэн. Нүглийн салгасныг

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Бурхан нэг цул болгон сэргээхээр тосолжээ. Эрчүүд, эмэгтэйчүүд “хотынхоо талбайд ч, газрын мухарт ч мөр зэрэгцэн” нигүүлслээр хийгээд хүчээр үйлчилсэн. Үйлс 2:46-47 дээр анхны чуулганы хэмнэлийг ийнхүү тайлбарлажээ:

“Өдөр бүр тэд нэг сэтгэлээр сүмд цуглаж, талхаа айлуудад хувааж, талархал хийгээд өгөөмөр зүрхээр хооллоцгоон, Бурханыг магтаж, хамаг ардын хайр хүндэтгэлийг олж байв. Эзэн, аврагдагсдыг тэдэн дээр өдрөөс өдөрт нэмэгдүүлж байлаа.”

Дээрх ишлэл дээрх “өдөр бүр” гэдэг хэмнэлийг анхны чуулган дээрх нигүүлсэл гэдэг. Иүдей итгэгчид сүмдээ нэгдэн цуглаж, айлаас айлд нөхөрлөж, талархалтай, өгөөмөр зүрхээр ширээ тойрон сууж, Бурханаа магтах магтаалаар амьдрал нь бялхаж, хүмүүсийн таалал дор алхаж байсан.

Тийм байтал Есүсийн сүйт бүсгүй болсон чуулган эмэгтэйчүүдийг хасч, бууруулж, үнэгүйдүүлж, дорд үзэж яаж чадна? Бид тэдгээр баатрууд шиг биш гэдэг худалд бид яагаад итгэнэ вэ?

Эрчүүд, эмэгтэйчүүд хамтдаа гэдэг баримтыг бид дэндүү удаан дарагдуулжээ. Аминч сэтгэлгээ, буруу шүүхээр тусгаарлагдсан амьдралын эндэл нь хоёр хүйсийг хоёуланг нь шархдуулжээ.

Гэхдээ энэ бол түүхийн төгсгөл юмуу эцсийн үг биш юм. Тэнгэр бидэнд бие биеэ шархлуулж, өрсөлдөх загвар өгөөгүй. Бид хамт байхдаа, ялгаагаараа бие биеэ нөхөж, ганц ганцаараа байснаас хавьгүй хүчтэй болдог. Бурханы хөвгүүд, охидын атгасан гар шиг нэгдмэл амьдрал нь энэ дэлхий дээр хараахан төгс илэрхийлэгдээгүй байж болно. Гэхдээ нэгдлээр дамжин Бурханы дүр төрх тайлагдаж, Бурханы алдар урьд хожид үзэгдээгүйгээрээ цацрах болно.

Хэлэлцэх асуулт

1. Эрчүүдийн өөрийнхөө хүчээр тулалдах гэж үздэг тулаанаас нэрлэнэ үү?
2. Эмэгтэй хүнийхээ хувьд чи Бурханы дуудлага хийгээд хүний тогтоосон заншлын дунд зөрчилдөж үзсэн үү?
3. Аугаа захирамж чиний амьдралд ямархуу харагдаж байна?
4. “Таарахгүй”, “итгэмтгий” “амархан мэхлэгддэг” гэдэг үгс чамд ямар санагдаж байна?
5. Чи Сайн мэдээний үйлчлэлийн тал дээрх ур чадвараа хэрхэн хөгжүүлж болох вэ?
6. Чи ялын тоглоомд урхидуулж үзсэн үү?

Айдсын болон хайрын өрсөлдөөн

Хайр бол сэтгэлийн гоо үзэсгэлэн.

Гэгээн Августин

Саяхан Жон, бид хоёр хамгийн хайртай нэгэн чуулгандаа асуулт хариулт явуулсан юм. Тэр бүтэн сайны оройн цуглаанд бидний хувьд бараг л гэр бүл шиг дотны хүмүүс маань цугладаг. Хичээлийн төгсгөлд бидэнд нэгэн том асуулт ирэв. “Гуч гаруй жил ханилсны эцэст та хоёрт эргэж хараад харуусдаг зүйл байдаг уу?” Үнэндээ бол надад тавьсан асуулт л даа. Цаг дуусч байсан болохоор, би үнэнээсээ бөгөөд товч хариулахыг хүссэн юм. Тэгээд том амьсгаа аваад: “Би Жонд илүү их алдаа хийхийг зөвшөөрч, харин өөрөө түүнийг илүү айдасгүй хайрлах байсан” хэмээн үнэнээ л хэллээ.

Тэгтэл хүмүүсийн дундуур гүйдэл гүйх шиг л болов. Би суусан газраасаа эрчүүд, эмэгтэйчүүд нулимсаа бушуухан шиг арчихыг бас гүн санаа алдаж, чив чимээгүй толгой дохихыг харсан. Айдас бол хайрын маш том өрсөлдөгч... эрч хүчээрээ эн тэнцүү бөгөөд завхруулах чадлаараа үхэлд ч хүргэх чадвартай эд.

Миний гэрлэлтийн амьдралдаа айдаг байсан маш олон зүйлс биелэх нь байтугай, төстэй ч юм болоогүй. Шөнөөр намайг тарчлаадаг байсан тэдгээр зовнил миний нүүрэнд зөвхөн үрчлээ

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

л нэмсэн юм. Би сайн хичээсэн учраас тэр биш, харин Бурхан дэндүү итгэмжтэй учраас л тэр.

Мэдээж би аль болох алдаагүй л амьдрах юмсан гэж хичээдэг. Гэхдээ одоо би өөрийгөө тэр үед илүү их айдасгүй байж, эрсдэл хийхгүй явдаа гэж харуусдаг. Айдас бидний амьдралыг хуу дээрэмддэгийг бид төсөөлөх ч үгүй. Айдас бол гэрлэлтийн маш муу зөвлөх. Энэ нь хайрын идэвхижлийг сааруулж бүр зогсонги байдалд оруулдаг. Бид үүнийг ухаарсан ч, ухаараагүй ч - хайр ба эрсдэл нь нягт холбоотой юм.

Би хайрбиш айдас ноёлсон гэрт өссөн. Айдас аав, ээжийн минь амьдралд том дуугардаг байсан. Тэдний найз нөхдийн хүрээнд ч лав сууж, тэр бүү хэл гэр бүлийн маань санхүүг ч хоосолсон. Манайд хэзээ ч хангалттай мөнгө, хайр, итгэх хүмүүс байгаагүй. Айдас манай сайхан гэрийн өрөө бүрээр исгэрч, зураггүй хананаас маань ойдог байсан. Аав маань барилгачин хүн байсан ч, айдас манай гэрийг хүртэл хүнийх юм шиг хүйтэн хөндий байлгаж дөнгөсөн юм. Өчнөөн олон шөнө дүү, бид хоёр аав, ээжийнхээ хэрүүлийн чимээнд унтаж чадахгүй, орондоо хөрвөөдөг байлаа. Би гар чийдэнгийн гэрэл дор тэмдэглэлийн дэвгэртээ сэтгэлээ уудалж, харанхуй дотор андгай тангараг өргөнө. Тэдгээр хурц хурц үгс маань намайг хамгаална гэж би бодсон юм. Тэгээд би өөрийгөө хэзээ ч сул дорой байхгүй гэж амласан. Аав, ээж хоёр маань хоёр ч удаа салж нийлж, эцэстээ эв найртайгаар биш, харин дайснууд шиг зам салсан юм даа.

Харин би итгэгч болоход зүрх минь гэртэй болсон ч, би гэртээ яг яаж байхаа мэддэггүй байв. Гэрлэлтийнхээ эхний арван жил би хүүхэд байхдаа өөрийн гараар барьсан үй олон хуурамч хамгаалалтын тортойгоо нүүр тулах хэрэгтэй болсон юм. Сул дорой байхыг хүсээгүйдээ, би яаж уучилж, уучлагдахаа мэдэхгүй байв. Тэдгээр торон утас нь намайг, миний гэр бүлийн амьдралыг ч боомилж алахаа дөхсөн юм. Нөхөр минь ааваас минь тэс өөр, би ч ээж шигээ биш атлаа нөхөртэйгээ муудалцах үедээ би аав, ээж маань намайг унтсан гэж бодоод, зоргоороо шидэлцэж байхад нь шүүрч аваад, өөрийн болгосон үгсээ Жон руу нүүлгэдэг байлаа.

Ийм замаар би ээж, аавынхаа айдсын өвийг үр хойчдоо авчирч байснаа даруй зогсоох хэрэгтэй байсан юм. Жоны төгс бус байдал миний төгс бус байдлыг илчилсэн бөгөөд үнэндээ миний бодсоноос ч том том хэмжээгээр илчилж байсан юм. Би үнэн гэж мэддэг зүйлээ хийхийн оронд хүүхэд байхдаа сурснаараа л үйлдэж байлаа.

Хэдийгээр би Жоныг таарсан тунгаар нь уучилж байна хэмээн харам сэтгэлээр жаахан жаахан өршөөдөг байсан ч, энэ дунд гэрлэлтийн гэрээ маань зүгээр л нэг албан гэрээ болон хувирч, хайр маань хагдарч байлаа.

Би айж байсан учраас, Жоныг айдасгүйгээр хайрлаж чадахгүй байсан юм.

Би биеэ хамгаалах гэж хичээхдээ, зүрхнийхээ том том үл хөдлөх хөрөнгийг эргүүлэн нэхэж эхэлсэн. Яагаад гэвэл гэрлэлтийнхээ эхний хэдэн жил Жон гэр бүлдээ порно, гар хангалга зэргийг авчирч байгааг би олж мэдсэн юм. (Жон, бид хоёр энэ тал дээр хэнээс ч ичдэггүй) Гэтэл миний өмнөх амьдралд Жон хичнээн өршөөнгүй хандсаныг би мартаад, түүнээс хөндийрөв. Би Жоны тал дээр “уучлагдахын тулд уучил” гэсэн Есүсийн үгийг огт хэрэгссэнгүй. Би айсандаа, чөлөөлөгдөх гэж тэмцэлдэж байгаа Жонд тус дэм болох нь бүү хэл, улам л ичээж зовоодог байлаа. Би энэ асуудлыг бидний биш, гагцхүү Жоны асуудал гэж үзсэн юм. Энэ бүхний гол шалтгаан нь би өөрөө өнгөрсөн амьдралынхаа дарамтаас чөлөөлөгдөж чадахгүй, өөрийгөө үүнээс илүү хувь заяагүй хүн гэж бодож байсанд оршиж байлаа. Би зогсоо зайгүй тэмцэлдэж байв. Би нөхрөөсөө хөндийрч, түүнийг яаж ганцаараа зовж байгааг алсаас л хардаг байлаа. Түүнийг ингэж шүүх нь зарим талаараа надад тайтгарал болдог байв. Тэр өөрчлөгдөхгүй бол, би түүнийг уучлах шаардлагагүй шүү дээ. Үүнээс болж амьдралын маань бусад тал ч хямардаг байв. Энэ бүхэн нь бид хоёрын амьдралын эхний хэдэн жилийг зовох ёстойгоос нь илүү зовоосон байх.

Нэгэн шөнө би цухалдаж, өвдсөндөө: “Би Жоныг өөрчлөгдөх юм бол, уучилна!” гэж Бурхан руу хашхирсан юм.

Тухайн үед би Жон, бид хоёрын хамаг итгэлцэл сүйрчихсэн гэж үзэж байсан тул дахиж сэтгэлээ өвтгөхийг хүсэхгүй байлаа. Гэтэл Бурхан миний мэдэгдлийг: “Лиза, чи Надад итгэдэг үү?” гэсэн асуултаар хариулав.

-“Итгэдэг.”

-“Сайн байна. Тэгвэл чи Жоныг уучил. Тэгвэл тэр өөрчлөгдөнө.”

Ингээд Бурхан надад хэлэх үгийг минь хүртэл зааж өгөв: “Чамайг өөрчлөгдөхийг хүсч байгаа гэдэгт би итгэж байна. Тиймээс би чамайг уучилна аа.”

Энэ нь “Чамайг өөрчлөгдөхөөр чинь үнэхээр гэмшжээ гэдэгт чинь итгэе” гэдэг миний өөрийн үгээс тэс өөр үг байв.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Миний хувьд ийм юм сэтгэнэ гэж хэзээ ч байхгүй учраас, энэ нь Бурханы удирдамж чиглүүлэг гэдэг нь эргэлзээгүй байлаа. Тэгээд миний зүгээс Жонд болзолгүй өршөөл үзүүлж эхэлмэгц, бид хоёр хоёулаа эдгэрч эхлэсэн юм. Тэр ичгүүрийн харанхуйгаас гэрэлд гарч, гэрэлд хүлээнэсээ тайлагдах эрх чөлөө олсон юм. Энэ бол эргэх цэг байв. Би хувирашгүй Бурханд итгэж найдаж чадах байлаа.

Аймшиггүй хайр

Аймшиггүй хайр хүний гүйцэтгэл дээр биш, Бурханы хайрын итгэмжтэй байдал дээр суурилдаг. Би нүгэл, зөрчлөө Есүсийн нэрээр Аавдаа хэлэхдээ хэзээ ч ичдэггүй. Бурхан миний сайн сайхан ирээдүйд итгэдэг.

Хүмүүс биднийг гомдооход, бид ирээдүйд гарах эрсдлийг багасгахын тулд тэдэнд тааруулж, хайраа хэсэглэн хувааж эхэлдэг. Бид байгаа бүхнээ тавьж туухаас айсандаа, хойш суудаг. Си. Эс. Люис энэ алдааг “Дөрвөн хайр” гэдэг номдоо маш сайхан тайлбарласан байдаг:

Хайрлана гэдэг өөрөө эмзэг зүйл шүү дээ. Ямар ч зүйлийг хайрласан бай зүрх чинь шархална, магадгүй бүр эмтэрнэ. Зүрхээ цул хадгалмаар байвал, зүгээр л хэнд ч бүү хүртээ - мал амьганд ч хүртэл. Зугаа, аахар шаахар тансаглалаар зүрхээ өлгийлж, бүх хэлбэрийн харилцаанаас зайлсхий. Зүрхээ аминч чанарынхаа авсанд юмуу аль нэг хайрцагт дангинатал түгжчих. Гэхдээ тэр хайрцаг дотор, аюулгүй, харанхуй, хөдөлгөөнгүй, агааргүй нөхцөлд зүрх өөрчлөгдөнө. Зүрх эмтэрдэг биш, харин эвдэршгүй, нэвтэршгүй, авралгүй болно. Тиймээс хайрлана гэдэг эмзэг байна.

Ойлгов уу. *Хайр эмзэг байдаг байх нь.* Чамд энэ зүйрлэл таалагдахгүй байж болно. Гэхдээ үүнээс зугтах арга зүгээр л байдаггүйг би өөрөө ч сурсан юм шүү. (Би өөр арга олох гэж өчнөөн оролдсон гэдэгт минь итгэж болно) Гэхдээ нэг зүйлийг мэдээрэй - эмзэг байна гэдэг нь хэн дуртайд нь хүссэнээр нь хүчирхийлүүлээд явна гэсэн үг биш шүү. Үнэндээ энэ нь өөрийгөө батлан харуулахыг л хэлж байгаа юм. Учир нь хайр хэзээ ч бууж өгдөггүй.

Бүгдээрээ эмзэг байх эрсдлийг арай жаахан малтаж үзье. Эмзэг байхыг “ил байх” гэж тодорхойлдог. Эмзэг байхыг нүцгэн байхтай

тэнцүүлж ойлгож болно. Нүцгэн байх нь маш эрсдэлтэй зүйл. Яагаад гэвэл бүх юм нь хамгаалалтгүй, ил байна. Харин чи нүцгэн бөгөөд үүндээ ичэхгүй байвал, хайр хамгийн аюулгүй байр сууриндаа байдаг.

Манай өнөөгийн соёл нүцгэн байдлаас бэлгийн сэтгэлгээ руу дэндүү амархан шилжиж байна. Харин би нүцгэн хийгээд ичгүүргүй гэдгийг ил зүрхтэй гэж дүрсэлнэ. Бид Бурханы өмнө нээлттэй зогсож байхдаа л хамгийн хүчтэй байр сууринд байна. Хүний ухаанаар бодохоор таарахгүй байгаа мэт боловч, цөхөрсөндөө хүнлэг байдлаа өөрийгөө зөвтгөх хувцсаар юмуу ичгүүрийн хучаасаар халхалж байснаас, Бурханы өмнө нүцгэн задгай зогсох нь хавьгүй дээр.

Есүс бидний төлөө, биднийг өөр шигээ болгох гэж тэнгэрлэг мөн чанараасаа нүцгэлэхдээ, Өөрийгөө эмзэг болгосон юм. Есүс бидэнд Бурханы хайрыг илчлэх гэсэндээ эмзэг болсон. Тиймээс л бид айдасгүй хайрлаж, аймшиггүй итгэж, аймаар найдах ёстой.

Чи айдасгүй хайрлах гэж байгаа бол, хайрла... гэхдээ дургүйцэлд бэлэн бай. Найдвараа тээр хол хөлгүй гүн усанд зангуу мэт хая.

Итгэл, найдвар, хайр гурав нь салшгүй. Эвлэн нэгдсэн итгэл, найдвар, хайр л бидэнд баг зогсох хүч өгдөг. Энэ гурван хүчний хамгийн том нь хайр юм. Хайр байхгүйгээр жинхэнэ итгэлийн үйлс байхгүй, хайр байхгүй бол, найдвар байхгүй.

Бурхан бол хайр. Хайр бол мөнхийн. Хайр хэзээ ч хөсөрдүүлдэггүй бөгөөд хайрлахаар итгэмжлэгдсэн зүйл нь хэзээ ч алдагдахгүй. Харин хайраас төрсөн юу ч үхэхгүй. Хайр өсдөггүй газар байна аа. Хайр нь өрсөлдөгч айдсын дэргэд цэцэглэхгүй. Айдас нь тарчлаанд хүргэдэг бурханлаг бус сүнс юм. Айдас эргэлзээний сүүдэр дорх суудлаасаа зөвлөдөг бол, хайр итгэлийн гэрэл дундаас цэц ухаанаа илгээдэг. Тэгээд хэрэв чи айдсыг цаг үргэлж анхааралтай сонсоод байвал, бүтэлгүйтнэ.

Олон жилийн өмнө би анхныхаа номыг бичиж байхдаа, айдсын эсрэг зүйл нь итгэл юмуу урам зориг биш, харин хайр болохыг олж мэдсэн юм. Хулчгар арсланг хайр бүтээснийг би жаахан



Айдсын эсрэг нь итгэл эсвэл эр зориг биш ... харин хайр юм.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

байхдаа уншдаг байсан “*Магад эрдэнийн хотын илбэчин*” гэдэг номоосоо санах ёстой байж. Тэгээд IКоринт 13-ыг айдсын сөрөг чанаруудаар орлуулахад, энэ санаа улам батажсан юм:

Айдас тэвчээргүй, энэрэнгүй биш. Айдас атаархдаг. Айдас агсанадаг, ихэрхдэг, зүй бус авирладаг, өөрийнхийг эрдэг, зэвүүрхдэг, өс хураадаг, зүй бус юманд баярладаг, харин үнэнд баярладаггүй, бүгдийг далдалдаггүй, бүгдэд итгэдэггүй, бүгдэд найддаггүй, бүгдийг тэсвэрлэдэггүй. Айдас хэзээд дуусдаг.

Айдсын үр жимс ба хөдөлгүүр нь хайрынхаас яг эсрэг байдаг. Би айдсыг цөмлөж гарахдаа л хийсэн бүхэн, сурсан бүхнээ ухаарсан юм.

Аюулд дурлахихсан хүмүүс бий. Тэд зоригтой хүмүүс мөн. Гэхдээ хайрлаж чаддаг хүмүүс л айдасгүй байдаг.

Бурхан - хайр. Хайр айдасгүй. Бурхан айдасгүй. Бид Бурханых. Бид айдасгүйгээр хайрлаж чадна. Бид биднийг гэх Бурханы айдасгүй хайрыг хүлээж авсан цагтаа л айдасгүйгээр хайрлаж сурна. Айдасгүйгээр хайрладаг хүмүүс айдасгүй амьдардаг.

Магадгүй энэ дэвшил мэдээжийн санагдаж байж болох ч, Бурханы олон хүмүүс хамгаалалтаа алдчихсан явж байдаг. Бид сонссон, харсан зүйлээсээ болж айж, уурладаг бөгөөд Бурхан ч бас харгислал, муу ёр, гамшигт яг ингэж ханддаг гэж бид төсөөлдөг ч, үнэндээ үгүй юм.

Төгс хайр

Хайрын сэдэл байхгүй бол, зоригтнууд зүгээр л эр бяраа гайхуулна. Тэдний үйлдэл нь хайрыг үлгэрлэн харуулна гэхээсээ илүү бусдыг бишрүүлэх гэсэн санаархалтай л байдаг. Зоригтой харагдах нь хангалтгүй юм. Учир нь чиний хийж болох хамгийн зоригтой үйлдэл нь бусдын төлөө өөрийгөө эрсдэлд оруулах юм. Энэ нь бид босоод тулалдахын оронд зүгээр л амиа өгөх ёстой гэсэн үг юм.

Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас илүү агуу хайр байхгүй.
(Иохан 15:13)

Мессеж Библи дээр “Нөхдийнхөө төлөө амиа дээсэн дээр тавих нь хайрын хамгийн дээд зам юм” гэдэг.

Энэ үйлдэл нь үзүүлбэр биш, харин золиос юм. Хайр байхгүй, ийм дан эр зоригийг 1Коринт 13:3 дээр ингэж жинлэсэн байна:

“Хэрэв би бүх өмч хөрөнгөө тараан өгч, биеэ шатаахаар тушаасан ч надад хайр үгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм.”

Тэгэхээр хайр байхгүй өглөг, золиос нь зүгээр л шашны тахилаас өөрцгүй юм.

Есүсийг Аав нь хамгаас хайрлаж, Есүс ч Аав шигээ гүн хайрлахыг сонгосон. Хайр л Есүст итгэл дотор тэвчих хүчийг өгсөн бөгөөд Түүний найдварын алсын хараа нь бид байв.

Есүс намайг хэн байсныг маань үл харгалзан хайрласан. Тэр намайг ирээдүйд алдчих вий гэж айгаагүй. Тэр намайг алдана гэдгийг мэдэж байсан. Бид бүгдээрээ алдаа хийдэг нь үнэн боловч, энэ нь чи өөрөө алдаа гэсэн үг биш юм. Хэрэв чи өөрийгөө алдаа гэж бодож байгаа бол, маш том алдаж байна.

Би хэдийгээр нүгэл үйлддэг ч, би өөрөө нүгэл биш. Би мэдэрсэн ч, мэдрээгүй ч, Есүс намайг зөвт болгосон. Надад найдсан тэр найдлагад нь хариу барих хамгийн айдасгүй, хайрын хариу үйлдэл нь Түүний итгэлийг дуулгавартай байдлаар хүндэтгэх юм.

“Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.” (2Коринт 5:21)

Есүс бидний ямар ч асуудалд хариулт болохоо амласан. Хэрэв чи нүгэл дээрээ л хамаг анхаарлаа тавьсаар байвал, нүглээс өөр юу ч харж чадахаа болино. Чи өөрийнхөө нүгэлтэй байдалд идэгдэж, дааж давшгүй болоод ирэхээр нь бусдын нүглийг ширтэж эхэлнэ. Бусдад хатуу ханддаг учирдагч хүн өөртөө хамгийн харгис ханддагт би гайхдаггүй. Би өөрийгөө харбал, бөөн алдаа харна. Харин би Христийг харбал, Түүний сүр жавхланд миний төгс бус байдал замхардаг. Тэгээд би Түүний өгдөг үзэгдлийг хамаагүй тод хардаг.

Тэд Түүнийг ажаад Гэрэлтэх болсон хийгээд Тэдний царай дахин Ичгүүрт эс ормой. (Дуулал 34:5)

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Бидний нүгэл, сүүдэр Өөрийнх нь хайрыг тасчиж хаяхыг Есүс зөвшөөрөхгүй. Хэрэв эмтэрч байгаа бол, хараагаа найдвараар өргөх ёстой болохоос биш, ичгүүрээр буруулах ёсгүй. Яагаад би төгс бус айдсаараа Түүний төгс хайрыг тулах ёстой гэж? Би энэ тэгшитгэл дэхь “яагаадыг” нь өнөө хүртэл ойлгоогүй ч, үүн дэхь “хэнд” нь итгэж болно гэдгийг сурсан. Учир нь Бурханы хайр нь өрсөлдөгчгүй юм. Бурхан хайраа миний дотор нутагшуулсан учраас, би найдвараа Түүн дээр тавихыг сонгодог. Бурхан охиддоо ямар үг хэлснийг Дуулал 91-ийн хэд хэдэн хэсгээс үзье.

Тэр Намайг хайрласан учир Би түүнийг аварна. Тэр нэрийг минь мэдсэн учир Би түүнийг өргөмжилнө. (и14)

Хэрэв үүнийг жинхэнээсээ бодоод үзбэл, хайр хөсөрдүүлдэггүй байж биднийг яаж эрсдэлд оруулах билээ? Хайр нь шархалсан хэсэг бүрийг эдгээх чадалтай.

Айдасгүйгээр хайрлах маш олон арга зам бий.

Хань ижлээ зоригтойгоор хайрлах нь бас л нэг талбар нь юм.

Хүүхдүүд болон эцэг эхчүүд айдасгүйгээр хайрлуулах ёстой. Бидний нөхөрлөл атаархал, эрхшээл, айдсаар биш, хайраар бойжих ёстой. Чи хийж байгаа зүйлдээ, ажилладаг газартаа хайртай байж болно. Чи аль нэг байгууллагын эсвэл чуулганы нэгээхэн хэсэг байгаадаа хайртай байж болно. Чи унших, инээх дуртай байж болно. Хайрыг хаанаас ч олсон бай, эрт орой хэзээ нэгэн цагт чи бэрхшээлтэй бас гомдолтой тулгарах л болно.

Үүнээс дараагийн шат ургана: дайснаа хайрлах. Есүс яагаад ийм юм хэлдэг билээ?

Яагаад гэвэл ийм хайр л хонийг ямаанаас салгадаг юм. Бидэнд хор хүргэхийг хүссэн хүмүүсийг хайрласнаараа бид онцгойрдог. Чи өөрийг чинь сохолж гэмтээхийг хүссэн хүнийг хайрлахыг сонгох үед ямар нэг юм өөрчлөгдөөд л явчихдаг. Нөхцөл байдал чинь өөрчлөгдөхгүй байсан ч, чи цаашид хүлээстэй биш, харин эрх чөлөөтэй болно.

Иргэний дайны үеэр нэгэн хар арьст боол Холбоотны талын эзэнтнээ тулааны талбар дээр хаячихаагүй, харин эмчид хүргэж өгсөн түүх байдаг. Тэр нь амархан сонголт байгаагүй ч, тэрбээр энэ шийдвэрээрээ өөрийгөө ямар эрх чөлөөтэй хүн болохоо харуулжээ.

Тэрбээр Эвслийнхэн босогчдыг ялахаас ч өмнө эрх чөлөөт хүн болжээ.

Тэгэхээр хүн эрх чөлөөтэй амьдрах уу, насаараа хүлээтэй явах уу гэдгээ нөхцөл байдлаас үл хамааран, чухам өөрөө л шийддэг. Хэдийгээр өнөөдөр боолын систем халагдсан ч, хүмүүс чамайг өөрт нь ямар нэгэн өртэй мэт шахалт дарамт үзүүлж эхлэх үед энэ нь нэгэн төрлийн өр болж хувирдаг. Эрх чөлөөтэй боловч, хүлээстэй амьдардаг хүмүүс байна. Хүмүүс чиний тухай юу гэж ярих, юу гэж үзэхийг чи хянаж чадахгүй ч, үүнд нь хэрхэн хариу үйлдэхээ сонгож чадна.

Хайр сонгодог. Айдас хариу үйлддэг.

Хайр бол эрх чөлөө. Айдас бол хүлээс.

Төгс хайр айдсыг хөөдөг.

Яасан ч хайрла

Кент Эмь. Кэйтийн доорхи шүлгийг хүмүүс ихэвчлэн Тереса эхийн үг гэж боддог юм. Учир нь Тереса эх хүн гэдэг амьтан ямар байдгийг өөртөө сануулахын тулд өдөр бүр энэ үгээр амьдардаг байжээ. Чи үүнийг хэсэгчлэн уншиж байсан байж магадгүй. Тэгвэл би бүрэн эхээр нь тавьлаа:

Парадокс тушаал

Хүн гэдэг амиа борлуулагч, бодлогогүй,

ухаангүй байдаг юм шүү,

Хайрлаарай тэднийг хамаагүй.

Сайныг үйлдвэл тэд чамайг дотуур тамиртай,

дороо нойтон гэж гоочилно шүү,

Сайнаа үйлдээрэй хамаагүй.

Амжилт хийморийг олбол чи хуурамч нөхдийг бас

жинхэнэ дайсныг олно,

Амжилтанд хүрээрэй хамаагүй.

Өнөөдрийн сайн үйлс чинь

маргааш гэхэд мартагдаж болох шүү,

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Сайнаа үйлдээрэй хамаагүй.

Зөв шулуун, чин үнэн зан чинь
чамд хор учруулж мэднэ шүү,
Зөв шулуун, чин үнэнээр амьдраарай хамаагүй.

Уужуу ухаан, холч бодолтой хүмүүс ухаан богино,
хомс бодолтой нэгэнд оногдож мэднэ шүү,
Уужуу томоор сэтгээрэй хамаагүй.

Хүмүүс ялагдагчийг хөөрхийлөвч,
зөвхөн ялагчийг л дагадаг юм шүү,
Ялагдагчийн төлөө тэмцээрэй хамаагүй.

Босгох гэж насаа барсан ажил чинь
ганц шөнийн дотор нурж болно шүү,
Барьж босгоорой хамаагүй.

Хүмүүст тус үнэхээр хэрэгтэй, гэхдээ
чамайг тусалбал, эргээд ээрч дайрч мэднэ шүү,
Туслаарай тэдэнд хамаагүй.

Энэ ертөнцийн төлөө хамаг л сайнаа өгөөрэй,
эргээд чи улаан нүүрэндээ татуулж мэднэ шүү,
*Эцсээ хүртэл хамаг л сайнаа өгөөрэй хамаагүй.*²

Хүмүүс чамайг гомдооно. Тэгсэн ч тэднийг хайрла. Кэйтийн үг яг л миний амьдралыг хүүрнэх шиг санагддаг юм. Хүн чиний итгэлийг алдаж байсан уу? Миний итгэлийг алдаж байсан. Тэд толгой сэгсрээд: “Чи ч ёстой бүтэхгүй хүн юм аа” гээд яваад өгсөн байж магадгүй. Дайсан чинь ч, найз чинь ч чамайг шархлуулж, урвана. Гэсэн ч тэднийг хайрла. Чи өрсөлдөөнөөс том амьдрал бүтээх гэж байгаа бол, хүний ухаан, хүчин чадлаас давж амьдрах хэрэгтэй.

Мэдээж эхлээд энэ бүхэн ямар ч утгагүй санагдана. Гэхдээ чи хүмүүст алдаанаасаа суралцах нэр төр олгобол, ирээдүйдээ илүү сайн сайхан болоход нь тусална.

Харамсалтай нь, яг одоо би нэг залруулга хийх хэрэгтэй байх.

Хүмүүст алдахыг зөвшөөр гэдэг нь хүмүүсийн хүчирхийлэл, урвалт, хууль бус үйлдлийг хүлцээд бай гэсэн үг огт биш шүү. Эдгээр нь алдаа биш юм. Алдаа нь эндэл, үл ойлголцол, буруу шүүх гэдэг ангилалд орно. Алдаа нь завхрал, харгислал юмуу хорлол зэрэг хорт санаархалтай ямар ч холбоогүй. Миний яриад байгаа алдаа нь зөв зүг рүү явж байхдаа, хүн бүрийн гаргадаг уналт юм шүү.

Зөвт хүн ч, муу хүн ч ялгаагүй бүдэрдэг. Цорын ганц ялгаа нь хайр зөвтийг босгодог. Учир нь зөвт нь долоо бүдрэвч нэг сэхнэ. Буруут харин гай гамшигт нэгмөсөн бүдэрнэ. (Сургаалт үгс 24:16) Хайр ямагт дахин босохыг сонгодог.

“...үнэнийг барьж, ингэхдээ харин хайранд, тэргүүн болох Түүн өөд, Христ өөд бүх талаар өсцгөө. Хэсэг нэгбүрийн зохистой үйл ажиллагааны дагуу холбоос болгоноос хангаж байдаг зүйлээр хамтдаа холбогдон нийлж буй бүхэл бие нь Христээр хайр дор өөрийгөө босгон барихын тулд биеийн өсөлтийг бий болгодог.” (Ефес 4:15-16)

Үнэний үгийг хайраар хэлбэл бие босгон байгуулагдана. Хайр амьдралын тал бүрийг цэцэглүүлдэг. Үзэн ядсан үгс ялзралыг үүсгэж, өсөлтийг сааруулдаг. Гэсэн ч хайр нь үзэн ядалт, айдсаас илүү хүчтэй юм.

Итгэлийг чинь хөсөрдүүлэх үед

Итгэж найдсан зүйл биелэхгүй үед итгэл хөсөрддөг. Хайр нь хамгийн шилдэгт итгэдэг бөгөөд энэ нь хамгийн шилдгийг шаардахаас өөр юм. Хүсэл горьдлого нь маш хурдан шаардлага руу хөрвөж чадах ч, хайр нь өсөөд найдвар руу хөрвөдөг.

Би нөхөртөө найддаг ч, туйлын найдвараа Бурханд л тавьдаг. Нөхөр, бид хоёр бие биедээ хайртай ч, бие биеийнхээ итгэлийг алдаж яваагүй гэсэн үг биш юм. Гэхдээ бид хоёр гомдлын нутагт суурьшилгүй, бушуухан шиг гомдлын гунигт хилийг давахаар шийдсэн билээ. Бид тэр явдлын ухаарал сургамжид талархаад, босоод, сургамж аваад, цаашаа явдаг. Энэ нь гомдлоо тойроод л яваад байхаас хавьгүй дээр хандлага шүү.

Гэхдээ гомдоод л яваад байх нь дээр гэж бодох үе бидэнд ч (эсвэл магадгүй ганцхан надад) байсан! Нөхрийнхөө алдаа

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

бүрийг нягталж, тал бүрээс нь сайтар ичээгээд өгбөл, тэр дахиж алдахгүй гэж би боддог байлаа. Би ийм харгис хандлагаар Жонд төдийгүй, өөртөө ч ханддаг байсан.

Гэхдээ миний энэ учир зүй алдаатай байсан учраас, бүтээгүй юм. Оронд нь бид хоёр бие биеийнхээ алдааг олдог хоббитой болж хувирсан билээ. Бид хоёр бие биеийнхээ хамгийн сайн сайханд итгэхийн оронд, зүгээр л бие биеэсээ хамгийн муу муухайг л хүлээдэг болсон юм. Тэгээд хэн хэн нь бие биеэсээ хайгаад байсан зүйлээ зайлшгүй олно.

Би хүүхдүүддээ хайртай. Гэхдээ бид бие биедээ гонсойдог. Хэдийгээр энэ явдал хааяа хааяа, ганц нэг тохиолддог бөгөөд голдуу би тэдэнд гонсойдог ч, энэ бол амьд харилцааны бас л нэг хэсэг юм. Түүнчлэн би найзууддаа ч итгэл алдаж явсан.

Гомдол нь хайр үхчихлээ гэсэн үг биш юм. Энэ нь Ариун Сүнстэй уулзах цаг гаргаж, жаахан зөвлөгөө сонс л гэсэн үг. Хайр харилцаа холбоог шаарддаг бөгөөд жинхэнэ харилцаа асуулт ба эмзэг байдлыг шаарддаг.

Гэхдээ эцсийн эцэст би нөхөр, хүүхдүүд, найзуудаасаа Есүс шиг төгс байхыг шаардаж чадахгүй. Хэрэв би тэднийг Аврагчийнхаа байр сууринд тавьчихбал, тэд мэдээж төгс бус хүн учраас, итгэлийг минь хөсөрдүүлж л таарна.

Эцэстээ хамаг асуудал нь тэдэнд биш, харин миний алдаатай хүсэн хүлээлтэд л байгаа юм.

Чи нэг их том юм хүлээгээд л, харин тэд түүнд чинь хүрэхгүй бол... итгэл чинь хөсөрддөг. Чи том юм хүсч, харин тэд багыг үйлдэх юм бол, бүх юм хараахан төгсөөгүй байгаагийн шинж шүү.

Чи шүүх гэж яараад, Бурханы барьж байгуулаарай гэсэн хүмүүсийг хяргаж тасдаад байвал, энэ нь хамгаалалтын механизм юм. Тийм ээ, зөвшилцөхгүй учраас, харилцаагаа тас татаад явчихдаг хүмүүс бий. Гэтэл бас чам дээгүүр гишгэлээд явчихдаг ч хүмүүс байна. Гэхдээ байна шүү - хүмүүс голдуу дахиж шархлахгүй гэсэндээ л яваад өгөхийг сонгодог юм.

Намайг өөртөө итгэж ч чадахгүй байхад, Бурхан хэзээд миний сайн сайханд итгэдэг. Бурхан миний өнгөрснөөс зуурдаггүй. Яагаад гэвэл Тэр миний ирээдүйг атгадаг. Тэр намайг хулчгар зан, айдсаас минь татаж гаргаад, надаас хамгийн сайн сайхныг гаргадаг. Паул Коринтын чуулганаас хүсэн хүлээсэн зүйлээсээ болж тэдэнтэй яльгүй зөрчилджээ:

Би та нар дээр очиход та нар хүссэнээр минь бус, би та нарын хүссэнээр чинь бус байх вий гэхээс айж байна. Эвдрэлцэл, атаархал, уур хилэн, маргаан, гүтгэлэг, цуурхал, их зан, үймээн самуун бүү байгаасай. (2Коринт 12:20)

Гутралыг хүсэн хүлээхээ больё. Учир нь бид юуг урина - тэр нь ирдэг. Зүгээр л чөлөөтэй хүлээн зөвшөөрөхийн оронд илүү ихийг шаардсаар байвал, эцэстээ үүнээсээ болж тусгаарлагдмал, ууртай жаал болж дуусна. Яг л мөрөөдлөө няцаасаар байгаад, найдваргүй болдог шиг. Бусдыг өөртөө найдаасай гэж хүсдэг шигээ бусдад итгэе. Тэд эцсийн дүнгээ үзээгүй байгаа гэдгийг тэдэнд итгүүлэе. Тэдний алдаа нь зүгээр л буруу алхам байсан гэж итгэе. Гаргасан алдаанаасаа болж бүхэл бүтэн хувь тавилангаасаа татгалзах гэж үү?

Чи нэг бол Есүст “за” гэж хариулж болно эсвэл өнгөрсөн алдаандаа харуусч болно. Энэ хүч нь гагцхүү чамд л байгаа.

Бид өөрсдөө өршөөлийг мэдэхгүй бол, бусдыг өршөөлөөс тасалдаг.

Айдсын зам

Айдас их үнэтэй шүү. Айдас чамайг сохолно. Хүч, мөрөөдөл, харилцаа, санхүү, итгэл, найдварыг чинь хулгайлна. Хайрын зүгээр л өгчихдөг зүйлийг айдас бохирлож, чамаас салгадаг. Айдас хааяа нэг үзэгддэг зүйл биш. Айдас хэзээ л бол хэзээ дурын цагтаа гэнэт л гараад ирнэ.

Айдас чамд амсхийх ч чөлөө өгөхгүй. Айдас чиний зүүдийг эвдэж, зүүд нойр руу чинь довтолно.

Айдас бол Ариун Сүнсний хүч, хайр, эрүүл саруул сэтгэлгээний эсрэг хүч юм. Ариун Сүнс чамайг чөлөөлөх гэж ирдэг бол, айдас чамайг саажлаах гэж ирдэг.

Айдас чиний өсөх бүх боломжийг дээрэмдээд зогсохгүй, ирээдүйн талаарх үзэл бодлыг чинь ч хулгайлдаг. Айдас, хайр хоёрын аль аль нь чиний амьдралд өөр өөрийн гэсэн төлөвлөгөөтэй. Нэг нь сайн бол, нөгөө нь хорлож хохироохын төлөө юм.

Хайрын зам

Гэтэл хайр нь эсрэгээрээ маш өгөөмөр байдаг. Хайр нь чиний харилцаа, мөрөөдөл, найдварыг сэргээдэг. Хүн бүр Бурханы амласан хайрын арга замд хүрч чадна. Гэхдээ хайрын шинэ амлалтыг айдсын хуучин материалтай хослуульж болно гэж бодох нь эндүүрэл юм. Бурхан шинийг шинэчлэгдсэнтэй л хослуулдаг.

Шинэ дарсыг хуучин туламд хийдэггүй. Тэгвээс тулам зад үсэрч дарс асгаран, тулам ч сүйднэ. Харин шинэ дарсыг шинэ туламд хийдэг. Ингэвэл аль аль нь хэвээрээ байх болно. (Матай 9:17)

Чиний дотор байгаа ямар нэгэн шинэ зүйлийг айдас өөрийн болгохыг хүсдэг. Харин түүнд бүү зөвшөөр. Айдасгүй нэгний хайр нь цоо шинэ савлагааг шаарддаг. Нэгэнт чи хайрын шинэ дарсыг хүсэх юм бол, бүх зүйлийг шинээр харж эхэлнэ. Нэгэн цагт чиний алба гэж хардаг байсан зүйлс чинь одоо үйлчлэх завшаан шиг харагддаг болно. Нэгэн цагт хураадаг байсан амьдралаа өдгөө чи өгөөмрөөр өгдөг болно. Хайр айдсыг зайлуулдаг.

Айдасгүй эмэгтэй

Өнгөрсөн жил манай нэг найзын илгээсэн төрсөн өдрийн мэндчилгээ надад дэндүү их таалагдсан учраас, би бүр аваад, толин дээрээ наачихсан юм. Нүүрэн дээрээ дөрвөлжин хээтэй өмдтэй охины зурагтай, харин доор нь “Хувцас биш, хандлага!” гэж бичсэн байсан юм. Өөрөөр хэлбэл “юу өмсөхдөө биш, яаж өмсөхдөө” гэсэн утгатай. Хайрыг эр зоригтойгоор тээж явах хамгийн гоё. Хайр бол хөдөлмөр.

Би чамд нэг үнэнийг хэлье: айдасгүй эмэгтэй шиг үзэсгэлэнтэй зүйл байхгүй.

Хэнэггүй эмэгтэй биш, харин аймшиггүй эмэгтэй.

Аймшиггүй охид Бурханы амлалтыг итгэлээр асааж өмсдөг. Өөрийгөө харах нь хэвийн л зүйл бөгөөд бид Бурханы Үгийн гэрэлд өөрсдийгөө шалгах үүрэгтэй. Гэхдээ өөрийгөө доош харах нь (доош хийх нь) ямар ч ашиггүй болно.

Айдас биднийг чадваргүй талаар минь хэмждэг бол, хайр Бурханы чадвар руу хөл тавьдаг.

Айдас үргээдэг, хайр татдаг.

Татна гэж юу гэсэн үг вэ?

Энэ нь үзэмжээс том зүйл шүү. Машины осол олны анхаарлыг татдаг. Илүү том ойлголт олохын тулд татах гэдэг үгийн үндсийг үзье. Энэ нь “ойртуулах юмуу наалдахад хүргэх” гэсэн утгатай. Мөн “Өөр рүүгээ яг л соронз шиг татаж, ойртуулах” гэсэн үг. Бас “Сонирхол, мэдрэмжийг төрүүлэх” гэсэн утгатай.

Чиний амьдрал бол ерөөл болон хараалын соронз юм. Тиймээс өөрөөсөө:

“Би юунаас айж байна?” гэж асуу.

Хайр чамайг юутай нүүрэлдүүлж байна?

Чи хэнийг өөрчлөгдөхөөс нь нааш уучлахаас татгалзаж байна?

Аль тал дээр чи хайраа хэсэглэж, хэмжээ хязгаартай хүртээж байна?

Чи бөөн бөөн айдсаар ширэлдсэн том тор нэхчихсэн яваа юм биш биз?

Одоо ширээгээ эргүүлэх цаг болжээ. Үүнийгээ чиний амьдрал дээр тунхагласан өрсөлдөөнгүй тунхаглалын цуурай шиг амархан эхэл. Тиймээс чамд бүхнийг эхлүүлэхэд чинь туслахын тулд би чамд Тимотод хандсан Паулын үгээр урласан залбирлыг бэлтгэлээ:

“Хайрт охин минь, Эцэг Бурхан ба бидний Эзэн Христ Есүсээс нигүүлсэл, өршөөл, амар тайван байх болтугай. ... Энэ шалтгааны улмаас, миний гар тавигдсанаар чамд өгөгдсөн Бурханы бэлэгийн дөлийг бадраахыг чамд сануулъя. Учир нь Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч хайр бас биеэ захирахын сүнсийг өгсөн. Тиймээс бидний Эзэний гэрчлэлээс бүү ич. Түүний хоригдол надаас ч бүү ич. Харин Бурханы хүчээр сайн мэдээний төлөө зовлон дотор надтай холбогд. Бурхан биднийг ажил үйлсээр минь биш, харин Өөрийнхөө зорилго болон бүх л өнө мөнхөөс Христ Есүс



**Айдасгүй
эмэгтэй шиг
үзэсгэлэнтэй
зүйл байхгүй.**

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

дотор бидэнд соёрхсон нигүүлслийн дагуу аварсан. Тэр биднийг ариун дуудлагаар дуудсан байна. (2Тимот 1:2; 6-9)

Үүнийг тогтоож ав. Эдгээр үгсийг амьдралд чинь зориулсан үгс хэмээн батлан хүлээж ав. Одоо надтай хамт залбирна уу?

“Тэнгэрийн Аав аа,

Би Таны нигүүлсэл, хайр, сайн сайхныг амьдралдаа хүлээн авч байна. Би надад дамжуулагдсан сүнслэг бэлгийн дөлөөр чинь дүрэлзэж байна. Та надад айдсын сүнсийг өгөөгүй учраас, би айдсын зөвлөгөөг сонсохгүй. Аав аа, хулгайчийн надаас хулгайлсан зүйлийг сэргээсэнд баярлалаа.

Та надад Ариун Сүнсээ өгсөн. Тэр надад хүч, эрх мэдэл, хайр, сайн шүүлтээр дүүрэн эрүүл ухааныг өгдөг. Өнөөдөр би хайрыг сонгож байна. Би Сайн мэдээнээс ичэхгүй, би айдсаар хойшоо суухгүй. Би зоригтойгоор хайрлана.”

Хэлэлцэх асуулт

1. Чамд илүү айдасгүйгээр хайрлаж болох ямар, ямар тал байна?
2. Гэрлэлтийн амьдралд чинь “бидний асуудал” гэхээсээ илүү “түүний асуудал” гэж үздэг тал бий юу?
3. Эмзэг байсангүй гээд хайрлахыг мэддэггүй гэсэн үг биш юм. Чи ингэж андуу бодож явсан уу? Үүнийг өөрчлөхийн тулд яах хэрэгтэй вэ?
4. Чи амьдралынхаа аль тал дээр гаргасан алдаагаа “би л өөрөө амьдралын алдаа” гэж боддог вэ?
5. Чи амьдралынхаа аль тал дээр уначихаад, босохоос айдаг вэ? Энэ талаараа найзтайгаа эсвэл хайртай хүнтэйгээ нээлттэй ярилц.
6. Аймшиггүй эмэгтэй, хэнэггүй эмэгтэйн ялгааг тодорхойлно уу.

Гүн худаг, хүслийн худаг

Сорил бидний хөрсийг гүн малтаж, биднийг юунаас бүтсэн юу болохыг маань харуулдаг.

Чарльс Спержен

Би чамайг гүн үндэстэй охин байгаасай гэж хүсч байна. Гүн лав байхыг хүсч байгаа бол, нилээд малтуулах нь байна шүү.

Би Чарльс Спержентэй санал нэг байна. Сорилт бол үнэхээр илчлэл шүү. Ямар ч байсан миний амьдрал дээр л тийм байсан. Уг нь тэдгээр нь бидний багш байх ёстой ч, эцсийн дүнд бид өөрөө л ямаршуу оюутан байхаа шийднэ. Надад л лав дөнгөн данган “D” дүн аваад л, арай чүү тэнцэх үе зөндөө л байлаа. Гэхдээ ийм үед би голдуу давтан шалгалт өгдөг. Үнэндээ хэдийгээр би төгс хийж чадахгүй ч, ямар ч байсан сайн хийхийг эрмэлздэг. Сорилтыг ашиглах уу эсвэл сорилтод самруулах уу гэдгээ би өөрөө л шийднэ.

Бидэнд юу тохиолдохыг бас бидний талаар хэрхэн ярихыг бид бараг хянаж чадахгүй ч, харин ямар хариу барихаа бүрэн хянаж чадна. Сперженийг нэгэнт эш татсан хойно, цаашаа лавшруулаад, сорилтод хариу хандах талаар юу хэлснийг нь үзье.

Тэрбээр “Намайг хадтай нялсан давалгааг би үнсэж сурсан” гэжээ.

Энэ нь бидэнд гэнэт л ирдэг юмст хариу үйлдэх ер бусын, санаандгүй хариу үйлдэл юм. Би саяхан ач охин Софиагаа давалгаанд тоглож байхыг харлаа. Тэр давалгаа бүрийг гайхшран яг өөдөөс нь тэврэн угтаж байв. Давалгаа түүнийг хичнээн ч

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

удаа цохиж унагасан, тэрбээр ахин дахин боссоор, давалгаатай наадсаар байв. Инээгээд л, босч ирээд л, нүдээ арчаад л, бэлтгээд л, дараагийн давалгааг хүлээнэ.

Спержен хадан эргийн талаар яриагүй, харин хад болсон Христийн тухай хэлжээ. Шинэ өдөр болгон нь бидний хувьд амьдралын давалгааг хэрхэн угтах шинэ боломж юм. Хэрэв бид хамгаалалтын байршилд орбол, айсуу асуудал болгон асуудал болно. Хэрэв бид өөрсдийгөө даруу болгобол, Ариун Сүнс биднийг улам гүнзгий болгож, үүнийгээ дагаад бурханлаг байдлын маань хүчин чадал ч нэмэгдэнэ. Амьдралын бэрхшээл биднийг хэн болохыг маань үгүйсгэлгүйгээр биднийг юунаас бүтэснийг маань илчилдэг. Бидний хэн болох маань бидний юу хийдэг эсвэл хийсэн дээр биш, харин бидний төлөө үйлдсэн Христийн үйлс дээр үндэслэн, “Христийн дотор” байгуулагдана. Сорил биднийг Христтэй адилхан болгож өсгөдөг бөгөөд Христтэй адилхан хүн ганхашгүй билээ. Христ бол надаас өндөр, алдарт Хад юм. Тэр бидний шөнө бүр дээр нь амардаг, өглөө бүр дээр нь зогсдог хад, амь юм. Зөвхөн Есүс л бидний мөнхийн төв болой.

Хөрсөө бэлтгэх

Одоо далайн уснаас хуурай газар руу нүүе. Би зарим үед ногоон, гэхдээ голдуу хуурай байдаг, үзэсгэлэнт байгальтай Колорадоод аж төрдөг учраас, миний хувьд хүний амьдралыг хөрстэй жиших нь их амархан буудаг. Хөрс эрс тэс уур амьсгалаас болж нягтаршин хатуурдаг. Цэцэрлэгийн маань хөрс дагтаршиж болох ч, харин зүрхний маань хөрс зөөлөн байх болтугай. Гомдлоос болж хэт цухалдах үед зүрхний маань хөрс их бага хэмжээгээр сүүйддэг нь үнэн. Малтсан шороон дунд буцаж хөрсөндөө шигдэхийг оролдож байгаа хортон шавьж харагддаг. Тэд хөрсөн доор яаж ажиллаж байгаа нь харагддаг. Намайг юу ч мэдээгүй явж байхад, тэр хортон шавьж миний гэрлэлтийн үндсийг мэрж, нөхөрлөлийн маань цэцэгсийн ургалтыг сааруулжээ. Ийм зүйл болох үед (харамсалтай нь хүссэнээс минь их болдог) Аав, бид хоёрын дунд нэг иймэрхүү яриа өрнөнө:

- “Төөх, Аав аа ямар муухай юм бэ! Яахаараа ийм бол

болдог байна аа? Аав аа, Та үүнийг харж байна уу? Та миний хэлснийг эсвэл бодсныг сонсов уу?”

Тэгтэл Аав маань: “Лиза, энэ явдлыг чи л одоо мэдэж байгаагаас биш, Би хэдийнээ мэдэж л байсан. Энэ шавьжнууд чиний хөрсөнд удаж байна шүү дээ. Тэгэхээр, одоо хамгийн гол нь чи эдгээрийг үржүүлсээр, ирээдүйнхээ ургацыг эрсдэлд оруулсаар байх уу?” гэнэ.

Ойроос сайтар ажиглал, хараахан соёолоогүй байгаа үрнүүд харагдана. Тэр үрд цаг хугацаа хэрэгтэй. Тэдгээр үр нь миний болоод гэр бүлийн маань амьдралд хараахан биелээгүй байгаа, Бурханы гүн гүнзгий амлалтууд юм. Тэгээд би тэднийг ер нь хэзээ нэгэн цагт ургах болов уу гэж гайхна. Тэгтэл Аав маань надад тэвчээртэйгээр тайлбарлана:

“Иймэрхүү хортон маш хурдан үрждэг. Гэхдээ сонголт нь үргэлж чинийх - чи тэдний дээгүүр шалтгийн шороо цацаад, хорт ажлыг нь нуун дарагдуулах уу? Тэгвэл хортон чинь байсаар л байна. Харин хортноос салмаар байгаа бол, үг ба үйлдлээрээ эсэргүүцэж, Надад тэдгээрийг устгах эрхийг олгох ёстой.”

Тэгээд би тэдгээр хортон нь атаархал, эргэлзээ, хүнээс айх айдсын ой гутмаар өтнүүд болохыг хараад байдгаараа эсэргүүцнэ.

- “Сайн байна! Харин одоо тэнд байгаа хогийн ургамлыг харж байна уу? Тэднийг ч гэсэн суга татаад хаячихбал яаж байна? Хөрс нь сийрэг байгаа дээр сугалж хаях хавьгүй амар шүү. Харин дараа нь тэдгээрийн оронд Миний Үгийн үрийг суулгаарай.”

Байзаарай ... одоо л жинхэнэ зовлон эхэлнэ. Далд байсан өг хорхойноосоо салах нь нэг асуудал. Харин эднээс болж, ил байгаа хамаг ургамал цэцэгсээ тасдаж хаячихаад, зэлүүд талбайд амлалтыг хүлээж сууна гэдэг тэс өөр асуудал юм. Тэгтэл надад халт мунхаг бодол төрнө. Цэцэрлэгээ хуу нүцгэлж байснаас, шинэ ургамал ургатал нь ганц хоёр ч гэсэн ногоон юм харагдаж байг гээд хэд гурван хогийн ургамал үлдээчихбэл яасан юм? Ямар

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

ч ногоон юм байхгүй бол, би чинь тас хар шороо шиг л халтартаж харагдана шүү дээ. Тэгээд Эзэнд ингэж хэлнэ:

- “Гэхдээ Эзэн минь, тэгвэл хөрс маань нүцгэн, хоосон харагдана шүү дээ.”

- “Лиза, чи үр жимстэй юм шиг харагдахыг хүсч байна уу, үр жимстэй байхыг хүсч байна уу?”

Энэ бол яг энэ үеийнхэнд тавигдах асуулт юм. Бид мөн чанартаа биш, үзэмждээ л анхаардаг болсон. Гэтэл үр жимстэй харагдах гэсэн үзэмждээ анхаарснаасаа болоод, ирээдүйн өсөлтийн улирлаа сүйтгэж болно. Нууцаар таригдсан зүйл нь нэг л өдөр ил болно. Тэгээд би гүн санаа алдана.

- “За за, зулгааж хаяя дөө.”

- “Сайн байна!”

Тэгээд би дан хөрсөөрөө нүцгэн үлдсэн ч ичэхгүй. Учир нь одоо миний дотор Бурханы амлалт ямар ч саадгүй ургана. Сорилт ба зовлон нь газрыг цэвэрлэж, ирээдүйн өсөлтийг сааруулах юмсыг зайлуулдаг. Эдгээр нь биднийг ирээдүйн хүчин чадалд шинэтгэн, бэлтгэх үйл явц юм. Сорилт гэдэг үгсийг өөр олон үгсээр орлуулж болно. Сорьц, бэрхшээл, даалгавар, зовиур, зовлон, туршилт, шалгалт юмуу эсвэл зүгээр л шалгуур гэж болно.

Үүний таагүй нөхцөлд бидний хүч, сул тал ил болдог. Эдгээр сорилт нь бидний хатсан, үржилгүй хөрсийг хагалаж, шинэ зүйлс, шинэ улиралд бэлтгэдэг. Энэ үндсэн ажлыг гүйцэтгэхгүй бол, бидний амьдралд Бурханы Үгийн ус шингэхгүй. Зүрх маань ямар ч ус хүлээж авах чадваргүй хатаж, дагтаршсан газар шиг л байна. Хатсан хөрсийг бэлтгэхгүй аваас, бороо зүгээр л дээгүүр нь урсаж, тэр их хур шимийн улиралд ямар ч ургацгүй үлдэнэ.

Нэгэн цагт би сорилтын зорилгын талаар хүмүүстэй зад маргаж мэдэх л хүн байлаа. Тэр үед би чамд “Хэрэв чи Бурханы Үгийн дагуу амьдарч л байгаа бол, ямар ч муу муухай юмтай тулгарах ёсгүй” гэж хэлэх байсан байх. Би залуу ч байж, тэнэг ч байж. Он цагийн шалгуурыг давахгүй итгэл үнэмшилтэй байж. Би үүнд гүнээ итгэдэг байсан ч, энэ үнэмшил маань намайг гүехэн бэрхшээлээр ч авч гарч чадаагүй юм.

Амьдралд болон бурханлаг байдалд хэрэгтэй бүхэн маань гагцхүү Бурханы Үгд байдаг ч, эдгээр үнэн бидний амьдралд бас

бидний амьдралаар дамжин ажиллаж чадахын тулд амьдралын сорилт биднийг сөхрүүлдэг. Энэ байршилд Бурханы Үг нь амьдрах зөвлөгөө байхаа больж, харин жинхэнэ амийн үг болж хувирдаг.

Амьдралаа малгах

Тэр үед би голдуу дүр исгэж, хамаг юмаа булдаг байсан учраас, хэдий богино боловч, нилээд самуурмаар улирал байж билээ. Тэр үед би залуу ч байж, шинэхэн итгэгч ч байж бас дөнгөж гэрлэсэн залуухан охин байсан болохоор газар шорооны ажил маань хараахан эхлээгүй байжээ. Магадгүй өнгөн хөрсөн дээрээ ганц, хоёр зураас л татсан байсан байх. Гэхдээ энэ бүхэн хэрхэн эхэлснийг би санаж байна. Би Бурханыг дотночлон магтаж, залбирч эхэлсэн юм. Би өөрийгөө чуулганы эхний эгнээнд суудаг, шинэхэн пасторын эхнэр учраас, амьдралд маань нэг их асуудал байхгүй хэмээн мунхаглан төөрөлджээ. Тиймээс өөртөө хачин итгэлтэйгээр Бурханаас амьдралыг минь малтахыг гуйчихаад, хорин дөрөв ч хүрэхгүй цагийн дотор энэ үгдээ харууссан юм.

“Аав аа, би малт гэж хэллүү? Больчихож болох уу? Би сэтгэл хөөрлөөрөө дэмий юм хэлчихэж. Үнэндээ би газрыг минь зүйл зүйлийн гоё цэцэг ургамлаар сайхан зүлэгжүүлж өгөөч л гэж хэлэх гэсэн юм шүү дээ.”

Гэхдээ Бурхан эхлэсэн ажлаасаа буцдаггүй. Малтлага гэдэг үг нь Ариун Сүнсээр хөтлөгдсөн үг байжээ. Үй олон итгэгч хүмүүсийн нэгэн адил би ч бас том санаатай ч, гүехэн залбирал хэлдэг байжээ. Тэр газар шорооны ажил эхлэхээс өмнө би залбирсныхаа дараа хов хоосон үлддэг байв. Хэлж байгаа үг маань юу ч өөрчлөхгүй. Учир нь би ямар ч зориулалтгүй, зүгээр л албан залбирал хэлдэг байв. Би бусдаас сонссон зүйлээ л давтаж хэлдэг байлаа. Тийм ээ, залбирал нь Бурхантай ярих яриа гэдгийг би заалгасан. Гэхдээ миний өчүүхэн залбирлыг сэнтийн өрөөн дэхь тэнгэрлэг оршигчид элэглэн дооглож байгаа байх даа хэмээн мунхаглан төсөөлдөг байсан юм.

Энэ сэтгэлгээнийхээ улмаас би дотроос минь орилж байгаа

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

цөхрөлийг ямар үгээр яаж илэрхийлэхээ мэддэггүй байв. Бас дотроос минь олгойдох их цангааг яах ёстойгоо ч мэдэхгүй байлаа. Гэтэл төдөлгүй Бурхан сорилтоор дамжуулан залбирлыг минь гүнзгийлдгийг ухаарч билээ. Гэхдээ би Бурханаар амьдралаа малтуулахаасаа өмнө Бурханд яаж ажиллах эрхийг нь олгохоо мэддэггүй байв. Ямар нэгэн бэрхшээл, сорилт ирмэгц л би шууд таслан зогсоочихдог байв! Сорилт дундуур сэлэхийн оронд би хуучин зуршлынхаа загвар, хүлээстэй зууралдсаар байв. Сорилт дуусахгүй бол, сүүлдээ зугтана. Зугтаад ч нэмэр болохгүй бол, тэднийг аяндаа зайлаасай хэмээн горьдон хүлээнэ.

Амьдралын маань бэрхшээл намайг ууртай, аймхай болгов. Би бусдад хатуурхаж, өөртөө бүр ч хатуу хандана. Хонгор бүсгүй минь, чи яг ийм байдалд байгаа бол, намайг сонс - тэртэй тэргүй чамд хатуураж байгаа энэ амьдралд өөртөө бүү хатуурх! Спержений зөв байсныг амьдрал надад сургасан. Цаг хугацааны явцад сурсан туршлагаараа би чамд нэг зүйлийг хэлье. Бид хэнийх болох маань бас сорилтод хэрхэн хариу хандах хандлага маань биднийг юунаас бүтсэн болохыг илчилдэг. Үүнийг Бурханы Үг хэлдэг. Сорилт биднийг хэн байгаагаас хэн болох руу өөрчилж чадна. Гэхдээ бид тулаангүйгээр баатар болж чадахгүй.

Гүн худаг

Надтай уулзаж учирдаг хүмүүс гүн худаг байгаасай гэж би хүсдэг. Энэ нь гадаад үзэмжээсээ илүү дотоод баялагтай гэсэн үг. Гүн худаг бол нууцлаг бөгөөд баялаг түүхтэй байдаг. Харин би түүхэнд дуртай. Тэд бол өчнөөн юмсыг туулсан ч, бусад худаг шиг хялбархан бохирдож, бузарлагдаагүй, цэвэр устайгаа үлдсэн худгууд. Гүн худаг оргилуур болдог. Учир нь тэд бусдыг ундаалдаг. Гүн худаг нь гүн хүчин чадлыг илтгэнэ. Чи гүн худагтай ярихдаа, магадгүй түүний талаар гэхээсээ илүү өөрийнхөө талаар нэгийг сурах байх.

Би ийм гүн худаг шиг хүмүүсийг мэднэ ээ. Тэд бол миний таньж мэдэхийг ямагт хүсдэг эмэгтэйчүүд. Би тэдний дэргэд байхдаа, эхлээд ичдэг. Надад асуумаар юм зөндөө байдаг. Гүн худгийн дэргэд би асуухаасаа илүү сонсохыг хүсдэг. Гэсэн ч ярьсаар байвч, цаана нь яриагүй зүйлс улам л их үлддэг. Би гүн

худаг баймаар байна. Гэвч амьдралынхаа зарим тал дээр зүгээр л нэг шалбааг шиг байх үе бий.

Заримдаа гүн худгийг мэдэхийн тулд зүрхтэйгээ нилээд ажиллах хэрэгтэй болдог. Тэд миний бичсэн ном, номлосон конференцийг сонирхохгүй. Тэд бүгдээрээ л ингэж үзсэн. Надаас ч илүү үзсэн. Тэд миний бялхалыг ч сонсохыг хүсэхгүй. Тэд зүгээр л намайг юугаар дүүрч байгааг л мэдэхийг хүсдэг. Тэд нөхөр, хүүхдүүд, ач нар, зүрхний маань талаар асууна. Тэд аль хэсгийг маань хөндөж, шалгахаа мэднэ ээ. Тэгээд би өөрөө ч мэдэлгүй хамаг юмаа хэдийнээ дэлгээд хаячихдаг. (Нөхөр маань үүнд жаахан дургүй байдаг)

Гэхдээ би итгэж чадах, зөв хүндээ л сэтгэлээ нээдгээс биш, таарсан болгоныхоо сүрдүүлгээр нээгдэнэ гэж байхгүй л дээ.

Тэр гүн худгуудтай уулзаж явахдаа, би хэдэн зүйлийг сурсан юм. Амьдралтай эрүүл саруул холбогддог хүн л гүн худаг болдог. Гүнийг худалдаж авч чадахгүй - харин хөдөлмөрлөж байж олдог. Үүний тулд хангалттай шударга байх ёстой. Энэ утгаараа гүн нь уйгагүй хөдөлмөрийн дүнд хөгждөг булчин юм.

Хүслийн худаг

Саяхан Жон, бид хоёртой нэгэн зурагтын продюссер ирж уулзлаа. Тэд бид хоёрыг өнөөгийн амьдрал дээр тулгарч байгаа сүнсний сэдвээс авахуулаад илүү ноцтой сэдвээр ярилцах нэвтрүүлэгтээ оролцооч гэсэн юм. Бид ч анх удаагаа зурагтын нэвтрүүлэгт оролцоогүй л дээ. Хэд хэдэн удаагийн реалити шоуны хүсэлтийн дараа би ийм юманд оролцох хүсэлгүй байгаагаа ойлгосон юм. Тэгээд туслахдаа татгалзсан хариу өгөөрэй гэж хэлж билээ. Гэхдээ тэр зурагтын продюссер өөрийнхөө шоуг тэс өөр гэдгийг батлан батлан хэлжээ. Продюссерүүд үзэгчдийг ямар нэг зүйлд хариулт хүсэхдээ нуггийн чуулганд явдаг байсан үеийг нь санагдуулахаар, өнгөрснийг дурсгам “галт тэргээр” аялуулахыг хүсчээ. Бид хоёр ч энэ санааг нь судалж үзэхээ дуртай дургүй амлалаа.

Тэгээд Жон нэг хотод, харин би өөр хотод байсан ч, бид конференц - дуудлага хийхээр болов. Тэд хэд, хэдэн асуулт асуусан бөгөөд бид ч үүнд нь шударгаар хариуллаа. Тэгээд дараа

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

нь бид тэднийг дахиж холбогдоно гэж санаагүй ч, тэд дахин холбогдов. Тэдэнд бидний эрч хүч таалагдсан учраас, ярилцлагаа нэг шат ахиулбал ямар вэ гэсэн санал дэвшүүлсэн юм. Тэгээд бид Скайпаар бүтэн цагийн турш асуулт хариултын хэлбэрээр ярилцах бичлэгт орохоор болов. Асуултаа ч урьдаас бэлтгэсэн байлаа. Жишээлбэл эхнийх нь нэг иймэрхүү асуулт байв:

“Миний арван зургаан настай охин өөрөөсөө арай ах залуутай үерхдэг. Тэрбээр ах учраас, бэлгийн амьдралын тал дээр охиноос минь хавьгүй туршлагатай хүн л дээ. Охины маань хувьд анхных нь хүн. Тиймээс эх хүний хувьд би охиндоо шинжилгээ хийлгэх үү эсвэл жирэмснээс сэргийлэх эм уулгах уу? Яах вэ?”

Би ч үүнд нь шууд л хариулав. Охин нь аав, ээжтэйгээ амьдардаг, насанд хүрээгүй охин. Тиймээс би юу хэлэхээ баттай мэдэж байлаа.

Библи биднийг садар самуун, завхайрлаас зугтаарай гэсэн. Тиймээс аав, ээж нь охинтойгоо сууж байгаад, тэр залуутай дахиад хэзээ ч уулзаж болохгүйг охиндоо тайлбарлаж өгөх ёстой гэлээ.

Тэгээд цааш нь тайлбарлах гэтэл, мөнөөх продюссер яриаг минь таслаад, нэгдүгээрт - тэр хоёр унтсаар л байх болно, хоёрдугаарт - Библийг битгий дурьдаарай гэж хэллээ. Тэд зүгээр л сүнсний зөвлөхүүдийг хүсчээ. Дараа нь тэрбээр надад дээрх асуултыг өөрөө асуусан болохоо хэлсэн юм. Үнэндээ тэр охин нь түүний дүү бөгөөд ээж нь яах ёстойгоо мэдэхийг хүсчээ. Тэр үед Жон, бид хоёр энэ ярилцлага цаашаа үргэлжлэх шаардлагагүй гэдгийг ойлгосон юм.

Агентлаг биднийг Библийн багш нар гэдгийг мэдэж байсан ч, Библийн сургаалын талаар сонсохыг хүссэнгүй. Тэд биднийг сүнслэг байлгахыг хүссэн ч, Библийн үнэнийг сонсохыг хүсээгүй юм. Ийм юм байж болно гэж үү? Бурханы зөвлөгөөгүй цэц ухаан байдаг гэж үү? Тэгээд би бодлоо. Хэрэв би Нью Эйж гүүргийн үгийг ишэлсэн бол, тэд зөвшөөрөх байсан болов уу? Үнэндээ тэд биднээс нэг их гүн сонсогддог, гүехэн хариулт хүсчээ. Энэ нь зүгээр л хүслийн худаг юм.

Тэд зөрчлөөс зайлсхийхийг хүсчээ. Тэд биднээр хатуу үнэнийг хэлүүлэхийг хүссэнгүй. Тэд биднээр бурууг ерөөж, мууг сайн гэж хэлүүлэхийг хүсчээ. Тэд “байгаагаар нь хүлээж ав - тиймээс

зөвтгөх үгийг л хэл” гэсэн сэтгэлгээтэй байв. Үнэндээ үнэнтэй ойрхон сонсогдохоор худлаа ярь л гэсэн юм. Тэд мөн Христчин итгэлийг ил тод байлгах биш, нуугдмал байлгахыг урамшуулсан. Тэд “Бурхан аугаа. Гэхдээ Есүсийг бас Библийг хойш тавья” гэжээ.

Өөрөөр хэлбэл тэд надаар: “Тийм ээ, охиндоо хайртай мундаг ээж минь, бушуухан бэлгийн замын халдварт өвчний шинжилгээнд охиноо хамруул. Тэгээд бас жирэмснээс хамгаалах эм уулга. Тэгээд найззалуу нь танайд зочлох үед нь түүний өмнө нөхөртэйгээ суугаад, охиндоо хичнээн хайртай болохоо хэл. Бас бэлгийн амьдралын тал дээрх туршлагыг нь хүндэтгэж байгаагаа хэл. Тэгээд гэр бүлийнхээ зүгээс хайрцаг дүүрэн бэлгэвч бэлэглэж байгаагаа хэл. Тэгээд л айх аюулгүй болно” гэж л хэлүүлэхийг хүсчээ.

Ямар хөгийн болохыг харж байна уу? Би бол харж байна. Тэр продюсерууд Библийн үнэнийг сонсохыг биш, хүслийн худагт хүслээ шивнэхийг л хүсчээ. Үнэндээ тэд Жон, бид хоёрт: “Бид та хоёрын дотор зоос хаяна. Хариуд нь та хоёр хүмүүсийн хүслийг биелүүл. Нүглийг нь ерөө, өөрийнх нь талаар сайн сайхан сэтгэгдэл төрүүл” гэсэн юм.

Маш олон итгэгчид гүн худаг болж хөгжихийн төлөө хэрэгтэй зүйлээ сонсохын оронд, зүгээр л хүслийн худаг болохыг хүсдэг. Маш олон эмэгтэйчүүд нэг их том хүсэлтэй атлаа тун гүехэн амьдралтай байдаг. Тэд өөрсдийнх нь дагадаг дэлхийн зөвлөгөө нь ердөө л өөрсдийнх нь дуу хоолойны хоосон цуурай гэдгийг мэддэг ч, өөрчлөхийг хүсдэггүй учраас, хүслийнхээ худагтаа л мөргөдөг. Амьдрал нь ч бөөн бөөн шалтаг, харуусал:

Тэр үгийг хэлээгүй байсан бол...
 Тэр зүйлийг хийгээгүй байсан бол...
 Тэр хүнтэй гэрлээгүй байсан бол...
 Тэр хүнтэй гэрлэсэн бол...
 Тэр сургуульд сурсан бол...
 Найз нөхөдтэй болсон бол...
 Түүн шиг болсон бол...
 Тэр юмыг авсан бол...
 Тэр юмыг аваагүй бол...
 Илүү их залбирсан бол...

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Библиэ уншсан бол...
Сахилга багтай байсан бол...
Илүү гэвчээртэй байсан бол.

Зоргоор болдог байсан бол, бид бүгдээрээ л гялалзсан, сайхан, хүчтэй, зоригтой байхгүй юу. Уолт Дисней “Зүүд гэдэг нь унтаж буй зүрхний хүсэл юм” гэсэн. Би үүнд итгэдэг. Гэхдээ сэрүүн байхдаа хөдөлмөрлөж байж л зүүд, мөрөөдөл бодитой биелдэг. Мөрөөдөл хүслээр жигүүрлэдэг бол, бодитоор бий болгох хэсгийг нь бид өөрсдөө хийдэг юм. Мөрөөдөх хангалтгүй... чи сайтар хөдөлмөрлөх ёстой. Энэ үед л гүн малтлага өрнөдөг.

Заль мэхийн аюул

Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн гэж боддог бол тэр нь мэргэн болохын тулд мунхаг болог. Учир нь энэ ертөнцийн мэргэн ухаан бол Бурханы өмнөх мунхаглал ажээ. Энэ нь “Тэрээр цэцдийг баширлал дээр нь барьж авдаг” гэж бичигджээ. Мөн “Цэцдийн эргэцүүлэл нь дэмий хоосон гэдгийг Эзэн мэддэг” (1Коринт 3:18-20)

Хэн ч бүү мэхлэгд гэснийг бид сайн мэддэг ч, эмэгтэй хүн өөрийгөө хялбархан мэхэлчихдэгийг дутахгүй сайн мэднэ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс яагаад нүдээ ноосоор хучиж байгаад, өөрийгөө мэхэлчихдэг вэ? Уг нь хэн ч зориуд мэхлэгдэхийг хүсдэггүй. Манай нөхөр “Заль мэхийн хамгийн гол асуудал нь энэ нь биднийг мэхэлдэг” гэж байнга хэлдэг.

Заль мэх нь юмс, хүмүүс, нөхцөл байдал, зөвлөгөөг яг үнэн байдлаас нь өөрөөр харагдуулдаг. Мэхлэл нь Бурханд захирагдах явдлыг хуулийн хүлээс гэж харагдуулдаг. Мэхлэл нь сэтгэлийн чинь дайсныг нөхөр шиг санагдуулж чадна. Мэхлэл нь мууг сайн, сайныг муу гэж харагдуулж чадна. Мэхлэл нь ямар ч цэвэр усыг юу ч үгүй булингартуулж, бохирлох хүчтэй. Бурхан биднийг ийм нөхцөлд орно гэдгийг мэдэж байсан учраас, цаг хугацаа, хүний соёл иргэншил, сэтгэл мэдрэмжийн хувьслаар өөрчлөгдөхгүй жишиг тогтоож өгсөн юм. Тэр жишиг нь Бурханы Үг бөгөөд тэр

жишгийг сахигч нар нь бурханлаг хүмүүс билээ.

Бид энэ үеийн цэц ухааныг хүсч байна уу эсвэл мөнхийн цэц ухааныг хүсч байна уу? Сонголт нь биднийх. Өөрийгөө Бүтээгчээсээ ухаантай гэж сэтгэж эхэлсэн бүтээл нь өөрийгөө мэхэлдэг. Нөхцөл байдал усыг булингартуулахад Бурханы Үг л ганцаараа бидний мэлмийг тод байлгана. Бичээсийн зөвлөгөөгүйгээр чи мунхаг байдлыг цэц ухаантай эндүүрнэ.

Тэгээд зальжин, хорон юмсыг цэвэр шударга хэмээн төсөөлж, алдаатай итгэл үнэмшилд орох эрсдэлтэй. Могойн атгаг санаа яг л ийм чимэгтэй, сонголонтой байсныг санаж байна уу? Өрсөлдөгчөө нэг зүйлээр олзлон, гоёор ятгахдаа, цаанаа тэс өөр зүйлд хүрэхийг санаархаж байсан. Могой Адам, Ева хоёрын талаар нэгийг сэдчихсэн гулгаж явсан. Найз царайлсан хорт могой мань хоёрт сайныг муугаас салгаад сурчихбал, илүү бурханлаг болно гэж хэлдэг. Бүр Бурханы цэц ухаанд захирагдалгүйгээр энэ төвшин рүү шууд ахиж чадна гэж амладаг. Адам, Ева хоёр мэхлэгдэхийг хүсээгүй, могойн амласныг л хүссэн. Тэд могойг худлаа хэлж байна гэдэгт итгэхийн оронд Бурханыг худалч гэдэгт итгэхийг сонгосон. Могой тэднийг бурхан шиг болно гэсэн ч, үнэндээ тэд бурхангүй болсон юм. Бичээс бидэнд анхааруулдаг:

Тийм биш ээ. Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн. (Ром 3:4)

Мэхлэлээс гарах арга нь гэмшил юм. Бид өөрийнхөө цэц ухааныг мунхаг гэж хэлээд, мөнхийн цэц ухаант Нэгэний өмнө өөрийгөө даруу болгох хэрэгтэй. Худлаас эргэж, үнэнээс барьж авах нь гэмшил юм.

Сатаны чимэгтэй амлалт өнөөдөр ч дэлхий даяар цуурайтаж байна. Эрт дээр үед могойн санал Бурханы тушаалаас илүү эелдэг, зөөлөн, баялаг сонсджээ. Чамд ч аль нь илүү сайхан сонсогдож байна? Идээд үх эсвэл идээд цэц ухаантай бол гэдгийн? Өөрийгөө

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

байгаагаасаа илүү цэцэн цэлмэг гэдэгт хэн ч итгэхийг хүснэ. Тиймээс л могойн үг хүнийг хөөргөсөн. Үнэндээ Христээс гадуур ямар ч цэц ухаан байхгүй. Бид газрын зуурдын, хязгаартай ухаарал дотроо хэсэгхэн л тэснэ.

Харин хожмын цагт зарим нь итгэлээ орхин, мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн сургаалд анхаарал хандуулна гэж Сүнс тодорхой хэлдэг. (1Тимот 4:1)

Мэхлэгч сүнс чамд Бурханы Үгээс гадуур гэгээрэл байдаг гэж байнга хэлнэ. Бид шинэ үед амьдарч байгаа бөгөөд Бурханы Үг өөрчлөгдсөн гэдэг. Эдгээр сүнс нь “Бурханыг бүү сонс, өөрөө өөртөө бурхан бай” гэсэн могойн үгсийг л цуурайтуулж байгаа юм. Дэндүү олон хүн мэхлэлийг гагцхүү илбэ шид, Сатанд мөргөх үйлээр л хязгаарлаж боддог. Гэтэл мэхлэгч сүнс нь цаанаа өөр санаа агуулаад л, наанаа өөр юм ярих маягаар хүмүүсийг олзлоод л явж байдаг. Чи Христэд итгэдэг бол, тэд чиний сэтгэлийг авч чадахгүй болохоороо, эрх мэдлийг чинь булааж, сайн сайхныг чинь бохирлохын тулд чадах бүхнээ хийнэ. Маш олон бурханлаг бус, дэлхийн зүйл нь манай үед хэвийн л зүйл болжээ. Тиймээс бидэнд маш хатуу сэрэмжлүүлсэн байна:

Харин олиггүй буюу эмгэдийн үлгэрүүдийг бүү зөвшөөр. Өөрийгөө итгэл сүсэгт дасгалжуул. Учир нь биеийн дасгал нь өчүүхэн тустай. Харин одоогийн болон ирэх амийн төлөөх амлалт бүхий итгэл сүсэг нь бүх зүйлд тустай. (1Тимот 4:7-8)

Иймэрхүү домгийг хүүхдэд зориулсан, хоргүй гэнэн гэж бүү эндүүрээрэй. Учир нь эдгээрийг ихэвчлэн нэг их ач холбогдолгүй бөгөөд хоргүй юмс гэж дүрсэлдэг. Гэхдээ энэ нь худлаа шүү. Тэдгээр нь шидэт үлгэр юмуу бидэнд үнэнийг заахаар уран сайхан аргаар зохиомжилсон түүх домог биш, харин биднийг алж, хулгайлж, сүйрүүлэхээр илгээсэн чөтгөрийн доктрин шүү.

Бурханы зөвлөлөөс гадуур жинхэнэ цэц ухаан гэж байхгүй.

Есүс бидэнд сонсохыг хүссэн зүйлийг маань л өгдөггүй, харин улам гүнзгийрч, сонсох хэрэгтэй зүйлийг маань хэлдэг.

Худгаасаа уух

Хүн нэг бүрийн дотор худаг бий. Энэ нь биднийг ундаалдаг сэтгэл гэдэг газар юм. Иеремиа үүнийг усан сан гэсэн:

“Учир нь Миний хүмүүс хоёр муут үйлдсэн билээ. Тэд өөрсдөдөө ус тогтоон барьдаггүй эвдэрхий усан санг чулуу ухан хийхийн тулд Амийн усны ундарга Намайг умартсан. (Иеремиа 2:13)

Сэтгэл маань гүехнээс авахуулаад гүн хүртэл янз янзын хэмжээ хэтгэй бөгөөд ус нь бидний хүчин чадлын хэмжээгээр л нэмэгдэнэ. Гэхдээ худаг хэр гүн байлаа ч, усан сан нь ангархай бол, ус тогтох уу даа. Цаг хугацааны аясаар худаг гүнзгийрч, хүчжиж, бэхжиж болно. Сэтгэл маань ч худагтай адил сав юм. Энэ дотор л бид хамгийн гүн санаашрал, айдас, хүслээ хадгална.

Заримдаа худгийн ус тогтуун байдаг. Заримдаа ус урсаж байгаа нь мэдэгдэж, худаг хоосон, дундуур юмуу хальж байсан ч, тэнд ус байдгаараа байж л байдаг. Ус бол амьдралын эх үүсвэр учраас, дээр үед дайснууд худгийг шороогоор булдаг байсан. Амьдралын хүнд бэрх үе ч бидний худгийг булж чадна.

Худаг маань хальж байгааг мэдэрбэл, бид сэтгэлийнхээ хамгийн гүн гуниг, санаашралынхаа дуу хоолойг гаргахын тулд худгаа нээх хэрэгтэй. Дотор минь харанхуйлж, бохирдож, тэр бүү хэл хатуурхах үед ганц сайхан магтаал сонсоход л худаг маань онгойж, сэтгэл маань сэргээд л явчихдаг. Эсвэл гэр бүлтэйгээ, бурханлаг найзуудтайгаа хамт байж, инээлдэж хөхрөлдөхөд л усан сан маань дүүрээд л явчихна. Үгийг уншиж, тэмдэглэж, залбирах нь халуун өдөр хүйтэн булгаас ундаалах мэт.

Өнгөрсөн амьдралтай эмэгтэй

Хүн бүрт өнгөрсөн амьдрал бий. Заримынх нь өнгөрсөн амьдрал бусдаасаа арай өнгөлөг байдаг. Заримынх нь жаргалтай. Заримынх нь аймшигтай. Гэхдээ өнгөрсөн сайн, муу байх нь үнэндээ одоо тийм чухал биш. Хамгийн аюултай нь хүн - бид өнгөрсөн амьдралаасаа салахгүй,

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

тэндээ амьдрах гээд байдаг явдал юм. Бид алдрын эсвэл ичгүүрийн сүүдэрт аж төрөхөөр бүтээгдээгүй! Бид яг одоогийн гэрэлд алхангаа, өсөн нэмэгдэж байгаа гэрэлт ирээдүйг харж амьдрахаар бүтээгдсэн юм.

Хүн ер нь байнга арагшаа харж, өнгөрсний тухай ярих дуртай байдаг бол, Бурхан урагшаа харж, ирээдүйг маань тунхагладаг. Хүмүүсийн түүхийг сонсох сайхан. Гэхдээ тэдний мөрөөдлийг мэдэж, урагшаа харах нь бүр чухал юм.

Би аялж номлож явахдаа, мянга мянган эмэгтэйчүүдийн дээр найдвар тунхагладаг, аз завшаантай хүн. Тэгээд дараах үгийг зоригтойгоор хэлмэгц, тэдний царайнд ухаарал гийгээд л явчихдаг:

Дайсан чамайг өнгөрсөнд хэн байснаас чинь болж биш,
ирээдүйд хэн болохоос чинь болж довтолдог.

Үүнийг ухаарсан хүмүүс амьдрал нь хараахан дуусаагүй байгааг мэддэг. Амьдрал нь стратегийн ач холбогдолтой учраас л, дайсан түүнийг арга барилтайгаар, санаатайгаар дайрч байгааг тэд ухаардаг. Тэр үед хүмүүс одоо миний чамд хэлэх зүйлийг ухаардаг. Энэ бүхэн хэзээ ч чиний өнгөрсөнтэй холбоотой байгаагүй. Энэ бүхэн нь хэзээд чиний ирээдүйтэй л холбоотой байсан. Тийм ээ, сонголтын үр дагавар гэж байдаг. Би үүнийг ойлгож байна. Гэхдээ чи юу ч хийсэн байсан, Бурхан хэдийнээ чиний өмнө яваад, гарцгүй газар гарц гаргасан байгаа.

Чи эргэж хараад, хийсэн үйлдлээрээ онгорхой байсан ганц хаалгаа хаачихсан шүү дээ гэж бодож байж магадгүй. Тэгвэл юу гээч? Энэ чинь худлаа. Тийм ээ, тэр хаалга хаагдчихсан байж болно. Гэхдээ сайтар харбал, өөр нэг хаалга чамайг хүлээж байна. Тэр хаалга эхнийхээсээ жаахан өөр, тэр бүү хэл жаахан чанга байж болох ч, Бурхантай гар нийлэн ажиллабал, Бурхан чамайг хүрэх ёстой газарт чинь хүргэхдээ л хүргэнэ. Тэр чамд усаа авах гүн бөгөөд хүчтэй худаг гаргах багажийг өгөхдөө л өгнө.

Гэхдээ хамгийн явдалтай нь дэндүү олон хүн цуурчихсан, гүехэн хүслийн худгийнхаа дэргэд: “Би тэгчихгүй яав, ингэчихгүй яав! Би бүгдийг сүйрүүлчихлээ!” гээд л уйлаад суугаад байдаг.

Гэхдээ ингэх боломжгүй! Үзэсгэлэнтэй найз минь, чамд арай ч тийм хүч байхгүй ээ. Өнгөрсөнтэй эмэгтэй байлаа гээд ирээдүйгүй эмэгтэй

болно гэсэн үг биш юм. Өнгөрсөнтэй эмэгтэй байлаа гээд хүмүүс ирээдүйг чинь хянах эрхгүй. Бурхан ирээдүйг чинь атгаж байгаа. Гэгээн Августин худгаа яаж гүн ухах талаар сайн зөвлөгөө өгчээ:

Чи өндиймөөр байна уу? Тэгвэл газар буу. Үүл баганадсан цамхаг босгомоор байна уу? Тэгвэл эхлээд даруу чанарын суурь тавь.

Есүс бидэнтэй бидний хамгийн доод цэг дээр нэг бус, харин байнга уулзахыг хүсдэг. Бид авралынхаа босгон дээр Есүстэй уулзах хэрэгцээгээ ойлгодог атлаа дараа нь Тэр биднийг өөрөө ганцаараа барилгаа барь гээд үлдээчихдэг юм шиг ойлгодог. Үүн шиг худлаа юм байхгүй. Бид аврагдахдаа Эзэнтэйгээ уулздаг. Тэгээд дараа нь даруу байдлаар ахин дахин уулзалдах ёстой. Учир нь Тэр л бидний сэтгэлийг хадгалж, зүрхний минь хагархай усан санг нааж засдаг юм.

Шалбаагт живэх

Би усны аврагч болохоор сургагдаж байхдаа, жил бүр живж, амиа алддаг хүмүүсийн дийлэнх нь аюулгүй газар живдэг болохыг мэдсэн юм. Эрсдэлтэй хүмүүсийг гурав ангилна: 1. Таваас доош насны хүүхдүүд; 2. Хэнэггүй залуус (20-25 насны эрчүүд); 3. Хөгшид (60-аас дээш насны). Хамгийн сонирхолтой нь амиа алдагсдын бараг тэн хагас нь метр наян санж хүрэхгүй усанд л живчихдэг ажээ. Тэд хэт сандрахдаа, орчин тойрноо ашиглах чадвараа алддаг ажээ. Энэ бол хүмүүсийн дийлэнх хувь нь метр ч хүрэхгүй усанд живчихдэгийн хамгийн гол шалтгаан ажээ. Хэрэв тэд сандраагүй бол, хөлөө доош нь явуулаад, тусламж иртэл зогсож байх юм уу эсвэл доороо дэвхэрсээр байх юмуу эсвэл бүр аюулгүй газар руу алхаад гарчихаж болох байсан. Тиймээс үнэндээ гүн хүнийг алдаггүй. Харин гэнэтийн юм болоход, гүехэн газар хий сандрах явдал л хүнийг алдаг ажээ. Айж эмээхийг мэддэггүй залуус усыг басч, өөрийгөө ялагдашгүй гэж боддог.

Тиймээс шалбаагт живчихдэг эмэгтэйчүүд байхаа больё. Ариун Сүнсэнд улам гүн малтахыг зөвшөөрье.

Сайн амьдрах

Газрын амьдрал дуусахад, бид бүгдээрээ л “Сайн байна!” гэдэг үгийг сонсохыг хүсдэг. Сайн гэдэг нь хийхээр дуудагдсан ямарваа ажлаа хэрхэн хийснийг маань дүрслэн хэлсэн үг юм. Хүний амьдрал, хайрын схемд “Төгс байна!” гэсэн ойлголт байхгүй. Гагцхүү төгс бус хүмүүс сайн хийх л гэсэн ойлголт байна. Сайн гэдэг үг нь хүн нэг бүрт өгөгдсөн бэлэг юм. Энэ нь эрүүл саруул бөгөөд сайн сайхан гэсэн үг. Энэ нь унадаг, бүтэлгүйтдэг боловч, тэр даруй босдог хүнийг дүрслэж байгаа юм. Бид унах бүрийдээ дахиад босох ёстой.

Биднийг даах гүнд хүрэхийг хүсч байвал, энэ байршлыг өөрийн болгох ёстой. Сургаалт үгс 24:16:

“Учир нь зөвт нь долоо бүдрэвч нэг сэхнэ.

Буруут харин гай гамшигт нэгмөсөн бүдэрнэ.”

Дайсагнал нь амьдралын их сургууль юм. Хэр хурдан босч байгаагаар чинь даац чинь хэмжигдэнэ. Босоод, толинд хараад, бүтэлгүйтснээ хүлээн зөвшөөрөх нь амаргүй бөгөөд өртөгтэй. Гэхдээ зөвт бус хүн тэр чигээрээ бүдэрдэг.

“Буруут харин гай гамшигт нэгмөсөн бүдэрнэ.”

Би мундаг бэлэгтэй хоёр пасторын амьдралыг мэдэх бөгөөд тэд хоёулаа төстэй байдлаар бүдэрсэн боловч, сэргээгдэх үйл явцдаа тэс өөрөөр хандаж билээ.

Нэг пастор нь зөвлөлийнхөө бөгөөд сэргээн засах багийнхаа гаргаж өгсөн төлөвлөгөөнд үг дуугүй захирагдав. Тэр төлөвлөгөө нь тэр удирдагчаас, гэргийгээс нь, хүүхдүүдээс нь нилээд их юм шаардаж байсан ч, тэд найз нөхдөө, амьдралаа зориулсан хотоо бас тариалсан чуулганаа - байгаа бүхнээ орхиод, өөр тийшээ нүүж, эдгэрлийн үйл явцад нь туслах өөр чуулганы гэр бүлд нэгдсэн юм. Тэд энэ бүхэн нь хэн хэндээ тустай гэдэгт итгээд, мэддэг чаддаг бүхнээ зүгээр л орхиод явж билээ.

Магадгүй энэ бүхэн нь тэднээс хэтэрхий ихийг шаардсан, шударга бус явдал байсан байж болох. Найз хэмээн үзэж явсан хүмүүс нь

ингэж хандсанд тэд гомдсон л байгаа. Хүмүүсийн оролцоо байгаа газар ямагт алдаа гардаг. Гэхдээ тэд зүрхээ гомдлоос цэвэр байлгаж, өдөр бүр хойшоо биш, урагшаа харж амьдрахаар шийджээ.

Түүнийг амарч, үйлчилж, сурч, эдгэрэх чимээгүй улиралдаа байх үед нь Жон тэр удирдагчтай хоолонд орсон юм. Цаг хугацаа өнгөрсөөр, тэд ч урагшаа явсаар байв. Одоо тэр хос эдгэрч, гэрлэлт нь бүтэн болж, хүүхдүүд нь цэцэглэж байгаа. Тэд Америкийн чуулган тариалдаг, маш том байгууллагатай нягт хамтарч ажилладаг. Энэ холбоогоороо тэд амьдралынхаа сургамжийг бусадтай илэн далангүй хуваалцаж, бусдыг эдгэрэлд хүрэхэд нь тусалж, бусдыг өөрсөд шигээ бүдрэхээс сэргийлдэг. Би тэдэнд урьд нь хайртай байсан бол, одоо бүр ихээр хайрлаж хүндэтгэх болсон. Тэд доороо үлдээгүйд би маш их баярладаг. Тэд ахин дахин боссон. Мэдээж маш хэцүү байсан. Гэхдээ тэд зам дээрээ үлдсэн.

Харин нөгөө удирдагч нь гэргийтэйгээ тэс өөр үйлдэл хийсэн юм. Жон тэр удирдагчтай мессежээр харилцаж, юу ч болж байсан зам дээрээ үлдэхийг ятгаж билээ. Тэр зөвшөөрсөн. Гэхдээ бэрхшээл ирэх үед үлдээгүй. Тэд үйл явц дундаас гарсан. Тэд удирдагч нарыгаа ямар ч утга учиргүй зүйл шаардаж, шударга бус хандаж байна гэж үзсэн. Магадгүй үнэн ч байж болох ... үүнийг зөвхөн Есүс л мэднэ.

Хамгийн эмгэнэлтэй нь гомдол нь тэднийг буцаагаад тэр их шавар шавхайд нь зоочихсон юм. Тэгээд тэд гомдлын “мэргэжилтэн” болж, өдий хүртэл хуримтлуулсан хамаг ач тус нь талаар болсон юм.

Уналт хүнийг ялан дийлдэг хоёр дахь арга зам нь - хүн алдаагаа амьдралын сургамж гэж биш, харин цаазын ял гэж үзэхэд ирдэг. Чи алдсан гээд бүтэлгүй амьтан болохгүй. Амьд хүн бүрт бэрхшээл ирнэ. Үүнээс ангид хүмүүс байхгүй. Зүгээр л зарим хүн бэрхшээлийг бусдаасаа арай дээр даваад гардаг юм. Бэрхшээлээс зайлах арга байдаггүйг би яс махаараа сурсан. Хүмүүс чамайг гомдооно. Зарим нь санаатайгаар, зарим нь санаандгүйгээр. Амьдрал чамайг шархлуулна - арай гайгүйдээ тав тухыг чинь алдагдуулна. Дайсагнал хүн бүрт эрт орой их бага хэмжээгээр ирнэ. Гэхдээ би чамд маш гоё үнэнийг хэлье. Нэгэн цагт хэзээ ч мартаггүй, аймшигтай зовлон гэж үзэж байсан зүйлсээ би одоо бараг санадаггүй. Яагаад? Би босоод, цаашаа явсан. Тэгээд цаашаа явахдаа, шинэ бэрхшээлтэй тулгарсан. Гучтай байхад

ӨРСӨЛДӨГЧГҮЙ


минь гүүрэн доогуур минь үерлэн орж ирээд, ингээд л дууслаа хэмээн бажгадуулдаг байсан юмсынхаа ачаар өдгөө тавь гаруй насандаа би магистрын зэрэгт хүрчээ.

Бүдрэлт болгон сургамж юм. Бид саад, хөнөөл бүрийг таньж эхэлдэг. Бид үдээсээ чанга үдэхийг сурдаг. Бид Үгийг уншиж, өмнөх замаа гэрэлтүүлдэг. Биднийг босох бүрийд хүчин чадал маань нэмэгддэг. Худаг маань гүнзгийрч, Ариун Сүнсний амьд усанд их зай гаргаж өгдөг.

ИТГЭМЖТЭЙ ТӨГСГӨХ

Одоо сайн гэдэг үгийн хоёр дахь утгыг үзье. Англи хэл дээр сайн ба худаг гэдэг хоёр үг нь адилхан үгс байдаг. Худаг нь булаг, оргилуур зэрэг усны эх үүсвэр юм. Бид өөрөө амийн уснаас

ундаалж байвал, бусдыг ундаалах ундарга болно. Амийн усны гүн худаг нь ширгэшгүй ундаргатай. Тэр цагт хүмүүс биднийг харахдаа, шалбаагт хэвтэх хэдэн задгай зоос гэж үзэхгүй. Тэд Бурханы хэзээ ч хувирашгүй итгэмжтэй байдлыг олж харна.



**Амьдралын
утга учир нь үйл
явцад биш, харин
уралдаанаа
хэрхэн дуусгахад
л оршино.**

“Сайн байна!” гэдэг үгийн “байна” нь гүйцэтгэлийг илэрхийлнэ. Библи сайн юмуу тааруухан дуусгах талаар ямар олон сургаалт үлгэр ярьдаг билээ.

Ноа гэдэг хүн өчнөөн жил мундаг завь барьж, төслөө сайн дуусгасан. Самсон гэдэг хүн өчнөөн алдаа гаргасан ч, адагтаа ер бусын тэнгэрлэг хүчийг харуулсан. Христийг мэдэхгүй гэж гүрийсэн Петр байна. Мөн Христийг хавчигч Паул эцэстээ Христийн хамгийн том зарц болсон. Тэгвэл эсрэгээрээ - тооцоо хийлгүйгээр барилгын ажил эхлүүлсэн хүн ч байна. Тэр сайн эхлэсэн ч, дуусгаж чадаагүй учраас, элэг доогь болдог. (Лук 14:27-29) Бас ганц талант хүлээж аваад, эзнээ иртэл ашиглалгүй, булахаар шийдсэн зарц байна. Зоос хөрсөнд ургадаггүй учраас, тэр юутай байсан түүнтэйгээ л үлдсэн. Үүнийхээ гороор тэрбээр залхуу муу боолоороо дуудуулж, гадаад харанхуйд хаягдсан. (Матай 25:14-30)

Тэгэхээр, эдгээр түүхээс нэг л зүйлийг сурч болно. Амьдралын утга учир нь үйл явцад биш, харин уралдаанаа хэрхэн дуусгахад л оршино. Тууштай, итгэмжтэй, тогтвортой дуулгавартай зан нь ямар ч агсам, эрчтэй даралтыг даваад гардаг бөгөөд замдаа хичнээн ч бүдэрч ойчсон бай, бушуухан босоод зөв зам руу явах юм бол, Бурхан биднийг гэрт маань авчрахдаа л авчирна.

Амьдралаар сайн аялахын тулд хүчтэй, гүн худаг ухах шаардлагатай. Харин үүний тулд эхэлсэн юмаа сайн дуусгах хэрэгтэй. Хүслийн худгийг хэн ч бүтээж чадна. Гэхдээ бидэнд гүн худаг - Бурханы Үгээр бэхэжсэн, Ариун Сүнсний сэргээгч оргилуураар шинэчлэгдсэн, амийн усан сан хэрэгтэй. Тэр цагт л Бурханы мундаг шагналыг - өрсөлдөөнгүй амь ба амлалтыг олно.

Хэлэлцэх асуулт

1. Амьдралд чинь Бурхан яг одоо малтлага хийж байгаа ямар тал байна?
2. Гүн худаг гэж ямар эмэгтэйг хэлэх вэ? Дүрслэнэ үү.
3. Библийн бус аргаар сүнслэг байж болох уу?
4. Сэтгэлийн чинь худаг юугаар дүүрч байна? Үүнийг чинь юу хоослож байна?
5. Худгаа хэрхэн бодитоор арчилж тордох вэ?

Өрсөлдөгчгүй охин

Дарангуйлагчийг үхэхэд, дарангуйлал нь төгсдөг.
Итгэлийнхээ төлөө амиа алдагчийг үхэхэд хаанчлал нь
эхэлдэг.

Сөрэн Киеркегаард

“Э нэ дэлхийн хамгийн хүчирхэг, муу ёрын захирагчийг
ялсан.
Эгнэшгүй гэж тооцогдож байсан Сайн мэдээг
зоригтойгоор танилцуулсан.

Хүний ухаанд багтамгүйгээр зодуулж, соригдож, тамлуулсан
ч, Сайн мэдээнд, найз нөхөддөө, Эзэнд үнэнч үлдсэн.

Шоронд хаягдсан боловч, хязгааргүй олон хүнд хүрсэн.

Ганц бие боловч, ганцаараа байгаагүй.

Элч нарын дунд байсан бөгөөд анхны чуулганы түүхчид
түүний үйлчлэлийг тэмдэг гайхамшгаараа бараг л өрсөлдөгчгүй
байсан” гэж үздэг нэгэн эмэгтэй байжээ.

Чи хэний тухай яриад байна хэмээн гайхаж байгаа байх.

Би өөрөө ч тэр эмэгтэйн талаар саяхан л олж мэдсэн юм.
Гэхдээ тэрбээр цаг хугацааны элсэнд нэрс нь дарагдсан чуулганы
эхчүүдийн нэг байжээ. Би түүний талаар зөндөө сонсож явсан л
даа. Гэхдээ яг нүүр нүүрээрээ уулзаагүй байсан юм. Би түүнийг
үлгэр домгийн хэмжээнд биш, жинхэнээсээ мэдэхийг хүссэндээ,
чуулганы түүхийг судалж үзлээ. Ингээд Библийн эрдэмтдийн

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

судалгаатай танилцаж, түүхэн номууд уншиж, интернэт баахан ухав. Тэгээд тэр эмэгтэйн нэрийг олж мэдээд, түүний талаар тайлан гаргахуйц хангалттай мэдээлэлтэй болсон учраас, та нарт ч мэдүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Түүнийг Фотина юмуу Фотини гэнэ. Грекээр “гэгээрсэн нэгэн” гэсэн утгатай. Тэрбээр Христэд итгэхдээ энэ нэрийг авчээ. Есүс түүний амьдралыг бидний л нэгэн адил гэрлийн илчлэлээр гийгүүлжээ. Христийн үнэнч зарц тэрбээр дээд өрөөнд цуглан залбирч байсан хүмүүсийн дунд байсан гэгддэг. Тэгээд Ариун Сүнсний галын дөл тэдний дээр буухад, тэр ч бас Сүнсээр дүүрч, харь хэлээр ярьжээ. Пентекост өдөр Фотина Сайн мэдээг дэлхийн хязгаар хүртэл номлох захирамж хүлээн авчээ.

Бидний эрэлхэг эгч маань өөрийг нь хязгаарлаж байсан бүхнийг - тав тухаа ардаа орхиод, алсын Африкийг зорихдоо, ганцаараа явалгүй, гэр бүлээрээ явжээ. Христ Фотинагийн амьдралыг орвонгоор нь эргүүлсэн учраас, үүнийх нь улмаас хөвгүүд нь ч, таван эгч дүү нь ч Христэд итгэжээ. Тэгээд Фотина хүү Иосеф, таван эгч, дүүгийнхээ хамт Үйлс 1:8 дээр Есүсийн айлдсаны дагуу дэлхийн хязгаар руу явсан байна.

Африкт тэд бүгдээрээ итгэмжтэй хөдөлмөрлөж, гайхамшигтай жимс ургадаг Карфагенд Христийн Сайн мэдээг тараажээ. Тэгтэл галзуу хаан Неро эзэнт гүрэн даяарх итгэгчдийг баривчлан алж байгаа мэдээ ирэв. Фотина Бурханы цэц ухааныг хайжээ. Есүс Фотинагийн зүүдэнд ирээд, түүнийг Ром орж, Неротой нүүрэлд гэжээ. Тиймээс тэд Нерогоос аль болох хол зугтахын оронд яг шуурганы нүд рүү явж оров. Фотина, түүний хүү, таван эгч, дүүс нь Карфагений итгэгчдийн хамт Ром руу явах замын усан онгоцонд суужээ.

Хүмүүс тэдэнд Христийг ил тодоор хүндэтгэх юм бол алуулах учраас, нууцаар л хүндэтгээрэй хэмээн анхааруулав. Энэ бол Ромд албан тушаал хашдаг Фотинагийн хүү Виктор, Себастиан гэдэг албаны хүн хоёрын хооронд өрнөсөн яриа:

“Виктор, ээж, дүү хоёр чинь Христийн дагалдагч. Найзын хувьд би чамд хааны тушаалыг биелүүлэхийг зөвлөө.

Христэд итгэгч хүмүүсийг мэдээллэх юм бол, чи эд мөнгөөр

шагнуулна. Би ээж, дүү хоёрт чинь Христийг олны дунд номлохгүй байхыг гуйсан захидал бичнэ. Тэд нууцаар л итгэг” гэтэл, Виктор Себастианд: “Би ээж, дүү хоёр шигээ Христигтэлийг номломоор байна” гэжээ. Тэгтэл Себастиан Викторт: “Виктор минь, Виктор минь, тэгвэл та нар алуулна шүү дээ”¹ гэв.

Амиа алдахаа мэдвэл, хичнээн хүн итгэлээ нээлттэй зарлах бол? Хожим Виктор ээж, дүү, эгч нартайгаа нийлсэн байдаг. Тэгээд Фотини хэмээх бэлбэсэн эмэгтэйн Неротой нүүр тулсан анхны уузалтыг түүхэнд ингэж тэмдэглэжээ:

Фотинигийн айлчлал, үйл ажиллагаа хотод бөөн шуугиан дэгдээв. Хүмүүс: “Тэр юун эмэгтэй вэ? Христийн баахан дагалдагч нартай ирээд, Христийг айдасгүйгээр ярих юм” гээд л. Цэргүүд Фотиниг баривчлахаар явсан боловч, Фотини өөрөө тэднийг хүлээж байлаа. Тэгээд цэргүүдэд баривчлагдахаасаа ч өмнө хүүтэйгээ бас итгэгч найзуудтайгаа Неро руу явжээ. Хаан түүнийг хараад яах гэж ирснийг нь асуув. Фотини: “Бид чамайг Христэд итгэ гэж хэлэхээр ирлээ” гэжээ. Ромын эзэнт гүрний хагас галзуу удирдагч түүнийг айлгасангүй. Тэр хааныг Христэд итгүүлэхийг хүсчээ.²

Мэдээж Неро хүлээж аваагүй. Тэгээд өөрсдийгөө Есүсийн мутарт байгаа гэж ярьдаг хүмүүсийн гарыг нь төмөр ташуураар бяцлахыг тушаав.

Гэвч бяцлаад ч нэмэр болоогүйг мэдмэгцээ, тэднийг шоронд хорьж, итгэлээс нь урвуулах төлөвлөгөө зохиожээ. Энэ удаа хаан тэдэнд эвээр хандав. Неро баярын танхимд зургаан сэнтийг засуулав. Тэгээд сэнтий бүрийг Ромын бүхий л баялгаар хүрээлэв. Эмэгтэй хүний сэтгэлийг олзлох юмсыг гар таталгүй хаяв. Алт мөнгөнөөс гадна эмэгтэй бүрийн өмнө сүр жавхлантай, тансаг хувцас, үнэт эдлэл тавьжээ. Христэд итгэх итгэлээ няцаагаад, Ромын бурхдад мөргөчих л юм бол, тэднийг ийм сайхан тансаг амьдрал хүлээж байв. Тэгээд санаандаа хүрэхийн тулд Неро охин Домнинагаа тагнуулаар явуулжээ.

Домнина өрөөнд орж ирээд, Фотинатай эелдгээр мэндлэхдээ

Христийн нэрийг дурьджээ. Фотина түүнийг итгэл нэгт дүүгээ байна гэж бодоод, тэвэрч авсныхаа дараа Христийн хайр, гайхамшгийн талаар хуваалцав. Гэтэл Домнина Фотинаг урвуулах нь бүү хэл, өөрөө Христэд итгэжээ. Фотинагийн зоригтой номлолоор Домнина төдийгүй, түүний зарц эмэгтэйчүүд ч бас итгэжээ. Дараа нь Фотина тэр бүх баялгийг өрөөнөөс зайлуулж, Ромын гудман дахь ядууст тарааж өгөхийг хүсэв. Домнина баптисм хийлгэж, шинэ нэрийг хүлээн авчээ.

Неро хилэгнэв. Тэр Фотинаг хөвгүүд, эгч дүүстэй нь шатааж алах тушаал буулгав. Тэгээд маш том зуух асааж, тэднийг зууханд хаясан ч, тэд шатсангүй. Дараа нь Неро тэднийг хордуулж ал гэж тушаав. Фотина тэр хорыг нь сайн дураараа хамгийн түрүүнд уусан ч, хор нь түүнд ч, бусдад нь ч нөлөөлсөнгүй. Тэгтэл хор уулгахаар очсон хүн нь өөрөө Христэд итгэв. Тэд итгэлийнхээ төлөө шоронд гурван жил хамгийн аймшигтай тамлуулжээ.

Гэхдээ тамлах тусам, итгэл нь улам л өссөөр байв. Итгэл, хүчний талаарх мэдээ нийслэл даяар тархаж, шорон нь өөрөө магтаал хүндэтгэлийн өргөө болон хувирчээ. Ромын иргэд залбируулж, Сайн мэдээ сонсохоор итгэгчдийн төмөр тор руу байнга ирдэг болжээ. Ийнхүү Христийн Сайн мэдээ гурван жил Ромыг шоронгоос эзэлж, үй олон хүн итгэжээ.

Неро шоронд хийсэн нэгэн хуучин зарцаа авчруулан асуутал, тэрбээр энэ бүхэн үнэн болохыг хэлжээ. Тэгээд Неро Фотинагаас бусад шоронд байгаа бүх итгэгчдийн толгойг даруй авах тушаал буулгав. Неро Фотинагийн эр зоригийг уй гашуу, ганцаардлаар мохоохоор шийдэн, тас харанхуй, усгүй худагт хаяжээ. Гэхдээ эхлээд аймшигтай шийтгэсэн талаар олон газарт тэмдэглэсэн байдаг. Тэгээд Фотинаг яг л онгорхой булш шиг аймшигтай харанхуй газар гав ганцааранг нь хэдэн долоо хоног хаяжээ. Тэр аймшигтай өдрүүдэд Фотина ихэд гашуудан уйлжээ. Гэхдээ хайртай хүмүүсээ алдсандаа уйлсангүй. Учир нь хайртай хүмүүс нь газрын шоронгоос суллагдаж, хэдийнээ тэнгэрт очсон гэдгийг Фотина мэдэж байлаа. Фотина үнэндээ хөвгүүд, эгч дүүсийнхээ хамт тамлуулан алуулаагүйдээ л уйлжээ. Учир нь тэрбээр зовогчийн титмээ алдсан юм. Энэ үе түүний хувьд хамгийн хүнд үе байсныг бүх эх сурвалж хэлдэг.

Миний уншсан бүх тэмдэглэл Фотинагийн худагт өнгөрүүлсэн энэ харанхуй үеийн талаар дурьдсан байдаг. Нэг бичвэрт түүнийг тэр хуурай худагт цөхөрсөндөө биш, харин сонголтоороо үхсэн гэдэг. Тэрбээр Степан шиг зүүдэндээ Аврагчаасаа зуураад, сүнсээ Түүнд даатгажээ. Гэтэл өөр нэгэн бичвэрт Фотинаг худагт нилээд удаан хорьсныхоо дараа гаргаж авсан. Хожим шоронд байхад нь Есүс түүнд үзэгдэж, тэрбээр амьсгал хураасан гэдэг. Ямар ч байсан тэр эмэгтэйн амьдрал үй олон хүнийг ундаалсан, амийн усны гүн худаг байжээ.

Орчин цагт итгэлийнхээ төлөө алуулж байгаа хүмүүс

Фотина зүгээр нэг бишрэгчид юм уу шүтэгч нарыг төрүүлээгүй. Түүний амьдрал гэрч нарыг болон итгэлийнхээ төлөө алуулахаас ч айдаггүй хүмүүсийг төрүүлжээ. Миний хүсдэг зүйл Фотинад байжээ. Тэр эмэгтэйд бидэнд бүгдэд маань хэрэгтэй ганхашгүй шийдвэр байжээ. Дэлхий Христэд итгэгч хүмүүсийг таалах үед Чуулганы ирц өсдөг. Гэхдээ жинхэнэ үнэнч дагалдагч нар зовлон дунд л төрдөг юм. Шинэчлэгдсэн Католик түүхч Христофер Хенри Давсон ингэж тайлбарласан байдаг:

Чуулган цаазлагч нарын ташуур, сүхний сүүдэр дор өсч, Христэд итгэгч бүр махан биеийн тамлал, үхлийн аюул дор амьдарч байлаа. Анхны Христитгэлийг тэр чигээр нь итгэлийнхээ төлөө алуулсан итгэгч нараар л харж байв. Гэхдээ энэ нь зөвхөн айдас биш, харин төгс бөгөөд найдвар байсан юм. Учир нь итгэлийнхээ төлөө амиа алдагч нь бүрэн төгс Христэд итгэгч, хуучныг ялан дийлсэн шинэ нийгмийн ялагч, баатар бөгөөд тэр бүү хэл сорилтыг давж чадаагүй Христэд итгэгч нарын хувьд ч авран хамгаалагч нар нь болж байв.³

Бид завхрал, муу ёр, хүчирхийлэлд идэгдсэн цаг үед аж төрж байна. Тэгээд үүнээс дордоно гэж байхгүй гэж бодохоор л үүнээс дордсоор байдаг. Өнөөдөр ч итгэгч хүмүүс итгэлийнхээ төлөө алуулсаар байгаа ч, дөжирсөн дэлхий үүнийг бараг тоохоо больжээ. Зүрх урагдмаар. Гэхдээ мэдээж цочирдсондоо биш л дээ. Саяхан

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Америкт Христэд итгэгч оюутнууд итгэлээсээ болж буудуулж алуулсан. Гэтэл үүнийг хүмүүс үзэн ядалтын гэмт хэрэг гэхээсээ илүү зүгээр л буу эзэмших эрхийг хязгаарлах сэдэв болгосон.

Тайтгарал ба чөлөөлөлт нь энэ дэлхийн удирдагч нараас ирэхгүйг Библи хэлдэг. Бид Фотина шиг харанхуйн нүүрэн дээр дуугарах ёстой. Бид 1Иохан 4:4-ийн амьд илчлэл болох ёстой:

“Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгчаас аугаа.”

Бусад улсад итгэгч хүмүүсийн толгойг авч, бичлэгийг нь өөрсдийгөө загалмайн хүмүүс гэдэг итгэгч хүмүүст сүрдүүлэг болгон дэлхий даяар цацаж байна. Гэмт этгээдүүд хүртэл биднийг хэн болохыг санаж байхад, бид өөрсдийгөө хэн болохыг мартчихсан юм биш байгаа?

Саяхан лгэхэд Лалын цэргүүд Кенийн Христэд итгэгчдийн коллежид нэвтрэн, өглөөний залбиралд цуглаад байсан хүмүүсийг алаад, дараа нь оюутнуудыг дотуур байр, хостелээс нь гаргаж ирээд, буу тулгаж байгаад итгэлийг нь шалгаажээ. Тэгээд итгэлээ хүлээн зөвшөөрөх зүрхтэй байсныг нь буудаж алсан юм. Бараг 150 хүн алуулж, олон хүн шархаджээ. Дараа нь тэр бүлэглэл энэ хэргээ олон нийтийн сүлжээгээр цацаад, загалмайн хүмүүсийг авлах ав эхэллээ гэж мэдэгдсэн юм.⁴

Чи Христийн төлөө зовоход бэлэн үү? Ямар ч бэлтгэлгүй явж байгаад, Түүнийг няцааж байснаас, хариултаа эхээд, хэзээд бэлэн явж байя. Үйлс 5:41-42 дээрх дагалдагч нар яг ийм үзэлтэй байсныг хар:

Түүний нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж тооцогддогт баярлалдан тэд Зөвлөлөөс гарч явлаа. Тэгээд өдөр бүр сүм дотор бас айлаас айлд зааж, Есүс бол Христ гэдгийг тунхаглахаа эс зогсоов.

Итгэлээсээ болж зодуулж байсан хүнтэй таарч байсан уу? Тэр нэрийн төлөө зовохоос ч айдаггүй хүнтэй уулзаж байсан уу? Би уулзаж байсан. Амьдрал нь дотроо ч, гаднаа ч цэв цэвэр тэдгээр хүмүүс Есүстэй уулзсан учраас, Есүсийн зовлонгийн хуваалцагч болохоос айдаггүй юм. Тэд миний мэдэхгүй нигүүлслээр титэмлэгджээ. Христэд итгэснийхээ төлөө амиа алдахад ч бэлэн хөдөлмөрлөж яваа хүмүүстэй би уулзсан. Тэд өдөр бүр аюул заналд алхдаг. Бидний номыг орчуулахаар хөдөлмөрлөж яваа ахан дүүс маань голдуу л

ийм хүмүүс байдаг. Миний амар тайван дотор бичиж байгаа зүйлийг тэд аюул дотор орчуулдаг. Тиймээс үнэндээ би өөрийгөө тэдэнтэй мөр зэрэгцэн ажиллах эрхгүй нэгэн гэж үздэг юм. Тэдний амьдрал 1Коринт дээрх Паулын үгсийг надад сануулдаг:

“Яагаад бид ч цаг үргэлж аюулд байна вэ? [Ах дүү нар аа,] би өдөр бүр үхдэг. Бидний Эзэн Есүс Христэд миний бахархал болдог та нарын талаарх бахархлаар би баталъя.”
(1Коринт 15:30-31)

Барууны сул дорой байдал

Үнэнээ хэлэх үү? Би Барууны чуулганы төлөө чичирдэг. Харамсалтай нь өнөө үед бид Христийн нэрийг үл хүндэтгэдэг хүмүүстэй л таарах нь их юм даа. Заримдаа би өөрийнхөө амиа бодсон, тоомжиргүй зандаа дургүй хүрдэг.

Саяхан Жон, бид хоёр чуулгандаа нэг зүйлийг байнга анхааруулдаг хоёр пастортай хоол идсэн юм. Тэд Эзэн Есүст итгэсэн хүмүүсийг бэлгийн ёс бус харилцаанд орохоос байнга сэрэмжлүүлдэг ажээ. Гэхдээ үүнийхээ хариуд нэг бол ямар ч хувиралгүй царайнууд эсвэл дурамжхан шалтаг сонсоно. Хамтран амьдардаг хосууд “Бид нэг л өдөр гэрлэнэ шүү дээ. Тэгээд одоо хамт амьдарч, унтах нь юу нь буруу байгаа юм?” гэдэг.

Бас нэгэн үйлчлэгч гэргийгээсээ ямар ч үндэслэлгүйгээр салж байгаа олны танил өөр нэгэн үйлчлэгчид санаа зовж байгаагаа ярьсан юм. Тэрбээр салалтаасаа болж жил гаруйн хугацаанд олон нийтийн өмнө гарч чадахгүй ч, жилийн дараа буцаж ирнэ гэж тооцоолжээ. Гэхдээ тэрбээр яг ингэж чадах учраас, туйлын аюултай юм. Хүнээс айх айдас маань биднийг нүглээс салгахгүй. Гагцхүү Эзэнээс эмээхүй л биднийг ёрын муугаас хол байлгана.

Ариун Сүнс зуу зуун эмэгтэйчүүдийг загалмайгаа аваад, Есүсийг дага хэмээн тосолсон, эмэгтэйчүүдийн маш хүчирхэг нэгэн цуглаан дээр удирдагч нь гарч ирээд, эмэгтэйчүүдэд: “Өөрийгөө хүчлэх хэрэггүй. Бурхан та нараар ямар нэг юм хийлгэхээр дуудаагүй. Та нар Бурханы хүчирхэг охид байхад л хангалттай” гэж хэлж билээ. Тийм гэж үү?

Есүс зүгээр л Бурханы Хүү байгаагүй, харин тэнгэрлэг мөн чанараа тайлж, бидний төлөө зарцын ажил хийсэнд нь би үнэхээр баярладаг. Би чуулган дэлхийтэй хүзүү сээрээрээ хэлхэлдсэн байгааг нь хараад үнэхээр айдаг.

Өнгөрсөн амьдралтай эмэгтэй

Фотина шууд ингэж эхлээгүй юм. Тэр нэгэн цагт маш журамгүй, ичгүүртэй, харийн эмэгтэй байжээ. Тэр хуулиар яллагдсан учраас, түүнд ирээдүй гэж байгаагүй юм.

Бичээс бидэнд нэгэн эмэгтэйн тухай өгүүлдэг. Түүнтэй анх уулзахад, тэр нэр ч үгүй, байх ёстой газраа ч олоогүй, ганц бие эмэгтэй байв. Түүний амьдрал олон талаараа ямар ч эмх замбараагүй байсан тул хэн ч түүнийг үйлчилнэ гэж санаагүй. Тэрбээр үүнийг ойлгож байсан болохоор, эхлээд Сайн мэдээг хүмүүсийн асуултад хариулах маягаар л хуваалцдаг байжээ. Магадгүй чамайг ч хүмүүс шүүсээр байгаа болохоороо хэлсэн үгийг чинь санаа юмуу асуулт төдий л үзэж болох.

Тэднийг уучил.

Чиний өнгөрснөөс зуурдаг хүмүүс Бурханы өршөөл ба дахин төрөлтийн хүчийг үзээгүй байгаа юм.

Магадгүй чи өөрөө өөртөө эргэлзэж байж ч болох. Миний өнгөрсөн ч надад олон асуулт төрүүлдэг. Гэхдээ амьдралын маань хамгийн харанхуй, бохир хэсгүүд л хожим авран сэргээгдсэнийхээ дараа амьдралын маань хамгийн гүн худаг болсон юм. Тийм ээ, анхлан эхэлж байгаа хүмүүсийг удирдлагад үтэр түргэн дэвшүүлж болохгүй ч, Христэд итгэдэг хүн бүр авралын хүчийг гэрчлэх ёстой. Гэхдээ Есүсийн үнэт нигүүлслийг хүчирхийлж, шалтаглаж улам их нүгэл үйлдэж болох юм. (Ром 6:1-2) Түүний нигүүлсэл бидний хувьд өөрчлөгдөж, өсөн нэмэгдэх зөвтгөлийн өөрчлөгдсөн амьдралаар амьдарч, шинэ нэр хүлээж авахад түлхэц болох ёстой.

Фотина “гэгээрсэн нэгэн” гэдэг нэрийг хүлээж авахаасаа өмнө гагцхүү өөрийнхөө хүмүүсийн дунд л танил байжээ. Бид түүнийг Есүстэй хувьчлан ярилцаж байхтай нь таардаг. Тэрбээр худаг дээр Есүстэй уулзсан Самари эмэгтэй юм. Хуучин таван нөхөртэй байсан эмэгтэй хожим таван эгч, дүүсийнхээ хамт үйлчилнэ чинээ санамгүй!

Би үүнд үнэхээр дуртай. Учир нь тавын тоо нь Библид нигүүлслийг билэгддэг. Тэрбээр нигүүлсэл дээрээ нигүүлслийг үзэж!

Би тэр эмэгтэйд үргэлж дуртай байсан. Би түүнийг хэзээд маш их хүчин чадалтай эмэгтэй гэж үзсээр ирсэн. Тэрбээр гүехэн амьдралтай гүн худаг байжээ. Амьдралынх нь бэрхшээл, сонголт нь түүний дотор гүн харанхуй, хуурай нүх ухаж хаяжээ. Сэтгэлийнх нь дайсан энэ газрыг мөнхөд түүнийг бусдаас тусгаарлаж, мөрөөдлийг нь булшилдаг нүх байлгахыг хүсчээ.

Иохан 4 дээрх Есүс, тэр эмэгтэй хоёрын уулзалтыг харахдаа, би дандаа өөрийгөө тэр эмэгтэйн оронд тавьдаг юм. Дагалдагч нар ядарсан Есүсийг худаг дээр орхиод явдаг. Хоньид сүргээ услахаар ирэх болоогүй байв. Харин эмэгтэйчүүд усаа хэдийн эртүү базаасан байлаа. Тэгтэл ийм явдал болов:

Иаковын худаг тэнд байжээ. Аянд зүдэж цуцсан Есүс худгийн дэргэд сууж байлаа. Энэ нь зургадугаар цагийн орчим байв. Самарийн нэгэн эмэгтэй ус татахаар тэнд ирэхэд Есүс түүнээс —Надад уух юм өгөөч гэв. Энэ үед шавь нар нь хүнс худалдан авахаар хот явсан байлаа. (Иохан 4:6-8)

Есүс урт аялал, Фарисайчуудаас болж ядарчээ. Тэгээд Иаковын эртний худаг дээр амсхийн сууна. Ойрх Дорнын мятрашгүй нар Түүнийг нозооруулав ч, худгаас сэрүү татна. Есүс худаг руу хараад, өдрийнхөө үйл явдлыг тунгаан, худгийн түүхийг эргэцүүлнэ. Тэд Иудеа дахь Сайн мэдээний ажлаа гэнэт дуусгахаас өөр аргагүй болж, урт удаан, шороо тоостой замыг туулсаар иржээ. Шашны удирдагч нар тэдний ажлыг Иоханы болоод Түүний дагалдагч нарын хоорондох сүмийн уралдаан болгосныг мэдээд, Есүс баптисмаа дуусгахаас өөр аргагүй болжээ (Иохан 1).

Шашныхан яагаад жинхэнэ юмыг гуйвуулна вэ? Тэд Иоханы дагалдагч нартай гар нийлэн ажиллаж байсан. Тийм ээ, олон хүн ирсэн. Ангаж цангасан хүмүүс. Учир нь эш үзүүлэл ба амлалт хүмүүсийг бэлтгэж, хүмүүс гэмшлээр бөгөөд баптисмын урсгал усаар дамжин сэргээгдэж байв.

Гэтэл шашныхан энэ өөрчлөлтийн давалгааг нарийхан тойрог болгохыг хүсчээ. Тиймээс л Есүс Иорданы усыг орхиод, дагалдагч нараа дагуулан тэр ангамал газар ирсэн аж.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Есүс нүдээ аниад, тоостой агаарыг сэтлэн, хуурай нар өөд харав. Тэрбээр эртний нэгэн худгийн дэргэд дагалдагч нараа хүлээн сууна. Тэгээд гүн санаа алдав. Гэнэт зүрхэнд нь найдвар асч, Ариун Сүнс: “Энэ үржил шимгүй Самарийн талбайд Надад нэгэн зорилго байна” гэж шивнэх нь сонсогджээ. Есүс ургац гэдэг үгийг сонсов. Тэрбээр нүдээ нээгээд, ус авахаар айсуй Самари эмэгтэйг олж харав.

Тэрбээр том сав тээжээ. Эмэгтэйчүүд яг ингэж үүрээр усаа базаадаг. Тэр эмэгтэйн сав нь ч, зүрх нь ч хоосон. Тэр эмэгтэй хүмүүстэй тааралдахаас зайлсхийсэндээ үдийн халуунаар яваа нь энэ. Библийн эрдэмтэд түүнийг худаг дээр зориуд хүнгүй үеэр ирдэг байсан гэдэг.

Есүс түүнийг харна. Тэр эмэгтэй Есүсийг хармагцаа бушуухан харц буруулав. Эмэгтэй Есүсийг хувцсаар нь Еврей хүн болохыг нь мэджээ. Еврейчүүд Самаричуудтай харилцдаггүй, нүд үзүүрлэдэг. Тэр эмэгтэй асуудал гэж юу байдгийг мэддэг учраас, дахиж асуудалд орохыг хүссэнгүй.

Эмэгтэй худгийн нөгөө талаас ойртоод, саваа буулгаад, ус авах гэтэл Есүс түүнийг дуудав. Тэрбээр гайхан, толгойгоо өргөөд, зог тусав. Есүсийн дуу хоолойн өнгө нь эмэгтэйг олзолжээ. Есүс түүнээс ус хүссэн ч, шаардлага биш, гуйлт шиг санагдав. Эмэгтэй учраа олохгүй:

“Та иудей хүн байж самари эмэгтэй надаас яагаад уух юм гуйна вэ?” гэв. (Иохан 4:9)

Жишээлбэл чи заваан гэж үзсэн аягаасаа уух уу? Тэр чинь Самари хүн төдийгүй, бүр эмэгтэй хүн шүү дээ. Гэхдээ Есүс түүний аягаас уухаас сэжиглэсэнгүй... Тэр түүний уур хилэнгийн аягаас уухаар бүр өмнө шийдчихсэн байжээ. Түүнчлэн Есүс түүнийг бусад эрчүүд шиг ашиглахыг ч хүсээгүй. Есүс түүнд Өөрийгөө хэн болохыг л мэдүүлэхийг хүсчээ. Магадгүй Есүс тайван ярилцахыг хүссэн байх. Магадгүй Есүс Өөрийг нь буруугаар таниулж байгаа бодлогогүй шашны удирдагч нараас залхсан байх. Тиймээс зүгээр л танихгүй хүнтэй зүрх сэтгэлээсээ ярилцахыг хүссэн байх.

Есүс түүнд хариулан —Хэрэв чи Бурханы бэлгийг болон “Надад уух юм өгөөч” гэж байгаа нь хэн болохыг мэдсэнсэн бол чи Түүнээс гуйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан гэж айлдсанд... (Иохан 4:10)

Эмэгтэй ангайв. Бурханы бэлгийн талаар ярьдаг энэ хүн хэн бэ? Тэгээд үнэхээр ийм аймаар мэдэгдэл хийх эрхтэй хүн мөн эсэхийг нь мэдэхээр худгийг тойрон, Түүн дээр ирдэг. Барьж явсан саваа магадгүй Есүсийн хөлд тавьсан байх. Эмэгтэй Есүсээс мэдэгдлийг нь баталчих юм олж харсангүй. Энэ хүн ч бас бусад эрчүүд шиг түүнд хоосон амлалт өгнө үү? Эмэгтэйн сэтгэл догдолж, Есүсийг үнэхээр амьд ус гаргаж чадах хүчин чадалтай эсэхийг нь лавладаг:

Эзэн, энэ худаг гүн, Танд утгах юм юу ч алга. Гэтэл Та амийн усыг хаанаас авах юм бэ? (и11)

Эмэгтэй тэр амийн усыг нь тэр худгаас гарах ёстой гэж боджээ. Энэ Еврей хүн Иаковын худгийг доромжлоод байна уу? Тэр худаг нь баян өвтэй, бусдаас гүн худаг. Тэгээд эмэгтэй бүр лавшруулж асуув:

Энэ худгийг бидэнд өгсөн Иаков өвгөөс маань Та агуу гэж үү? Тэр өөрөө, түүний хөвгүүд, мал сүрэг нь ч эндээс л ундаалсан. (и12)

Энд гарч байгаа худаг нь Иаковынх байгаа нь тун сонирхолтой юм. Иаков гэдэг нэр нь өөрөө “буруу газраа тавигдсан, мэхлэгч, өсгийнөөс зуурагч” гэсэн утгатай. Бурхан эмэгтэй болоод могойн үр удмын дайсагналын тухайд могой эмэгтэйн үр удмын өсгий рүү хатгана гэж зөгнөсөн байдаг. Гэтэл хожим Бурхан Иаковын нэрийг “Бурханы ханхүү” гэсэн утгатай Израиль гэдэг нэрээр сольсон юм. Эр хүн л түүний цангааг тайлж чадна хэмээн удаа дараа мэхлэгдсэн тэр эмэгтэй Иаковын худаг дээр Израилийн амар тайвны Ханхүүтэй ярилцжээ. Эмэгтэй юу болоод байгааг мэдэхгүй байсан ч, Есүс маш сайн мэдэж байв.

Энэ амлалт нь эцсийн эцэст худагтай хамаатай биш, харин эмэгтэйн доторх цангаатай холбоотой байв. Тэгээд Есүс Өөрийнхөө хамгийн сайн хийдэг зүйлээ хийн... асуултыг нь сонсоогүй мэт шууд л эмэгтэйн хамгийн гүн санаашрлыг хөнджээ.

Есүс — Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. Харин Миний өгөх уснаас уух хэн ч хэзээ ч цангахгүй. Миний өгөх ус тэр


ӨРСӨЛДӨГЧГҮЙ

хүний дотор мөнх амь өөд оргилох булгийн ус болно гэхэд...
(Иохан 4:13-14)

Есүс хэн ч гэдэг үгдээ энэ дэлхийд байгаагаас илүү зүйлийг хүсч байгаа хүн бүрийг багтаажээ. Тэр Иүдей, Самаричуудыг болон энэ оргилуур дээр өнгөрсөн, одоо ирээдүйд ирэх бүх хүмүүсийг хооронд нь сүлжжээ. Газрын худаг нь хүний дуусашгүй цангааг л илтгэдэг. Пэйшн Библи дээр Иохан 4:13-ыг:

“Чи Иаковын худгаас уух юм бол, ахин дахин, ахин дахин цангана” гэдэг.

Хуучин худаг чамайг ахин дахин цангаана. Гагцхүү Бурхан л бидний цангааг төгс тайлах юм. Тэдгээр эртний худгийн ундарга нь газрын нөхцөлтэй холбоотой байсан учраас, мөнхийн үр дүн авчирч чадахгүй. Эхний боломжоор л дайсан нэвтэрч, худгийг хордуулах юмуу шороогоор дүүргэнэ эсвэл худаг өөрөө цагийн аясаар хатна.



Газрын худаг нь хүний дуусашгүй цангааг л илтгэдэг.

Хуучин худаг шиг хууль ч бас маш амархан хүний статусаар хордох юмуу хүний зохиосон хууль дүрэм, ёс заншилд булагдах боломжтой. Самаричууд Торагийн эхний таван номыг л мэддэг, өөрсдийнхөө уулан дээр л Бурханыг дээдэлдэг байжээ. Тэд хуулийн сүүдэр дор амьдардаг байсан ч, хууль ч бидэнд хүссэн амьдралыг маань өгч чадахгүйг Иүдейчүүд баталсан юм. Хуулийн болоод өвгөд дээдсийн эдгээр хуучин худаг нь хүнд Ариун Сүнсний амьд ус хэрэгтэй гэдэг үнэнийг л батлан харуулахын төлөө өгөгджээ. Хууль нь байршил болон хүндэтгэлийн газрыг шаарддаг. Хууль нь бидний хувьд Бурханыг хүрэшгүй болгодог. Бурханы хүндэтгэл нь амийн ундарга шиг биш, харин сахил шиг болно. Хуулин дор дадал хэвшил биш, харин айлчлал зочил л байдаг. Хууль дотор байгаа хүн холоос л харахаас биш, хүрч чадахгүй. Хууль нь хүн Бурханыг ширтэхээс биш, Бурхан биднийг атгадаггүй Синай уулын л хэлбэрийг агуулна.

Хүндэтгэлийн ариун газар нь бидний дотор биш, гадар байхад, бид гадны хүмүүс хэвээр үлдэх эрсдэлтэй. Самари эмэгтэй Есүс хоёрын уулзалт нь маш олон хуулийн хүрээг эвдсэн. Тэр эмэгтэй хуулийг эвдэж, нэг эртэй хамтран амьдарч байсан. Өнөөгийн хавьгүй чөлөөт чуулган ч түүнийг “нүгэлтэйд” тооцох байсан. Тэгэвч Есүс түүний ичгүүрт гадаад байдлаас цаашхийг харж, шархалсан зүрхэнд нь хүрчээ.

Хууль нь чамд өгч чадахаасаа илүүг чамаас шаарддаг. Амьд ус нь шингэн гэрэл учраас, үүнийг тээх юмуу тэр бүү хэл жинлэх боломжгүй. Харин үхмэл ус нь тийм биш. Хэрэв чи Иаковын худгийн уснаас арай том зүйл хүсч байвал, чамд сав хэрэгтэй. Чи савныхаа хэмжээгээр л ерөөл хүртэнэ. Жирийн ус хөнгөн биш. Хэрэв хүн өдөрт уух ёстой 1,8 литр усаа ууна гэж үзбэл, гэрийнхээ гишүүн бүрийн тоогоор 1,8 литр ус тээвэрлэх нь байна. Хэрэв хоол хийх, цэвэрлэх, усанд орох зэрэг дөрвөн хүний хэрэглээний усыг нэгтгэбэл, даруй ес орчим литр болно. Савны чинь жин, туулах замыг чинь тооцолгүй, зөвхөн усаа хэмжихэд л ийм тоо гарч байна.

Тэгээд чи энэ замаар ахин дахин, ахин дахин явна. Есүс ханашгүй, мөнхийн цангааны тухай ярьжээ. Ойрх Дорнын хуурай, ангамал талд төрж өссөн тэр эмэгтэй цангаа гэж юу байдгийг сайн мэднэ. Түүний хайр, баталгаа, нөхөрлөлөөр ангах цөхөрсөн хэрэгцээг нь хангах хангалттай гүн худаг юмуу хүйтэн ус байхгүй. Түүний сэтгэл нь цөхөртлөө хатжээ. Тэрбээр энэ л зүйл намайг хангах байх гээд ахин дахин мэхлэгджээ. Түүний цангаа нь бодитой бөгөөд тэрбээр яг л бидэн шиг зөв зүйлээ буруу газраас хайсаар байв.

Хайрлагдахыг хүсэх нь буруу биш.

Хүнтэй дотно амьдрал байгуулахыг хүсэх нь буруу биш.

Нэр төртэй амьдрал байгуулахыг хүсэх нь буруу биш.

Зорилготой амьдрал байгуулах нь буруу биш.

Найз нөхдийг хүсэх нь буруу биш.

Хүндэтгэлтэй амьдрал хүсэх нь буруу биш.

Есүс эмэгтэйн санаашралыг хязгаарлахыг хүсээгүй шигээ чинийхийг ч дорд үзэхгүй. Тэрбээр эмэгтэйн цангааг чухалчилсан учраас л тайлна

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

хэмээн амлажээ. Тэр түүнд хана мөргөдөг амьдрал биш, төгсгөлгүй амьдралыг санал болгосон. Тэгмэгц эмэгтэй сэтгэлийнхээ угаас гуйжээ:

“Эзэн, тэр усаа надад өгөөч. Тэгвэл би цангахгүй. Ус утгахаар энд ирэхгүй болно.” (Иохан 4:15)

Эмэгтэйн цөхөрсөн гуйлтаас надад түүний найдвар сонсогддог. Надад ч бас яг тийм санаашрал байсан. Есүс ээ, миний бүтэлгүйтлийг байнга сануулдаг энэ газарт би дахиж ирмээргүй байна. Тэр эмэгтэй шиг би ч бас залуу насныхаа хуулийг сахиж чадаагүй. Тэр эмэгтэй олж авч чадахгүй бас хүлээж авах зохисгүй гэдгээ мэдэж байсан бөгөөд гагцхүү хэн нэг нь түүнд бэлэглэсэн тохиолдолд л тэрбээр хүлээж авч чадах байв. Яг л донтой хүн шиг зарцуулах юм түүнд нэг ч үлдсэнгүй. Цангаа түүнийг боолчилжээ.

Есүс түүнд амийн усаа өгөхөөсөө өмнө тэрбээр үнэхээр өөрийгөө хоосолсон эсэхийг нь баттай болгохыг хүсчээ. “Тэр хуучнаа ардаа орхиход үнэхээр бэлэн үү?” Тэгээд Есүс эмэгтэйн өнөөдрийг хүртэл ундаалж байсан, ямар ч нэмэргүй, ангархай худаг болох “эрчүүдийнх” нь асуудлыг хөндсөн.

Есүс —Явж, нөхрөө дуудаад энд ир гэж айлдав. (и16)

Есүс энэ үгээрээ эмэгтэйн нөхрийнх нь зөвшөөрлийг авахыг хүссэн юмуу нүглийг нь чичилсэн юм биш. Есүс эмэгтэйн шархыг нь олж тогтоохын тулд нөхрийнх нь асуудлыг хөнджээ. Манай зоригт эгч үнэнээ хэлснээрээ раббигийн амийн уснаас уух эрхээ хасуулж магадгүй гэдгээ мэдэж байсан ч, үнэнээ хэлжээ.

“Би нөхөргүй.” (и17)

Үүнийгээ хэлэхэд мэдээж тэр эмэгтэйд амаргүй байсан. Тавын таван бүтэлгүй гэрлэлт. Тэр өөрийгөө буруутгах юмуу зөвтгөөгүй. Хэдий муухай ч, байгаа үнэн нь л тэр. Надад нөхөр байхгүй.

Эмэгтэй —Би нөхөргүй гэсэнд Есүс —“Би нөхөргүй” гэж чи зөв хэлэв. Чи таван нөхөртэй байсан бөгөөд одоо чамтай байгаа хүн ч нөхөр чинь биш тул чи үнэнээр хэлэв гэв. (и17-18)

Есүс үнэнээ зоригтой хүлээж байгаа хүмүүстэй ажиллаж чадна. Есүс эмэгтэйн өнөөгийн бодит байдлыг хөндөхдөө, өнгөрсөн амьдралынх нь ан цавыг бөглөжээ. Таван эр түүнийг эхнэрээ болгох гэж аваад, хаясан. Заримдаа би яагаад хүмүүс тэр эмэгтэйг л нүгэлтэн болгоод байдгийг гайхдаг. Би өөрөө гурван нөхөртэй дөрвөн удаа гэрлэж явсан хүний ач охин. Эмээ маань золиос байгаагүй. Тэр зүгээр л тэгж амьдрахыг сонгосон. Тэгвэл тэр Самари эмэгтэйн хувьд өөр байсан байж болно. Энэ бүхэн түүний буруу байсан эсэхийг бид мэдэхгүй. Ямар ч байсан тэр үед эрэгтэй хүн л салах эсэхээ шийдэж, эхнэрээ салсан гэрчилгээтэй нь хамт төрхөмд нь буцаадаг хууль үйлчилдэг байв. Эмэгтэй хүн дураараа нөхрөө солих эрхгүй байсан. Тэгээд дахин гэрлэх тоолонд өмнөх гэрлэлтээ цуцлуулсан гэрчилгээ нэхэгдэнэ. Таван удаа бүтэлгүйтсэн гэхээр төсөөлж байна уу? Тэгээд одоо тэрбээр нэрээ хуваалцдаггүй нэг эртэй ороо хуваалцаж байгаа аж. Гэсэн ч мөнөөх цангаа нь тайлагдаагүй хэвээрээ л. Тэрбээр эмтэрсэн сүнстэйгээ арга тасрахгүй найдсаар л. Иохан 4:19 дээр:

“Эмэгтэй —Эзэн, би Таныг эш үзүүлэгч болохыг харлаа” гэжээ.

Би саяхныг хүртэл энэ үгийн жинг ойлгодоггүй байлаа. Эмэгтэй мэддэг бүхнээсээ давж гарчээ. Учир нь Самаричууд Мосег л эш үзүүлэгч гэж итгэдэг байв. Матай 10:41-ээс үзбэл, энэ хүлээн зөвшөөрөл нь Самари эмэгтэйг эш үзүүлэгчийн шагналд хүргэжээ: “Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна.”

Энэ эш үзүүлэгчийн шагнал нь юу вэ? Энэ бэлгийг олон талаар илэрхийлж болох ч, амьд үнэний илчлэл хийгээд ухаарлаас илүү үнэт зүйл үгүй. Эш үзүүлэгч нарыг мөн хардаг, үздэг хүмүүс гэдэг. Есүс явсан газар бүрийдээ ойлголтын нүдийг нээдэг байсан. Эмэгтэй Есүсийг эш үзүүлэгчээрээ хүлээн авахдаа, ирээдүйгээ харж, ирээдүйд Бурханыг хаана хүндэтгэхээ Есүсээс лавлажээ. Эмэгтэй үнэхээр хуучин арга замтай хуучин амьдралаасаа залхсан байх. Мэдээж тэрбээр Бурханыг аль нэг газар хүндэтгэдэг биш, харин хүмүүс өөрсдөө Бурханыг хүндэтгэдэг газар болох цаг ирчихснийг мэдээгүй.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Эмэгтэй, Надад итгэ. Та нар энэ уулан дээр ч биш,
Иерусалимд ч биш, Эцэгт л мөргөх цаг ирж байна. (и21)

Арамей хэлээс хөрвүүлсэн Пэйшн орчуулга бидэнд арай гүн ойлголт өгдөг:

“Хүндэт эмэгтэй минь, чи Аавыг уулан дээр ч биш, Иерусалимд ч биш, харин зүрхэндээ хүндэтгэх цаг ирчихээд байна.”

Эмэгтэй Есүсийг жинхэнэ эш үзүүлэгч хэмээн хүндэтгэж, хариуд нь Есүс ч түүнийг жинхэнээсээ хүндэтгэжээ. Энэ нэр томъёо нь “хайрлагдсан, нандигнагдсан, шагнагдсан, үнэт, үнэлэшгүй, үнэлэгдсэн, хадгалагдсан” гэсэн утгатай. Тэр эмэгтэйг хэзээ хамгийн сүүлд хэн нэг нь ингэж дуудсан бол гэж би гайхдаг юм. Есүс түүний эмтэрсэн зүрх, шархалсан сүнснийг хувь тавилангийн үгээр дахин байгуулсан.

Өнөөдөр ч Есүс охин болгоноо “Миний үнэ цэнэтэй, хадгалагдсан, хайрлагдсан охин минь, чиний цаг ирчихээд байна” гэдэг. Энэ бол чиний итгэх ёстой цаг. Есүс чиний сэтгэлд юу шивнэсэн бэ?

Бурхан ууланд, хотод эсвэл чуулганд чамтай ойрхон байдаг юм биш. Түүний оршихуйгаас чамайг хэн ч салгаж чадахгүй. Үүгээр барахгүй чиний ямар ч алдаа чамайг Түүнээс салгаж чадахгүй нь бүр баярламаар. Есүс чиний зүрхний худгийн дэргэд суугаад, чиний хүндэтгэлийг хүлээж байна. Бурхан бидэнд шивнээ шиг ойрхон байдгийг Бичээс хэлдэг:

Харин энэ нь юу хэлдэг вэ? «Үг нь чамд тун ойрхон, аманд чинь, зүрхэнд чинь бий» гэдэг. Энэ нь бидний тунхаглаж буй итгэлийн үг юм. (Ром 10:8)

Есүс энэ хувьсгалч ойлголтыг хүний нийгмийн бараг л хог шаар болсон эмэгтэйтэй хуваалцжээ. Ямар ч байршилд баригддаггүй, хаа ч хамаагүй хүндэтгэх боломжтой Бурханы талаар тэр хэзээ ч сонсоогүй. Энэ түүнд ямар гайхамшигтай мэдээ болсныг төсөөлж байна уу? Тэр эмэгтэй чинь Иүдейчүүдэд байтугай, өөрийнхөндөө ч адлуулсан хүн атал Бурхан түүний зүрхэнд нутаглахыг хүсчээ. Бурханы Хүү түүнд өөрийг нь илчлээд зогсохгүй, Өөрийгөө илчилж өгчээ. Тэрбээр сонголтоороо гадуурхагдсан бол, Есүс түүнийг дотогш урьжээ. Есүс цааш нь:

“Та нар мэдэхгүй юманд мөргөдөг бол бид мэддэг юмандаа мөргөдөг. Тиймээс ч аврал иудейчүүдээс гарна. Харин үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг эрж байна. Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой” гэж айлджээ. (Иохан 4:22-24)

Есүс түүний уламжлалыг үнэнээр эвджээ. Энэ раббигийн хэлж байгаа үнэн бол, тэр эмэгтэй Аавын эрэн хайж байгаа сүнс ба үнэнээр хүндэтгэгч нарын нэг ажээ.

Бид үүний наадгайг хардаггүй. Учир нь бид Есүсийн тайлж байгаа бүхнийг ойлгогдсон үнэн хэмээн мэдэж, хүлээж авдаг бол, заримдаа эдгээр ойлголт нь үнэхээр эрс тэс байв. Тэр эмэгтэй Бурхан Аавын талаар сонсоогүй нь бараг баталгаатай байв. Иохан 4:22-23-ыг Пэйшн Библи:

“Өдгөөгөөс Аавыг хүндэтгэх нь зөв байршлын асуудал бус, харин зөв зүрхний асуудал болсон. Учир нь Бурхан бол Сүнс бөгөөд Тэрбээр Өөрийг нь Сүнсний талбарт болоод үнэнээр хүндэтгэж, биширдэг чин үнэнч хүндэтгэгч нарын хүслэн болдог юм” гэдэг.

Эмэгтэй эрэн хайж байсан Бурхантайгаа холбогдож чадна гэнэ. Яг энэ үед түүний царай найдвараар гийсэн байх. Тэрбээр итгэх үгүйгээ мэдэхгүй байсан ч, зүрх нь найдвар, эргэлзээ, гайхширлаар чичирсэн байх. Тэгээд мэддэг байсан ганц зүйлээ хэлсэн.

Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ. Тэр ирэхдээ бүх зүйлийг бидэнд мэдүүлнэ. (и25)

Есүс тэр эмэгтэйн хүүхдийнх шиг итгэлийг эсэргүүцэхийн аргагүй гэж үзсэн болов уу? Есүс тэр эмэгтэйгээс үнэнийг нуух аргагүй байв. Тэгээд Өөрийг нь ширтэх эмэгтэйд:

“Тэр чинь чамтай ярьж буй Би байгаа юм” (и26) гэж шивнэсэн байх.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Есүс Мессаиагийн хийх ёстой байсан бүх зүйлийг хийсэн. Есүс түүнд бүгдийг хэлсэн. Заримдаа бидний Бурхан юу ч хэлэлгүйгээр бүгдийг хэлдэг. Зүрх минь тайвшир. Бидний тослогдсон нэгэн болох Христ маань бидний Бурханыг хүндэтгэх талаар асуусан асуултыг бидний өөрийн талаарх үнэнээр хариулдаг. Тэрбээр үнэний илдээрээ ганц далайгаад л мунхаг заншлыг илчилж, хүний шалтгааныг тасар татдаг. Ийм юм сонссон хүн усныхаа савыг хаячихаад, гүйж одох нь аргагүй юм. Тэр чинь бидний Есүс шүү дээ. Есүс ичгүүртэйг ичээдэггүй. Есүс тэднийг Өөрийнхөө итгэлд урьж, Фарисайчуудын (тэр бүү хэл дагалдагч нарын) сонсохоос татгалзсан сурвалжит зүйлсийг тэдэнтэй хуваалцдаг.

Энэ явдал өндөрлөв. Дагалдагч нар буцаж ирээд, Эзэн нь “зохисгүй” эмэгтэйтэй ярьсныг нь олж мэддэг. Гэхдээ тэр эмэгтэй одоо тэдний дургүйцлээс айхгүй. Бурханыг хүлээн авсан хүнд хүний эсэргүүцэл юу вэ? Есүс Самаричуудаас дагуулаад ир гэж аль нэг дагалдагчаа илгээгээгүй нь сонирхолтой. Яагаад гэвэл Есүс тэр нутгийнхан руу хэдийнээ Өөрийнхөө элчийг илгээсэн байжээ.

Тэгтэл эмэгтэй усны саваа орхин хот уруу эргэн явж, хүмүүст — Үйлдсэн бүхнийг минь надад хэлсэн хүнийг ирж үзэгтүн. Тэр Христ биш үү? гэсэнд тэд хотоос гарч, Есүс уруу явжээ. (и28-30)

Сайтар харбал, эмэгтэй үгээ бодлоготой хэлснийг харж болно. Эмэгтэй Түүнийг эш үзүүлэгч юмуу Иүдей гэж хэлээгүй. Яагаад гэвэл энэ нь хүмүүсийн дургүйг хүргэж мэдэх байв. Харин эмэгтэй нутгийнхандаа замчлахын тулд эхлээд өөрийнхөө гэрчлэлийг хэлжээ. Найз маань ирээд сонс гэхийн оронд ирээд хар гэж хэлсэн нь бас л гайхмаар. Харах нь итгэх гэсэн утгатай. Нүд нь нээгдсэн хүн бусдыгаа бас хараасай гэж хүсдэг.

Бусдын эвдэрсэн, байдаг л, бохир гэж үзсэн эмэгтэйд Есүс Өөрийнхөө эрх бүхий, ариун нандин зүйлийг гаргаж хуваалцсанд нь би хайртай байдаг. Есүс Бурханы нууцыг “хүний ад” болсон хүнтэй хуваалцсанаараа, бид бүгдэд хаалга нээж өгсөн юм. Иймээс л би энэ эмэгтэйн талаар бараг ном болгондоо өөр өөр өнцгөөс ярьдаг. Би энэ түүхийг тоохгүй өнгөрч үнэхээр чадахгүй.

Энэ ичгүүртэй, шоовдор эмэгтэй олон талаараа намайг

санагдуулдаг учраас, би түүнд хайртай байдаг. Тэр бүү хэл тэр эмэгтэйд нэр ч байхгүй. Тиймээс түүний оронд би өөрийнхөө нэрийг орлуулж чадна. Би түүнийг гэгээрсэн Фотина гэдгээр нь таних хүртлээ ингэж л боддог байв. Энэ явдлын дараагаас тэрбээр Самари даяар Сайн мэдээ дэлгэрүүлсээр, сүүлдээ дэлхий даяар явсныг нь одоо ч мэддэг боллоо.

Түүний түүх нь гүехэн амьдралтай гүн худаг болох биднийг урамшуулж байна. “Журамгүй” эмэгтэйн Бурханы эш үзүүлэгчтэй Бурханыг хүндэтгэх талаар дэлгэсэн энэ яриаг өөр яаж тайлбарлах вэ? Эмэгтэйн худаг гүнээс гадна хатчихсан байсан. Тэрбээр таван нөхөртэй хоёр хүүтэй байсан ч, сэтгэл нь хоосон хэвээрээ байсан. Туйлын хүчин чадалтай тэр эмэгтэй амьдралынхаа төлөө өөрийгөө хайр гамгүй зориулсан байв.

Тэгтэл Есүстэй уулзсаны дараа бүх юм өөрчлөгдсөн. Тэрбээр өөрийгөө ямар бэлэгтэй болохоо мэдсэн. Есүс түүнийг урьсан бөгөөд тэр ч амийн усыг зоригтой гуйжээ. Тэр гайхамшигт Мессаиа түүнийг бүрэн мэдэж, ямар ч татлаагүй хайрласан. Тиймээс тэр өрсөлдөгчгүй охин Есүсийн амийн уснаас том том балгалж, ямар ч аюулд аймшиггүй нэвтэрсэн Сайн мэдээ дэлгэрүүлэгч, элч Фотина болжээ.

Хэлэлцэх асуулт

1. Чи амьдралдаа Бурханы хүчийг илүү их хүсч байна уу?
2. Фотинагийн амьдрал чамд яаж нөлөөлөв?
3. Фотина бол худгийн дэргэд Есүстэй уулзсан тэр эмэгтэй гэдэгт чи дурлахгүй байна уу? Энэ нь бидэнд ямар амлалт илэрхийлж байна?
4. Чамд гүехэн амьдралтай гүн худаг шиг амьдарч байгаа тал байна уу?

Өрсөлдөгчгүй амьдрал

Шинэ зорилго тавьж, шинээр мөрөөдөхөд чи хэзээ ч хөгшдөхгүй.

Си. Эс. Люис

Би чамд урам хайрлах үүднээс бас нэгэн эртний түүхийг хуваалцмаар байна. Эрт дээр үед Текла гэдэг маш үзэсгэлэнтэй онгон охин байжээ.¹ Тэрбээр Паулыг залуу эрчүүд, эмэгтэйчүүдийг Христийг ухаан ба үйлсээр хүндэтгэ хэмээн урамшуулан ятгаж байхыг нь сонсчээ. Паулын энэ үгийн дараа Текла зуучлуулсан гэрлэлтээсээ татгалзахаар шийдэн, тавьсан сүйгээ цуцлаад, насан турш Бурханыг алдаршуулах амьдралаар амьдрахыг хүсчээ. Паул Теклад тэгж нөлөөлснөө мэдээгүй ч, харин Теклагийн ээж, сүйт хархүү хоёр нь нэр нөлөөгөө ашиглан, Паулын эсрэг бослого эсэргүүцэл дэгдээжээ. Иргэний үймээн самуун нь Паулыг Икониумын захирагч нарын өмнө аваачиж, тэр даруй шоронд хориулав.

Гашуудсан Текла Паултай шоронд уулзаж, түүнээс Есүсийн талаар сонсохоор үнэт эдлэлээрээ хахуульданд оржээ. Гэр бүл нь алга болсон охиноо Паулын шоронгийн торонд байгааг мэдээд, хоёуланг нь захирагчийн өмнө авчруулав. Паулыг зодож, хотын гадна гаргаж хаясан бол, Теклагийн ээж нь охиноосоо татгалзаж, охинд цаазын ял тулгав. Тэгээд ийм маягаар тэрсэлсэн залуу охидод сургамж болгон түүдэг дээр шатааж алахаар болжээ.

Теклаг цааз руу явж байхад, Паул бусад итгэгчдийн хамт хотын гадна газар дорх байгууламжид цуглаад, чин сэтгэлээсээ залбирчээ. Теклаг түүдэг дээр хүлж, галдсан боловч, дөл нь түүнд хүрсэнгүй. Тэгтэл маш хүчтэй шуурга дэгдэж, галыг нь Теклагийн хөлд унагаж, Текла чөлөөлөгджээ. Энэ нь Грек бурхдын тэмдэг байж магадгүй хэмээн айсан эрх мэдэлтнүүд Теклаг суллаад, хотоос хөөжээ. Текла болон хөөгдсөн бусад итгэгч нар Паулыг даган Антиох руу аялахаар явав.

Тэднийг хотод ормогц Александр нэртэй маш нэр нөлөө бүхий хүн Теклагийн гоо үзэсгэлэнд татагдан, түүнийг Паулаас авахыг хүсчээ. Гэтэл Паул татгалзсан учраас, Александр Теклаг хүчээр авахыг хүсэв. Текла Александртай байдаг хүчээрээ тэмцэлдэхдээ, лаврын навчин титмийг нь унагаж хаяад, Бурханы зарцад бүү хүр хэмээн тушаажээ.

Хилэгнэсэн Александр Теклаг Антиохын захирагч дээр чирч гулдчин авчрав. Текла зугтахаар тэмцэлдэж байхдаа, Александрын хувцсыг урснаа хүлээн зөвшөөрчээ. Теклад дахиад л цаазаар авах ял оноов. Маргааш нь түүнийг арсланд амьдаар нь идүүлэх ял тулгажээ. Антиохын эмэгтэйчүүд Теклад шударга бус шийтгэл оноолоо хэмээн хилэгнэв. Тэгтэл Ромын нэгэн сурвалжит хатагтай Теклаг шоронд байлгахын оронд онгон байдлыг нь хамгаалахын тулд гэртээ байлгахыг санал болгов. Тэгээд тэр оройдоо настай эмэгтэй, залуу эмэгтэй хоёр найзууд болжээ.

Маргааш нь Теклаг гинжлээд, араатанд идүүлэхээр авч явахад нь настай эмэгтэй гашуудан уйлав. Теклаг нүцгэлэн, арслан баавгайгаар дүүрэн цэнгэлдэх хүрээлэн рүү түлхэхэд, үзэгчид бархиралдаж байлаа. Хамгийн түрүүнд Теклад эрслэн хүрчээ. Эрслэн Текла руу давхиж ирснээ, дайрахын оронд яг л хамгаалж байгаа юм шиг хөлд нь хэвтжээ.

Баавгай дайрсан ч, эрслэн баавгайг алчихав. Дараа нь арслан дайрсан ч, эрслэн бас л Теклаг хамгаалан тулалдаж, эцэстээ хоёул Теклагийн хөлд зууралдсан хэвээрээ үхэдхийн унажээ. Тоглоомын эзэд Текла руу бусад араатнуудыг дайруулахаар баруун зүүнгүй ташуурдсан ч, араатнууд бүгдээрээ дайрахаас татгалзан, биеэ хураацгаав. Хүмүүс нам гүн болж, цэнгэлдэх хүрээлэнг Эзэнээс эмээхүй нөмрөв. Тэр үед Текла чангаар маш зоригтой залбирчээ.

Захирагч босоод, тоглоомыг зогсоов. Тэрбээр тэр эмэгтэй хэн болохыг бас түүний тэр их хүч хаанаас гарч байгааг мэдэхийг

шаарджээ. Тэгтэл Текла захирагчид: “Би бол амьд Бурханы зарц бүсгүй. Би Бурханы хайртай Хүүд итгэдэг. Тэр бол авралд хүргэх цорын ганц зам, мөнхийн амь... Түүнд итгэгч нь үхэхгүй, амьдарна” гэж хэлжээ.

Захирагч түүнд хувцас өгөөд, суллахыг тушаав. Тэр өдөр мянга мянган хүн биш юмаа гэхэд хэдэн зуун хүн Христэд итгэж, Антиохын эмэгтэйчүүд Бурханыг нэгэн дуугаар хотыг доргитол магтаж байсан талаар түүхэн бичээс байдаг.

Текла ерэн насандаа өөд болох хүртлээ урт удаан, бүрэн бүтэн амьдрал туулж, Сайн мэдээг номложээ.

Аймшиггүй зоригтой амьдрах

Теклаг юу тийм зоригтой болгов? Тэр нүцгэн байсан ч, Есүстэй уулзахдаа өөрийгөө хэн болохыг мэдсэн учраас, ичээгүй. Хэдийгээр Текла шинэхэн итгэгч байсан ч, Христийн маш мундаг элчин сайд болжээ. Тэрбээр үхлийн улаан нүүрэн дээр эр зоригоо харуулан залбирсан. Олон индэр дээр бүрэн хувцастайгаа номлохыг хориглуулсан зоригт охин аймшигт араатнуудаар хүрээлүүлсэн хүрээлэн дотор нүв нүцгэн залбирахдаа, үй олон хүнийг авралд хүргэжээ. Би ийм түүх уншихдаа, Еваг инээмсэглэж байгаагаар төсөөлдөг. (Сарах ч инээмсэглэж байгаа нь тодорхой!) Учир нь Ева ямар ч аюулгүй, багалгаатай нөхцөлд ялагдсан бол, дахин төрсөн охид нь амь өрсөн дайны талбар дээр ахин дахин ялалт байгуулж байна.

Тэр хүмүүс цаазыг гэрчлэхээр ирсэн боловч, ялагдал хэрхэн ялагдахыг л гэрчлэн харжээ. Бидний амьдрал энэ өвийг үргэлжлүүлэх болтугай. Бид аврал ба суурь нь гагцхүү Христ дотор байдгийг өдөр бүр тунхаглахдаа, Христээр дүүрч, Христийн хоёр дахь айлчлалыг улам түргэсгэнэ.

Өнөөдөр бид Библийг хамгийн их мэддэг үеийнхэн. Гэхдээ энэ мэдлэг маань биднийг юунд хүргэв? Өнөөдөр бид мэдээллийн илүүдэлтэй, өөрчлөлтийн хомсдолтой болсон. Олон тал дээр Библийн Үг, Ариун Сүнсний удирдамжийг оюуны мэдлэг, авьяас чадвараар орлуулдаг болсон.

Харин би үүнээс том зүйл хүсч байна. Миний сүнс өрсөлдөгчгүй бялхал, ургацыг хүсч байна.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Энэ завхарсан дэлхий Бурханы хүчийг харах хэрэгтэй. Магадгүй бид анхны чуулганы залбирлыг давтаж залбирах шаардлагатай болсон байх.

Одоо Эзэн, тэдний заналхийллийг хараач. Таны үгийг ярих зоригийг боолууддаа соёрхооч. Таны ариун зарц Есүсийн нэрээр эдгээх гайхамшиг ба тэмдгүүдийг үйлдүүлэхийн тулд Та мутраа сунгаач. (Үйлс 4:29-30)

Тэгээд энэ залбирал нь хэрхэн ажилласан гээч?

Ийнхүү залбирч байтал тэдний цугларан байсан газар нь доргив. Тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгийг зоригтойгоор ярьцгаав. (Үйлс 4:31)

Одоо Бурханы Үгийг ямар ч саадгүй аймшиггүй зоригтойгоор ярих цаг нь болсон. Теклад ирсэн бэрхшээл нь олон талаараа биднийхээс нэг их ялгаагүй. Тэрбээр санаанд оромгүй замаар явж, өргөгдсөн амьдралаар амьдрахаар шийдэхдээ, асар том эсэргүүцэлтэй тулсан. Гэрийнхэн нь түүнийг хорьж, захирагч түүний итгэлийг хуульчилж, эрчүүд түүнийг хүчээр авахыг хүсэхдээ эсэргүүцлийг нь тэрслэл гэж үзсэн. Гэхдээ Текла шиг эрх чөлөөтэй хүн байгаагүй юм. Тэрбээр хүмүүст танигдахгүйгээр үхсэн ч, Хамгийн дээд Бурханы зарц мөн болохоо мэдэж байсан.

Өрсөлдөгчгүй амьдрал

Бид эргэн тойрны бүх юмс биднийг өдөөн хатгасан эрин үед аж төрж байна. Чи өөрийгөө хэний хэн болохоо мэддэг бол, эсэргүүцэн зогсож чадна. Бид гагцхүү Ариун Сүнсний барьж босгож чадах өрсөлдөгчгүй амьдралыг сонгосон.

Хэрэв бид Сүнсэнд амьд байгаа юм бол мөн Сүнс дотор явцгаая. Бид нэг нэгнээ өдөөн сөрж, өөр зуураа атаархан, сайрхахгүй байцгаая. (Галат 5:25-26)

Тэгэхээр, бид эхэлсэн газраа өндөрлөж байна.

Чи бол дагтагдашгүй, цорын ганц эх хувилбар гэдэг онцгой илэрхийлэл нь чамайг Ариун Сүнстэй хөл нийлүүлэн алхах амьдрал руу хөтөлнө. Чи харьцуулагдахаар бүтээгдээгүй... чи Бурханы Хүүгийн төлөө бүтээгдсэн. Тэнгэрийн Аав чинь чамайг анхны амьсгалаа авахаас ч өмнө амьдралын чинь хэсэг бүрийг ширхэгчлэн ном болгон бичсэн байсан юм. Амьд үсгээр бичсэн. Чиний амьдралаар өөр хэн ч амьдарч чадахгүй. Бусдын төлөө бичигдсэн амьд түүхийн мөртүүд нь хараахан биелээгүй байгаа Ариун Сүнсний зүйлсийг орхидог. Чи өрсөлдөөнгүй амьдралаар амьдрах гэж байгаа бол, Ариун Сүнсний чиглүүлэг маш чухал шүү. Сүнсээр удирдуулсан амьдрал нь зүгээр нэг ойлголт юмуу романтик найдвар биш, сүнсний сахилга бат, хувийн хүндэтгэл мөргөлийн илэрхийлэл юм. Энэ бол самуурлын биш, зориулалтын амьдрал. Бурхан чиний дуулгавартай үйлдэл бүрээр дамжуулан чиний хувийн бөгөөд хувьсгалын амьдралд хандсан зорилгоо нэг бүрчлэн гүйцэтгэж, чамд хандсан Түүний дуу хоолой ч бүр тодорхой болно.

Чиний амьдрал бүхий л хүчин чадлаараа Бурханаас өгөгдсөн итгэмжлэл болно. Чи өөрт байгаа эрдэнэсээ өрөөлийн санал бодол, хүсэн хүлээлт дор булж байвал, үнэхээр ичгүүртэй. Чи энэ дэлхий дээр үзэгч шиг ирээгүй. Чиний амьдралд хийх илүү чухал, сонирхолтой юм байна. Үүнийг мэдэх цаг чинь болсон.

Чиний ирээдүй ирчихээд байна.

Чиний цаг ирчихээд байна. Маргааш юу болохыг бид мэдэхгүй ч, одоо цаг бол чинийх. Тэгээд чи сонголтоороо өөрийнхөө эгшин бүрийг авран сэргээх хүчтэй.

Чамд амлалтын гайхамшигтай түүхийн үр таригдсан. Амьдралын чинь ном хаалттай чигээрээ үлдэж болно эсвэл чи хуудсаа эргүүлсээр байж болно. Галатад хэлсэн Паулын үгийг унш:



Чи

**харьцуулагдахаар
бүтээгдээгүй...
чи Бурханы
Хүүгийн төлөө
бүтээгдсэн.**

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Харин хүн бүр үйл хэргээ шалга. Тэгвэл уг хүн өөрийгөө бусадтай харьцуулалгүй, өөрийнхөөрөө сайрхах болно. Учир нь хүн бүр ачаагаа үүрнэ. (Галат 6:4-5)

Өөрийгөө хэн ч биш хэмээн бусдыг ширтгээд байвал, өөрийгөө хэн болохыг жинхэнээсээ харж чадахгүй. Чи амьдрал нэртэй энэ аялалд өөрийгөө хэн болохыг мэдэх ёстой бөгөөд ухаан алдаж унах биш, урагш явах ёстой юм.

Тиймээс та нар мэргэн бусчууд шиг биш, мэргэн хүмүүсийн ёсоор, хэрхэн алхаж буйгаа хянаж бай. Өдөр хоног цөвүүн тул цагийг үнэл. (Ефес 5:15-16)

Хэрэв чи зориуд цаг гаргахгүй бол, өдөр хоногууд чинь янз бүрийн шаардлага, шахалтаар чамаас сарниж алга болно. Чи энэ номоо дуусгаад, үзэг цаас аваад цагаа аль талаараа ухаалаг бөгөөд ухаалаг бус ашиглаж байгаагаа ангилаарай.

Зорилго, мөрөөдлөө нягт холбо. Өрсөлдөгчгүй охин минь, чи юу мөрөөдөж байна? Амьдрал чинь нэгэн хэвийн уйтгартай санагдаж болно. Гэхдээ би чамаас статус мэдээ шаардаагүй. Харин сэтгэлийн хүслэн чинь юу вэ гэж асууж байна? Хэрэв чи алдчихсан бол, Бурханы оршихуйд дахин очоод, хүсэл мөрөөдлөө дахин олж ав. Тархиа ч, зүрхээ ч тунгалагжуул. Алх, магтаалын дуу сонс, сэтгэлийнхээ худагтай дахин холбогд.

Зорилго тавьж, шинээр мөрөөдөхөд чи хэзээ ч хэт хөгшдөхгүй, ядуудахгүй, баядахгүй, хэт боловсролтой юмуу боловсролгүй болохгүй. Бас хэзээ ч хэт залуудахгүй.

Заримдаа би өнөөгийн итгэгч эмэгтэйчүүдийн цэцэрлэгжилтийг хараад, он цагаа олж амьдралд хэмнэлээ олон бүжиж чадаж байгаа, үйлчилж чадаж байгаа хүмүүсийг хараад мэл гайхдаг. Маш үзэсгэлэнтэй, эрэлхэг, бурханлаг залуу эмэгтэйчүүд яг одоо галын шугаман дээр дайтаж байгааг хараад зүрх минь найдвараар бадардаг. Тэгээд өөрийгөө арай аажуухан авирч, арай ахиухан гулгаж эхэлдэг юм билүү гэсэн санаа төрнө. Саяхан ингэж бодож байтал Ариун Сүнс намайг: “Тэд гарч ирж байгаа нь чамайг ухар гэсэн үг биш. Чи урагшаа явдгаараа яв. Би чамайг хажуу руу түлхээгүй байна. Тэд чамайг дээш нь түлхэг” хэмээн зассан юм.

Миний “дээшлэх” зам нь өмнөхөөсөө арай өөр харагдаж байж болох ч, Бурхан намайг хэзээ ч доошоо хар юмуу толгой гудай гэж хэлээгүй. Бурхан хэзээд өөдөө, дээшээ гэдэг. Охид нь нэгдэж байхад, Бурханы алдар гийдэг.

Тиймээс, хонгор минь би чамтай чин хүслээ хуваалцъя. Чиний дотор Тослогдсон Нэгэн болох Христ бүрэлдтэл чамайг хичээнгүй хөдөлмөрлөхийн төлөө би залбирна. Чи анхнаасаа чамд итгэмжлэгдсэн зүйлдээ хүрэхийн төлөө Христийн дотор боловсорч, байр сууриа олохыг чинь би хармаар байна. Би чиний Христийг таньж мэдэх хамгийн эрхэм хайгуулд чинь тусалмаар байна. Би энэ номыг бичиж байхдаа, дэндүү том сэдэв барьж авснаа ойлгосон юм. Яагаад гэвэл өнөөдрийн нийгэм, амьдрал өрсөлдөөнөөр буцалж байна. Паул өөрөө асуудалгүй байсан ч, түүний хайртай чуулганд яг ийм асуудал тулгарсан байдаг:

Бурханы хардалтаар би та нарыг хардаж байна. Учир нь би та нарыг Христийн өмнө ариун онгон охин мэт аваачих гэж ганц нөхөртэй сүй тавиулсан. Могой, залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ дор [цэвэр] эгэл байдлаас чинь та нарын санаа бодлыг төөрүүлчих вий гэхээс би харин айж байна. Учир нь хэрэв хэн нэг нь очоод, бидний тунхагласнаас өөр Есүсийг тунхаглахад эсвэл хүлээн авсан хэн нэгнээсээ та нар өөр сүнснийг хүлээн авахад эсвэл хүлээн авсан хэн нэгнийхээ өөр сайнмэдээг та нар хангалттай тэвчдэг. (2Коринт 11:2-4)

Тэгэхээр, намайг ээж хүний минь хувьд - үгүй ээ, эмээ хүний минь хувьд сонс - чи буулт хийхээр юмуу харьцуулагдахаар бүтээгдээгүй. Бүтээгч Өөрийнхөө эх чанарыг чиний ДНХ - д уусгасан. Гагцхүү чи л Түүнд хайр, алдрыг авчирч чадах бөгөөд үүнийхээ төлөө мөнхийн үр жимс ургуулж, мөнхийн шагнал хүлээн авна.

Мөнхийн титэм

Би номоо чи хэн болох, Бурханы хэн болох илчлэлээр эхлүүлсэн бол, бидэнд юу өгөгдсөн талаарх яриагаар өндөрлөмөөр байна. Биднийг Бурханы тэнгэрлэг мөн чанарыг хуваалцагч болгох хязгааргүй, эрхэм амлалтаас гадна бидэнд эрх мэдлийн гоёо өгөгджээ.

Би гоёл чимэглэлд дуртай. Гэхдээ зүгээр нэг биш, өөрийн гэсэн

түүхтэй гоёлд дуртай. Миний хуримын бөгж Жон, бид хоёрын гэрлэлтийн түүхийг төлөөлнө. Бас хөвгүүдийг маань төрөх бүрийд бэлэглэсэн бөгж бий. Надад сэлэмтэй хүзүүний зүүлт, суман бугуйвч бас хэрхэн эмэгтэй хүн шиг дайтахыг төлөөлсөн өөр нэг бугуйвч бий. Бас тэмдэглэлт үйл явдлаар минь найзуудын маань бэлэглэсэн гоёл чимэглэл ч бий. Тэр гоёл чимэглэлийн цаадаг цаг хугацаа юмуу утга учир нь тэр гоёл чимэглэлийг эрх мэдэл шиг хэрэглэж байна уу эсвэл гоёл шиг хэрэглэж байна уу гэдгийг шийддэг.

Би Ханна Хөрнардын бичсэн “Өндөр газар дээрх боолуудын хөл” гэдэг түүхэнд дуртай. Энэ түүхийг би анх хорин тавтай орчим байхдаа уншсан бөгөөд өдий хүртэл мартаагүй. Бас хөвгүүдээ бага байхад нь уншиж өгдөг байлаа. Бас өөрөө сэргэх хэрэгтэй үедээ уншдаг. Энэ нь айдсаар дүүрэн нэгэн залуу бүсгүй гэрээсээ гараад, төгс хайр айдсыг зайлуулдаг өндөрлөг газар руу аялдаг түүх юм. Замд нь бөөн бөөн эргүүлэг, эргэлт, сорилт тулгарна. Зохиолын маань гол дүр болох Аймхай очсон газар бүртээ тахилын ширээ босгож, өөртөө урам бас сануулга болгон тахилын ширээний чулуунаас нь нэгийг авч, халаасалдаг байв. Нэг удаа Аймхай маань асар их гутарсандаа, амлалтанд хэзээ ч хүрэхгүй хэмээн санаж, мөнөөх дурсамжийн чулуунуудаа бүтэлгүйтлийнхээ сануулга мэт үзэн, хэдэн зүг тарааж шиддэг. Тэгээд жаахан уужирсан хойноо чулуунуудаа цуглуулж авна. Энэ нь ч ухаалаг хэрэг байв. Яагаад гэвэл хожим чулуу бүр нь Аймхайгийн титэм дэхь эрдэнэсийн чулуу болж хувирдаг.

Бичээс таван титмийн талаар онцгойлон дурьдсан байдаг.² Зөвт байдлын титэм. Үүнийг бид нүгэл ичгүүрээ Христийн зөвтгөлөөр солихдоо хүлээж авдаг бөгөөд Тэр биднийг авралаараа титэмлэдэг юм. Бас баяр баяслын титэм гэж байна. Үүнийг нөхцөл байдлаасаа үл хамааран Бурханыг магтдаг хүмүүс хүлээж авна. Мөн Христийн сүр жавхланта ирэлтийг хүсэн хүлээж байгаа хүмүүс Алдрын титэм хүлээн авна. Харин үлдсэн хоёр титмийн талаар би арай дэлгэрэнгүй ярьмаар байна.

Үгүйршигүй титэм

Энэ талаар 1Коринт 9:24-27 дээр ярьдаг:

Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар ялахын тулд гүйцгээ. Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй, харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог.

Энэ титмийг уралдаж авдаг бөгөөд бэлтгэл маань бидний гүйлтэд нөлөөлдөг. Бэлтгэл хийх хөгжилтэй биш. Гэхдээ уралдаанаас хасагдах юмуу хожигдох бүр ч хөгжилтэй биш. Ариун Сүнс олон талаараа бидний дасгалжуулагч болдог.

Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан юм шүү. (Ефес 4:30)

Бүх зүйл зөвшөөрөгдсөн ч, бүгд бурханлаг байдал ба сайн гүйлтэд ашигтай биш. Үүнд юу хэрэгтэйг Бурхан мэднэ. Биднийг хэзээд нь хурдалж, хэзээд нь удаашрах ёстойг Бурхан мэднэ. Биднийг хэнтэй дасгалжих, хэнээс хол байхыг Бурхан мэднэ. Түүний зааврыг дагах нь бидэнд л хэрэгтэй юм. Бид үгүйрэх зүйлийн төлөө биш, мөнхийн зүйлийн төлөө уралдаж байна.

Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод, хулгайлдаг аж. Харин өөрсдөдөө эд баялгийг тэнгэрт хураа. Учир нь тэнд хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Эд баялаг чинь хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно. (Матай 6:19-21)

Зүрх чинь тэнгэрт байвал, чи тийшээ хүрэх замаа олно. Энэ эрдэнэс зүрхэнд чинь байгаа бөгөөд үүнийг хайр хамгаалдаг. Бид үг, санаа, ном, бодол, нийгмийн харилцаа, гоо үзэсгэлэн, бүтээлч байдал, цэц ухаанаар жирэмсэлсэн дэлхийд аж төрж байна. Ихэнх

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

нь сайн зүйлс. Гэхдээ чамайг гүйлгэхгүй гэж энэ дэлхий доош татаж чангаана. Тиймээс бидэнд ингэж сэрэмжлүүлжээ:

Хорвоо хийгээд хорвоогийн юмсад бүү дурла. Хэн нэг нь хорвоод дурладаг бол түүнд Эцэгийн хайр алга. Учир нь хорвоод байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ хорвоогоос юм. Хорвоо хийгээд түүний хүсэл тачаал өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлдэгч нь мөнхөд оршму. (1Иохан 2:15-17)

Биднийг газрын арга замтай хүлж уяж байдаг зүйлс байдаг. Дэлхийн хүсэл тачаалыг гурав ангилна:

1. Махан биеийн хүслэн буюу өөрийнхөөрөө хүсэх.
2. Нүдний хүслэн буюу харсан бүхнээ авахыг хүсэх.
3. Амьдралын бардамнал буюу чухал харагдахыг хүсэх.

Хүн болгон хэзээ нэгэнтээ эдгээрийн аль нэгтэй тэмцэлддэг. Эдгээр жолоогүй хүсэл нь хүний амьдралд бүх арга замаар тоглодог бөгөөд амьдралын улирал бүрт өөр өөр хэлбэрээр ирж болно. Би анх гэрлээд, хүүхэдтэй болоогүй байхдаа, маш амиа бодсон хүн байлаа. Би ихэнх юмыг өөрийнхөөрөө хүсч бас харсан бүхнээ авахыг хүсдэг байв. Гэхдээ миний муу зан авирыг хөхүүлэн дэмжих мөнгө байгаагүй нь сайн хэрэг юм. Гэвч тэглээ гээд би харсан бүхнээ авахыг хүсэхээ больсонгүй. Тэгтэл таван жилийн дотор гурван хүүхэдтэй болсныхоо дараа би жаахан унтаж амрахаас өөр ямар ч хүсэлгүй болсон юм. Харин чухал харагдахын тал дээр - нас ахих тусам надад гэр бүлдээ, найз нөхөддөө тэгээд дагалдагч охиддоо л чухал байхаас өөр хүсэл байхаа больсон.

Дэлхийтэй уялдаатай эдгээр жолоогүй хүсэл нь өнө мөнхлөлийн жин дор үйрэх тавилантай. Олон нийтийн сүлжээгээс авахуулаад, суртчилгаа, зугаа цэнгээ нь энэ хүслийг улам л угждаг. Одоогийнх шиг танихгүй хүмүүс хоорондоо ингэж харилцаж холбогдож явсан үе хүн төрөлхтний түүхэнд байхгүй. Гэхдээ таньдаг хүмүүстэйгээ (гэр бүл, найз нөхөдтэйгээ) харилцаж чаддаггүй хүмүүс чинь харагдахгүй Бурхантай холбогдох гэж зүдэрдэг нь аргагүй юм даа.

Хорвоо хийгээд түүний хүсэл тачаал өнгөрнө. Харин
Бурханы хүслийг үйлдэгч нь мөнхөд оршму. (1Иохан 2:17)

Энэ дэлхийгээс холбоо хамаарлаа салгахын тулд бид хүслээ доош тавьж, Бурханы хүслийг тэврэх ёстой. Түүний дотор л энэ аюултай хамаарлаас аврагдах эмчилгээ бий.

тэр — Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла гэв. (Лук 10:27)

Бурханы хайр амьдралд дүүрэхэд, энэ дэлхийн атга сулардаг. Бурхан дээр төвлөрч, Түүгээр улам хайрлуулах үедээ би өөртөө хавьгүй зөөлөн ханддаг. Өөртөө зөөлөн ханддаг хүн бусдыг илүү хайрладаг. Бурхан дээр төвлөрч Бурханыг хайрладаг бол, хоосон юмстай бага хөөцөлдөнө. Яагаад гэвэл харилцаа маань битүүрч, бүрэн бүтэн болдог учраас тэр.

Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. (Иаков 4:4)

Заримдаа би “Бид Бичээст үнэхээр нухацтай ханддаг уу эсвэл нигүүлслийн эрин үед Бичээс хэрэгжихгүй гэж үздэг болсон уу?” гэж гайхдаг юм. Хүн санаатайгаар Бүтээгчтэйгээ тэрсэлдэнэ гэхээр төсөөлөхөд хэцүү. Паул нэгэн зэрэг хуулийн ч дор, нигүүлслийн ч дор амьдрахыг хүссэн, завхай хүмүүсийн асуудлыг шийдвэрлэсэн бол, Иаков мөнхийн гэрээтэй боловч, Лотын авгай шиг байнга дэлхий рүү эргээстэй хүмүүсийн талаар ярьжээ.

Энэ шарвалт нь дэлхийтэй найзлах гэсэн энгийн хүслээс эхэлдэг гэжээ. Иаков энд яг юуны тухай ярина вэ? Дэлхий дээр найзтай байх юмуу дэлхийн найзтай байх нь дэлхийтэй найзлахаас өөр юм. Бид дэлхийн хүмүүстэй найзалж болох ч, дэлхийтэй найзалж болохгүй. Эхнийх нь биднийг дэлхийн оршин суугчидтай хэрхэн харилцахыг дүрсэлж байгаа бол, хоёр дахь нь дэлхийн системтэй нөхөрлөх талаар ярьж байна. Чи доор нь орчихсон юмныхаа дээр хэзээ ч мэдэлтэй байж чадахгүй. Бид

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

дэлхийг хүлээн зөвшөөрөх биш, харин энэрэн өрөвдөх ёстой.

Бид нүцгэн дэлхийг хувцаслах ёстой болохоос биш, дэлхийтэй хамт нүцгэлэх ёсгүй.

Бид өлсгөлөн дэлхийг хооллох ёстой болохоос биш, дэлхийгээр өлсөж цангах ёсгүй.

Бид хэвтэрт орсон дэлхийг асарч сувилах ёстой болохоос биш, дэлхийтэй нэг оронд орох ёсгүй.

Бид хүмүүстэй харилцахдаа ч, өөрийнхөө Хааны тушаалыг дагангаа, тэднийг өөр хаанчлалын элчингүүд гэж харах ёстой. Яагаад гэвэл тэр харилцаа нэг л өдөр асуудалтай тулгарна.

Бид энэ титмийн төлөө өрсөлдөгч айдсаа хаяж, Бурханыг, бусдыг, өөрийгөө хайрлах Бурханы дуудлагыг тас тэврэх ёстой.

Амийн титэм

Тэгэхээр хамгийн сүүлийн титэм нь Амийн титэм. Үүнийг бас итгэлийнхээ төлөө амиа алдагч нарын титэм ч гэж хэлж болох байх. Еврей ном дээрх “Итгэлийн танхимд” жагсаагдсан баатруудын олонх нь энэ титмийг хүлээн авсан байгаа. Тэдний дунд Степан, Петрээс гадна энэ дэлхий дээр нэрийг нь ч дуулаагүй Христийн олон дагалдагч бий. Бүхнээ өгдөг хүмүүс бий. Энэ титмийг өрсөлдөөнгүй үнээр олддог юм.

Эдлэх гэж буй зовлонгуудаасаа бүү ай. Үзэгтүн, диавол та нарыг сорихын тулд та нараас заримыг чинь шоронд хаяж гэж байна. Та нарт арван өдөр зовлон ирнэ. Үхэл хүртэл үнэнч бай. Тэгээд Би чамд амийн титэм өгнө. Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун. Ялагч нь хоёр дахь үхлээр гэмтэхгүй. (Илчлэл 2:10-11)

Мессеж Библи дээр 10-аар ишлэлийг нь “*Чамд л таарах Амийн титмийг чамд бэлтгэсэн байгаа*” гэж хэлсэн байдаг.

Бид бүтэлгүйтэхээс айдаг эрин үед аж төрж байна. Харгислал, гамшиг, гай, дайн нь үхлийн айдсыг тэжээж байна. Гүтгэлгэ, ял, хавчлага нь хүний айдсыг тэжээж байна. Тиймээс Сатан биднийг саажуулах гэж оролдож байгаа нь ойлгомжтой. Яг л Неро шиг Сатан биднийг нэг талаар харгислал, аймшгаар сүрдүүлж, нөгөө

талаар баялаг, тачаалаар өддөг. Дайсан биднийг хүслийн худагтаа зоос шидээд, хүслээ шившдэг сүсэгтнүүд л болгохыг хүсдэг. Гэтэл бид Амийн титмийг хүлээж авахын төлөө гүн болох ёстой.

Би саяхан нэг өдрийн дотор гурван аймшигтай түүх сонслоо. Хоёрынх нь линкийг нэгэн дагалдагч охин маань илгээсэн байв. Тэрбээр гэр бүлийнхээ хамт Израиль дахь хүний наймаатай тэмцдэг байгууллагыг тэргүүлдэг юм. Түүний явуулсан эхний линк дээр ISIS-д олзлогдож, бэлгийн боол болсон 150 охид, эмэгтэйн амиа егүүтгэсэн эмгэнэлт түүх байв. Алуурчид үүнд ч ханахгүй, эмэгтэйчүүдийн биесээр нохдоо хоолложээ. Би итгэж ядсандаа тэр мэдээг бүр хэд хэд уншив. Ийм аймшигтай муу ёрын юм байж болно гэж үү? Яг одоо үүнийг бичиж байхад охидын биесийг хүүлж идэж байгаа араатан нохдын дүр зураг төсөөлөгдөхийн хамт Илчлэл 12:17 санаанд орж байна:



**Бид Амийн
титмийг хүлээж
авахын төлөө гүн
болох ёстой.**

Луу мөнөөх эмэгтэйд хилэгнэж, Бурханы хуулиуд болон Есүсийн гэрчлэлийг сахидаг, эмэгтэйн бусад үр удамтай нь дайтахаар явав.

Хүн төрөлхтөнд байж боломгүй ийм харгислал нь... луугийн хилэн юм.

Луугийн уур хилэн “Эмэгтэйг” болоод “Бурханы хуулиуд болон Есүсийн гэрчлэлийг сахидаг эмэгтэйн хүүхдүүдийг” чиглэжээ (Илчлэл 12:17). Энэ муу ёр сүүлийн арван жил аймшигтай газар авч байна.

Дараагийн линк дээр нь Кораныг цээжилсэн эрчүүдийг бэлгийн боолоор шагнадаг тухай бичжээ. Тэдгээр завхрагчид бэлгийн хүчирхийллийг хүндэтгэл мөргөлийнхөө нэг хэсэг гэж үздэг аж. Харамсалтай нь энэ ном хэвлэгдэж гарах үед эдгээр түүх нь үй олон аймшигт түүхийн далайд живээд, хэдийн замхрах байх даа.

Гурав дахь түүхийг нь манай нэг ажилтан над руу цахим шуудангаар илгээжээ. Тэрбээр Христчин материал тэр бүр олдох боломжгүй, ядуу буурай улс орнуудад бидний ном, сургалтын

материалыг үнэгүй тараах ажлыг зохицуулдаг хүн л дээ. Гэтэл тэрбээр Ойрх Дорнод ажилладаг бидний нэг зоригт найз маань Сирийн Христэд итгэгчдийг чиглэсэн галлагад өртөн, амиа алдсан талаар бичсэн байв. Манай холбоочин тэр хүний талаар хэлэхдээ “Зарим нь чадахаа өгдөг, зарим нь бүхнээ өгдөг” гэж бичсэн байсан юм.

Намайг үлэмжийн гуниг нөмрөв. Тэгээд би уулзалт руугаа явж байхдаа, эхнэрт нь юу гэж бичихээ төсөөллөө. Юу ч хэллээ гэсэн, үг маань доромжлол болох юм шиг санагдав. Уучлаарай гэх нь дэндүү гэнэн, баярлалаа гэх нь дэндүү буруу. Би итгэлийнхээ төлөө алуулна гэж юу байдгийг мэдэхгүй, амар тайван, тав тухтай газар суучихаад, хөөрхий эмэгтэйд ийм үг бичих гэж үү? Би хурууныхаа үзүүрээр магтаалын дуу асаадаг бас уншиж барахгүй олон Библи, номтой хүн. Агуулах сав маань хоол хүнсээр, шүүгээ маань хувцсаар дүүрэн. Орой нь би дэлхийн өнцөг булан бүрт итгэл нэгт ахан дүүс маань амиа алдаж байгааг мэдэхгүй, ач нартайгаа инээлдэн тоглоно.

Би асар их ичэв. Хамаг амьдрал маань хоосон хясаа шиг, мэддэг бүхэн маань ач нарын маань үлээж тоглодог хөөс шиг эмзэг санагдав. Хэнд ч хамаагүй сэтгэлээ уудалмаар. Тэгээд миний дотор булгилж байгаа асуултуудад хариулахгүй ч, зүгээр л сонсоод ойлгох, надаас ахмад, надаас ухаалаг нэгэн эгч рүүгээ ярьлаа.

Миний дотор бөөн бөөн “яагаад” дүрэлзсээр. Яагаад надад ийм их зүйл байхад, далайн цаана өөр нэгэн эмэгтэй дахиад ганц ч эгшин амьдрахыг хүсэлгүй, амиа егүүтгэнэ вэ? Шударга ёс гэж хаана байна аа? Би дотроос олгойдож байгаа уур хилэн, шаналлаа хэрхэн боловсруулахаа мэдэхгүй байв. Тэгтэл би өөрийгөө харьцуулж байгаагаа мэдрэв. Мэдээж би ялгаа мэдрэх эрхтэй ч, харьцуулалт нь ямар ч нэмэргүй байв. Үүнд хариулт байхгүй. Могой л луу болон хувирсан шүү дээ. Луугийн нөлөөн дор эрчүүд, эмэгтэйчүүд бие биедээ аймшигтай юмс үйлддэг. Тэгээд надад сонголт байгааг ухаарав. Би уурлаж, хурц асуулт тавьсаар байж болно эсвэл амьдрал дахь асуултынхаа тэмдгийг анхаарлын тэмдэг болгон хувиргаж чадна. Тиймээс би нулимсаа арчаад, тэдний амьдралыг өөрийнхөө амьдралд анхааруулга болгохоор шийдэв.

Хавчлага бол шинэ юм биш - үеийн үед л байсан. Тавин тавтай өдий насны хүн чинь энэ дэлхийгээс хэзээ ч хариулт олохгүй

асуултанд уймраад байхааргүй, төлөвшилд хүрсэн байх ёстой. Нас бидэнд утгагүй зүйлийг тайлж өгч чадахгүй. Бид хурдны замаар явж байна. Тиймээс өнөөгийн үйл явдлууд нь биднийг өнө мөнхийн амьдрал руу улам л тэмүүлэхэд хүргэх учиртай. Ийм учраас чадаж байгаа дээрээ улам хичээнгүй хөдөлмөрлө. Энэ бүх ойлгомжгүй зүйлсийн учир гагцхүү өнө мөнхлөлд л тайлагдана. Харин одоо бид энэ бүхний төлөө залбирч, зүрх маань өрсөлдөөн, агаархал, харьцуулалтаас чөлөөтэй үед л Бурхан бидний залбирлыг сонсдог гэдгийг санаж явах ёстой юм.

Та нар дуудлагынхаа нэг л найдварт дуудагдсаны адил нэг бие, нэг Сүнс, нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм, нэг Бурхан байна. Тэр бол бүгдийн Эцэг бөгөөд бүгдийн дээр бүгдээр дамжин бүгдийн дотор байдаг. Харин Христийн бэлгийн хэмжээгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл өгөгдсөн байв. (Ефес 4:4-7)

Өөрийнхөө амьдралаар амьдар!

Бидэнд маш их зүйл өгөгджээ. Бидний давтагдашгүй онцгой чанар бол бэлэг юм. Бидний үзэж туулсан бүхэн маань ч бэлэг мөн. Бидэнд сонголт байгаа. Бид зүгээр л алмайраад л, юу ч хийхгүй байж болно. Эсвэл байдаг л зүйл шиг хандан, дэмий цалгардуулж болно. Эсвэл байнгын гайхамшгийн амьдарлаар амьдарч болно. Цаг хугацааныхаа хүчийг гайхаж байгаа бол, урагшаа яв.

Сүүлийн арван жилийн хугацаанд би эрслэн эмэгтэйчүүд, илд загалмайтай охид, баатар шиг байлддаг охидын талаар бас үнсэлт нь охидын сэтгэлийг тордохоосоо илүү уйлуулдаг тухай хэд хэдэн ном бичсэн. Харин одоо энэ номоороо дамжуулан би чамд чиний доторх тэр их хүлээлт хэдийн биелсэн гэдэг найдварыг хэлж байна. Учир нь чи:

Өрсөлдөөнгүй амьдралд дуудагдсан.
Аваараа өрсөлдөгчгүй хайрлагдсан.
Өрсөлдөөнгүй цаг үед амьдарч байгаа.
Өрсөлдөгчгүй улсаас дуудагдсан.
Өрсөлдөгчгүй Бурханд үйлчилж байгаа.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Өрсөлдөгчгүй тахилаар авчруулсан.
Өрсөлдөгчгүй нэрээр итгэмжлэгдсэн.
Өрсөлдөгчгүй Сүнсээр хүчирхэгжсэн.
Өрсөлдөгчгүй хэлээр илэрхийлэгдсэн.
Өрсөлдөгчгүй биеийн нэг хэсэг.
Өрсөлдөгчгүй захирамжийг хүлээж авсан.
Өрсөлдөгчгүй зэвсгээр зэвсэглэсэн.
Өрсөлдөгчгүй дайнд оролцсон.
Өрсөлдөгчгүй залбиралд дуудагдсан.
Бидний өмнө өрсөлдөгчгүй боломжууд байна. Учир нь бид
Өрсөлдөгчгүй ургац хурааж
Өрсөлдөгчгүй өнө мөнхөд амьдрах тавилантай.
Тиймээс одоо гоо үзэсгэлэн, хүч, мөн чанар, цар хүрээгээрээ
өрсөлдөгчгүй амьдралаар амьдаръя. Зарим нь чадахаа
өгөг, зарим нь бүхнээ өгөг.

Бурханы өмнө найдвараар гийж, итгэмжтэй үйлчилж, хайраар айдасгүй үйлд. Учир нь найз минь, эгч, дүү минь чи, өрсөлдөгчгүй хувь тавилантай болой. Хайр, эр зориг, урмаар аймшиггүй амьдар.

Хэлэлцэх асуулт

1. Теклагийн түүх чамд юу өгүүлэв?
2. Дэлхийтэй нөхөрлөх нөхөрлөл болон дэлхийн найз байхын ялгааг дүрслэ.
3. Чи амьдралынхаа аль хэсэг дээр зохицуулалт хийх ёстой байна?
4. Өрсөлдөгчгүй амьдралын төлөө хамгийн түрүүнд ямар алхам хийе гэж бодож байна?

НОМЫН ЗҮҮЛТ

Бүлэг 3:

1. Though the true meaning of *selah* is not known, many think it is a liturgical notation. The Amplified Bible translates *selah* as “pause, and think of that.”

Бүлэг 5:

1. A. L. Duckworth, C. Peterson, M. D. Matthews, and D. R. Kelly, “Grit: Perseverance and Passion for Long-Term Goals,” *Journal of Personality and Social Psychology* 92, no. 6 (2007): 1087.
2. Malcom Gladwell, *David and Goliath: Underdogs, Misfits, and the Art of Battling Giants* (New York: Little, Brown and Co., 2013).

Бүлэг 6:

1. Mark Driscoll, *On Church Leadership* (Wheaton, IL: Crossway, 2008).
2. Ibid.
3. Kris Vallotton, *Fashioned to Reign* (Grand Rapids: Chosen, 2013), chap. 7.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

4. Gilbert Bilezikian, *Beyond Sex Roles: What the Bible Says about a Woman's Place in Church and Family*, 3rd ed. (Grand Rapids: Baker, 2006).

Бүлэг 7:

1. C. S. Lewis, *The Four Loves* (New York: Harcourt Brace Jovanovich, 1960).
2. Kent M. Keith, *The Paradoxical Commandments* (Makawao, HI: Inner Ocean, 2001).

Бүлэг 9:

1. <http://oca.org/saints/lives/2015/05/10/39-sunday-of-the-samaritan-woman>.
2. <http://www.pravoslavie.ru/english/print79178.htm>.
3. Christopher Henry Dawson, *Religion and World History: A Selection from the Works of Christopher Dawson* (Garden City, NJ: Image Books, 1975).
4. The facts reported in this paragraph are culled from the following accounts: Robyn Dixon, "At Kenya College, Christian Students Foretold Massacre," *Los Angeles Times*, April 5, 2015; "Gunmen Kill 147 at University in Kenya," *Chicago Tribune*, April 3, 2015; "At Least 147 Killed in Islamic Terror Attack at Kenya University Targeting Christian Students," *KTLA.com*, April 2, 2015.

Бүлэг 10:

1. For more on the life of Thecla, see these sources: <http://www.pbs.org/wgbh/pages/frontline/shows/religion/maps/primary/thecla.html> (the account from the Apocryphal Acts); http://www.antiochian.org/life_of_thekla; <http://dce.oca.org/assets/templates/bulletin.cfm?mode=html&id=101>; <http://www.newadvent.org/cathen/14564a.htm>.
2. Henry Clarence Thiessen, *Lectures in Systematic Theology* (Grand Rapids: Eerdmans, 1979), 389.

Лиза Бивэр - олон улсад нэрд гарсан номлогч, шилдэг борлуулалттай номын зохиолч, хоёр зуу гаруй улсад гардаг *The Messenger* нэвтрүүлгийн хамтран хөтлөгч. *Lioness Arising*, *Сэлэмтэй охид*, *Fight Like a Girl* номын зохиолч, *Life Today* нэвтрүүлгийн байнгын зочин, Women of Faith, Жойс Мэйэрийн конференц, Хилсон чуулганы зочин номлогч. Жон, Лиза хоёр маань дөрвөн хүүтэй бөгөөд Колорадоод аж төрдөг.

Дэлгэрэнгүйг: LisaBevere.com хаягаас



ӨРСӨЛДӨГЧГҮЙ


Лиза Бивэрийг дараах цахим хуудсаар дагаж, ном сургаалтай нь танилцана уу:

LisaBevere.com


#WithoutRival

X MessengerX.com

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

“Христ доторх тодорхойлолтын маань эсрэг зогсоо зайгүй дэгдэх дайнд Өрсөлдөгчгүй ном маш онцгой байр суурьтай хандаж байна. Энэ номоор дамжуулан та таныг гэх Христийн гүн, онцгой хайрыг бас энэ хайрын авчирдаг хүчийг таньж мэднэ.”

—ЖОЙС МЭЙЕР

Библийн багш, бестселлер зохиолч

Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Шилдэг борлуулалттай номын зохиолч Лиза Бивэр “Өрсөлдөгчгүй” номдоо Бурханы хайр нь энэ бүх хязгаарыг хэрхэн тасар татдаг талаар хуваалцжээ. Та хүнээс эрэн хайгаад байдаг тодорхой, дотно харилцаагаа Бүтээгчтэйгээ тогтообол, өөрийгөө хэн болохыг жинхэнээсээ мэдэж, бусадтай өрсөлдөн барьцахаа болино. Лизагийн Библийн ул суурьтай, эш үзүүлэлтэй, хошин мэдрэмж, халуун сэтгэлтэй үгсээр та:

- Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга.
- Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт
- Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь
- Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сурах болтугай.

Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ.

Лиза Бивэрийн жинхэнэ, халуун сэтгэлтэй, хошин хандлага нь Библийн үнэнийг маш практик болгодог. Түүний *Fight Like a Girl, Lioness Arising, Сэлэмтэй охид* ном нь дэлхийн сая сая хүнд хүрчээ. Лиза нөхөр Жоньхоо хамт Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан бестселлер зохиолч бөгөөд дөрвөн хүү, дөрвөн ачтай Сицили гаралтай ээж, эмээ юм. Дэлгэрэнгүйг дараах хаягаас үзнэ үү.



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org



Бусад материалыг дараах цахим хуудаснаас: MessengerX.com

Энэ номыг зохиогч БЭЛЭГЛЭЖ байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

MessengerX.com

Илгээгч

